



Мултимедиа
Хэрэглэгчийн гарын авла

RX500h / RX450h+ /
RX350h / RX350



©2022 ТОО ТОЙОТА МОТОР КОРПОРАЦ

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Тойота
Мотор Корпорацийн бичгээр олгосон
звсрлгйгээрт ус материалыг бүхэлд
нь болон хэсэгчлэн хувилах, хэвлэхийг
хориглоно.

Үндсэн ажиллагаа	Мултимедиа системийн үндсэн ажиллагаа	1
Тохиргоо ба бүртгэл	Олон төрлийн функцийн тохиргоо ба бүртгэл	2
Ухаалаг утас, харилцаа холбооны төхөөрөмж холбох	Bluetooth® эсвэл Wi-Fi® ашиглах	3
Навигаци	Газрын зургийн дэлгэцийг ажиллуулах Газрын зураг хайх Маршрутын зааварчилгааг идэвхжүүлэх	4
Аудио систем	Радио сонсох Хөгжим сонсох	5
Гарын оролцоогүй дуудлага	Гарын оролцоогүй гар утсанд ашиглах	6
Холбогдсон үйлчилгээ	Холбогдсон үйлчилгээ ашиглах	7
Зогсоолд байрлуулахад туслах систем	Автомашины ойр орчмыг нягтлах	8
Хавсралт	Холбоотой мэдээлэл Сертификат	9
Индекс	Үсгийн дарааллаар хайна	

Танилцуулга

Таньд хэрэгтэй мэдээлэл.....	7
Аюулгүй байдлын зааварчилгаа	9
Тус гарын авлагын мэдээлэл.....	10
Зурган индекс	12

1 Үндсэн ажиллагаа

1-1. Мультимедиа системийн үндсэн ажиллагаа	
Дэлгэц ба удирдлага	14
Мультимедиа дэлгэцийн ерөнхий мэдээлэл	16
Үндсэн цэс	18
Статусын тэмдэг.....	20
Мэдрэгчтэй дэлгэц дарах...	22
Дэлгэцийн үндсэн функц ...	25
Тоо, үсэг оруулах.....	27
1-2. Навигацийн системийн үндсэн ажиллагаа	
Газрын зургийн дэлгэц.....	28
Автомашин одоогийн байрлалыг дэлгэцээр харуулах	30
Газрын зургийн масштаб өөрчлөх.....	31
Газрын зургийн чиглэлийг өөрчлөх	32
Газрын зураг хөдөлгөх	33
1-3. Аудио системийн үндсэн ажиллагаа	
Аудио систем асаах/унтраах, дууны түвшин тохируулах.....	34
Аудио эх үүсвэр солих	36
Эх сурвалж сонгох дэлгэцний товчны байрлал өөрчлөх.....	38

USB портод холбох.....	39
------------------------	----

1-4. Дуу хоолойн удирдлагын систем	
Дуу хоолойн удирдлагаар систем удирдах.....	40
Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх.....	42
Дуу хоолойн команд хэлэх.....	45
Үсэг шивэх гар ашиглан мэдээлэл хайх	49

2 Тохиргоо ба бүртгэл

2-1. Мультимедиа системийн анхны тохиргоо	
Хэрэглэгчийн профайл бүртгэх.....	52
2-2. Олон төрлийн тохиргоо	
Олон төрлийн тохиргоог өөрчлөх.....	58
2-3. Жолоочийн тохиргоо	
Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх.....	60
Жолооч таних тохиргоо хийх.....	63
2-4. Ерөнхий тохиргоо	
Мультимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх.....	67
2-5. Дэлгэцийн тохиргоо	
Дэлгэцийн тохиргоог өөрчлөх.....	70
2-6. Дуу хоолойн удирдлагын тохиргоо	
Дуу хоолойн удирдлагын тохиргоог өөрчлөх	72
2-7. Автомашин тохиргоо	
Дилерийн мэдээлэл тохируулах.....	74

Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх	75	Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх	113
Программ хангамжийн мэдээлэл шинэчлэх, шалгах	77	Бүртгэлтэй Bluetooth® төхөөрөмж устгах	116
2-8. Навигацийн тохиргоо		Bluetooth® төхөөрөмжтэй холбох	117
Навигацийн системийн тохиргоо	80	Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах	121
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх	81	Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах	122
Маршрутын тохиргоо	84		
Зааварчилгааны тохиргоо	87	3-2. Wi-Fi® сүлжээнд холбох	
Бусад тохиргоо	89	Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга	123
2-9. Дуу болон медиа тохиргоо		Wi-Fi® ашиглан сүлжээнд холбогдох	125
Дуу болон медиа тохиргоо өөрчлөх	95	3-3. Apple CarPlay болон Android Auto ашиглах	
Дэлгэцийн горим солих	98	Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга	128
Дүрсний чанарыг тохируулах	99	Бүртгэгдээгүй ухаалаг утасны Apple CarPlay ашиглах	131
Эх үүсвэр бүрийн дууг тохируулах	100	Бүртгэгдсэн ухаалаг утасны Apple CarPlay ашиглах	134
2-10. Wi-Fi® тохиргоо		Android Auto ашиглах	137
Wi-Fi® тохиргоо өөрчлөх ..	101	Apple CarPlay эсвэл Android Auto доголдон үед	139
2-11. Bluetooth® тохиргоо			
Bluetooth® төхөөрөмж тохируулах	103		
3			
Ухаалаг утас, харилцаа холбооны төхөөрөмж холбох			
3-1. Bluetooth® функц ашиглах			
Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга	108		
Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд	111		

4 Навигаци

4-1. Навигацийн систем

Wi-Fi® ашиглан авах
боломжтой газрын
зургийн мэдээлэл 144

Холбогдсон навигаци 146

Connected навигаци
(системд суурилсан
навигацитай) 147

4-2. Газрын зургийн мэдээлэл

Тухайн газрын мэдээлэл
харуулах 148

Газрын зургийн
сонголтын дэлгэц 149

POI тэмдэг гаргах 150

Газрын зургийн
дэлгэцийн тохиргоо 151

Хурдны замын горим 155

4-3. Очих газар хайх

Очих газар хайх 156

Очих газраа хайх дэлгэц.. 157

Хайлтын үр дүнгийн
дэлгэц 160

Замын цэг нэмэх 161

Ухаалаг утаснаасаа очих
газар тохируулах 162

4-4. Очих газрын тохиргоо

Бүтэн маршрутын газрын
зургийн дэлгэц 164

Маршрут
зааварчилгааны демо
үзэх 165

Маршрутын сонголтыг
өөрчлөх 166

Маршрут өөрчлөх 167

Маршрут дээр дайрч
өнгөрөх цэг тохируулах . 168

Замын цэг засварлах 169

4-5. Маршрутын зааварчилгаа

Маршрут заах дэлгэц 170

Замын эгнээний дэлгэц.... 171

Маршрут дахин хайх 173

Ердийн дуут
зааварчилгаа 174

4-6. Газрын зураг шинэчлэх

Газрын зургийн
мэдээллийн сан ба
хамрах хүрээ 175

5 Аудио систем

5-1. Радионы ажиллагаа

Радио сонсох 178

DAB сонсох 181

Аюулгүйн үүднээс эдгээр
функцуудыг автомашин
явж байх үед ашиглах
боломжгүй. 184

5-2. Интернет радио

Интернет радио ашиглах 185

5-3. USB флашны ажиллагаа

USB флаш тоглуулах
үеийн анхааруулга 186

USB флашнаас дуу
тоглуулах 188

USB флашнаас видео
файл тоглуулах 191

5-4. iPod/iPhone-н ажиллагаа

iPod/iPhone тоглуулах
үеийн анхааруулга 194

iPod/iPhone тоглуулах 195

5-5. Apple CarPlay-н ажиллагаа

Apple CarPlay тоглуулах
үеийн анхааруулга 198

Apple CarPlay тоглуулах.... 199

5-6. Android Auto-н ажиллагаа

Android Auto-г тоглуулах
үеийн анхааруулга 202

Android Auto-г тоглуулах..	203	Холбоо барих хаяг руу дуудлага хийх.....	230
5-7. Bluetooth® аудионы ажиллагаа		Дэлгэцийн гарнаас дуудлага хийх.....	231
Bluetooth® аудио тоглуулах үеийн анхааруулга	205	Хүлээх эсвэл түр зогсоох дохио ашиглан дуудлага хийх.....	232
Bluetooth® аудио тоглуулах.....	207	6-4. Дуудлага хүлээн авах Дуудлагад хариулах	233
5-8. Miracast®-н ажиллагаа		Дуудлага цуцлах	235
Тоглуулах үеийн анхааруулга. Miracast®...	210	6-5. Дуудлага дундах үйлдэл Дуудлагын дэлгэц дээр үйлдэл хийх	236
Miracast® дэмждэг төхөөрөмж холбох	211	Давхар дуудлагад хариулах.....	238
Miracast® тоглуулах.....	212	Дуудлага дундуур өөр хүн рүү дуудлага хийх.....	239
6 Гарын оролцоогүй дуудлага		Олон хүнтэй зэрэг дуудлага хийх.....	240
6-1. Гарын оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга		Дуудлага дуусгах.....	241
Гарын оролцоогүй дуудлагын анхааруулга..	216	6-6. Гарын оролцоогүй дуудлагад ашиглах утас солих	
Гарын оролцоогүй дуудлагад доголдол үүсэх нөхцөл	220	Гарын оролцоогүй дуудлагад ашиглах гар утас солих	242
6-2. Жолооны хүрдний товчоор гарын оролцоогүй дуудлага удирдах		6-7. Холбоо барих хаяг засах Холбоо барих хаягийг дамжуулах.....	244
Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл).....	224	Холбоо барих хаягт шинэ хаяг нэмэх	248
Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл).....	226	Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх.....	250
6-3. Дуудлага хийх Дуудлагын түүхээс дуудлага хийх.....	228	6-8. Мессеж функц хэрхэн ашиглах тухай Мессежний функц ашиглах үеийн анхааруулга	251
Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх.....	229	Мессежний функцаас дуудлага хийх.....	256

7 Холбогдсон үйлчилгээ

7-1. Веб хөтөч (Интернет)

Интернет хөтөч функцийн тухай.....	258
Интернет хөтчийн дэлгэц гаргах.....	259
Веб хөтчийн дэлгэц удирдах	260

8 Зогсоолд байрлуулахад туслах систем

8-1. Lexus parking assist монитор

Lexus parking assist мониторын функц.....	266
Чиглүүлэх дэлгэц гаргах...	268
Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх	270
Lexus parking assist мониторын анхааруулга	275

8-2. Панорамик дэлгэц

Панорамик дэлгэцийн функц	285
Арааг "P"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим.	289
Арааны "D" эсвэл "N" байрлал дахь дэлгэцийн горим	291
Арааг "R"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим.	299
Хажуугийн толь эвхэгдсэн үеийн дэлгэц..	307
Дэлгэц дээр томруулах	308
Автомашины доод талыг нэвт харуулах дэлгэц	310
Хөдөлж буй объектын анхааруулга	312
Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх	314

Панорамик дэлгэц ашиглах үеийн анхааруулга.....	316
---	-----

Дараах шинж тэмдэг гарсан үед	333
--	-----

9 Хавсралт

9-1. Хавсралт

Аудио системд ашиглаж болох медиа болон датагийн тухай мэдээлэл.....	338
Сертификат	348
Индекс	350

Таньд хэрэгтэй мэдээлэл

ckk1649033692564.dita

Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага

qfv1649033692486.dita

- Тус гарын авлага нь мултимедиа системийн ажиллагааг тайлбарлана. Зөв ашиглах үүднээс тус гарын авлага болон "Хэрэглэгчийн гарын авлага"-г сайтар уншина уу.
- Программ хангамжийн шинэчлэл, техник үзүүлэлт зэргээс хамаарч тус гарын авлагын мэдээлэл бодит системээс зарим нөхцөлд өөр байж болно.
- Тус гарын авлага нь системийн программ хангамжийн Ver.1310 хүртэлх хувилбарын мэдээллийг агуулдаг. Шинэчлэгдсэн мэдээллийг дараах холбоосноос авна уу. Программ хангамжийн одоогийн хувилбарыг ["Программ хангамжийн мэдээлэл шинэчлэх, шалгах"](#)(→Х. 77)-с харна уу.

Тухайн улс орон, бүс нутгаас хамаарч программ хангамжийг шинэчлэх боломжгүй байж болно.

► RX500h/RX350h

- URL:
<https://lexusmanuals.com.au/owners-manual-and-navigation-manual-updates/replace.html?param=om48l02e.rx.2210.hev.mm>
- QR код:



► RX350

- URL:
<https://lexusmanuals.com.au/owners-manual-and-navigation-manual-updates/replace.html?param=om48l02e.rx.2210.cv.mm>
- QR код:



- Ашиглах боломжтой функц, хамрагдсан үйлчилгээний нөхцөл, тухайн гарын авлагыг гаргах үеийн газрын зургийн мэдээлэл зэргээс хамаарч гарын авлага дахь дэлгэцний зураг бодит дэлгэцнээс өөр байж болно.
- Тус гарын авлага дахь компаний нэр болон бүтээгдэхүүн нь тус бүрийн компаниудад бүртгэлтэй барааны тэмдэгт болно.

Дата өгөгдлийн нөхөн төлбөрийн тухай мэдэгдэл

jrg1649033692517.dita

Энэ систем нь өгөгдлийг дотоод санах ойд хадгалдаг. Санах ойд хадгалагдсан өгөгдөл нь системийн доголдол, засвар, доголдол, алдаа болон бусад шалтгааны улмаас эвдэрч, алдагдаж болзошгүй.

Тоёота нь шууд болон шууд бус гэмтэлд ямар ч хариуцлага хүлээхгүй бөгөөд дотоод санах ойд хадгалагдсан өгөгдлийг зохих ёсоор хадгалж чадаагүй тохиолдолд өгөгдөлд нөхөн төлбөр олгохгүй.

12 вольтын аккумулятор салгах

vbz1649033692501.dita

Асаах товч <power товч> унтраасан үед бүх дата системд хадгалагддаг. Дата хадгалагдахаас өмнө 12в аккумуляторын шон салгасан үед дата зөв хадгалагдахгүй байж болно.

Австралийн хэрэглэгчдэд

ohw1649033692533.dita

Lexus группын хувийн мэдээллийг хамгаалах, зээлийн мэдээллийн бодлогын тухай дэлгэрэнгүйг <http://www.lexus.com.au/privacy-c> харна уу.

Аюулгүй байдлын зааварчилгаа

vqm1649033692548.dita

Тус системийг аюулгүй ашиглах үүднээс дараах аюулгүйн зааварчилгааг баримтлана.

Тус систем нь зөв ашигласан үед зорьсон газартаа хүрэхэд туслах зорилготой. Жолооч нь тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, зорчигчдын аюулгүй байдлыг дангаараа хариуцна. Тус системийн аливаа функцийг анхаарал болгоомжгүй жолоодлого, аюулгүй байдлыг хангаагүй жолоодлогод ашиглаж болохгүй. Жолоодлогын үед нэн түрүүнд анхаарах зүйл бол тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа байх ёстой. Жолоодлогын үед замын хөдөлгөөний бүх дүрмийг дагаж мөрдөнө. Хэрэв замын хөдөлгөөний тэмдгийг өөрчилсөн бол нэг чигийн хөдөлгөөн зэрэг шинэчлэгдсэн мэдээлэл байхгүй байж болно.

Жолоодлогын үед аль болох дуут зааварчилгааг түлхүү сонсох ба зөвхөн аюулгүй үед дэлгэц рүү богино харна. Нөгөөтэйгүүр дуут зааварчилгаанд хэт даатгаж болохгүй. Зөвхөн мэдээллийн журмаар ашиглана. Систем одоогийн байршлыг зөв тогтоож чадахгүй үед зааварчилгаа буруу эсвэл оройтож өгөх эсвэл дуут зааварчилгаа огт өгөхгүй байж болно.

Системийн дата нь зарим нөхцөлд бүрэн гүйцэд биш байж болно. Замын нөхцөл, замын тэмдэг тэмдэглэгээ (зүүн эргэхийг хориглох, зам хаах зэрэг) нь тогтмол өөрчлөгддөг. Тиймээс системийн аливаа зааварчилгааг дагахаас өмнө аюулгүй байдал болон хууль дүрмийн үүднээс зааварчилгааг мөрдөх нь зүйтэй эсэхийг нягтлана.

Тус систем нь тухайн газар нутгийн аюулгүй байдал, гудамжны нөхцөл, яаралтай үйлчилгээний бэлэн байдал зэрэг мэдээллийг агуулдаггүй. Тухайн газар аюулгүй эсэхийг мэдэхгүй үед явахгүй байх нь зүйтэй. Ямар ч нөхцөлд тус систем нь жолоочийн хувийн шийдвэр гаргалтыг орлохгүй.

▲ АЮУЛТАЙ

- Аюулгүйн үүднээс жолооч жолоодлого хийх үедээ системийг удирдаж болохгүй. Зам болон замын хөдөлгөөнд анхаарал дутуу хандуулах нь осолд хүргэх аюултай.
- Жолоодлогын үед замын хөдөлгөөний дүрэм журмыг мөрдөж замын нөхцөлийг мэддэг байх шаардлагатай.

Тус гарын авлагын мэдээлэл

ibi1649033707481.dita

Тус гарын авлагад ашиглагдсан тэмдгийн утга.


Тэмдэг

ild1649033707513.dita


Тэмдэг	Утга
	АЮУЛТАЙ : Дагаж мөрдөөгүй тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах зүйлсийг тайлбарлана.
	АНХААР : Дагаж мөрдөөгүй тохиолдолд автомашин болон түүний эд ангид гэмтэл учруулах зүйлсийг тайлбарлана.
1 2 3...	Үйлдлийн эсвэл ажиллагааны дарааллыг илтгэнэ.
	Хэрэглэгчийн мэдэх ёстой эсвэл мэдүүштэй функц, үйлдлээс бусад үйлдэл болон функцийг тайлбарлана.

Зураг дахь тэмдэг

hjlw1649033707497.dita




Тэмдэг	Утга
	Товч болон төхөөрөмжийг ажиллуулах үеийн үйлдэл (дарах, эргүүлэх г.м.)-г тайлбарлана.



Тэмдэг	Утга
	Тайлбарлаж буй эд анги, түүний байрлалыг заана.

Дараах зурагт зүүн жолооны хүрдтэй автомашиныг харуулав.



- A** Жолооны хүрдний товч
 - Аудио удирдах.....X.36
 - Дуу хоолойн командаар систем удирдахX.42
 - Дуудлага хийх X.224,226
- B** Дэлгэц X.14
- C** [VOL] товч X.34
- D** USB порт X.39

1-1. Мультимедиа системийн үндсэн ажиллагаа

Дэлгэц ба удирдлага	14
Мультимедиа дэлгэцийн ерөнхий мэдээлэл	16
Үндсэн цэс	18
Статусын тэмдэг.....	20
Мэдрэгчтэй дэлгэц дарах...	22
Дэлгэцийн үндсэн функц ...	25
Тоо, үсэг оруулах.....	27

1-2. Навигацийн системийн үндсэн ажиллагаа

Газрын зургийн дэлгэц.....	28
Автомашины одоогийн байрлалыг дэлгэцээр харуулах	30
Газрын зургийн масштаб өөрчлөх.....	31
Газрын зургийн чиглэлийг өөрчлөх	32
Газрын зураг хөдөлгөх	33

1-3. Аудио системийн үндсэн ажиллагаа

Аудио систем асаах/унтраах, дууны түвшин тохируулах.....	34
Аудио эх үүсвэр солих	36
Эх сурвалж сонгох дэлгэцний товчны байрлал өөрчлөх.....	38
USB портод холбох.....	39


1-4. Дуу хоолойн удирдлагын систем

Дуу хоолойн удирдлагаар систем удирдах.....	40
---	----


Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх.....	42
Дуу хоолойн команд хэлэх.....	45
Үсэг шивэх гар ашиглан мэдээлэл хайх	49

Дэлгэц ба удирдлага

► 14 инчийн дэлгэц



► 9.8 инчийн дэлгэц



A Дэлгэц

Мэдрэгчтэй дэлгэц дээр шууд гараар товшин удирдана.

B [VOL] товч

Аудио асааж унтраах мөн дууны түвшин тохируулна.

 МЭДЭЭЛЭЛ

- LCD дэлгэц нь орчны нөхцөл байдал мөн харж буй өнцгөөс шалтгаалж цайрах эсвэл харлаж харагдаж болно.
- Дэлгэц дээр нар болон бусад гэрэл туссан үед сайн харагдахгүй байж болно.
- Туйлширсан нарны шил зүүсэн үед дэлгэц хар харагдах эсвэл сайн харагдахгүй байж болно.

 АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед дэлгэц аль болох бага удирдах ба удирдах үед автомашин зогсоох нь зүйтэй. Жолоодлогын үед дэлгэц удирдах нь жолооны хүрд санамсаргүй эргүүлэх, бусад гэнэтийн

▲ АЮУЛТАЙ

осолд хүргэх аюултай. Мөн жолоодлогын үед зөвхөн шаардлагатай үед богино хугацаанд харах зэргээр дэлгэц аль болох бага харна.

▲ АНХААР


Асаах товч <хайбрид систем> унтарсан үед дэлгэцийг удаан ашиглаж болохгүй. 12в аккумуляторын цэнэг суулгана.

Систем дахин асаах

lph1649033784163.dita


Системийн хариу үйлдэл хэт удаан үед дахин асаах боломжтой.

- [ VOL] товчийг 3-с дээш секунд дарна.



Мультимедиа дэлгэцийн ерөнхий мэдээлэл

wqa1649033784241.dita

**A** Үндсэн цэс

Тэмдэг дарах үед дэлгэцээр гарах функцийг өөрчлөнө.

B Микрофоны товч

Дуу хоолой таних дэлгэц гаргаж навигацийн систем, аудио, цаг агаар болон бусад олон төрлийн функцийн дуу хоолойн ажиллагааг идэвхжүүлнэ.

C Статусын тэмдэг

Цаг болон мэдээлэл дамжуулалтын статусын тэмдэг зэрэг нь дэлгэцийн дээд талд гарна.

D Цаг агаарын удирдлагын товч

Агааржуулалтын систем болон автомашины функцуудыг удирдана.*1

МЭДЭЭЛЭЛ

- Мультимедиа дэлгэцийн хэмжээнээс хамаарч дэлгэцээр гарах контент өөр байж болно.
- Зөвхөн 14 инчийн дэлгэц:

Газрын зургийн дэлгэцний [≡]-г дарж газрын зургийг том хэмжээтэй гаргаад аудио дэлгэцний [🔊]-г дарж контентийг томоор гаргана.



— Холбоотой холбоосууд —

[Үндсэн цэс\(Х. 18\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)


*1 :Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Статусын тэмдэг(Х. 20)

Үндсэн цэс

mms1649033784210.dita

Дэлгэцээр гарах функцийг тэмдэг дээр даран өөрчлөх боломжтой.



 : Apple CarPlay

Apple CarPlay-н дэлгэц гаргана.

 : Android Auto™

Android Auto-н дэлгэц гаргана.

 : Навигацийн систем

Газрын зургийн дэлгэц гаргана. Навигацийн систем ашиглан очих газар хайх, бусад навигацтай холбоотой үйлдэл хийх боломжтой.

 : Аудио

Аудио удирдлагын дэлгэц гаргана. Тоглуулах аудио эх үүсвэрийг сонгох боломжтой.

 : Гар утас

Утасны дэлгэц гаргана. Bluetooth®-р холбогдсон гар утсыг гарын оролцоогүй дуудлагад ашиглах боломжтой.

 : Автомашины мэдээлэл*1

Автомашины мэдээллийг дэлгэцээр гаргана. Шатахуун зарцуулалтыг дэлгэцээр харуулах, төхөөрөмжийн тохиргоо хийх боломжтой.

 : Connected үйлчилгээ

Аппликейшний дэлгэцийг гаргана.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Дэлгэрэнгүйг (үйлчилгээ нэвтэрсэн улс, ажиллагаа, тохиргоо зэрэг) та өөрийн Lexus дилерээс авна уу.

 : Тохиргоо

Тохиргооны дэлгэц гаргана. Мультимедиа систем болон автомашины тохиргоог өөрчлөх боломжтой.

 МЭДЭЭЛЭЛ


Дэмждэг төхөөрөмж холбогдож боломжит функц идэвхжих үед Apple CarPlay/Android Auto тэмдэг гарна.

*1 :Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Статусын тэмдэг

zkr1649033784178.dita

Цаг болон холболтын статусын мэдээлэлтэй тэмдэг дэлгэцийн дээд талд гарна.



4:12

Одоогийн цаг харуулна. Цаг дээр товшиж цаг, огноо тохируулах дэлгэцэнд шилжинэ.



Bluetooth®-р холбогдсон гар утасны холболтын статусыг харуулна. Тэмдэг дээр товшиж Bluetooth® тохиргооны дэлгэцэнд шилжинэ.



Гар утасны сүлжээний түвшинг харуулна.



Холбогдсон гар утасны зайны цэнэгийн түвшинг харуулна.



DCM-н холболтын түвшинг харуулна.*1



Wi-Fi® сүлжээний долгионы түвшинг харуулна.



Lexus parking assist-мэдрэгч идэвхтэй үед дэлгэцээр гарна.



Утасны дэлгэцээс бусад дэлгэц гарч байгаа үед гарын оролцоогүй дуудлага хийгдэх үед гарна.



Интернет радио тоглуулах үед гарна.*2



Утасгүй цэнэглэгч асаалттай үед гарна. *1

МЭДЭЭЛЭЛ

- Дэлгэцээр харуулах гар утасны цэнэгийн түвшин гар утасны дэлгэцээр гарах түвшнээс зөрж болно. Мөн утасны загвараас хамаарч гар утасны цэнэгийн түвшин дэлгэцээр гарахгүй байж болно.
- Долгион сул үед Wi-Fi®-д холбох боломжгүй байж болно.
- Гар утсыг дараах байрлалуудад тависан үед Bluetooth® ашиглах боломжгүй байж болно:
 - Гар утас суудлын ард эсвэл доод талд, урд хайрцаг, голын хайрцагт байгаа
 - Гар утас металл эд зүйлстэй нийлсэн эсвэл хучигдсан байгаа
- Гар утсыг зайны цэнэг хэмнэх горимд тохируулсан үед Bluetooth® холболт автоматаар салгагдаж болно. Энэ нөхцөлд гар утасны зайны цэнэг хэмнэх горимыг унтраана.

— Холбоотой холбоосууд —

Мультимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх(X. 67)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(X. 103)

*1 :Тоноглогдсон автомашинд

*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.


Мэдрэгчтэй дэлгэц дарах

ujm1649033784303.dita

Мэдрэгчтэй дэлгэцийг хуруугаараа шууд дарж ажиллуулна.


■ Мэдрэгчтэй дэлгэц дарах

Дэлгэцийг зөөлөн даран дэлгэц дээрээс сонголт хийх боломжтой.




■ Чирэх

Дэлгэцийг дарангаа хуруугаа шилжүүлэн жагсаалт болон газрын зургийг гүйлгэх боломжтой.




■ Хуруугаараа хөнгөн түлхэх

Дэлгэцэнд хүрсэн хурууны үзүүрээ хурдан шилжүүлэн жагсаалт болон газрын зургийг гүйлгэх боломжтой.



■ Томруулах/жижгэрүүлэх

Дэлгэцэнд 2 хуруугаа хүргэнгээ хөдөлгөн газрын зургийг томруулах, жижгэрүүлэх боломжтой.



☐ МЭДЭЭЛЭЛ

- Зарим функцийг ажиллуулах үүднээс дэлгэцийг удаан дарах эсвэл 2 удаа дарна.
- Дэлгэц дарах үеийн дэлгэцийг мэдрэг байдлыг өөрчлөх боломжтой.
- Дэлгэц дарах үеийн дууг ON/OFF тохиргоо хийх боломжтой
- Өндөрлөг газар хуруугаараа хөнгөн түлхэх үйлдлийг хийх боломжгүй байж болно.
- Жолоодлогын үед дэлгэц удирдах үйлдэл хязгаарлагддаг.

— Холбоотой холбоосууд —

Мультимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх(Х. 67)

Мэдрэгчтэй дэлгэц ашиглах үед анхаарах зүйлс

cvr1649033784225.dita

☐ МЭДЭЭЛЭЛ

- Дэлгэцний товч ажиллахгүй үед хуруугаа салгаад дахин товшино.
- Дараах нөхцөлүүдэд дэлгэцний товч ажиллахгүй байх эсвэл доголдож болно:
 - Бээлий өмссөн
 - Дэлгэц дээр хумсаараа дарсан
 - Дэлгэц дээр товших үед өөр хуруу эсвэл гарын алга дэлгэц дээр зэрэг хүрсэн
 - Дэлгэц дээр ус, бохирдол байгаа
 - Дэлгэц дээр пластик хуулга наасан

- Телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, өргөн нэвтрүүлгийн станц, том дэлгэц, нисэх буудал, бусад хүчтэй радио долгион, шуугиан гаргадаг газрын ойр орчимд байгаа
- Радио, гар утас зэрэг зөөврийн утасгүй харилцааны төхөөрөмж автомашинд байгаа эсвэл цэнэглэж байгаа үед
- Дараах металл эд зүйлс дэлгэцэнд хүрсэн, дэлгэцийг халхалсан үед товч ажиллахгүй байх эсвэл доголдоно:
 - Хөнгөн цагаан ялтас зэрэг металлаар бүрхэгдсэн карт
 - Хөнгөн цагаан ялтастай тамхины сав
 - Металл эд ангитай түрийвч, цүнх
 - Зоос
 - CD, DVD зэрэг медиа болон USB холбогч зэрэг
- Дэлгэцийг хуруугаар дарангаа систем асаасан үед дэлгэцийн товч ажиллахгүй байж болно. Дэлгэцээс хуруугаа салган дахин оролдоно. Товч ажиллахгүй үед асаах товч <power товч> унтраагаад систем дахин асаана.
- Apple CarPlay газрын зургийн апп нь 2 хуруугаар чимхэж томруулах, жижгэрүүлэх үйлдэл дэмждэггүй.

АНХААР

- Дэлгэц хамгаалах үүднээс дэлгэц ашиглах үед хуруугаараа зөөлөн товшино.
- Хуруунаасаа өөр зүйлээр дэлгэц ажиллуулж болохгүй.
- Дэлгэцийг шилний даавуун алчуур эсвэл түүнтэй төстэй зөөлөн даавуугаар зөөлөн цэвэрлэнэ. Хуруугаараа хүчтэй дарах, хатуу даавуугаар арчих нь дэлгэцэнд хортон суулгах аюултай.
- Бензин, шүлтлэг уусмал ашиглан дэлгэц цэвэрлэж болохгүй. Дэлгэц гэмтээх аюултай.
- Тодорхой нөхцөлүүдэд дэлгэц бага зэрэг халсан мэдрэгдэж болно. Хөнгөн түлэгдэл үүсгэх аюултай тул удаан дарахаас зайлсхийнэ.


Дэлгэцийн үндсэн функц

ugu1649033784256.dita

1

Үндсэн ажиллагаа

Тохиргоо, аудио зэрэг ашиглах боломжтой олон сонголт байгаа үед дэлгэц гарна. Жагсаалтыг доош гүйлгэж сонгоно.



A Үндсэн цэс

Тэмдэг дээр дарж дэлгэцээр гарах функцийг өөрчлөнө.

B Дэд цэс

Жагсаалтаар сонголтууд гаргана. Дэлгэц дээр даран дээш доош хөдөлгөн жагсаалтыг гүйлгэх боломжтой.

C Тайлбарын хэсэг

Дэд цэс дээр сонгосон зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл гаргана.

D Түвшний дараалал

Дэлгэцийн гарчгийг түвшний дарааллаар харуулдаг. Нэг түвшин дээшлүүлэх үед [<]-г дарна.

МЭДЭЭЛЭЛ

Жолоодлогын дэлгэц дээр хийх үйлдэл хязгаарлагддаг.

■ **Жагсаалтаас хайх**

Индекс дахь үгийг дарж жагсаалтаас сонгоно.



■ Тохиргоог асаах, унтраах

Тухайн зүйл дээр дарах үед тохиргоо асах буюу унтрана.



: ON



: OFF



■ Олон тохиргооны сонголт

[⋮]-г агуулсан зүйл дээр дарж олон сонголтоос сонгоно.



■ Түвшин тохируулах

Дээш доош гүйлгэн тохиргооны түвшинг тохируулах боломжтой.



— Холбоотой холбоосууд —

Үндсэн цэс(Х. 18)

Тоо, үсэг оруулах

jqg1649033784194.dita

1

Дэлгэцийн гар ашиглан тоо, үсэг оруулах боломжтой. Үсэг бичих үед санал болгох үгнүүд гарна.

► Жишээний дэлгэц



/ : Дэлгэцийн гар хааж өмнөх дэлгэц рүү буцна.

: Курсор хөдөлгөнө.

: Одоогийн бичсэн текст дээр үндэслэн санал болгох үг харуулна.

: Нэг үсэг устгана.

: Дэлгэцийн гар солино.*1

: Том жижиг үсэгт шилжүүлнэ.

[Go] : Оруулсан текст дээр үндэслэн хайлт хийнэ.

: Дэлгэцийн гар хаана.

123 : Тоо болон тэмдэгт бичих горимд солино.

ABC : Үсэг бичих горимд шилжүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ


- Тухайн функцаас хамаарч дэлгэцээр гарах дэлгэцийн гарын загвар өөр байна.
- Гарын төрөл шууд сонгох үед []-г удаан дарна.*1
- Том үсгээр бичих үед []-г давхар дарна.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Газрын зургийн дэлгэц

Газрын зургийн дэлгэц нь дараах мэдээлэл болон зорилготой.

Үндсэн цэсний [A] -г дарна.



A Одоогийн байрлалыг заах тэмдэг

Одоогийн байрлал болон чиглэл заана.

B Замын эгнээний мэдээллийн дэлгэц

Уулзвараар чигээрээ явах, эргэх эгнээний мэдээлэл гаргана. (Зөвхөн газрын зургийн мэдээлэлтэй уулзварт хамаарна)

Маршрутын зааварчилгааны үед систем явахыг зөвлөсөн эгнээг тодоор харуулна.

C Нэрийн дэлгэц

Нөхцөл байдлаас хамаарч дараах зүйлс харуулна: (Зөвхөн газрын зургийн мэдээлэлтэй замд хамаарна)

● Явж буй замын нэр

D Масштабын дэлгэц

Газрын зургийн масштаб харуулна.

E Чиглэлийн тэмдэг

Газрын зургийн чиглэлийг харуулна. Хуруугаар товшиж чиглэл өөрчилнө.

Газрын зургийн чиглэл өөрчлөх тухай дэлгэрэнгүйг газрын зургийн чиглэл өөрчлөхөөс харна уу.

F Томруулах/жижигрүүлэх товч

Газрын зураг томруулна/жижигрүүлнэ.

G Дэлгэцийн тохиргооны товч

Тохиргооны дэлгэц гаргах ба мөн ойр байрлах POI дэлгэцийг өөрчлөх зэрэг тохиргоо хийнэ.

H Очих газрын товч

Очих газрын хайлтын дэлгэц гаргана.

I Микрофоны товч

Дуу хоолой таних удирдлагын дэлгэц гаргана.

— **Холбоотой холбоосууд** —

Автомашины одоогийн байрлалыг дэлгэцээр харуулах(Х. 30)

Газрын зургийн чиглэлийг өөрчлөх(Х. 32)

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо(Х. 151)

Очих газар хайх(Х. 156)

Дуу хоолойн удирдлагаар систем удирдах(Х. 40)

Автомашины одоогийн байрлалыг дэлгэцээр харуулах

bup1649898436145.dita

Автомашины одоогийн байрлал [▲] тэмдэг дээр гарна.



Газрын зургийг өөр тийш гүйлгэсэн үед үндсэн цэсний [▲] эсвэл [▼]-г дарж одоогийн байрлалд буцаана.

МЭДЭЭЛЭЛ

- Автомашин шинэ эсвэл 12в аккумуляторыг залгаад салгасан үед автомашины бодит байрлал болон дэлгэцээр гарах [▲] одоогийн байрлал [▲] өөр байж болно. Нөгөөтэйгүүр тодорхой зайнд явж GPS-н мэдээллийг зөв хүлээн авах үед дэлгэцээр гарах одоогийн байрлал [▲] автоматаар засагдана. (Нөхцөл байдлаас хамаарч хэдэн минут болж болно.) Хэрэв GPS мэдээлэл хүлээн аваагүй ба байрлал автоматаар засагдахгүй үед автомашиныг аюулгүй газарт зогсоож байрлалыг гар аргаар засна.
- Газрын зургийн өнгөөс хамаарч одоогийн байрлалын тэмдэгний [▲] хэлбэр өөр байна.

— Холбоотой холбоосууд —

Газрын зургийн дэлгэцийн өөрчлөх боломжтой тохиргоо(Х. 82)

Байрлал/Чиглэлийн тохиргоо хийх(Х. 94)

Газрын зургийн масштаб өөрчлөх

kju1649898436176.dita

1

Газрын зургийн дэлгэцийг томруулах/жижигрүүлэх боломжтой.

Газрын зурагний дэлгэцийн [+] эсвэл [-]-г дарна.



- Дэлгэц дээр 2 удаа товших, 2 хуруугаар удирдах үйлдлээр масштабыг мөн өөрчлөх боломжтой.
2 товшиж томруулах: Дэлгэцийг хурдан 2 удаа товшино
Товшиж жижигрүүлэх: Дэлгэц дээр 2 хуруугаар зэрэг товшино
- Масштаб үргэлжлүүлэн өөрчлөх үед [+]/[-]-г удаан дарна.

Хотын газрын зураг

see1649898436192.dita

Газрын зургийг бүрэн томруулсан үед хотын газрын зураг харах боломжтой.

Газрын зургийн масштаб 50 м (150 фут) үед [+]-г дарна.

Хотын газрын зургийг цуцлах үед [-]-г дарах эсвэл дэлгэц дээр 2 хуруугаа чимхэж ойртуулах үйлдэл хийнэ..

МЭДЭЭЛЭЛ

- Тухайн байрлал газрын зургийн өгөгдөлд ороогүй үед хотын газрын зураг гарахгүй.
- Хотын газрын зураг байхгүй газар луу автомашин орсон эсвэл газрын зургийг шилжүүлсэн үед автоматаар хотын газрын зураг цуцлагдана.

Газрын зургийн чиглэлийг өөрчлөх

npe1649898436207.dita

Газрын зургийн чиглэлийг автомашины чиглэлтэй тохируулан засах эсвэл өөрчлөх боломжтой. Та өөрийн хүссэнээр өөрчлөн тохируулна уу.

Газрын зургийн дэлгэцний []-г дарах бүрт газрын зургийн чиглэл хойд зүг, явж буй зүг болон 3D дэлгэцээр солигдоно.

- Хойд зүгийг дээд талд харуулах дэлгэц []
Автомашины явж буй чиглэлээс үл хамааран хойд зүгийг цаг ямагт дээд талд харуулна.
- Явж буй зүгийг дээд талд харуулах дэлгэц []
Автомашины явж буй чиглэлийг цаг ямагт дээд талд харуулна.
- 3D газрын зураг []
Газрын зургийг 3 хэмжээсээр харуулна. 3D газрын зураг дээр дарсан үед явж буй чиглэлийг цаг ямагт дээд талд харуулна.

** МЭДЭЭЛЭЛ**

- 3D газрын зургийн дэлгэцийн өнцгийг тохируулах боломжтой.
- Газрын зургийг явж буй чиглэлийг дээд талд харуулах эсвэл 3D-р тохируулсан үед дэлгэцийг одоогийн байрлалаас өөрчилсөн нөхцөлд (очих газрын тохиргооны дэлгэц, бүтэн маршрутын газрын зураг зэрэг) газрын зургийн чиглэл хойд зүгийг дээд талд харуулах байдлаар өөрчлөгдөнө. Нөгөөтэйгүүр одоогийн байрлалыг дэлгэцэнд буцах үед өмнөх явж буй чиглэлийг дээд талд харуулах эсвэл 3D газрын зурагт буцна.

Холбоотой холбоосууд

[Дэлгэцийн өнцөг тохируулах\(Х. 82\)](#)

Газрын зураг хөдөлгөх

ncs1649898436160.dita

1

Газрын зураг хөдөлгөн товшсон цэгийг газрын зургийн төв болгон тохируулах боломжтой.

Газрын зураг дахь цэгийг товшино.

- Газрын зургийн төв хөдлөж товшсон цэг рүү шилжинэ.



- Хэрэв тухайн POI-н мэдээлэл байгаа үед дэлгэцээр гарна.
- Газрын зургийг хөдөлгөөд [📍] -г дарах үед тухайн цэгийг шинэ очих газар эсвэл замын цэгээр тохируулах боломжтой.
- Газрын зургийг хөдөлгөөд [❤️] -г дарж тухайн цэгийг тогтмол ашигладаг хаягаар бүртгэх боломжтой.
- [📍] эсвэл [📍] -г дарж автомашины одоогийн байрлал руу буцна.

МЭДЭЭЛЭЛ

Газрын зургийг дэлгэц дээр товшиж, чирж эсвэл хөдөлгөн тохируулах боломжтой.

Холбоотой холбоосууд

[Мэдрэгчтэй дэлгэц дарах\(Х. 22\)](#)

[Газрын зургийн чиглэлийг өөрчлөх\(Х. 32\)](#)

[Тухайн газрын мэдээлэл харуулах\(Х. 148\)](#)

Аудио систем асаах/унтраах, дууны түвшин тохируулах

Аудио системийг ашиглаагүй үед унтраах, мөн дууны түвшинг тохиромжтой түвшинд тааруулах боломжтой.

Асаах товчны <power товч> ACC эсвэл ON горимд системийг ашиглах боломжтой.


АНХААР

- Хөдөлгүүр асаагүй <хайбрид систем ажиллаагүй> үед аудио системийг удаан хугацаанд ашиглаж болохгүй. 12в аккумуляторын цэнэг суух аюултай.
- Аюулгүй жолоодлогод саад учруулахгүй хэмжээнд дууны түвшинг тохируулна.

■ Аудио удирдлагын товч ажиллуулах


[VOL] товч

Товч дарж асааж унтраана.
Эргүүлж дууны түвшинг тохируулна.



■ Жолооны хүрдний товчоор удирдах

► А төрөл



[+] товч


Дууны түвшинг нэмнэ.

Үргэлжлүүлэн тохируулах үед удаан дарна.

[-] товч

Дууны түвшинг хасна.

Үргэлжлүүлэн тохируулах үед удаан дарна.

► В төрөл**Аудио систем асааж унтраах товч**

Тус товчийг өөрчлөх боломжтой тохиргоо функцаар тогтмол ашигладаг жолооны хүрдний товч болгон тохируулсан үед ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Товч дарж асааж унтраана.

[+] товч

Дууны түвшинг нэмнэ.

Үргэлжлүүлэн тохируулах үед удаан дарна.

[-] товч

Дууны түвшинг хасна.


Үргэлжлүүлэн тохируулах үед удаан дарна.

Аудио эх үүсвэр солих

mvd1649896272378.dita

Аудио эх үүсвэрийг радио, USB зэргээр солих боломжтой.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 Сонгох эх үүсвэрийг дарна.



МЭДЭЭЛЭЛ


- Аудио хөгжим сонсох үед автомашин дотор эсвэл ойр орчимд гар утас ашигласан нөхцөлд спикернээс шум гарч болно.
- Apple CarPlay-н холболтын төрлөөс хамаарч дараах функц ашиглах боломжгүй.
 - iPod
 - USB аудио эсвэл USB видео
 - Bluetooth® аудио
 - Miracast®
 - Android Auto
- Android Auto холбоотой үед дараах функц ашиглах боломжгүй.
 - iPod
 - USB аудио эсвэл USB видео
 - Apple CarPlay

Жолооны хүрдний товчоор эх үүсвэр солих

owz1649896272425.dita

Жолооны хүрдний товчоор эх үүсвэр солих боломжтой.

► А төрөл


**[MODE] товч**

Эх үүсвэр дарааллын дагуу солигдоно.

Удаан дарж түр зогсоох эсвэл дууг хаана. Дахин удаан дарж цуцлана.

Эх үүсвэр сонгох дэлгэц дээр товчны байрлал өөрчилсөн үед солих дараалал мөн өөрчлөгдөнө.

► ► В төрөл

**Mode товч**

Өөрчлөх боломжтой тохиргоогоор тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Эх үүсвэр дарааллын дагуу солигдоно.

Удаан дарж түр зогсоох эсвэл дууг хаана. Дахин удаан дарж цуцлана.


Эх үүсвэр сонгох дэлгэц дээр товчны байрлал өөрчилсөн үед солих дараалал мөн өөрчлөгдөнө.

Эх сурвалж сонгох дэлгэцний товчны байрлал өөрчлөх

eti1649896272394.dita

Товчийг илүү хялбараар удирдах боломж бүрдүүлэн байрлалыг нь өөрчлөх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 Өөр байрлалд шилжүүлэх эх үүсвэрийн баруун талын [☰]-г дараад товчны байрлал өөрчлөөд салгана.



USB портод холбох

rbt1649896272441.dita


1

Үндсэн ажиллагаа

Ухаалаг утас, зөөврийн тоглуулагч зэрэг төхөөрөмж холбоно.

● **USB холбогчийг портод хийнэ.**

USB флаш залгах үед шууд USB портод хийнэ.



 МЭДЭЭЛЭЛ


- Тухайн төхөөрөмжөөс хамаарч файлыг үзэх боломжгүй байж болно.
- Тухайн холбох USB холбогч болон төхөөрөмжийн зааварчилгааг харна уу.
- Холбосон төхөөрөмжийн цахилгааны эх үүсвэрээр зай хураагуур зэргийг ашиглана. Автомашины залгуур ашиглах нь шуугиан үүсгэж болно. (Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

 АНХААР

- Холбосон төхөөрөмжийг доош дарах, хөшихийг хориглоно. Төхөөрөмж болон терминал гэмтээх аюултай.
- Портод гадны биет орохоос сэргийлнэ. Төхөөрөмж эсвэл порт гэмтэх аюултай.

Дуу хоолойн удирдлагаар систем удирдах

Дуу хоолойн удирдлагын систем ашиглах нь навигаци, агааржуулалтын систем, аудио, гарын оролцоогүй дуудлага болон бусад олон үйлдлийг дуу хоолойн командаар хийх боломж бүрдүүлнэ. Lexus Connect*¹ ашиглах үед үүлэн хадгалах сан дахь мэдээллийг ашиглан хайлт хийх давуу тал бүрдэнэ.



- A** Дуу хоолойг таньсан байдлыг харуулна.
 [■] / [■] : Ярьж эхлэхийг хүлээнэ
 [■] : Сонсох
 [○] : Дуу хоолойг таних явц
- B** Системийн хариу үйлдэл болон таньсан үр дүнг текстээр харуулна.
- C** Дэлгэцийн үсэг шивэх гар гаргана.
 Үг оруулан олон төрлийн мэдээлэл хайх боломж бүрдүүлнэ.
- D** Дуу хоолойн командын жишээг жагсаалтаар гаргана.
 Үйлдэл тус бүрээр олон ашигласан командын жишээг харах боломжтой.
- E** Дуу хоолойг таних дэлгэцийг хаана.

МЭДЭЭЛЭЛ

- Дэлгэц дээр Lexus Connect*¹-н холбогдсон байдлыг харуулна.
 [No online service] : Lexus Connect-н үйлчилгээнд хамрагдаагүйг илтгэнэ.
 [No internet connection] : Интернетэд холбогдоогүйг заана.

- Жолоодлогын үед дуу хоолой таних дэлгэц самбар байдлаар гарна.
- Зарим нөхцөлд ROI эсвэл хаяг хайх боломжтой улсын нэрүүдийг дэлгэцээр гаргаж болно.*1

— Холбоотой холбоосууд —

Үсэг шивэх гар ашиглан мэдээлэл хайх(Х. 49)

Дэмжих боломжтой хэл

nrt1649033838580.dita

Тус функц нь дараах хэл дээр ажиллах боломжтой:

■ Номхон далайн орнууд

Англи

■ Зүүн Өмнөд Ази

Англи, Тайланд, Индонези хэлнүүд

■ Ойрхи Дорнод

Англи, Араб хэлнүүд

■ Өмнөд болон Төв Америк

Англи, Испани, Бразилийн Португали хэлнүүд

■ Өмнөд Африк

Англи, Франц хэлнүүд

■ Хонгконг

Англи, Мандарин Хятад хэл, Кантон хэлнүүд

■ Энэтхэг

Англи

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх


wia1649033838517.dita

Дараах аль нэг үйлдлээр дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх боломжтой:


■ Дуудлага хийх, яриаг дуусгах товчийг дарна

Жолооны хүрдний [] товч (дуудлага хийх, яриаг дуусгах) дарна.

► А төрөл



► В төрөл




Тухайн автомашин болон мультимедиа системээс хамаарч товч тус бүрийн байрлал өөр байж болно.

■ Системийг сэрээх үг хэлэх

"Hey Lexus" гэж хэлнэ.

- Тохиргооны дэлгэц дээр сэрээх үгийг өөрчлөх боломжтой.
- Сэрээх үгийг хэлээд үргэлжлүүлэн дуу хоолойн удирдлага, команд өгөх боломжтой.

Жишээ: "Hey Lexus, go to nearby coffee shop"



■ Микрофоны товч дарна

Дэлгэцний []-г дарна.



МЭДЭЭЛЭЛ

- Дуу хоолойн удирдлагын системийг сэрээх үгээр идэвхжүүлсний дараа жолооч эсвэл зорчигчийн суудлаас дуу хоолойгоор удирдах боломжтой. Энэ нөхцөлд системийг идэвхжүүлсэн суудлаас өөр суудлаас өгсөн дуу хоолойн командыг систем танихгүй.
- Нөгөөтэйгүүр зарим үйлдлийг зорчигчийн суудлаас дуу хоолойн удирдлагаар хийх боломжгүй.
- Дуудлага хийх, яриаг дуусгах товч эсвэл микрофоны товчоор дуу хоолойн удирдлагын системийг идэвхжүүлсэн үед зорчигчийн суудлаас дуу хоолойн команд өгөх боломжгүй.
- Командыг цэвэр тод хэлээгүй нөхцөлд дуу хоолойн удирдлагын систем танихгүй байж болно. Систем ашиглах үед дараах зүйлсийг анхаарна уу:
 - Цэвэр тод хэлнэ.
 - Дуу чимээнээс (салхи, гадаад чимээ шуугиан) шалтгаалж команд зөв танигдахгүй байж болох тул цонхоо хаана.
 - Агааржуулалтын систем хүчтэй ажиллаж байгаа нөхцөлд команд зөв танигдахгүй байж болох тул агаарын хэмжээг бууруулна.
 - Хөгжимний дуу чанга үед команд зөв танигдахгүй байж болох тул дууны түвшинг бууруулна.
 - Нэгэн зэрэг олон хүн ярьж байгаа үед команд зөв танигдахгүй байж болно.
- Дуу хоолойн командаар та системийн дуу хоолойн зөвлөмжийг цуцлах боломжтой.
- Тохиргооны дэлгэц дээр та системийн дуу хоолойны зөвлөмжийг идэвхжүүлэх болон унтраах боломжтой.
- Тохиргооны дэлгэц дээр системийн дуу хоолойны дууны түвшинг тохируулах боломжтой.

— Холбоотой холбоосууд —

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 72)

Дуу хоолойн удирдлагын системийг асаах сэрээх үг солих(Х. 72)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх(Х. 95)

Дуу хоолойн удирдлага зогсоох

sne1649033838533.dita

Дуу хоолойн удирдлагыг дараах аль нэг аргаар дуусгах боломжтой:

- "Cancel" гэж хэлнэ.
- Дуу хоолойн удирдлагын дэлгэцний -г дарна.
- Жолооны хүрдний дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарна.

Дуу хоолойн команд хэлэх

zht1649033838595.dita

1

Дуу хоолой таних дэлгэц гарсан үед команд хэлнэ. Дуу хоолойн систем нь хэвийн байдлаар ярих үед танина.*1



МЭДЭЭЛЭЛ

- Аялгатай ярих, хэвийн бус үг хэллэг ашигласан үед дуу хоолойг танихгүй байж болно.
- Газар, байгууламжийн нэрийг товчлолоор хэлэх, өөр нэршилээр хэлсэн үед систем танихгүй нөхцөлд албан ёсны нэрээр дахин хэлнэ.
- Ямар үйлдэл хийх гэж байгаагаа дуу хоолойн командад давхар хэлсэн үед систем командыг илүү хялбар танина. Жишээлбэл очих газрын нэр хайх үед зөвхөн газрын нэр хэлж болохгүй. Үүний оронд "Go to nearby coffee shop" гэх байдлаар газрын нэр болон үйл үг хамт хэлнэ.

Ажиллагааны жагсаалт

org1649033838564.dita

Дуу хоолойн командын жишээ болон дуут командаар ажиллуулах боломжтой ажиллагааг харуулав.

Автомашин болон системээс хамаарч ашиглах боломжтой ажиллагаа өөр байж болно.

■ Нийтлэг командууд

Үйлдэл	Дуут командын жишээ
Эхнээс нь эхлэх	"Start over"
Дуут команд цуцлах	"Cancel"
Дуут командын санаа өгөх	"Help"
Өмнөх дэлгэц рүү буцах	"Go back"
Жагсаалтын дугаар сонгох	"Number one"
Жагсаалтын хуудас солих	"Next page" "Previous page"

*1 :Тоноглогдсон автомашинд

■ Очих газрын хайлт*2

Нэр, төрөл, байгууламжийн хаягаар очих газрыг тохируулах боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Байгууламж хайх	"Find a <POI category/POI name>" "Go to nearby <POI category>"
Хаяг хайх	"Get directions to <address>"
Гэр лүүгээ харих	"Take me home"

■ Навигацийн ажиллагаа*2

Газрын зураг ашиглах, мөн очих газрыг устгах боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Газрын зургийн төрөл солих	"Change map to 3D"
Газрын зургийн масштаб солих	"Zoom in" "Zoom out"
Газрын зургийн дэлгэц гаргах	"Show map"
Маршрутын мэдээлэл шалгах	"What's my ETA?"
Очих газрыг устгах	"Delete destination"
Очих газрын түүх харуулах	"Show recent destinations"

■ Аудио ажиллагаа

Радио, USB санах ой, Bluetooth® аудио зэрэг аудио ажиллагааг удирдах боломжтой.

Медиад хадгалагдсан дуучин, цомог, дууны нэрийг заах боломжтой.

Радио станцийн нэрнээс мөн заах боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Дууны түвшин тохируулах	"Volume up", "Volume down"
Дуу хаах	"Mute audio"
Дараагийн/өмнөх дууг тоглуулах	"Next song", "Previous song"
Тоглуулах дууг заах*3	"Play <artist>", "Play <album>", "Play <song>"
Радио станц сонгох	"Tune to <FM frequency>", "Tune to <FM station name>"
Аудио эх үүсвэр солих	"Change to <audio source>"

■ Гарын оролцоогүй утасны ажиллагаа*4

Автомашинд холбогдсон Bluetooth® гар утсаар дуудлага хийх боломжтой.

Холбоо барих хаягт бүртгэгдсэн нэр, утасны төрлийг зааж утасны дугаар луу залгах боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Хаягийн жагсаалтад байгаа дугаар луу дуудлага хийх	"Call <contacts>"
Утасны дугаар луу дуудлага хийх	"Call <phone number>"
Дуудлагын түүх харуулах	"Show recent calls"
Мессеж илгээх*2	"Send message to <contact name>"
Мессежийг дуудаж унших*2	"Read message"
Bluetooth® холболтын дэлгэц гаргах	"Show Bluetooth Settings"

■ Мэдээлэл хайх үйлчилгээ*2*5

Онлайн үйлчилгээ ашиглан мэдээлэл хайх боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Цаг агаарын мэдээлэл шалгах	"Tell me the weather in Sydney tomorrow"

■ Цаг агаарын удирдлага

Агааржуулалтын системийн хэм, сэнсний хурдыг удирдах боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Агааржуулалтын систем асаах, унтраах	"Turn on the air conditioner", "Turn off the air conditioner"
Агааржуулалтын системийн хэм тохируулах	"Turn up the temperature", "Turn down the temperature", "Set the temperature to 25 degrees"
Агааржуулалтын системийн сэнсний хурд тохируулах	"Turn the fan speed up", "Turn the fan speed down", "Set the fan speed to 3"

■ Автомашины төхөөрөмжийн ажиллагаа*2*5

Цонх нээх, хаах зэрэг автомашины функцийг удирдах боломжтой.

1-4. Дуу хоолойн удирдлагын систем

Үйлдэл	Дуут командын жишээ
Цонх нээх ба хаах	"Open all windows", "Close all windows", "Open driver side window", "Close driver side window"
Дээврийн нээлхий нээх, хаах*2	"Open moon roof", "Close moon roof"
Салхины шил арчигч ажиллуулах*4	"Turn on the front wiper"
Байрлал санах тохиргоог дахин дуудах/бүртгэх*2*4	"Set seat position number 1", "Save seat position number 1"
Гэрэлтүүлгийн өнгө өөрчлөх*2	"Set the illumination to red"
HUD дэлгэц асаах*2*4	"Turn on head up display"
Одометр гаргах*4	"Show odometer"
А гүйлт хэмжигч гаргах*4	"Show Trip A"
Камерны дэлгэц гаргах*2*4	"Show side camera view", "Show wide front camera", "Show moving camera"
Камерны дэлгэц өөрчлөх*2*4	"Change camera view"

■ Автомашины мэдээлэл

Шатахуун зарцуулалт, туулах боломжтой зай зэрэг автомашины мэдээлэл шалгах боломжтой.

Үйлдэл	Дуут командын жишээ
Шатахууны хэмнэлт шалгах	"What's my fuel consumption?"
Туулах боломжтой зайг шалгах	"What's my cruising range?"
Дундаж хурд шалгах	"What's my average speed?"

■ Дэлгэцээр гарсан мэдэгдэлд дуу хоолойгоор хариу үйлдэл хийх

Дуудлага ирэх, бусад мэдэгдэлд дуу хоолойгоор хариу үйлдэл хийх боломжтой.

— Холбоотой холбоосууд —

[Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх\(Х. 72\)](#)

*2 :Тоноглогдсон автомашинд

*3 :USB-р холбогдсон төхөөрөмжинд хадгалсан дууг тоглуулах боломжтой.

*4 :Зорчигчийн суудлаас дуут команд өгөх боломжгүй.

*5 :Lexus Connect-н үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.

Үсэг шивэх гар ашиглан мэдээлэл хайх

|dc1649033838611.dita

1

Гар ашиглан олон төрлийн мэдээлэл хайх боломжтой.

1 []-г дарна.



Өмнөх хайлтын түүх байгаа үед түүхээс хайх боломж бүрдүүлж дэлгэц дээр хайлтын түүх гарна.

2 Хайх категорио сонгоно.

[Navigation] : Хаяг, байгууламжийн нэр, утасны дугаар, хороо, замын нэр, уулзвар зэргийг оруулна.

[Media] : Цомог, дуучин, дууны нэр, дууны жагсаалт, төрөл, радио станц зэргийг оруулна.


[Phone] : Нэр, утасны дугаар, утасны холбоо барих хаягт бүртгэгдсэн бусад зүйлсийг оруулна.

[Vehicle] : Шатахуун зарцуулалт болон дэлгэц дээр гаргахыг хүсч буй автомашины бусад мэдээллийг оруулна.

[Settings] : Аудио, утас, агааржуулалтын систем зэрэг өөрчлөхийг хүсч буй тохиргоог оруулна.



3 Хайх түлхүүр үгийг оруулаад [Go]-г дарна.



4 Хайлтын үр дүн жагсаалтаар гарч ирэх үед хүссэн зүйлээ сонгоно.

МЭДЭЭЛЭЛ

- Автомашин явж байх үед дэлгэц удирдах үйлдэл хязгаарлагддаг.
- Apple CarPlay/Android Auto-д холбогдоогүй үед хайлт хийх боломжгүй.

2-1. Мултимедиа системийн анхны тохиргоо	
Хэрэглэгчийн профайл бүртгэх.....	52
2-2. Олон төрлийн тохиргоо	
Олон төрлийн тохиргоог өөрчлөх.....	58
2-3. Жолоочийн тохиргоо	
Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх.....	60
Жолооч таних тохиргоо хийх.....	63
2-4. Ерөнхий тохиргоо	
Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх.....	67
2-5. Дэлгэцийн тохиргоо	
Дэлгэцийн тохиргоо өөрчлөх.....	70
2-6. Дуу хоолойн удирдлагын тохиргоо	
Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх.....	72
2-7. Автомашины тохиргоо	
Дилерийн мэдээлэл тохируулах.....	74
Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх.....	75
Программ хангамжийн мэдээлэл шинэчлэх, шалгах.....	77
2-8. Навигацийн тохиргоо	
Навигацийн системийн тохиргоо.....	80
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх.....	81
Маршрутын тохиргоо.....	84
Зааварчилгааны тохиргоо.....	87
Бусад тохиргоо.....	89
2-9. Дуу болон медиа тохиргоо	
Дуу болон медиа тохиргоо өөрчлөх.....	95
Дэлгэцийн горим солих.....	98
Дүрсний чанарыг тохируулах.....	99
Эх үүсвэр бүрийн дууг тохируулах.....	100
2-10. Wi-Fi® тохиргоо	
Wi-Fi® тохиргоо өөрчлөх..	101
2-11. Bluetooth® тохиргоо	
Bluetooth® төхөөрөмж тохируулах.....	103

Хэрэглэгчийн профайл бүртгэх*1

Мултимедиа системийн анхны тохиргооны үед үндсэн хэрэглэгчээр бүртгэнэ.

Хэрэглэгчийн профайл бүртгэн жолоодлогын байрлал, мултимедиа болон төрлийн тохиргоог жолооч бүрт хийх боломжтой. Найз нөхөд, гэр бүлээрээ зэргээр олон жолооч тус автомашиныг жолооддог үед та бусад жолоочийн тохиргоог өөрчлөлгүйгээр жолоодох боломжтой.

Хэрэглэгчийн профайл бүртгэхгүй үед та зочин жолоочийн горимоор жолоодох боломжтой.

Хэрэглэгчийн профайл

Жолооч тус бүрийн жолоодлогын байрлал, мултимедиа тохиргоо болон автомашины бусад тохиргоог сануулж тухайн жолооч автомашин ашиглах үед эдгээр тохиргоог дуудаж ашиглах боломж бүрдүүлнэ.

- 3 хүртэлх хэрэглэгчийн профайл бүртгэх боломжтой.
- Хэрэглэгчийн профайлд дараах тохиргооны мэдээллийг сануулах боломжтой:
 - Зарим мултимедиа тохиргоо : Дууны түвшин, дууны чанар, навигацийн систем, аудио зэрэг.
 - Автомашины зарим тохиргоо : Жолоодлогын байрлал, хянах самбарын хэмжих хэрэгслүүд зэрэг.
- Автомашины тохиргоог өөрчилсөн үед тухайн хэрэглэгчийн профайлд өөрчлөлт автоматаар хадгалагддаг.
- Хэрэглэгчийн профайлыг тохируулснаар хайлтын түүх, хувийн тохиргоо болон бусад хувийн мэдээллээ хамгаалах боломжтой.
- Жолооч таниулах төхөөрөмж бүртгүүлсэн үед хэрэглэгчийн профайл автоматаар дуудагдана. Ухаалаг утас, ухаалаг түлхүүрийг бүртгүүлэх боломжтой.

■ "Lexus Connected App" аккаунт руу холбох*2

- Профайл ашиглах үед "Lexus Connected App"-н үйлчилгээний эрх нь идэвхтэй аккаунт шаардлагатай.
- Хэрэв таны "Lexus Connected App" аккаунт "Lexus Connected App"-тай холбогдсон үед LEXUS Connect үйлчилгээнд хамрагдсан бөгөөд адил загварын мултимедиатай аль ч автомашин жолоодох үед өөрийн хэрэглэгчийн профайлаа "Lexus Connected App Profile"-с татаж авах боломжтой.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- Бүртгэгдсэн хэрэглэгчийн профайлыг "Lexus Connected App" дээр шалгах, өөрчлөх боломжтой.
- Эзэмшигчээр бүртгэгдсэн жолооч бусад бүх жолоочийн бүртгэлийг устгах боломжтой. Эзэмшигчээр бүртгэгдээгүй жолооч эзэмшигчийн хэрэглэгчийн профайлыг устгах боломжгүй.
- Өөр автомашинд адил хэрэглэгчийн профайл нэгэн зэрэг ашиглагдах боломжгүй.
- Автомашины тохиргоог өөрчлөх үед хэрэглэгчийн профайл автоматаар өөрчлөгдөх ба жолоочид хэрэглэгчийн профайл өөрчлөгдсөнийг мэдэгдэх мэдээлэл дэлгэцээр гарна.
- Мултимедиа системийн зарим тохиргоо нь үүлэн хадгалах санд хадгалагдах ба автомашинд устгасан ч үүлэн хадгалах сангаас устгагдахгүй.

— Холбоотой холбоосууд —


Жолооч таних тохиргоо хийх(Х. 63)

Жолоочийн профайл анхны удаа бүртгэх (А төрөл)

Idu1649033902175.dita

Профайл ашиглах үед идэвхтэй "Lexus Connected App"-н хэрэглэгчийн аккаунт шаардлагатай.

- 1 **Автомашин ассаны дараах эхний дэлгэц дээр [OK]-г дарна.**



- 2 **[Yes]-г дарна.**
 - Хэрэглэгчийн профайл бүртгэхгүй үед [No]-г дарна.
- 3 **Ухаалаг утасны "Lexus Connected App" апп ашиглан хэрэглэгчийн профайл бүртгэх үед [Through Lexus app]-г дарна.**
 - Хэрэглэгчийн аккаунт, нууц үг ашиглан бүртгэх үед [Enter account & password]-г дарна.
- 4 **[Next]-г дарна.**

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- Ухаалаг утасны "Lexus Connected App" апп байхгүй үед дэлгэцээр гарах QR код ашиглан татах боломжтой.
- 5 **Ухаалаг утасны "Lexus Connected App" апп нээгээд дэлгэцний зааварчилгааг баримтлах ба QR код уншуулаад [Link acc. via verification code]-г дарж баталгаажуулах код оруулан жолооч бүртгэнэ.**
- 6 **[Confirmed]-г дарна.**
Бүртгэл дууссан үед мэдээлэл гарч таны профайл хадгалагдана.
- 7 **Хэрэглэгчийн профайл хадгалаад жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.**
Төхөөрөмжийг дараа бүртгэх боломжтой.
- 8 **Жолоочийн тохиргооны дэлгэц дээр төхөөрөмж бүртгэнэ. Жолооч таних төхөөрөмж бүртгэсэн үед таны тохиргоо автоматаар дуудагдана.**
 - Ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг төхөөрөмжийг та хэрэглэгчийн профайлдаа бүртгэх боломжтой.
 - Олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

Хэрэглэгчийн профайл бүртгэгдээгүй үед жолоочийн тохиргооны дэлгэцнээс бүртгэх боломжтой.

Шинэ хэрэглэгчийн профайл анх удаа бүртгэх (В төрөл)

lfu1649033902253.dita

- 1 **Автомашин асаасны дараа хэл сонгох дэлгэц гарна. Хэл сонгоно.**
Жолооч бүртгэх үеийн дэлгэцийн хэл сонгоно. Жолоочийн бүртгэл дууссаны дараа системийн хэл үндсэн хэлэнд буцна.
Тус дэлгэц зарим улс, бүс нутагт гарахгүй байж болно.
- 2 **Хэрэглэгчийн профайл бүртгэх үед [Create]-г дарна.**
Хэрэглэгчийн профайл бүртгэхгүй үед [Don't create now]-г дарна.
Хэрэв [Do not show set-up again]-г дарсан үед хэрэглэгчийн профайлын дэлгэц дахин гарахгүй.
- 3 **Хэрэглэгчийн профайлын нэр оруулна.**

4 PIN код оруулна.

- Хэрэглэгчийн профайлын хувийн мэдээллийг хамгаалах үүднээс PIN код хийнэ.
- PIN кодгүйгээр бүртгэх үед [Skip]-г дарна.

**5 PIN код дахин оруулж бүртгэлийг баталгаажуулна.**

Бүртгэл дууссан үед дэлгэц дээр мэдээлэл гарна.

6 Хэрэглэгчийн профайл бүртгээд жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.

Төхөөрөмжийг дараа бүртгэх боломжтой.

7 Жолоочийн тохиргооны дэлгэц дээр төхөөрөмж бүртгэнэ. Жолооч таних төхөөрөмж бүртгэснээр жолоочийн тохиргоо автоматаар дуудагдана.

- Ухаалаг утас, ухаалаг түлхүүр зэрэг төхөөрөмжийг та хэрэглэгчийн профайлдаа бүртгэх боломжтой.
- Та өөрийн хэрэглэгчийн профайл дээр олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

Холбоотой холбоосууд

[Жолооч таних тохиргоо хийх\(Х. 63\)](#)

Хэрэглэгчийн профайл автоматаар дуудах

00a1649033902284.dita

Ухаалаг утас, ухаалаг түлхүүр эсвэл бусад жолооч таних төхөөрөмжтэй үед тухайн хэрэглэгчийн профайл автоматаар дуудагдана.

- Асаах товчийг <power товч> ACC эсвэл ON горимд шилжүүлэх үед автомашин тухайн бүртгэгдсэн төхөөрөмжийг танина. Бүртгэгдсэн төхөөрөмжийг таньсан үед холбогдох хэрэглэгчийн профайл дуудагдана.
- Хэрэглэгчийн профайлд бүртгэгдсэн төхөөрөмж илрээгүй үед автомашин зочин жолоочийн горимд шилжинэ.
- [Settings]-г дарж жолоочийн тохиргооны дэлгэц гаргана.
- Та ухаалаг утас, ухаалаг түлхүүр болон бусад төхөөрөмжийг жолооч таних төхөөрөмжөөр бүртгэх боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Тухайн хэрэглэгчийн профайл дээр олон төхөөрөмж бүртгэгдсэн үед эхэлж таньсан төхөөрөмжийн дагуу тохиргоо дуудагдана. Үүний дараа илүү найдвартай төхөөрөмж танигдсан үед тохиргоо өөрчлөгдөнө.
- Хэрэглэгчийн профайлд бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжүүд байгаа үед хамгийн сүүлд холбогдсон хэрэглэгчийн Bluetooth® төхөөрөмжийг танина. Bluetooth® төхөөрөмжийн ашиглалтын байдлаас хамаарч автомашин асаагүй үед жолооч танихад хугацаа шаардагдах эсвэл танихгүй байж болно. Иймээс Bluetooth® төхөөрөмж дээр нэмж ухаалаг түлхүүр нэмж бүртгэх нь зүйтэй.

— Холбоотой холбоосууд —

[Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх\(Х. 60\)](#)

[Жолооч таних тохиргоо хийх\(Х. 63\)](#)

Хэрэглэгчийн профайл өөрчлөх

xuo1649033902206.dita

Автомашинд бүртгэгдсэн хэрэглэгчийн профайлын жагсаалтаас ашиглах тохиргоогоо сонгох боломжтой.

- 1 Үндсэн цэсний -г дарна.
- 2 "Saved profiles"-с өөрчлөх хэрэглэгчийн профайл сонгоно.



- 3 PIN код эсвэл нууц үг оруулна.

- Жолоочийн тохиргоон дээр [Profile lock by password]-г идэвхжүүлсэн үед нууц үг оруулах шаардлагатай.
- "Lexus Connected App" аккаунт үүсгэх үед үүсгэсэн нууц үгээ ухаалаг утасны "Lexus Connected App" дээр оруулна. (А төрөл)
- Lexus хэрэглэгчийн аккаунт үүсгэх үед үүсгэсэн PIN кодоо оруулна. (В төрөл)
- Хэрэглэгчийн профайл өөрчлөгдсөн үед дэлгэц дээр мэдээлэл гарна.

 МЭДЭЭЛЭЛ

Өөр хэрэглэгчийн профайлд бүртгэгдсэн төхөөрөмжийг систем таньсан үед дэлгэц дээр мэдээлэл гарна. []-г дарж хэрэглэгчийн профайл өөрчилнө.

Олон төрлийн тохиргоог өөрчлөх

Мултимедиа системтэй холбоотой олон төрлийн тохиргоог өөрчлөх боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Хүссэн зүйлээ сонгоно.



Тохиргоо	Тайлбар
"Current driver"	
[](Хэрэглэгчийн профайл эсвэл автомашины нэр) [ Guest]	Одоогийн жолоочийн тохиргооний нэрийг харуулна. Тохиргоон дээр дарж тохиргоог өөрчлөх, бүртгэх боломжтой. (→X. 60)
"My settings"	
[Personal info]	Жолоочийг таних төхөөрөмж бүртгэнэ. (→X. 63)
[Bluetooth & Devices]	Bluetooth® төхөөрөмж бүртгэх, бүртгэл өөрчлөнө. (→X. 103)
[General]	Цаг, дэлгэцийн хэл болон мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөнө. (→X. 67)
[Wi-Fi] ([Data & Wi-Fi])	Wi-Fi® тохиргоо болон бусад тохиргоог тохируулна. (→X. 101)
[Display]	Дэлгэцийн өнгөний ялгарал, гэрлийн түвшин зэргийг тохируулна. (→X. 70)
[Sound & Media]	Системийн дуу хоолойны түвшин болон аудио эх үүсвэрийн тохиргоог өөрчилнө. (→X. 95)

Тохиргоо	Тайлбар
[Navigation]	Газрын зургийн дэлгэц, маршрут заах чиглэлийн тохиргоог өөрчилнө.(→X. 80)
[Voice & Search]	Дуу хоолой таних функцтай холбоотой тохиргоог өөрчилнө. (→X. 72)
"Vehicle"	
[Vehicle customize]* ¹	Хянах самбар, жолооны хүрдний товч зэрэг автомашины төхөөрөмжтэй холбоотой тохиргоог өөрчилнө.
[Driving assist]* ¹	Lexus parking assist-мэдрэгч болон бусад жолоодлогод туслах функцийн тохиргоог өөрчилнө.
[Dealer info]* ²	Дилерийн мэдээлэл бүртгэх болон устгана.(→X. 74)
[Info & Security]	Аюулгүй байдал болон нууцлалтай холбоотой тохиргоог өөрчилнө.(→X. 75)
[Software update]	Программ хангамжийн шинэчлэлтэй холбоотой мэдээллийг шалгаж шинэчилнэ. (→X. 77)

МЭДЭЭЛЭЛ

Аюулгүйн үүднээс зарим функцийг жолоодлогын үед өөрчлөх боломжгүй.

*1 :Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх*1

rvh1649033912775.dita

Хэрэглэгчийн профайл шинээр бүртгэх, мөн өөрчлөх боломжтой. Хэрэглэгчийн профайл бүртгэснээр жолоодлогын байрлал, мултимедиа тохиргоо болон бусад хувийн тохиргоогоо жолооч тус бүрийн хэрэглэгчийн профайлд сануулах боломжтой.

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 Дэд цэсний [👤](Хэрэглэгчийн профайлын нэр эсвэл автомашины нэр) эсвэл [👤][Guest]-г дарна.
- 3 Тохируулах тохиргоогоо сонгоно.



Тохиргоо	Дэлгэрэнгүй мэдээлэл
"Saved profiles"	Автомашинд бүртгэгдсэн хэрэглэгчийн профайл дэлгэц дээр жагсаалтаар гарна. Ашиглах хэрэглэгчийн профайлыг дэлгэц дээр дарж сонгоно. Жолоочийн профайлын дээр [Profile lock by password]*2 гарсан үед нууц үг оруулах шаардлагатай. [Edit] товчийг даран хэрэглэгчийн профайлыг устгах боломжтой.*2
[👤][Connect your account]/ [Create profile]	Шинэ хэрэглэгчийн профайл бүртгэх.
[Sign out to guest mode]	Зочин жолооч руу шилжүүлэх үед сонгоно. Тус тохиргоог ашиглах үед жолоочийн тохиргооны дэлгэц дээр [Profile lock by password]-г идэвхжүүлэх нь зүйтэй.*2 (→X. 63) Зочин жолоочийн профайл ашигласнаар бусад хэрэглэгчийн профайлд сануулалгүйгээр хувийн

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*2 :Тоноглогдсон автомашинд

Тохиргоо	Дэлгэрэнгүй мэдээлэл
[Sign out to guest mode]	тохиргоогоо өөрчлөх боломж бүрдүүлдэг. Бусад хүнд автомашинаа өгөх үед [Sign out to guest mode]-г дарж холбогдсон төхөөрөмжийн хувийн мэдээллийг нууна. Ингэснээр хайлтын түүх, хувийн тохиргоо зэрэг хувийн мэдээллээ хамгаалах боломж бүрдүүлнэ. Хайлтын түүх, хувийн тохиргооноос бусад профайлыг зочин жолооч ашиглах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Аюулгүйн үүднээс эдгээр функцуудыг автомашин явж байх үед ашиглах боломжгүй.

Шинэ хэрэглэгчийн профайл үүсгэх (А төрөл)

wbv1649033912822.dita

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 Дэд цэсний [👤] (профайлын нэр) эсвэл [👤][Guest]-г дарна.
- 3 Ухаалаг утас ашиглан хэрэглэгчийн профайл "Lexus Connected App"-р бүртгэх үед [Connect your account]-г дарна.
 - Та өөрийн бүртгэл болон нууц үг ашиглан жолоочийн бүртгэл хийх үед [Enter account & password]-г дарна.
- 4 [Next]-г дарна.
 - Хэрэв таньд ухаалаг утасны "Lexus Connected App" аппликейшн байхгүй үед дэлгэц дэх QR код ашиглан татан авах боломжтой.
- 5 Ухаалаг утасны "Lexus Connected App" аппликейшн нээн дэлгэцний зааварчилгааг дагах ба QR код уншуулах эсвэл [Link acc. via verification code]-г даран баталгаажуулах код оруулан жолооч бүртгэнэ.

Бүртгэл дууссан үед мэдээлэл дэлгэц дээр гарах ба таны тохиргоо хадгалагдана.
- 6 Хэрэглэгчийн профайл бүртгэсний дараа жолоочийг таниулах үүднээс төхөөрөмжийн бүртгэл хийнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.

Төхөөрөмжийн бүртгэлийг дараа хийх боломжтой.
- 7 Жолоочийн тохиргооны дэлгэц дээр төхөөрөмжийн бүртгэлийг хийнэ. Төхөөрөмж бүртгэн жолооч таниулснаар хэрэглэгчийн профайлыг автоматаар дуудна.
 - Та өөрийн тохиргоондоо ухаалаг утас эсвэл ухаалаг түлхүүр зэрэг аль ч төхөөрөмжийг бүртгүүлэх боломжтой.

- Та өөрийн хэрэглэгчийн профайлдаа олон төхөөрөмжийг бүртгүүлэх боломжтой.

— Холбоотой холбоосууд —

Жолооч таних тохиргоо хийх(X. 63)

Шинэ хэрэглэгчийн профайл анх удаа бүртгэх (В төрөл)

chb1649033912838.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [] (Хэрэглэгчийн профайл эсвэл автомашины нэр) эсвэл [][Guest]-г дарна.
- 3 [][Create Profile]-г дарна.
- 4 Хэрэглэгчийн профайлын нэр оруулна.
- 5 PIN код оруулна.
 - Хэрэглэгчийн профайлын хувийн мэдээллийг хамгаалах үүднээс PIN код хийнэ.
 - PIN кодгүйгээр бүртгэх үед [Skip]-г дарна.
- 6 PIN код дахин оруулж бүртгэлийг баталгаажуулна.

Бүртгэл дууссан үед дэлгэц дээр мэдээлэл гарна.
- 7 Хэрэглэгчийн профайл бүртгээд жолооч таних төхөөрөмж бүртгэнэ. Тохиргоог үргэлжлүүлэх үед [Continue]-г дарна.

Төхөөрөмжийг дараа бүртгэх боломжтой.
- 8 Жолоочийн тохиргооны дэлгэц дээр төхөөрөмж бүртгэнэ. Жолооч таних төхөөрөмж бүртгэснээр жолоочийн тохиргоо автоматаар дуудагдана.
 - Ухаалаг түлхүүр, ухаалаг утас зэрэг дурын төхөөрөмжийг өөрийн профайлдаа бүртгэх боломжтой.
 - Та өөрийн хэрэглэгчийн профайл дээр олон төхөөрөмж бүртгэх боломжтой.

— Холбоотой холбоосууд —


Жолооч таних тохиргоо хийх(X. 63)

Жолооч таних тохиргоо хийх

itm1649033912853.dita

Жолооч таниулах үед төхөөрөмжийн тохиргоог хийнэ. Асаах товч <power товч> ACC эсвэл ON горимд ассан ба бүртгэгдсэн төхөөрөмж танигдсан үед тухайн төхөөрөмжинд бүртгэгдсэн хэрэглэгчийн профайл автоматаар дуудагдана. Та ухаалаг утас эсвэл смарт түлхүүр, бусад төхөөрөмжийг бүртгүүлэх төхөөрөмжөөр ашиглах боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Personal info]-г дарна.
- 3 Өөрчлөх тохиргоог сонгоно.



► А төрөл

Тохиргоо	Тайлбар
"Profile Name"	Хэрэглэгчийн профайлын нэр гарна. [Edit] дээр дарж нэр өөрчлөнө.*1
"Devices linked to your profile"	
"Face identification"*1*2	Жолоочийн нүүрээр жолооч таньж холбогдох профайлыг уншина. Бүртгэх үед [Set-up face]-г дарна.(→X. 65) Бүртгэгдсэн нүүрний мэдээлэл устгах үед [Remove face data]-г дарна.

Тохиргоо	Тайлбар
[Link key]*2*3	Автомашинд бүртгэх гэж буй бүх түлхүүрийг байрлуулаад бүртгэх үйлдлийг эхлэнэ. Бусад жолооч дээр бүртгэгдсэн түлхүүрийг ашиглах боломжгүй. Smart entry & start системийг цуцласан үед хаалганы түгжээ тайлахад ашиглах түлхүүрийг тухайн жолооч дээр бүртгэх шаардлагатай.
"Bluetooth devices"	Смарт утас эсвэл бусад Bluetooth® төхөөрөмж болон холбогдох хэрэглэгчийн профайлаар жолоочийг танина. [Link devices]-г дарж бүртгэнэ..(→X. 121)
[Profile lock by password]	Хэрэглэгчийн профайлыг гар аргаар өөрчлөх нууц үг оруулна.
[Reset settings]	Сонгосон хэрэглэгчийн профайлын тохиргоо тэглэгдэнэ.
[Delete driver]	Сонгосон хэрэглэгчийн профайл автомашинаас устгагдана. Эзэмшигчээр бүртгэгдсэн хэрэглэгчийн профайлыг устгах үед бүх хэрэглэгчийн профайл устгагдана.

► В төрөл

Тохиргоо	Тайлбар
"Profile Name"	Хэрэглэгчийн профайлын нэр гарна. [Edit] дээр дарж нэр өөрчлөнө.*1
"Devices linked to your profile"	
"PIN"	Пин код болон холбогдох хэрэглэгчийн профайлаар жолоочийг танина. [Set new PIN] дээр дарж бүртгэнэ.


Тохиргоо	Тайлбар
[Link key]*2*3	Автомашинд бүртгэх гэж буй бүх түлхүүрийг байрлуулаад бүртгэх үйлдлийг эхлэнэ. Бусад жолооч дээр бүртгэгдсэн түлхүүрийг ашиглах боломжгүй. Smart entry & start системийг цуцласан үед хаалганы түгжээ тайлахад ашиглах түлхүүрийг тухайн жолооч дээр бүртгэх шаардлагатай.
"Bluetooth devices"	Смарт утас эсвэл бусад Bluetooth® төхөөрөмж болон холбогдох хэрэглэгчийн профайлаар жолоочийг танина. [Link devices] дээр дарж бүртгэнэ.(→X. 121)
[Reset settings]	Сонгосон хэрэглэгчийн профайлын тохиргоо тэглэгдэнэ.
[Delete driver]	Сонгосон хэрэглэгчийн профайл автомашинаас устгагдана.

Нүүр таних бүртгэл хийх

dq11649817637865.dita

Нүүр таних функц нь системд жолооч таних боломж олгодог.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Personal info]-г дарна.
- 3 [Set-up face]-г дарна.
- 4 Үйлчилгээний нөхцөлийг сайтар уншаад [Accept]-г дарна.
- 5 Жолоочийн мониторын камер луу эгц харж дэлгэц дээр таны нүүр гарч байгааг нягтлаад [Begin]-г дарна.



*1 :Тоноглогдсон автомашинд

*2 :Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

*3 :Түрээсийн автомашин зэрэг байгууллагын олон тооны автомашинд ашиглах боломжгүй.

6 Систем таны нүүрийг уншиж эхэлнэ.

- Бүртгэл дууссан үед дэлгэц дээр мессеж гарна.
- Алдааны мессеж гарсан үед дэлгэцийн зааварчилгааг баримтлан дахин үйлдэнэ.

Мултимедиа системийн ерөнхий тохиргоог өөрчлөх

Цаг, дэлгэцийн хэл, мөн бусад мултимедиа системийн тохиргоог өөрчлөх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [Settings]-г дарна.
- 2 Дэд цэсний [General]-г дарна.
- 3 Хүссэн тохиргоогоо сонгоно.



● [Ашиглахад хялбар байдал]

Тохиргоо	Тайлбар
[Reduce animation]	Дэлгэц солих үеийн анимацийг бууруулна.
[Screen beep]	Дэлгэц товших үед гарах дууг асаах буюу унтраана.
[Screen sensitivity]	Товших үеийн дэлгэцийн мэдрэг байдлыг тохируулна.

● [Өдөр, цаг]

Тохиргоо	Тайлбар
[Set automatically]*1	GPS мэдээлэл болон газрын зургийн дата ашиглан цаг автоматаар тохируулна. Тус тохиргоог унтраасан үед цаг, цагийн бүсийг гараар тохируулах боломжтой.
"Time"	
[24-hour time]	Цагийг 12 болон 24 цагаар гаргана.
[Time zone]*2	[Set automatically]-г унтраасан үед цагийн бүсийг гараар тохируулах боломжтой.

Тохиргоо	Тайлбар
[Daylight savings] ^{*2}	[Set automatically]-г унтраасан үед тус тохиргоог [Auto] ^{*1} , [On] эсвэл [Off] горимд тохируулах боломжтой.
[Set time automatically]	[Set automatically]-г унтраасан үед GPS ашиглан цаг автоматаар тохируулах үгүйг сонгох боломжтой. Тус тохиргоог унтраасан үед цаг гараар тохируулах боломжтой.
[Set time manually]	[Set time automatically]-г унтраасан үед цаг гараар тохируулах боломжтой.
"Date"	
[Format]	Огнооны формат өөрчилнө.

● [Дэлгэцийн гар]

Тохиргоо	Тайлбар
"Түүх"	
[Memorize keyboard]	Гараар бичиж оруулсан үгний түүхийг санана.
[Delete keyboard history]	Гарын үг санах түүхийг устгана.
[Delete search history]	Гарын хайлтын түүх устгана.

● [Language & Units]^{*2}

Тохиргоо	Тайлбар
[Language] ^{*2}	Хэл солино. Дэлгэцийн болон дуу хоолойн системийн хэлийг солих боломжтой.
[System language] ^{*2}	Дэлгэцний хэлийг солино.
[Voice language] ^{*2}	Системийн дуу хоолойн хэлийг солино.
"Нэгжүүд"	
[Set automatically]	Зай, шатахууны хэмнэлт, дугуйн даралт болон бусад мэдээллийг тухайн улсын мэдээлэл дээр үндэслэн автоматаар тохируулна.

Тохиргоо	Тайлбар
[Trip info. unit]	[Set automatically]-г унтраасан үед шатахууны хэмнэлтийн дэлгэцийн нэгжийг гараар солих боломжтой.
[Tire pressure]	[Set automatically]-г унтраасан үед дугуйн даралтын дэлгэцийн нэгжийг гараар тохируулах боломжтой.

 **МЭДЭЭЛЭЛ**

- Хэлний тохиргоог өөрчилсөн ч дэлгэцээр гарах бүх контент, дуут зааварчилгаа сонгосон хэлэнд шилжихгүй. Мөн хэл өөрчилсөн үед зарим дуут зааварчилгааны функц ажиллахгүй.
- Apple CarPlay/Android Auto-н хэлний тохиргоог холбосон төхөөрөмж дээр хийнэ.

*1 : Навигацийн функцтай
*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Дэлгэцийн тохиргоо өөрчлөх

pk11649033925036.dita

Дэлгэцийн өнгөний ялгарал, гэрлийн хэмжээг тохируулах боломжтой.

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 Дэд цэсний [Display]-г дарна.
- 3 Хүссэн зүйлээ сонгоно.



● [Screen]

Тохиргоо	Тайлбар
[Display]	Дэлгэц асаах эсвэл унтраах тохиргоо хийнэ. Дэлгэц унтраасан үед дэлгэц дээр дүрс гарахгүй ба зөвхөн аудио тоглуулна. Дэлгэцийг дахин гаргах үед дэлгэц дээр товшоод дэлгэцийн голд байрлах товчийг дарна.
"Mode"	
[Automatic] ^{*1}	Их гэрэл асаах, унтраах үед дэлгэц автоматаар өдрийн болон шөнийн горимд солигдоно.
[Daytime (light)]	[Automatic] тохиргоог унтраасан үед өдрийн горимд гараар шилжүүлэх боломжтой.
[Nighttime (dark)]	[Automatic] тохиргоог унтраасан үед шөнийн горимд гараар шилжүүлэх боломжтой.
[Brightness]	Дэлгэцийн гэрлийн түвшинг тохируулна.
[Contrast]	Дэлгэцийн өнгөний ялгарлыг тохируулна.

● [Camera]

Тохиргоо	Тайлбар
"Camera screen"	
[Brightness]	Дэлгэцийн гэрлийн түвшинг тохируулна.
[Contrast]	Дэлгэцийн өнгөний ялгарлыг тохируулна.

 МЭДЭЭЛЭЛ

- Аудио дүрсний чанарыг хэрхэн тохируулах тухай дэлгэрэнгүйг **"Дүрсний чанарыг тохируулах"**(→Х. 99)-с харна уу.
- Дэлгэцийг унтраасан үед ч GPS автомашины одоогийн байрлалыг үргэлжлүүлэн хянана.
- Дэлгэц
 - Дэлгэц унтраасан үед дэлгэц дээр товшин агааржуулалтын систем удирдах боломжтой.
 - Дэлгэц дээр агааржуулалтын системийн товч эсвэл дэлгэцний төвийн товч гарч ирсэн үед тодорхой хугацаанд товч дараагүй нөхцөлд дэлгэц буцаж унтарна.
 - Дуудлага хийх, яриаг дуусгах товч дарсан зэргээр автоматаар гарч ирдэг дэлгэц гарсан эсвэл ухрах араанд шилжүүлэх үед камерын дэлгэц гарсан үед тус дэлгэцийг хаахад дэлгэц буцаж унтарна.
 - Дэлгэцний төвийн товчоос бусад дэлгэцийн хэсэг дээр дарсан үед дэлгэц буцаж унтарна.
 - Унтраасан дэлгэц дээр товших үед түгжээ тайлах товч гарна. 3 секундын дотор тус товч дараагүй үед дэлгэц дахин унтарна.

*1 : Автомат их гэрэл ашиглах явцад их гэрэл асах болон унтрах үед дэлгэц өдрийн болон шөнийн горимд автоматаар шилжихгүй байж болно.

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх

Дуу хоолой танихтай холбоотой тохиргоог өөрчлөх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [Settings]-г дарна.
- 2 Дэд цэсний [Voice & Search]-г дарна.
- 3 Өөрчлөх тохиргоогоо сонгоно.




Тохиргоо	Тайлбар
"Дуу хоолой таних"	
[Wake word]	Дуу хоолойн удирдлага эхлүүлэх сэрээх үгийг өөрчлөнө. (→X. 72)
[Set custom wake word]	Дуу хоолойн удирдлага эхлүүлэх дурын сэрээх үг тохируулна.
[Mic button]	[Microphone icon]-г гаргах буюу унтраана.
"Дуу хоолойн хариу үйлдэл"	
[Voice prompt]	Дуу хоолойн сануулга асааж унтраана.
"Мэдэгдэл"	
[Voice support]	Ирж буй дуудлага, бусад мэдэгдэлд үгээр хариу үйлдэл үзүүлж болно.

Дуу хоолойн удирдлагын системийг асаах сэрээх үг солих

- 1 Үндсэн цэсний [Settings]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Voice & Search]-г дарна.
- 3 [Wake word]-г дарна.

4 Жагсаалтаас өөрчлөх сэрээх үгийг сонгоно.




МЭДЭЭЛЭЛ

- Сэрээх үгийг өөрийн хүссэн үгээр шинээр тохируулах үед [**Set custom wake word**]-г дараад дэлгэц дээр үсгийг бичиж оруулна.
- Шинээр тохируулах үг хэт богино үед тухайн үгийг хэлэх үед дуу хоолойн удирдлагын систем танихгүй байж болно. 3-с дээш үетэй үг ашиглана.

Дилерийн мэдээлэл тохируулах*1

Дилерийн мэдээлэл шинээр бүртгэх, устгах боломжтой. Засвар үйлчилгээнд ордог дилерийн мэдээлэл бүртгэснээр засвар үйлчилгээ шаардлагатай үед тус дэлгэцээс шууд цаг захиалах боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэсний [Dealer info]-г дарна.
- 3 Шаардлагатай зүйлсийг сонгоно.



Тохиргоо	Тайлбар
[Add dealer]	Дилерийн мэдээлэл бүртгэнэ.
[Dealer name]	Дилерийн нэр өөрчлөнө.
[Contact name]	Дилерийн хариуцсан ажилтаны нэр бүртгэх эсвэл өөрчилнө.
[Phone number]	Дилерийн утасны дугаар бүртгэх эсвэл өөрчилнө.
[Delete dealer]	Дилерийн мэдээлэл устгана.


*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх

gde1649033935911.dita

Аюулгүй байдал, нууцлалтай холбоотой тохиргоог өөрчлөх боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Info & Security]-г дарна.
- 3 Хүссэн зүйлээ сонгоно.



Тохиргоо	Тайлбар
[Vehicle name]	Системийн нэр (автомашины нэр)-г харуулна. Тус нэр нь бусад Bluetooth® төхөөрөмжөөр хайх үед дэлгэцээр гарна. Нэр дээр товшин өөрчлөх боломжтой.
"Нууцлал"	
[Privacy lock]	Холбоо харилцааны үйлчилгээ ашиглах үед байршлын мэдээллээ илгээх үед тохируулна. Тус тохиргоог унтрааснаар байршлын мэдээлэл ашигладаг зарим үйлчилгээг идэвхгүй болгоно.
[Reset privacy lock password]	Аюулгүй байдлын түгжээний нууц үгийг арилгана.
[Remote Security]*1	Алсын зайны аюулгүй байдлын ажиллагааны байдлыг харуулна.
[System reset]	Системийн бүх өгөгдлийг устгаж үйлдвэрийн үндсэн тохиргоонд буцаана.

МЭДЭЭЛЭЛ

- Системийг тэглэсний дараа мэдээлэл дамжуулалт таслагдаж болно. Энэ нөхцөлд системийг дахин асаана.
- Бүх мэдээллийг тэглэсний дараа мултимедиа системийн бүх өгөгдөл тэглэгдэж үйлдвэрийн үндсэн тохиргоонд буцна. Тохиргоог тэглэхээс өмнөх тохиргоонд буцаах боломжгүй.

— Холбоотой холбоосууд —

Систем дахин асаах(Х. 15)

Аюулгүй байдлын нууц үг тохируулах

etx1649033935989.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Info & Security]-г дарна.
- 3 [Privacy lock]-г дарна.
- 4 [OK]-г дарна.
- 5 Тоо болон үсгээс бүрдсэн 4-15 тэмдэгттэй нууц үг тохируулна.
- 6 Нууц үгийг дахин оруулна.

Мэдээлэл гарч нууц үг идэвхжинэ.

МЭДЭЭЛЭЛ

- Нууц үг тохируулсны дараа 12в аккумулятор сольсон, мултимедиа системийг автомашинаас салгасан нөхцөлд мултимедиа системийг дахин ажиллуулах үед нууц үг оруулна. Тохируулсан нууц үгээ оруулна.
- Нууц үгийг олон удаа буруу оруулсан үед систем түгжигдэнэ. Энэ нөхцөлд та өөрийн дилерт хандаж нууц үгийн түгжээ тайлуулах эсвэл [System reset]-г дарж системийг дахин ачааллана.
- Нууц үгийг олон удаа буруу оруулсан үед систем түгжигдэнэ. Энэ нөхцөлд та өөрийн дилерт хандаж нууц үгийн түгжээ тайлуулна уу.

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Программ хангамжийн мэдээлэл шинэчлэх, шалгах

ljz1649033935926.dita

2

Тохиргоо ба бүртгэл

Программ хангамжийн мэдээлэл шинэчлэж шалгана. Мультимедиа системийн функцийг сайжруулах, илүү хялбар ашиглах боломж бүрдүүлэх үүднээс программ хангамж шинэчлэгддэг.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Software update]-г дарна.
- 3 Хүссэн зүйлээ сонгоно.



Тохиргоо	Тайлбар
"Software update"	
[Updates available]*1	[View]-г дарж шинэчлэлийн мэдээлэл шалгана. Программ хангамжийн шинэчлэл байгаа үед татан авч шинэчлэх боломжтой. Шинэчлэл байхгүй үед дэлгэц дээр [No updates available] гарна.
[Model info]	Программ хангамжийн одоогийн хувилбар зэргийг шалгана.
[Update software]*1	Программ хангамж шинэчлэнэ. Шинэчлэл байхгүй үед тус мэдээлэл гарахгүй.
[Output info to USB memory]*1	Тус автомашинд энэ функцийг ашиглах боломжгүй.
[History]*1	Программ хангамжийн шинэчлэлтийн түүхийг шалгана. Шинэчлэлийн түүх байхгүй үед тус мэдээлэл гарахгүй.
[License information]	Программ хангамжийн лицензийн мэдээлэл харуулна.
[Update notification]*1	Программ хангамжийн шинэчлэлийн мэдэгдлийг асаах буюу унтраана.

Программ хангамжийг шинэчлэх

dix1649033935942.dita

Дараах аль нэг аргаар шинэчилнэ:

- **Өгөгдлийн холболтын модуль (DCM) ашиглан шинэчилнэ**
- **Wi-Fi® холболтоор шинэчилнэ**

МЭДЭЭЛЭЛ

- Тус үйлчилгээгээр газрын зургийн мэдээллийг шинэчлэх боломжгүй.
- Программ шинэчлэгдэх үед зарим функцийг ашиглах боломжгүй.
- Нэмэлт мэдээлэл шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

АНХААР

- Программ шинэчлэх үеийн гарч болох эрсдэлийг тооцно.
- Шинэчлэгдсэн үед программ хангамжийг өмнөх хувилбарт буцаах боломжгүй.
- Шинэчлэгдсэн программ хангамжийг зөвхөн тус системд ашиглах боломжтой ба бусад төхөөрөмжид ашиглах боломжгүй.
- Шинэчлэгдсэн агуулгаас шалтгаалж зарим тохиргоо тэглэгдэж болно. Энэ нөхцөлд тохиргоог дахин хийнэ.
- Программ шинэчлэгдэх үед үндсэн функцууд ажиллах ч удааширч болно. Боломжтой нөхцөлд системийг ашиглахгүй байх нь зүйтэй.
- Программ шинэчлэгдсэний дараа Тоёота Мотор Корпорацийн серверт үйлдэл дууссан мэдэгдэл ирнэ. Тоёота Мотор Корпорац нь тус мэдэгдлийг зөвхөн системийн шинэчлэлтэд ашиглана. Мэдэгдэл дамжуулах үед таны үйлчилгээний гэрээний нөхцөлөөс хамаарч төлбөр гарч болзошгүйг анхаарна уу.

Программ шинэчлэх. DCM эсвэл Wi-Fi®*2

vtp1649033935957.dita

Тус систем нь тогтмол серверт холбогдож программын шинэчлэлийг шалгадаг.

1. Программ шинэчлэлийн мэдэгдлийн [] дээр дарна.
2. Дэлгэцийн зааварчилгааны дагуу шинэчлэлийн агуулга, үйлчилгээний нөхцөлийг шалгаж баталгаажуулна.
 - Дата татаж эхлэнэ. Дата татагдсан үед шинэчлэлт эхлэнэ. (10-15 минут зарцуулагдана)
 - Сүлжээний холболтоос хамаарч дата татах, шинэчлэлтийг суулгахад хугацаа шаардагдаж болно. Шинэчлэлтийг суулгах

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

үед асаах товч <power товч> унтраасан нөхцөлд дараагийн удаа автомашин асаах үед программ суулгах үйлдэл дахин эхлэнэ.

- Шинэчлэлт дууссан үед дэлгэц дээр мэдээлэл гарна.
- Системийг дахин асаах шаардлагатай үед мэдээлэл гарна. [Yes]-г дарж систем дахин асаана.
- Программ шинэчлэлтийн түүхийг шалгах үед [History]-г дарна.

■ Программыг гар аргаар шинэчлэх

1. Үндсэн цэсний [Settings]-г дарна.
2. Дэд цэсний [Software update]-г дарна.
3. [View]-г "Updates available"-с дарна.
4. Дэлгэцийн зааварчилгааны дагуу шинэчлэлийн агуулга, үйлчилгээний нөхцөлийг шалгаж баталгаажуулна.
 - Дата татаж эхлэнэ. Дата татагдсан үед шинэчлэлт эхлэнэ. (10-15 минут зарцуулагдана)
 - Сүлжээний холболтоос хамаарч дата татах, шинэчлэлтийг суулгахад хугацаа шаардагдаж болно. Шинэчлэлтийг суулгах үед асаах товч <power товч> унтраасан нөхцөлд дараагийн удаа автомашин асаах үед программ суулгах үйлдэл дахин эхлэнэ.
 - Шинэчлэлт дууссан үед дэлгэц дээр мэдээлэл гарна.
 - Системийг дахин асаах шаардлагатай үед мэдээлэл гарна. [Yes]-г дарж систем дахин асаана.
 - Программ шинэчлэлтийн түүхийг шалгах үед [History]-г дарна.

□ МЭДЭЭЛЭЛ

- Нэн чухал шинэчлэлт серверт байгаа үед дэлгэц дээр мэдээлэл гарна. [OK]-г дарж датаг татна.
- Программ шинэчлэх үед дараах шаардлага хангасан Wi-Fi®-тай байх шаардлагатай:
 - Систем Wi-Fi®-д холбогдсон байна (гэр, ажил зэрэг)
 - Автомашин Wi-Fi®-д холбогдох боломжтой газарт байна
 - Холболтын тохиргоог [Wi-Fi] болгосон байна

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Навигацийн системийн тохиргоо

Навигацийн системийн тохиргоогоор газрын зургийн өнгө, үсгийн хэмжээ зэрэг олон төрлийн тохиргоо хийх боломжтой.

- 1 **Үндсэн цэсний []-г дарна.**
- 2 **[Navigation]-г дарна.**
- 3 **Тохируулах зүйлээ дарна.**
 - Газрын зургийн дэлгэцийн тохиргоо
 - Маршрутын тохиргоо
 - Зааварчилгааны тохиргоо
 - Газрын зураг шинэчлэх тохиргоо
 - Бусад тохиргоо

Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 81)

Маршрутын тохиргоо(Х. 84)

Зааварчилгааны тохиргоо(Х. 87)

Газрын зургийн мэдээллийн сан ба хамрах хүрээ(Х. 175)

Бусад тохиргоо(Х. 89)

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх ycf1649898458890.dita

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Map display]-г дарна.
- 4 Хүссэн зүйлээ сонгоно.



Тохиргоо	Агуулга
[Country border guidance] ^{*1*2}	Улсын хилийн зааварчилгааны тохиргоог асаана/унтраана. Тохиргоог асаасан нөхцөлд улсын хил нэвтрэх үед зааварчилгаа гарна.
[Map style customization]	Газрын зургийн дэлгэцний өөрчлөх боломжтой тохиргоог гаргана.
"Traffic information"	
[Show road class]	Замын хөдөлгөөний мэдээлэл гаргах замын хамрах хүрээг тохируулна. Замын төрөл сонгоод [OK]-г дарна.
"Real-time information"	
[Show traffic jam flows]	Одоогийн мэдээлэл дээр үндэслэн замын түгжрэлийн мэдээлэл гаргана/унтраана.
[Show free traffic flows]	Одоогийн мэдээлэл дээр үндэслэн чөлөөтэй эгнээний мэдээлэл гаргана/унтраана.
[Traffic incident warning]	Авто ослын мэдээлэл гаргана/унтраана.

2
Тохиргоо ба бүртгэл

Тохиргоо	Агуулга
[Show POI icons settings]	POI тэмдгийн тохиргоог өөрчилнө.
[3D view settings]	Дэлгэцийн өнцгийг 3D газрын зурагт шилжүүлэх үед дарна.
[On street parking suggestion]*2	Гудамжны авто зогсоол санал болгох функцийг асаана/унтраана.
[Map language]*2	Газрын зургийн хэл өөрчлөх үед дарна. [Region] эсвэл [System Language]-г дараад [OK]-г дарна.

Холбоотой холбоосууд

Дэлгэцийн өнцөг тохируулах(Х. 82)

Газрын зургийн дэлгэцийн өөрчлөх боломжтой тохиргоо(Х. 82)

Газрын зургийн дэлгэцийн өөрчлөх боломжтой тохиргоо


xcc1649898458859.dita

Газрын зургийн өнгө болон үсгийн хэмжээг өөрчлөх боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Map style customization]-г дарна.
- 4 Хүссэн зүйлээ сонгоно.

- A Газрын зургийн дэлгэцийн үсгийн хэмжээ өөрчлөх үед дарна.
- B Газрын зургийн өнгө өөрчлөх үед дарна.

- 5 [OK]-г дарна.



Дэлгэцийн өнцөг тохируулах

ybh1649898458656.dita

3D газрын зургийн дэлгэцийн өнцгийг тохируулах боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.

*1 : Навигацийн системтэй

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт some countries or areas.

- 2 [Navigation]-г дарна.
- 3 [3D view setting]-г дарна.
- 4 [] (өнцөг нэмэх) эсвэл [] (өнцөг хасах)-г дарна.
- 5 [OK]-г дарна.

Маршрутын тохиргоо

afi1649898458687.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Route]-г дарна.
- 4 Сонгох зүйлээ дарна.



Тохиргоо	Агуулга
[Area to avoid]	Зайлсхийх газрыг бүртгэх, засварлах үед товшино.
[Avoid traffic] ^{*1}	Түгжрэлээс зайлсхийх функцийг тохиргоог өөрчлөх үед дарна. Эхлээд [Auto], [manual] эсвэл [off]-г дараад [OK]-г дарна.
[Gas stations suggestion]	ШТС-н жагсаалт автоматаар гаргах функцийг асаах буюу унтраана.
[Route learning]	Маршрут сурах функцийг асаах буюу унтраана.
[Reset route learning]	Маршрут сурах функцийг санах ойг тэглэнэ.

— Холбоотой холбоосууд —

- [Зайлсхийх зам, газрыг тохируулах\(Х. 84\)](#)
- [Хайлтын үр дүнгийн дэлгэц\(Х. 160\)](#)
- [Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц\(Х. 164\)](#)

Зайлсхийх зам, газрыг тохируулах


ixa1649898458828.dita

Зам засвар, хөдөлгөөн хаасан, тогтмол түгжирдэг зэрэг замуудыг зайлсхийх зам, газраар тохируулсан нөхцөлд тухайн хэсгийг оруулахгүй байдлаар маршрутын хайлт хийгдэнэ.

^{*1} :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Route]-г дарна.
- 4 [Area to avoid]-г дарна.
- 5 Хүссэн зүйлээ сонгоно.

- ☐ A Зайлсхийх зам, газрын жагсаалтыг гаргана. Жагсаалт дээр дарж өөрчлөлт хийнэ.
- ☐ B Зайлсхийх зам, газрыг устгах үед дарна.
- ☐ C Зайлсхийх зам, газрыг бүртгэх үед дарна.



Зайлсхийх зам, газрыг бүртгэх

mhi1649898458812.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Route]-г дарна.
- 4 [Area to avoid]-г дарна.
- 5 [Add]-г дарна.
- 6 Газрын зургийг хөдөлгөн зайлсхийх газрыг сонгоно.
- 7 [Complete]-г дарна.

Зайлсхийх газар дэлгэц дээр шар дөрвөлжнөөр тэмдэглэгдэнэ.

- 8 [] (нэмэх) эсвэл [] (хасах)-г дарж зайлсхийх газрыг тохируулаад [Complete]-г дарна.
- 9 Дэлгэц дээр өөрчлөх тохиргоог дуусгаад [OK]-г дарна.

МЭДЭЭЛЭЛ

- Зайлсхийх зам, газраар нэвтрэхгүйгээр явах боломжтой маршрут байхгүй үед хайлтын үр дүнд зайлсхийх зам, газар орж болно.
- Зайлсхийх зам, газрыг багасган [] (зайлсхийх зам санах ой)-н дэлгэцийг өөрчлөх боломжтой. Хурдны зам, далай тэнгисээр явах маршрутыг хайлтын үр дүнгээс хасах боломжгүй байж болно. Зам тус бүр дээр зайлсхийх зам санах ойг тохируулна.

Зайлсхийх газрыг засварлах


lro1649898458781.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.

- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Route]-г дарна.
- 4 [Area to avoid]-г дарна.
- 5 Засварлах зайлсхийх газрыг сонгоно.

- 6 Өөрчлөхийг хүссэн тохиргоог дарна.

- ☐ A Зайлсхийх газрыг нэрийг өөрчлөх үед дарна.
- ☐ B Зайлсхийх газрыг өөрчлөх, хамрах хүрээг өөрчлөх үед дарна.



- 7 [OK]-г дарна.

Зайлсхийх газрыг устгах

rou1649898458640.dita

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Route]-г дарна.
- 4 [Area to avoid]-г дарна.
- 5 [Edit]-г дарна.
- 6 Устгах гэж буй зайлсхийх газрын [⊖]-г дарна.
 - [Del. All] : Бүх зайлсхийх газрыг устгана.
 - [Cancel] : Устгах үйлдлийг цуцлана.
- 7 [Complete]-г дарна.

Зааварчилгааны тохиргоо

krd1649898458906.dita

2

Тохиргоо ба бүртгэл

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Guidance]-г дарна.
- 4 Тохиргоо хийх зүйлийг дарна.



Тохиргоо	Тайлбар
[Intersection map]	Уулзварын томруулсан дэлгэц гаргах, унтраах үед дарна.
[Automatic zoom]	Автоматаар томруулах функцийг асаах, унтраах үед дарна.
[Speed limit] ^{*1*2}	Хурдны дээд хязгаарын мэдээг асаах, унтраах үед дарна. Автомашин цагийн бүсчлэлтэй хурдны хязгаартай бүсэд орсон (худалдааны төв, явган хүний бүс, сургуулийн ойр орчим зэрэг) үед хурдны дээд хязгаарын мэдээллийн дэлгэцний хажууд нэмэлт анхааруулга гарна.
[Speed camera] ^{*1*2}	Хурдны камерны байрлалыг тэмдгийг өөрчлөх үед дарна. [On], [On & Audible] эсвэл [Off]-г дараад [OK] дарна.
[Guidance with street names]	Гудамжны нэрийн зааварчилгааг асаах, унтраах үед дарна.
[Weather warning] ^{*2*3}	Цаг агаарын анхааруулга асаах, унтраах үед дарна.
[ERP warning] ^{*2}	Маршрутанд ERP нэвтрэх цэг орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр ERP нэвтрэх цэгийн анхааруулга гарна.

Тохиргоо	Тайлбар
[Traffic jam warning]([Guide traffic jam warnings])	Замын түгжрэлийн дуут анхааруулга асаах, унтраах үед дарна.
[Landmark voice guidance]([Guide landmarks])* ¹	Түүхэн дурсгалт газрын дуут зааварчилгааг асаах, унтраах үед дарна.
[Guide language]	Дуут зааварчилгааны хэл өөрчлөх үед дарна. ● Хэл сонгоод [OK]-г дарна. ● Ерөнхий дуут зааварчилгааны хэлийг өөрчлөх боломжтой боловч байршлын оноосон нэрийн хэлийг өөрчлөх боломжгүй.
[SALIK warning]* ²	Маршрутанд SALIK нэвтрэх цэг орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр SALIK нэвтрэх цэг байгааг анхааруулах анхааруулга гарна.
[Rodizio warning]* ²	Маршрутанд Rodizio сегмент орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр Rodizio сегмент байгааг анхааруулах анхааруулга гарна.
[E-toll warning]* ²	Маршрутанд e-toll нэвтрэх цэг орсон үед бүтэн маршрутын газрын зураг дээр e-toll нэвтрэх цэг байгааг анхааруулах анхааруулга гарна.

МЭДЭЭЛЭЛ

Контентын менежментийн байдлаас шалтгаалж SALIK, e-toll, ERP нэвтрэх цэгийг танихгүй байж болно.

Холбоотой холбоосууд

[Замын эгнээний дэлгэц\(Х. 171\)](#)

[Хурдны камер\(Х. 152\)](#)

*1 :Зөвхөн 14 инчийн дэлгэцтэй

*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*3 :Connected навигацид холбогдсон үед тус функц гарна.

Бусад тохиргоо

fyu1649898458921.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Other]-г дарна.
- 4 Хүссэн зүйлээ сонгоно.



Тохиргоо	Агуулга
[Delete recent destinations]	Очих газрын түүх устгана. Устгах гэж буй очих газрыг сонгоод [OK]-г дарна. Бүх түүх устгах үед [Delete all]-г дараад [OK]-г дарна.
[Favorites]	Тогтмол ашигладаг тохиргоог өөрчилнө.
[Position/Direction]	Автомашины байрлал засах үед дарна.
[Service information]	
[Expiration date:]*1	Үйлчилгээний үргэлжлэх хугацааг гаргана.
[Service ID:]*1	Үйлчилгээний ID-г гаргана.
[Terms and conditions]*1	Үйлчилгээний нөхцөлийг харуулна.
[Consent status]*1	Зөвшөөрлийн статусыг харуулна.
[Consent day]*1	Зөвшөөрлийн өдрийг харуулна.
[Privacy/Policy]*1	Хувийн нууцлал/нөхцөлийг харуулна.
[Copyright]	Зохиогчийн эрхийг гаргана.

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Холбоотой холбоосууд

Тогтмол ашигладаг тохиргоо(Х. 90)

Байрлал/Чиглэлийн тохиргоо хийх(Х. 94)

Тогтмол ашигладаг тохиргоо

rnх1649898458843.dita

1 Үндсэн цэсний []-г дарна.

2 [Navigation]-г дарна.


3 [Other]-г дарна.

4 [Favorites]-г дарна.

5 Тохиргоо хийх зүйлээ дарна.

A Тохиргооны жагсаалтыг өөрчлөх үед дарна.

B Тохиргоог USB төхөөрөмжид хуулах, төхөөрөмжөөс системд оруулах үед дарна. *2



Тогтмол ашигладаг газар бүртгэх

dgg1649898458718.dita

Тухайн цэгийг тогтмол ашигладаг газраар бүртгэх үед газрын зургийн дэлгэц дээр тухайн цэгийн мэдээллийн дэлгэц гарган []-р бүртгэнэ.

► Газрын зургийг гүйлгэсэн үед



*2 :: Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

► Тухайн цэгийн мэдээллийн дэлгэц

□ **МЭДЭЭЛЭЛ**

400 хүртэлх тогтмол ашигладаг газрыг бүртгэх боломжтой.

— Холбоотой холбоосууд —

[Тухайн газрын мэдээлэл харуулах\(Х. 148\)](#)


[Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц\(Х. 164\)](#)

Тогтмол ашигладаг тохиргооны жагсаалт засах

ugv1649898458734.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Other]-г дарна.
- 4 [Favorites]-г дарна.
- 5 Өөрчлөх тохиргоог дарна.
- 6 Хүссэн зүйлээ сонгоно.

- ☐ A Тохиргооны нэр өөрчлөнө.
- ☐ B Утасны дугаар засна.
- ☐ C Одоогийн байршлыг гэр гэж бүртгэнэ.
- ☐ D Одоогийн байршлыг тогтмол очдог газраар бүртгэнэ.
- ☐ E Газрын зурагны тэмдгийг өөрчилнө.



- 7 [OK]-г дарна.

□ **МЭДЭЭЛЭЛ**

Тогтмол очдог газраар бүртгэсэн нөхцөлд очих газрын хайлт хийх үед тус байршил жагсаалтын дээд талд гарна.

Тогтмол ашигладаг тохиргоог устгах

qfp1649898458671.dita

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 [Navigation]-г дарна.
- 3 [Other]-г дарна.
- 4 [Favorites]-г дарна.
- 5 [Edit]-г дарна.
- 6 Устгах тогтмол ашигладаг тохиргооны []-г дарна.
 - [Del. All]: Бүх тогтмол ашигладаг тохиргоог устгана.
 - [Cancel]: Устгах үйлдлийг цуцлана.
- 7 [Complete]-г дарна.

USB төхөөрөмж рүү гаргах

ifs1649898458875.dita

Навигацийн системд тогтмол ашигладаг тохиргоогоор бүртгэгдсэн мэдээллийг USB төхөөрөмжинд сануулах боломжтой. Дата өгөгдлийг хуулбарлан нөөцлөх үед нууц үг шаардагдана. Дата нь зөвхөн нөөцлөх буюу back up зорилгоор ашиглагдах ба бусад төхөөрөмжинд хуулбарлах, түгээхийг хориглоно.

- 1 **Системд USB төхөөрөмж холбоно.**
Асаагүй үед USB төхөөрөмжийг асаана.
- 2 Үндсэн цэсний []-г дарна.
- 3 [Navigation]-г дарна.
- 4 [Other]-г дарна.
- 5 [Favorites]-г дарна.
- 6 [Import/Export]-г дарна.
- 7 [Export to USB]-г дарна.
- 8 Нууц үг оруулаад [Confirm PIN]-г дарна.
 - Хялбар таах боломжтой (төрсөн өдөр зэрэг), эсвэл өөр газар ашигладаг нууц үг ашиглахаас зайлсхийнэ.
 - Бодит үг ашиглахаас зайлсхийнэ.
- 9 Датаг экспортлох үед явцын дэлгэц гарч байгааг нягтлана.
Тус функцийг цуцлах үед [Cancel]-г дарна.
- 10 Үйлдэл дууссан үед баталгаажуулах дэлгэц гарсныг нягтлана.

АНХААР

Датаг экспортлох үед USB төхөөрөмжийг салгах, унтрааж болохгүй. USB төхөөрөмж гэмтэх аюултай.

Холбоотой холбоосууд

Нууц үг тохируулах(Х. 93)

USB төхөөрөмжөөс мэдээлэл оруулах

rdo1649898458703.dita

2

Тохиргоо ба бүртгэл

USB төхөөрөмж ашиглан өмнө нь хадгалсан байрлалуудыг навигацийн системд шилжүүлэх боломжтой. Тус функцийг ашиглахын тулд USB санах ойг навигацийн системд холбох шаардлагатай.

1 USB төхөөрөмжийг системд холбоно.

USB төхөөрөмж асаагүй байгаа нөхцөлд асаана.

2 Үндсэн цэсний []-г дарна.

3 [Navigation]-г дарна.

4 [Other]-г дарна.

5 [Favorites]-г дарна.

6 [Import/Export]-г дарна.

7 [Import from USB]-г дарна.

8 Нууц үгээ оруулаад [Confirm PIN]-г дарна.

- Таахад хялбар (төрсөн өдөр зэрэг), эсвэл өөр газар ашигладаг нууц үг сонгохоос зайлсхийнэ.

- Бодит үг ашиглахаас зайлсхийнэ.

9 Дата өгөгдлийг системд оруулах үед явцын самбар дэлгэц дээр гарч байгааг нягтлана.

Тус функцийг цуцлах үед [Cancel]-г дарна.

10 Үйлдэл дууссан үед баталгаажуулах дэлгэц гарч байгааг нягтлана.

МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн өгөгдлөөс гадна байрлах тогтмол ашиглагддаг тохиргоог оруулах боломжгүй.
- 400 хүртэлх тогтмол ашиглагддаг тохиргоог сануулах боломжтой.
- Навигацийн системд өмнө хадгалсантай адил нэртэй тогтмол ашиглагддаг тохиргоог оруулах боломжгүй.

Нууц үг тохируулах

bva1649898458937.dita

Нууц үг тохируулсан үед навигацийн системээс тогтмол ашигладаг тохиргоог гаргах, USB төхөөрөмж ашиглан системд оруулах бүрт нууц үг шаардана.

1 USB төхөөрөмжийг системд холбоно.

USB төхөөрөмж асаагүй үед асаана.

2 Үндсэн цэсний []-г дарна.

3 [Navigation]-г дарна.

4 [Other]-г дарна.

5 [Favorites]-г дарна.

6 [Import/Export]-г дарна.

7 [Set new PIN]-г дарна.

8 Нууц үг оруулаад[Set PIN]-г дарна.

Өмнө нь бүртгэсэн нууц үг өөрчлөх үед нууц үгээ оруулаад[Confirm PIN]-г дарж шинэ нууц үг оруулна.

9 Баталгаажуулах үүднээс нууц үгээ дахин оруулаад [Confirm PIN]-г дарна.

● Нууц үгээ мартсан үед:

- Хувийн мэдээлэл агуулсан дата өгөгдлийг[System reset]-р устгах боломжтой.
- Та өөрийн Lexus дилерт хандана уу.

— Холбоотой холбоосууд —

[Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх\(X. 75\)](#)

Байрлал/Чиглэлийн тохиргоо хийх

ljs1649898458765.dita

Жолоодлогын үед GPS дохиог ашиглан одоогийн байрлалын тэмдгийн байрлал автоматаар тохируулагдана. Тухайн байрлалд GPS долгион сул үед одоогийн байрлалын тэмдгийг гараар тохируулах боломжтой.

1 Үндсэн цэсний []-г дарна.

2 [Navigation]-г дарна.

3 [Other]-г дарна.


4 [Position / Direction]-г дарна.

5 Газрын зургийг тухайн тохируулах байрлал хүртэл гүйлгээд [OK]-г дарна.

6 Одоогийн байрлалыг заах тэмдэг дээр дарж явж буй чиглэлийг тохируулаад [OK]-г дарна.

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Sound & Media]-г дарна.
- 3 Тохируулах зүйлээ сонгоно.



● [Дуу] > [Түвшин]

Тохиргоо	Агуулга
[Автомат дууны түвшин тохируулагч]	Автомашины хурдад нийцүүлэн дууны түвшинг автоматаар тохируулна.

● [Sound] > [Voice]

Тохиргоо	Агуулга
[System volume]	Системийн аудио дууны түвшин тохируулна.
[Navigation volume]	Навигацийн системийн дуут зааварчилгааны дууны түвшинг тохируулна.
[Navigation during calls]	Утсаар ярих үед навигацийн системийн дуут зааварчилгаа яриан дундуур орж ирэх эсэх тохиргоог хийнэ.
[Adaptive volume control]	Хурдны замаар явах үед дуут зааварчилгааны дууны түвшинг автоматаар нэмэгдүүлнэ.
[Driving assist volume]	Жолоодлогод туслах системийн дууны түвшинг тохируулна.

● [Sound] > [Acoustic setting]

Тохиргоо	Агуулга
[Surround sound]	Тал бүрээс дуугарах дууны тохиргоог хийнэ.

● [Media] > [General]

Тохиргоо	Агуулга
[Display cover art]	Дууны цомгийн хавтасны зураг зэргийг гаргана.

● [AM/FM] > [AM/FM]

Тохиргоо	Агуулга
[Station list]	Станцийн жагсаалтыг өөр дарааллаар жагсаана.
[FM traffic announcement] ^{*1}	FM радио станц замын хөдөлгөөний мэдээлэл дамжуулж эхлэх үед автоматаар станц солино.
[FM alternative frequency] ^{*1}	FM радио станцийн дохио сулрах үед илүү хүчтэй долгионтой нөөц давтамж руу шилжүүлнэ.
[Regional code change] ^{*1}	Адил программтай сүлжээний орон нутгийн дамжуулалт руу шилжүүлнэ.
[FM program type] ^{*1}	Программын төрлийг (PTY) харуулна.
[FM radio text] ^{*1}	FM радио станцийн дамжуулж буй радио текстийг харуулна.

● [Internet radio]^{*1}

Тохиргоо	Агуулга
[Enable internet radio]	Радио долгионы хүч суларсан үед IP радиод шилжинэ.
[Changing to IP stream]	IP радио руу шилжих үед тохиргоог өөрчилж болно. • [Auto]-г идэвхжүүлсэн үед автоматаар шилжинэ. • [By request] гэж тохируулсан үед шилжүүлэх үед зөвшөөрөл хүснэ.
[Enhanced metadata/art work]	Gracenote радио таних технологи ашиглана. • Тогтмол ашигладаг радио станцийг лого харуулна. • Станцийн жагсаалтын категорийн нэр өөрчлөнө. • Станцийн жагсаалт автоматаар шинэчлэнэ.

● [DAB]^{*1}

Тохиргоо	Агуулга
[Traffic announcement]	DAB замын хөдөлгөөний мэдээлэл дамжуулж эхлэх үед автоматаар станц солино.
[Alternative frequency]	DAB-н дохио сулрах үед илүү хүчтэй долгионтой нөөц давтамж руу шилжүүлнэ.
[Radio text]	DAB-н радио текст харуулна.

МЭДЭЭЛЭЛ


Систем дуут зааварчилгаа өгөх явцад [ **VOL**] товч эргүүлж зааварчилгааны дууны түвшин тохируулна.

Дэлгэцийн горим солих

fcs1649896290643.dita

Энгийн видео болон өргөн дэлгэцийн видео хооронд солино.
Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- 1 **Үндсэн цэсний [🎵]-г дарна.**
- 2 **[Sources]-г дарна.**
- 3 **Дэлгэцийн горим солих эх үүсвэрийг дарна.**
- 4 **[...] -г дарна.**
- 5 **[Screen]-г дарна.**
Тус товч видео горимд гарна.
- 6 **[Screen format]-г дарна.**
- 7 **Хүссэн горимоо сонгоно.**



[Normal] : Видеог 4:3 харьцаагаар тоглуулна.

[Stretched] : Дэлгэц дүүрэн гаргах үүднээс видеог томруулна.

[Zoomed] : Босоо болон хөндлөн чиглэлд адил харьцаагаар видеог томруулна.

МЭДЭЭЛЭЛ

- Видеоны горимоос хамаарч өөрчлөх боломжтой тохиргоо өөр байна.
- Эдгээр тохиргоо нь хэрэглэгч өөрийн хэрэгцээнд видео үзэх үед ашиглах боломжтой. Нөгөөтэйгүүр бизнесийн зорилгоор эсвэл олон нийтэд үзүүлэх үед дэлгэцийн харьцааг өөрчлөх нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан видеоны зохиогчийн эрхийг зөрчиж болзошгүй.
- Видеоны харьцааг зөв гаргах үүднээс хар зураас дэлгэц дээр нэмэгдэж болно.

Дүрсний чанарыг тохируулах


rgu1649896290642.dita

2

Тохиргоо ба бүртгэл

Видеоны өнгөний ялгарал, гэрлийн хэмжээг тохируулна.
Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- 1 **Үндсэн цэсний [🎵]-г дарна.**
- 2 **[Sources]-г дарна.**
- 3 **Аль дүрсний чанарыг тохируулахаа сонгоно.**
- 4 **[...] -г дарна.**
- 5 **[Screen]-г дарна.**
Тус товч нь видео горимд гарна.
- 6 **[Display]-г дарна.**
- 7 **Тохиргоог хийнэ.**



"Brightness" : Гэрлийн түвшинг тохируулна.

"Contrast" : Өнгөний ялгарлыг тохируулна.

Эх үүсвэр бүрийн дууг тохируулах


nub1649896290627.dita

Эх үүсвэр бүрийн дууны чанар болон түвшний балансыг тохируулна.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 Тохиргоо хийх эх үүсвэрийг сонгоно.
- 4 [⋮]-г дарна.
- 5 [Sound]-г дарна.

Эх үүсвэрээс хамаарч дэлгэц дээр гарахгүй байж болно.

- 6 Зүйл тус бүрийг тохируулна.



"Treble" : Дууны өндөр намыг тохируулна.

"Mid" : Дунд түвшинд тохируулна.

"Bass" : Дууны басс дуугаралтыг тохируулна.

Fader and balance : Дуугаралтыг бүхээг дотор урагш хойш, баруун зүүн тийш [🔵]-р шилжүүлнэ.

Буцаан голлуулах үед [Recenter]-г дарна.

📖 МЭДЭЭЛЭЛ

Дууны өндөр нам, дунд түвшин, бассын тохиргоог эх үүсвэр тус бүрт өөрөөр хийнэ.

Wi-Fi® тохиргоо өөрчлөх

Wi-Fi® тохиргоо өөрчлөнө.

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 Дэд цэсний [Wi-Fi] ([Data & Wi-Fi])-г дарна.
- 3 Тохиргоонуудыг хийнэ.



● "Wi-Fi settings"

Тохиргоо	Агуулга
[Wi-Fi]	Wi-Fi® функцийг асаах буюу унтраана.

- Мультимедиа системийн тохиргооноос хамаарч дэлгэц дээр мэдээлэл гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтална.
 - [Wi-Fi]-г асаах үед ойр орчмын боломжит сүлжээг дэлгэцээр харуулна.
 - [Wi-Fi]-г унтраах үед Wi-Fi® холболтыг салгана.
- "Available networks" ("Available networks" жагсаалт [Wi-Fi] асаалттай үед дэлгэцээр гарна.)

Тохиргоо	Агуулга
Холбох сүлжээний нэр (Network SSID)	Дарсан сүлжээтэй холбогдоно.
Холбох сүлжээний нэр (Network SSID) [i]	Сүлжээний мэдээллийг дэлгэцээр гаргана.

- Нэг сүлжээг нэгээс олон MAC хаяг хуваан ашиглаж байгаа үед сүлжээний нэр хуулбарлагдан харагдаж болно.
- 30 хүртэлх сүлжээг харуулах боломжтой. Жагсаалт автоматаар 6 секунд тутамд шинэчлэгдэнэ.
- Сүлжээний адил нэртэй (SSID) өөр төхөөрөмж байгаа үед аль төхөөрөмж ашиглахыг ялгаж таних боломжгүй. Олон төхөөрөмж ашиглаж байгаа үед сүлжээний өөр нэр (Network SSIDs) төхөөрөмж тус бүрт ашиглана.

- Сүлжээний мэдээллийн дэлгэц (Сүлжээний нэрийн []-г дарах үед гарна.)

Тохиргоо	Агуулга
[Auto connect]*1	Сүлжээ хайх үед автоматаар холбох тохиргоог асаах буюу унтраана.
"Network SSID"	Сүлжээний нэр (SSID) гаргана.
"MAC address"	Сүлжээний MAC хаяг гаргана.
"Security"	Сүлжээний мэдээллийн аюулгүй байдлын протокол гаргана.
"Frequency band"	Сүлжээний давтамж гаргана.
[Forget this network]*1	Сонгосон сүлжээний холболтын түүхийг мультимедиа системээс устгана. Тухайн устгасан сүлжээ нь өмнө нь огт холбогдож байгаагүй сүлжээ болж танигдана.

- [Forget this network] нь одоогийн Wi-Fi® холболтыг салгахгүй. Wi-Fi® функцийг дахин асаах үед тухайн Wi-Fi® сүлжээний мэдээлэл системээс устгах ба сүлжээнд холбогдохгүй.



МЭДЭЭЛЭЛ

- 20 хүртэлх сүлжээний холболтын түүхийг хадгалах ба шинэ холболт үүсэх үед хамгийн хуучин холболтын мэдээллийг устгана.
- Аюулгүй бус холболт нь сүлжээний холболтын түүхэнд хадгалагдахгүй.

Холбоотой холбоосууд

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 123)

Wi-Fi® ашиглан сүлжээнд холбогдох(Х. 125)

*1 :Зөвхөн мультимедиа системтэй холболтын түүхтэй сүлжээг харуулна.

Bluetooth® төхөөрөмж тохируулах

Мултимедиа системийн ашиглалт болон холбосон Bluetooth® төхөөрөмжийг тохируулах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Bluetooth® төхөөрөмж тус бүр дээр өөр тохиргоо хийгдэнэ.
- Bluetooth® аудио тоглуулах үед гарын оролцоогүй утас сонгосон үед дуу солигдож болно.
- Bluetooth® төхөөрөмжийн загвараас хамаарч Bluetooth® төхөөрөмж дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- Яаралтай дуудлагын үед Bluetooth® төхөөрөмж сонгох боломжгүй.
- Жолоодлогын үед тохиргоо сонгох боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмжийн ажиллагааны байдлаас хамаарч сонгох боломжгүй байж болно.

- 1 Үндсэн цэсний -г дарна.
- 2 Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.
- 3 Дэд цэснээс тухайн тохиргоо хийх Bluetooth® төхөөрөмж сонгоно.

Нэг ч Bluetooth® төхөөрөмж бүртгэгдээгүй үед дэлгэц хоосон байна.

- 4 Тохиргоо хийнэ.



Тохиргоо	Агуулга
[Гар утсанд ашиглах]	Гарын оролцоогүй утасны функцийг асааж унтраана.*1
[Медиад ашиглах]	Аудио функцийг асааж унтраана.*1
[Apple CarPlay-д ашиглах]	Apple CarPlay функцийг асааж унтраана.*1
[Android Auto-д ашиглах]	Android Auto функцийг асааж унтраана.*1

● "Дууны түвшин"

Тохиргоо	Агуулга
[Ringtone]	Дуудлагын аяны дууны түвшин тохируулна.
[Received volume]	Ярианы дууны түвшинг тохируулна.
[New message]	Ирсэн мессежний аяны дууны түвшинг тохируулна.*2

● "Ерөнхий"

Тохиргоо	Агуулга
[Ringtone]	Гарын оролцоогүй утасны аяыг дараах байдлаар тохируулах боломжтой. - Гар утсанд аяыг мултимедиа системийн утасны аяар тохируулна. - Байгаа аянаас сонгоно. - Дуудлага ирэх үед залгасан хүний нэрийг систем дуудаж хэлэх тохиргоог хийнэ.
[Message tone]	Ирсэн мессежний аяыг дараах байдлаар тохируулах боломжтой.*2 - Байгаа аяар тохируулах. - Дууг хаах. - Илгээгчийн нэрийг дуудаж унших.
[Sort contacts by]	Бүртгэлтэй холбоо барих хаягийг дараах байдлаар жагсаана.*2 - Илгээгчийн нэрийн дарааллаар жагсаах. - Илгээгчийн овгийн дарааллаар жагсаах.
[Auto read messages]	Мессеж автоматаар дуудаж унших функцийг идэвхжүүлнэ.*2
[Clear call history]	Гарын оролцоогүй дуудлагын түүх устгана.*3

● "Синхрончлох"

Тохиргоо	Агуулга
[Sync contacts]	Хаяг, тогтмол ашигладаг хаяг, дуудлагын түүхийг мултимедиа системд автоматаар дамжуулах тохиргоог асааж унтраана. Тохиргоог идэвхжүүлсэн үед холбосон утасны холбоо барих хаягийн жагсаалт автоматаар шилжинэ.

Тохиргоо	Агуулга
[Sync contacts]	Зарим загварын гар утас тогтмол ашигладаг хаяг дамжуулах боломжгүй байдаг.
[Display contact images]	Хаягны зургийг дэлгэцээр гаргах тохиргоог идэвхжүүлж цуцлана.* ² [Sync contacts]-г асаагаагүй үед зураг дамжуулах боломжгүй.
[Set as secondary device]	Тухайн төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмжөөр холбоно.* ⁴
[Remove secondary device setting]	Тухайн төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмж тохиргооноос салгана.
[Connect]	Мултимедиа систем болон Bluetooth® төхөөрөмжийг холбоно.
[Disconnect]	Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмж салгана.
[Forget]	Бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл устгана.

— Холбоотой холбоосууд —

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 108)

Гарын оролцоогүй дуудлагын анхааруулга(Х. 216)

Bluetooth® аудио тоглуулах үеийн анхааруулга(Х. 205)

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 128)

Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 121)

*1 : Зөвхөн Bluetooth® төхөөрөмж тус функцийг гүйцэтгэх боломжтой үед дэлгэцээр гарна. Товчийг асааж унтраах үед холбогдох функцийг дэлгэцээр гаргах болон нуух эсвэл функцийг асааж унтраана. Apple CarPlay эсвэл Android Auto-г асаасан үед тус функцаар гарын оролцоогүй дуудлага эсвэл аудио ашиглах боломжгүй. Холболт эхлүүлэх үед [Connect] товч дарна.

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*3 : [Sync contacts] тохиргоог унтраасан гар утас холбох үед дэлгэцээр гарна.

*4 : Тус тохиргоог жолоочийн бүртгэл хийсэн бөгөөд жолоочийг систем таньсан ба таньсан гар утас нь үндсэн төхөөрөмжөөр бүртгэгдээгүй үед ашиглах боломжтой. Хоёрдогч төхөөрөмжөөр бүртгэсэн үед систем төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмжөөр танина. Автомашины Bluetooth® холболт үндсэн төхөөрөмж, хоёрдогч төхөөрөмж болон хамгийн сүүлд холбогдсон төхөөрөмж гэсэн дарааллаар холбогдоно.

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 122)

Хэрэглэгчийн профайл бүртгэх(Х. 52)

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх(Х. 60)

3-1. Bluetooth® функц ашиглах

Bluetooth® төхөөрөмж
ашиглах үеийн
анхааруулга..... 108

Bluetooth® техник
үзүүлэлт ба дэмжих
функцууд 111

Мултимедиа системээс
Bluetooth®
төхөөрөмжийн бүртгэл
үүсгэх 113

Бүртгэлтэй Bluetooth®
төхөөрөмж устгах..... 116

Bluetooth® төхөөрөмжтэй
холбох..... 117

Үндсэн төхөөрөмжөөр
Bluetooth® төхөөрөмж
тохируулах..... 121

Хоёрдогч төхөөрөмжөөр
Bluetooth® төхөөрөмж
тохируулах..... 122

3-2. Wi-Fi® сүлжээнд холбох

Wi-Fi® төхөөрөмж
ашиглах үеийн
анхааруулга..... 123

Wi-Fi® ашиглан сүлжээнд
холбогдох..... 125

3-3. Apple CarPlay болон Android Auto ашиглах

Apple CarPlay болон
Android Auto ашиглах
үеийн анхааруулга..... 128

Бүртгэгдээгүй ухаалаг
утасны Apple CarPlay
ашиглах..... 131

Бүртгэгдсэн ухаалаг
утасны Apple CarPlay
ашиглах..... 134

Android Auto ашиглах..... 137

Apple CarPlay эсвэл
Android Auto доголдсон
үед 139

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга

Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж ашиглах үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.

МЭДЭЭЛЭЛ

- Bluetooth® нь 2.4 GHz үелзлээр утасгүй холболт үүсгэх функц юм.
- Адилхан 2.4 GHz үелзэл ашигладаг Wi-Fi®-г Bluetooth®-тэй зэрэг ашиглах үед холболтууд нөгөө холболтондоо саад учруулна.
- Bluetooth® болон Wi-Fi® холболт хоорондоо саад учруулах нь видео дүрс сарних, аудио үсрэх эсвэл холболтын хурд буурахад хүргэнэ.
- Bluetooth® төхөөрөмж холбосон үед саад учруулалт буурна. Bluetooth® төхөөрөмж бүртгэгдсэн үед бүртгэлтэй төхөөрөмжтэй холбох нь саад учруулалтыг бууруулна. (Мултимедиа системийн дэлгэцний тэмдгээр Bluetooth® төхөөрөмжийг шалгах боломжтой.)
- Bluetooth® гар утсыг бусад утасгүй холболтын төхөөрөмжтэй зэрэг ашиглах нь нөгөө төхөөрөмжийн холболтод сөрөг нөлөө үзүүлнэ.
- Wi-Fi® функц (Wi-Fi® болон Miracast®) нь адилхан 2.4 GHz үелзлээр утасгүй холболт үүсгэдэг. Bluetooth® төхөөрөмж зэрэг холбох нь холболтууд хоорондоо саад учруулна. Wi-Fi® функц унтраасан үед холболтод саад үүсэхгүй.
- Bluetooth® төхөөрөмжийг Bluetooth®-р холбосон үед хэвийн үеэс илүү зайны цэнэг хурдан буурна.
- Bluetooth® холболт яаралтай дуудлагын үед салгагдана. Яаралтай дуудлага дуусах үед Bluetooth® төхөөрөмжийн холболт дахин сэргэнэ.

АЮУЛТАЙ

- Аюулгүйн үүднээс гарын оролцоогүй дуудлага хийнгээ жолоодох үедээ жолооч гар утсыг шууд удирдаж болохгүй.
- Дуудлага хийхийн өмнө аюулгүй газар зогсоно. Жолоодлогын үед дуудлага ирсэн нөхцөлд жолоодлогын аюулгүй байдлыг хангангаа богино ярина.

АНХААР

- Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж хэт ойрхон ашиглаж болохгүй. Хэт ойртуулсан үед дууны чанар, холболт муудахад хүргэнэ.
- Автомашины бүхээгт гар утас үлдээж болохгүй. Бүхээгийн хэм хэт өндөр болсон үед гар утсанд доголдол үүсгэх аюултай.

■ Пэйсмейкер, бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хамт ашиглах

Bluetooth® холболтын үед радио долгионтой холбоотой дараах зүйлсийг анхаарна.

▲ АЮУЛТАЙ

- Автомашины Bluetooth® холболтын антен урд удирдлагын самбарын төв хэсэгт байрладаг.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэй хүн Bluetooth® антенаас зайтай сууна. Радио долгион эдгээр эмчилгээний төхөөрөмжид нөлөөлөх аюултай.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер эсвэл дефибриллятор суулгац эмчилгээнээс бусад төрлийн эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн Bluetooth® төхөөрөмж ашиглахын өмнө радио долгионы учруулах нөлөөг эмчилгээний төхөөрөмж үйлдвэрлэгчээс тодруулна уу. Радио долгион нь эдгээр төхөөрөмжинд урьдчилан мэдэх боломжгүй нөлөөтэй байж болно.

■ Bluetooth® аудиотой зэрэг ашигласан үед

- Bluetooth® дэмждэг төхөөрөмжийг (гар утас) гарын оролцоогүй дуудлага хийх зорилгоор Bluetooth® аудиотой зэрэг холбосон үед дараах нөхцөлүүд үүсч болно.
 - Гар утасны Bluetooth® холболт салгагдаж болно.
 - Гарын оролцоогүй дуудлагын үед аудионд шуугиан үүсч болно.
 - Гарын оролцоогүй дуудлагын үйлдэл хоцрогдолтой байж болно.
- Bluetooth® аудио тоглуулах үед гарын оролцоогүй дуудлагад ашиглах төхөөрөмжийг өөр төхөөрөмжөөр сольсон үед аудио дууг алгасаж болно.
- Холбоо барих хаяг дамжуулах үед зөөврийн төхөөрөмжийн холболт салгагдаж болно. Хаяг дамжуулалт дуусах үед холболт сэргэнэ. (Зарим загварт холболт дахин автоматаар хийгдэхгүй байж болно)
- Гар утас гарын оролцоогүй дуудлага болон аудио холболтыг зэрэг дэмждэг байсан ч эдгээр функцуудыг зэрэг ашиглах боломжгүй байж болно.
- Системтэй холбож ашиглах боломжтой төхөөрөмжийн жагсаалтыг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

Холбоотой холбоосууд

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 123)

Bluetooth® аудио тоглуулах үеийн анхааруулга(Х. 205)

Гарын оролцоогүй дуудлагын анхааруулга(Х. 216)

Тоглуулах үеийн анхааруулга. Miracast®(Х. 210)

Статусын тэмдэг(Х. 20)

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд

woe1649830594078.dita

Мултимедиа систем нь дараах техник үзүүлэлттэй төхөөрөмжийг дэмжинэ. Бүх Bluetooth® төхөөрөмжийг дэмжихгүй.

► А төрөл

■ Дэмжих Bluetooth® техник үзүүлэлт

Bluetooth® үндсэн техник үзүүлэлт Ver. 5.0

■ Дэмжих функцууд

- HFP (Hands Free Profile) дэмжих хувилбар: Ver. 1.7.2
Гар утас ашиглан гарын оролцоогүй дуудлага хийх боломж бүрдүүлнэ. Дуудлага хийх, хүлээн авах функцтай.
- PBAP (Phone Book Access Profile) дэмжих хувилбар: Ver. 1.2.3
Холбоо барих хаяг, дуудлагын түүх зэрэг мэдээллийг синхрончилно.
- OPP (Object Push Profile) дэмжих хувилбар: Ver. 1.2.1
Холбоо барих хаягийг дамжуулах профайл
- MAP (Message Access Profile)*¹ дэмжих хувилбар: Ver. 1.4.2
Утасны мессежний функц ашиглах профайл.
- SPP (Serial Port Profile) дэмжих хувилбар: Ver. 1.2
 - Bluetooth®-тэй төхөөрөмжийг виртуал цуврал порт болгож хувиргах профайл
 - Ухаалаг утас холбох профайл
- A2DP (Advanced Audio Distribution Profile) дэмжих хувилбар: Ver. 1.3.2
Стерео аудио, өндөр чанарын дууг аудио системд дамжуулах профайл.
- AVRCP (Audio/Video Remote Control Profile) дэмжих хувилбар: Ver. 1.6.2
Аудио системийг зайнаас удирдах профайл

► В төрөл

■ Дэмждэг Bluetooth® техник үзүүлэлт

Bluetooth® үндсэн техник үзүүлэлт Ver. 5.0

■ Дэмжих функцууд

- HFP (Hands Free Profile) дэмжих хувилбар: Ver. 1.8

Гар утас ашиглан гарын оролцоогүй дуудлага хийх боломж бүрдүүлнэ. Дуудлага хийх, хүлээн авах функцтай.

- PBAP (Phone Book Access Profile) дэмжих хувилбар: Ver. 1.2.3
Холбоо барих хаяг, дуудлагын түүх зэрэг мэдээллийг синхрончлоно
- OPP (Object Push Profile) дэмжих хувилбар: Ver. 1.2.1
Холбоо барих хаягийг дамжуулах профайл
- MAP (Message Access Profile)*¹ дэмжих хувилбар: Ver. 1.4.2
Утасны мессежний функц ашиглах профайл.
- SPP (Serial Port Profile) дэмжих хувилбар: Ver. 1.2
 - Bluetooth®-тэй төхөөрөмжийг виртуал цуврал порт болгож хувиргах профайл
 - Ухаалаг утас холбох профайл
- A2DP (Advanced Audio Distribution Profile) дэмжих хувилбар: Ver. 1.3.2
Стерео аудио, өндөр чанарын дууг аудио системд дамжуулах профайл.
- AVRCP (Audio/Video Remote Control Profile) дэмжих хувилбар: Ver. 1.6.2
Аудио системийг зайнаас удирдах профайл

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх

dcw1649830594218.dita

Гарын оролцоогүй дуудлага эсвэл Bluetooth® аудио ашиглах үед гар утас, зөөврийн төхөөрөмж холбоно. Бүртгэл дууссан үед Bluetooth® автоматаар мултимедиа систем асаах бүрт холбогдоно.

Apple CarPlay/Android Auto төхөөрөмж USB-р холбогдсон үед Bluetooth® төхөөрөмж автоматаар холбогдоно.

Bluetooth® төхөөрөмж холбогдоогүй үед бүртгэлийн дэлгэцийг жолооны хүрдний  товч удаан дарж гаргана.


МЭДЭЭЛЭЛ

- Гар утсыг гарын оролцоогүй утас болон Bluetooth® аудио төхөөрөмжөөр зэрэг бүртгэх боломжтой.
- 5 хүртэлх Bluetooth® төхөөрөмж бүртгэх боломжтой ба 2 төхөөрөмж гарын оролцоогүй утсаар ашиглах боломжтой. (Гарын оролцоогүй утсаар 2 төхөөрөмж бүртгэх үед жолооч таниулах шаардлагатай.)
- Bluetooth® төхөөрөмж хэрхэн ажиллуулах тухай дэлгэрэнгүйг Bluetooth® төхөөрөмжийн зааварчилгаанаас харна уу.
- Нэг зэрэг олон Bluetooth® төхөөрөмж ашиглах үед Bluetooth® төхөөрөмж бүрийг бүртгэх шаардлагатай.
- Мултимедиа системд Bluetooth® төхөөрөмж бүртгэх үед PIN кодоор баталгаажуулах шаардлагатай.
- Гар утасны тохиргооноос хамаарч холбогдсоны дараа дуудлага хийх үед дэлгэц түгжигдэж болно. Гар утас ашиглахын өмнө автоматаар түгжих тохиргоог арилгана.
- Гар утас, зөөврийн төхөөрөмж холбогдсон үед өөр зөөврийн төхөөрөмж бүртгэсэн нөхцөлд аудио тоглуулж буй гар утас, зөөврийн төхөөрөмжийн холболт салгагдана.
- Miracast® ашиглах үед Bluetooth® төхөөрөмж холбосон нөхцөлд Miracast® аудио дараагийн дуунд шилжиж болно.
- Аюулгүйн үүднээс жолоодлогын үед төхөөрөмж бүртгэх боломжгүй.
- Bluetooth® бүртгэл амжилттай хийгдэхгүй үед Bluetooth® төхөөрөмжийг дахин асаана.

- 1 Үндсэн цэсний  -г дарна.
- 2 Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.
Төхөөрөмж бүртгэгдээгүй үед 4 үйлдэлд шилжинэ.
- 3 [Add another device]-г дарна.

Мултимедиа системд төхөөрөмж холбогдсон үед төхөөрөмжийг салгах баталгаажуулах дэлгэц гарч ирж болно. Бүртгэлийг үргэлжлүүлэх үед төхөөрөмжийг салгана.

4 [If not found]-г дарна.



5 Үндсэн хэсэг дэх бүртгэх төхөөрөмж дээр дарна.

- Bluetooth® хаягны оронд төхөөрөмжийн нэр гарч болно.
- Үндсэн хэсэг дээр бүртгэх төхөөрөмж гарч ирэхгүй үед Bluetooth® төхөөрөмжөөс бүртгэх оролдлого хийнэ.
- Зарим загварын Bluetooth® төхөөрөмж нь тодорхой үйлдлийг Bluetooth® төхөөрөмж дээр хийгээгүй үед дэлгэц дээр гарч ирдэггүй. Дэлгэрэнгүйг Bluetooth® төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.

6 Дэлгэцээр гарч буй PIN код Bluetooth® төхөөрөмжтэй таарч байгааг нягтлаад [OK] дарна.

- Бүртгэл дуусгах үед зарим Bluetooth® төхөөрөмж дээр үйлдэл хийх шаардлагатай байдаг.
- Үндсэн төхөөрөмжийн тохиргоо гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- Apple CarPlay-н тохиргоо гарч болно. Ашиглалтыг идэвхжүүлсэн үед Apple CarPlay-н дэлгэц гарна.
- Холболт хийгдсэнийг илтгэх мэдээлэл дэлгэцээр гарах ба дэд цэсэн дээр бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн нэр гарна.
- Үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарсан үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

— Холбоотой холбоосууд —

[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(Х. 52\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх\(Х. 60\)](#)

[Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга\(Х. 128\)](#)

Бүртгэл Bluetooth® төхөөрөмжөөс хийх

rpp1649830594047.dita

Мултимедиа систем Bluetooth® төхөөрөмжийг хайгаад олохгүй үед мултимедиа системийг Bluetooth® төхөөрөмжөөс хайх боломжтой.

1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.

2 Дэд цэсний [Bluetooth & Devices]-г дарна.

Өөр төхөөрөмж бүртгэгдээгүй үед 4 үйлдэлд шилжинэ.


3 [Add another device]-г дарна.

Өөр төхөөрөмж мултимедиа системд холбогдсон үед төхөөрөмжийн холболтыг салгах дэлгэц гарч болно. Бүртгэл хийх үед төхөөрөмжийг салгана.

4 Тухайн ашиглах Bluetooth® төхөөрөмж дээр мултимедиа системийг бүртгэнэ.

- Bluetooth® төхөөрөмжийн ажиллагааны зааврын дагуу үйлдлийг хийнэ.

- Тус Bluetooth® холболтын дэлгэцийг Bluetooth® төхөөрөмж дээр бүртгэл хийхийн өмнө гаргана.



5 Дэлгэцээр гарах PIN код нь Bluetooth® төхөөрөмжийн PIN кодтой таарч байгааг нягтлаад [OK]-г дарна.

- Зарим Bluetooth® төхөөрөмжийг бүртгэл хийх үед удирдах шаардлагатай байдаг.

- Үндсэн төхөөрөмжийн тохиргоо гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

- Apple CarPlay-н тохиргоо гарч болно. Идэвхжүүлсэн үед Apple CarPlay-н дэлгэц гарна.

- Холболт дууссаныг илтгэх мэдээлэл гарч бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийн нэр дэд цэс дээр гарна.

- Үйлдэл амжилтгүй болсон үед дэлгэцийн зааварчилгааг баримтлана.

— Холбоотой холбоосууд —

Хэрэглэгчийн профайл бүртгэх(Х. 52)

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх(Х. 60)

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 128)

Бүртгэлтэй Bluetooth® төхөөрөмж устгах

cen1649830594140.dita

Бүртгэлтэй Bluetooth® төхөөрөмжийг устгах боломжтой.

- 1 **Үндсэн цэсний []-г дарна.**
- 2 **Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.**
- 3 **Дэд цэснээс устгах Bluetooth® төхөөрөмжийг сонгоно.**
- 4 **[Forget]-г дарна.**
Өөр хэрэглэгчийн үндсэн төхөөрөмжөөр бүртгэгдсэн төхөөрөмжийг устгах боломжгүй.
- 5 **[Forget]-г дарна.**



МЭДЭЭЛЭЛ

- Яаралтай дуудлагын үед бүртгэлтэй гар утас устгах боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмжөөс хамаарч анхны оролдлогоор устгах боломжгүй байж болно.

Холбоотой холбоосууд

Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 121)

Хэрэглэгчийн профайл бүртгэх(Х. 52)

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх(Х. 60)

Bluetooth® төхөөрөмжтэй холбох

ykv1649830593984.dita

Мултимедиа системийн олон төрлийн функц ашиглах үед Bluetooth® төхөөрөмжтэй холбох шаардлагатай. Автомат болон гараар холбох 2 арга байдаг.

МЭДЭЭЛЭЛ

- Bluetooth® төхөөрөмж хэрхэн ашиглах тухай мэдээллийг Bluetooth® төхөөрөмжийн ашиглалтын заавраас харна уу.
- Гар утас холбох үед холболт тогтворгүй байгаа нөхцөлд дуудлагыг таслаад дахин холбоно.
- Bluetooth® төхөөрөмжийн Bluetooth®-г асаагаагүй үед холбох боломжгүй.
- Bluetooth® төхөөрөмж холбогдсон үед дэлгэцийн дээд талд тэмдэг гарна.
- Bluetooth® төхөөрөмж холбогдсон үед Bluetooth® холболтын байдлын тэмдэг гарна.
- Гар утасны загвараас хамаарч асаах товч <power товч> асаах үед дэлгэцийн хэсэг үргэлжлэн асч болно. Энэ нөхцөлд гар утасны дэлгэцийн гэрлийг унтраана. (Тохиргооны тухай мэдээллийг гар утасны ашиглалын заавраас харна уу)
- Apple CarPlay-р холбогдсон төхөөрөмжийн Bluetooth® функцийг ашиглах боломжгүй.
- Android Auto-р холбогдсон төхөөрөмжийн гарын оролцоогүй дуудлагаас бусад Bluetooth® функцийг ашиглах боломжгүй.
- Miracast® ашиглах үед Bluetooth® төхөөрөмж холбосон нөхцөлд Miracast® аудио дуу дараагийн дуунд шилжиж болно.

■ Bluetooth® дахин холболт

Өмнө нь холбогдсон Bluetooth® холболт асаах товч <power товч> асаах үед автоматаар дахин холбогдох оролдлого хийнэ.

■ Холбох боломжтой Bluetooth® төхөөрөмжийн тоо

- Систем жолоочийг таньсан үед
2 хүртэлх гарын оролцоогүй утас болон 1 аудио төхөөрөмж автоматаар холбогдох боломжтой. (Гарын оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр тохируулах боломжтой.)
- Систем жолоочийг таниагүй үед
1 хүртэлх гарын оролцоогүй утас болон 1 аудио төхөөрөмж автоматаар холбогдох боломжтой. (Гарын оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр тохируулах боломжтой.)

МЭДЭЭЛЭЛ

- Дахин холболт амжилтгүй болсон үед гараар дахин холболт хийнэ.
- Apple CarPlay-р холбосон төхөөрөмжийг Bluetooth® төхөөрөмжөөр дахин холбох боломжгүй байж болно.

— Холбоотой холбоосууд —

[Статусын тэмдэг\(Х. 20\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(Х. 52\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх\(Х. 60\)](#)

Автоматаар Bluetooth® төхөөрөмж холбох

rqc1649830594156.dita

Bluetooth® төхөөрөмж нь асаах товчийг <power товч> off-с on горимд шилжүүлэх үед холбох дарааллын дагуу мултимедиа системд автоматаар холбогдоно.

● Систем жолоочийг таньсан үед

Үндсэн төхөөрөмж, 2-р төхөөрөмж болон хамгийн сүүлд холбосон төхөөрөмжийн дарааллаар автоматаар холбогдоно. 2 хүртэлх гарын оролцоогүй утас болон нэг аудио төхөөрөмж автоматаар холбогдоно. (Гарын оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр сануулах боломжтой.)

● Систем жолоочийг таниагүй үед

Хамгийн сүүлд холбогдсон дарааллаар автоматаар холбогдоно. 1 хүртэлх гарын оролцоогүй утас болон нэг аудио төхөөрөмж автоматаар холбогдоно. (Гарын оролцоогүй утас болон аудио төхөөрөмжийг нэг төхөөрөмжөөр сануулах боломжтой.)

Дахин холболт алдаа заасан үед гар аргаар холбоно.

МЭДЭЭЛЭЛ

Bluetooth® төхөөрөмжийн загвараас хамаарч Bluetooth® төхөөрөмжийг удирдаж ажиллуулах шаардлагатай.

— Холбоотой холбоосууд —

[Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 121\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(Х. 52\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх\(Х. 60\)](#)

Bluetooth® төхөөрөмж гар аргаар холбох

bbk1649830594015.dita

Өөр Bluetooth® төхөөрөмж холбох эсвэл автомат холболт алдаа заасан үед бүртгэгдсэн Bluetooth® төхөөрөмжийг гар аргаар холбох боломжтой.

1 **Үндсэн цэсний [⚙️]-г дарна.**

2 **Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.**

Bluetooth® төхөөрөмж бүртгэгдээгүй үед мултимедиа систем дээр төхөөрөмж хайх дэлгэц гарна. Bluetooth® төхөөрөмжийг бүртгүүлнэ.

3 **Дэд цэснээс тухайн холбох Bluetooth® төхөөрөмжийг сонгоно.**

Хэрэв дэд цэсний жагсаалтад тухайн холбох Bluetooth® төхөөрөмж байхгүй үед Bluetooth® төхөөрөмжийг бүртгүүлнэ.

4 **Үндсэн хэсэг дэх [Connect]-г дарна.**

Өөр төхөөрөмж системд холбогдсон байгаа нөхцөлд баталгаажуулах дэлгэц гарна.



МЭДЭЭЛЭЛ

Тухайн Bluetooth® төхөөрөмжийн ажиллагааны байдлаас шалтгаалж эхний оролдлогоор холбогдохгүй байж болно. Энэ нөхцөлд тодорхой хугацааны дараа дахин оролдono.

Холбосон Bluetooth® төхөөрөмж салгах

ucu1649830593953.dita


Мултимедиад холбосон Bluetooth® төхөөрөмжийг салгах боломжтой.

1 **Үндсэн цэсний [⚙️]-г дарна.**

2 **Дэд цэсний [Bluetooth & Devices]-г дарна.**

3 **Дэд цэснээс салгах Bluetooth® төхөөрөмжийг сонгоно.**

4 Үндсэн хэсгээс [Disconnect]-г дарна.



Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах

iuf1649830594031.dita

Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулан автомат холболтын үед эхлээд холбогдох төхөөрөмжийг сонгох боломжтой.


- Тохируулах гэж буй гар утас мултимедиа системд холбогдсон байх шаардлагатай.
- Тохиргоо хийхийн өмнө тухайн тохиргоо хийх жолоочийн тохиргоог нээсэн байна.

МЭДЭЭЛЭЛ

Бусад хэрэглэгчийн үндсэн төхөөрөмжөөр бүртгэгдсэн гар утсыг тохируулах боломжгүй.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Personal info]-г дарна.
- 3 Үндсэн хэсгээс [Link devices] эсвэл [Change link devices]-г дарна.

Үндсэн төхөөрөмжөөр бүртгэх боломжтой гарын оролцоогүй утас байхгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарч ирнэ. Гар утас хайж мултимедиа системд шинээр бүртгэнэ. Шинэ бүртгэл хийсэн үед үндсэн төхөөрөмжөөр бүртгэх боломжтой.



- 4 Үндсэн төхөөрөмжөөр бүртгэх гар утас сонгоно.

Одоогийн холбогдсон Bluetooth® төхөөрөмжийг салгаад үндсэн төхөөрөмж болон хоёрдогч төхөөрөмж холбоно.

— Холбоотой холбоосууд —

Bluetooth® төхөөрөмж тохируулах(X. 103)

Хэрэглэгчийн профайл бүртгэх(X. 52)

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх(X. 60)

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх(X. 113)

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах

hrl1649830594172.dita

Хоёрдогч төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж бүртгэх үед тус төхөөрөмж холбогдох үедээ хоёрдогч төхөөрөмж болж холбогдоно.

- Нэг Bluetooth® төхөөрөмжийг үндсэн ба хоёрдогч төхөөрөмжөөр зэрэг бүртгэх боломжгүй.
- Мультимедиа системд HFP дэмждэг Bluetooth® төхөөрөмж холбох шаардлагатай.

1 **Үндсэн цэсний [⚙️]-г дарна.**

2 **Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.**


Bluetooth® төхөөрөмж бүртгэгдээгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарна. Гар утас бүртгэнэ.

3 **Хоёрдогч төхөөрөмжөөр тохируулах гар утсыг сонгоно.**

Жагсаалт дээр тохируулах гар утас гарч ирэхгүй үед гар утас бүртгэнэ.

4 **Үндсэн хэсгээс [Set as secondary device]-г дарна.**

Тус төхөөрөмжийг хоёрдогч төхөөрөмжөөр урьд нь бүртгэсэн үед [**Remove secondary device setting**] цуцлах товч болж өөрчлөгдөнө.



Холбоотой холбоосууд

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(X. 52\)](#)

[Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх\(X. 60\)](#)

Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга hzf1649830594125.dita

Wi-Fi® сүлжээ ашиглах эсвэл Wi-Fi® цацах үйлдэлтэй ухаалаг утастай холбон ашиглах үед дараах мэдээлэлд онцгой анхаарал хандуулна.

■ Пэйсмейкер, бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хэрэглэгч

Wi-Fi® холболтын үед радио долгионы нөлөөлөлтэй холбоотой дараах зүйлсийг анхаарна.

▲ АЮУЛТАЙ

- Wi-Fi® төхөөрөмжийг ашиглах нь аюулгүй бөгөөд хууль дүрэмд зөвшөөрөгдсөн үед ашиглана.
- Автомашины Wi-Fi® антен нь мультимедиа систем дотор байрладаг.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэй хүн Wi-Fi® антенаас хангалттай зайтай байх шаардлагатай.
Радио долгион нь эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд сөрөг нөлөөтэй.
- Wi-Fi® төхөөрөмж ашиглахын өмнө дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер эсвэл дефибриллятор суулгац эмчилгээнээс бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн тус холболтыг ашиглахын өмнө өөрийн эмч эсвэл эмчилгээний төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс зөвлөгөө авна.
Радио төхөөрөмж нь эдгээр төхөөрөмжүүдэд урьдчилан таамаглах боломжгүй нөлөө үзүүлэх аюултай.

■ Wi-Fi® болон Bluetooth®-г зэрэг ашиглах

Wi-Fi® нь 2.4 GHz давтамж дээр суурилсан боломжит хамгийн өндөр гүйцэтгэлээр холболт үүсгэх утасгүй харилцааны функц юм. Адилхан 2.4 GHz-н давтамж ашигладаг Bluetooth® холболтыг Wi-Fi®-тай зэрэг ашигласнаар холболтууд хоорондоо сөрөг нөлөө үзүүлдэг.

■ Wi-Fi®-н талаар зайлшгүй мэдэх зүйлс

□ МЭДЭЭЛЭЛ

- Wi-Fi®, Miracast®, Wi-Fi Direct® болон WMM® нь Wi-Fi Alliance®-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.
- Wi-Fi Protected Setup™, Wi-Fi CERTIFIED™, WPA™, WPA2™ болон WPA3™ нь Wi-Fi Alliance®-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.

- Энэ боломжит хамгийн өндөр гүйцэтгэлээр дамжуулах функц болно.
- Тус функцийг зөөврийн төхөөрөмж холбох үед ашиглана. Тухайн нөхцөлөөс хамаарч тус зөөврийн төхөөрөмжөөс бусад төхөөрөмжийн холболт салгагдаж болно.
- Wi-Fi®-тай бүсээс гарах үед холболт сална.
- Хэрэв автомашин радио антен, радио станц эсвэл бусад хүчтэй радио долгион, цахилгаан шумны эх үүсвэрийн ойр орчимд байгаа үед холболтын хурд удаан эсвэл холбох боломжгүй байж болно.
- Тодорхой ашиглалтын орчнуудад (утасгүй холболтын антен болон төхөөрөмж ойрхон байгаа зэрэг) холболтын хурд удаан эсвэл холбох боломжгүй байж болно.

Тохирох Wi-Fi® дамжуулалтын протокол

IEEE 802.11b/g/n (2.4GHz)

Тохирох мэдээллийн нууцлалын протокол

- WEP
- WPA™
- WPA2™
- WPA3™

Холбоотой холбоосууд

Тоглуулах үеийн анхааруулга. Miracast®(Х. 210)

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 108)

Статусын тэмдэг(Х. 20)

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 101)

Интернет хөтөч функцийн тухай(Х. 258)

Wi-Fi® ашиглан сүлжээнд холбогдох

wtv1649830593922.dita

Мултимедиа системийг интернетэд Wi-Fi® сүлжээ ашиглан холбох боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Сүлжээний дохио хүлээн авалтын хэмжээг дээд хэсэгт гаргадаг.
- Apple CarPlay утасгүй холболттой үед ашиглах боломжгүй.
- Зарим ухаалаг утасны загвар тухай бүр холболт үүсгэхийг шаарддаг.
- Wi-Fi® функц асаалттай үед сүлжээ танигдсан нөхцөлд хамгийн сүүлд холбогдсон сүлжээнд түрүүлж холбогдоно.

Холбоотой холбоосууд

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 101)

Ухаалаг утас ашиглан Wi-Fi®-д холбох

yae1649830594187.dita

Дараах жишээний дагуу Wi-Fi® холболт дэмждэг гар утас ашиглан Wi-Fi® цацалт хийх боломжтой. Дэлгэрэнгүйг ухаалаг утасны гарын авлага зэрэг материалаас харна уу. Зарим утасны загвар холболт хийх бүрт баталгаажуулалт шаарддаг.

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 Дэд цэсний [Wi-Fi] ([Data & Wi-Fi])-г дарна.
- 3 Үндсэн хэсгийн [Wi-Fi]-г асаана.

- Мултимедиа системийн тохиргооноос хамаарч мессеж гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтална.
- [Wi-Fi]-г асаах үед ойр байгаа боломжит сүлжээг харуулна.



- 4 Ухаалаг утаснаас цацаж байгаа сүлжээний нэрийг сонгоно.

- Нэгээс олон MAC хаяг нэг сүлжээг хуваан ашиглаж байгаа үед сүлжээний нэр хувилбартайгаар гарч болно.
- Дэлгэцээр 30 хүртэлх сүлжээг харуулах боломжтой. Жагсаалт 6 секунд тутамд автоматаар шинэчлэгдэнэ.
- Адил сүлжээний нэртэй (SSID) төхөөрөмж байгаа үед төхөөрөмжийг таних боломжгүй. Олон төхөөрөмж ашиглаж байгаа үед өөр сүлжээний нэр (SSID) ашиглана.
- Жолоодлогын үед сонголт хийх боломжгүй.

5 Сүлжээний нууц үг оруулна.

- Нууц үг тохируулаагүй үед сүлжээ сонгох үед холболт үүснэ.
- Автомат холболтын тохиргоотой сүлжээ танигдсан үед автоматаар холбогдоно.

МЭДЭЭЛЭЛ

Шинэ холболт үүсэх үед хуучин холболтоос устгах байдлаар 20 хүртэлх сүлжээний холболтын түүх хадгалагддаг.

Боломжит сүлжээтэй Wi-Fi® холболт үүсгэх

maz1649830594062.dita

Ойр байрлах Wi-Fi® сүлжээ ашиглан интернетэд холбоно.

Холбох сүлжээний нууц үгийг урьдчилан шалгана.

- 1 Үндсэн цэсний -г дарна.
- 2 Дэд цэсний [Wi-Fi] ([Data & Wi-Fi])-г дарна.
- 3 Үндсэн хэсгийн [Wi-Fi]-г идэвхжүүлнэ.

- Мультимедиа системийн тохиргооноос хамаарч мэдээлэл гарч болно. Дэлгэцийн зааварчилгааг баримтлана.
- [Wi-Fi]-г асаах үед ойр орчмын боломжит сүлжээг дэлгэцээр харуулна.



- 4 Үндсэн хэсгийн [Available networks]-с холбох сүлжээг сонгоно.

- Нэгээс олон MAC хаяг нэг сүлжээг хуваан ашиглаж байгаа үед сүлжээний нэр олон хувилбартай гарч болно.
- 30 хүртэлх сүлжээг дэлгэцээр харуулна. Жагсаалт 6 секунд тутамд шинэчлэгдэнэ.
- Адил сүлжээний нэртэй (SSID) төхөөрөмж байгаа үед аль төхөөрөмж ашиглахыг тогтоох боломжгүй. Олон төхөөрөмж ашиглаж байгаа үед өөр сүлжээний нэр (SSIDs) өгнө.
- Жолоодлогын үед сонголт хийх боломжгүй.
- Боломжит сүлжээний -г дарж сүлжээний дэлгэрэнгүй мэдээлэл харна.

5 Сүлжээний нууц үг оруулна.

- Нууц үггүй үед сүлжээ сонгох үед холболт хийгдэнэ.
- Автоматаар холбох тохиргоог асаасан үед сүлжээ танигдсан нөхцөлд автоматаар холбогдоно.

МЭДЭЭЛЭЛ

20 хүртэлх сүлжээний холболтыг түүхийг хадгалах ба шинэ холболт үүсэх үед хамгийн хуучин түүхийг устгана.

Wi-Fi® холболт салгах

kuz1649830594234.dita

Wi-Fi® холболтыг Wi-Fi® функцийг унтрааж салгах боломжтой.

- 1 Үндсэн цэсний [⚙️]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Wi-Fi] ([Data & Wi-Fi])-г дарна.
- 3 Үндсэн хэсгийн [Wi-Fi]-г унтраана.



Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга

Apple CarPlay болон Android Auto нь зарим аппликейшн (газрын зураг, утас, дууны зэрэг) мультимедиа систем дээр ашиглах боломж олгодог. Apple CarPlay эсвэл Android Auto-г холбосон үед дэлгэц дээр ашиглах боломжтой аппликейшн гарна. Apple CarPlay эсвэл Android Auto ашиглах үед дараах мэдээлэлд онцгой анхаарал хандуулна.

Android Auto-г тус автомашинд ашиглах үед Google Play Store™-с Android Auto-г татаж суулгана.

■ Ашиглах боломжтой төхөөрөмж

- Apple CarPlay-г дэмждэг Apple iPhone төхөөрөмж. (iOS Ver. 13.3-с хойших)

Дэлгэрэнгүйг <https://www.apple.com/ios/carplay/>-с харна уу.*1

- Android Auto-г дэмждэг Android™ төхөөрөмж.

Дэлгэрэнгүйг <https://www.android.com/auto/>-с харна уу.*1

⚠ АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед ухаалаг утсыг шууд ашиглаж болохгүй.

⚠ АНХААР

- Бүхээгт ухаалаг утас үлдээж болохгүй. Бүхээг хэт халах үед ухаалаг утсанд гэмтэл учруулах аюултай.
- Холбоотой үед ухаалаг утсыг дарах, хөшихийг хориглоно. Ухаалаг утас эсвэл порт гэмтэж болно.
- USB портод гадны биет орохоос сэргийлнэ. Ухаалаг утас эсвэл порт гэмтэж болно.

📖 МЭДЭЭЛЭЛ

- USB-р холбох үед гар утасны үйлдвэрлэгчийн дата USB холбогч ашиглана.
- Apple CarPlay эсвэл Android Auto холбогдсон үед системийн зарим товчны ажиллагаа өөрчлөгдөж болно.

*1 : Аппликейшнууд зөв ажиллана гэсэн баталгаа байдаггүй.

- Дараах функцууд Apple CarPlay эсвэл Android Auto-н төстэй функцаар солигдох эсвэл Apple CarPlay эсвэл Android Auto-р системд холбогдсон гар утсан дээр идэвхгүй болно.
 - Bluetooth® утас (зөвхөн Apple CarPlay)
 - Bluetooth® аудио
 - Miracast® (зөвхөн утасгүй холболтоор холбогдсон Apple CarPlay)*²
- Мультимедиа системд Apple CarPlay утасгүй холболтоор холбогдсон үед Bluetooth® функц ашиглах боломжгүй.
- Apple CarPlay эсвэл Android Auto-г Miracast® ашиглах үед дахин асаасан нөхцөлд Miracast® зогсоно.
- Тохиргооны дэлгэц дээр зааварчилгааны дууны түвшинг тохируулах боломжтой. Мөн дууны түвшинг [ VOL] товчоор тохируулах боломжтой.
- Нэг төхөөрөмжийн Apple CarPlay эсвэл Android Auto холбогдсон үед өөр төхөөрөмжийн Apple CarPlay эсвэл Android Auto-г ашиглах боломжгүй.
- Apple CarPlay болон Android Auto нь тус бүр Apple болон Google™-н хөгжүүлсэн бүтээгдэхүүн болно. Үйлдлийн систем, техник болон программ хангамж эсвэл Apple CarPlay эсвэл Android Auto-н үзүүлэлтийн өөрчлөлтөөс хамаарч холбогдсон төхөөрөмжийн ажиллагаа болон үйлдэл урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болно.
- Apple CarPlay эсвэл Android Auto-г дэмждэг аппликейшний мэдээллийг эдгээрийн цахим хуудаснаас харна уу.
- Apple CarPlay эсвэл Android Auto-г ашиглах үед байршил, автомашины хурд зэрэг автомашин болон хэрэглэгчийн мэдээллийг эдгээр аппликейшний үзүүлэгч болон үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгчид дамжуулна.
- Аппликейшн татах болон ашиглах нь ашиглах нөхцөлтэй танилцаж хүлээн зөвшөөрснийг илтгэнэ.
- Интернетээр дата дамжуулах нь төлбөртэй байж болно. Дата тарифын талаар та өөрийн үүрэн холбооны оператороос тодруулна уу.
- Аппликейшнээс хамаарч дуу тоглуулах зэрэг зарим функц хязгаарлагдаж болно.
- Аппликейшны функцууд нь урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөж болно. Дэлгэрэнгүйг тухайн хөгжүүлэгч компанийн цахим хуудаснаас харна уу.
- Автомашины навигацийн систем ашиглан маршрутын зааварчилгаа хийгдэж байгаа үед Apple CarPlay эсвэл Android Auto-н газрын зургийн аппликейшнээр шинэ маршрут тохируулсан нөхцөлд навигацийн

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

системийн маршрутын зааварчилгаа зогсоно. Apple CarPlay эсвэл Android Auto-н газрын зургийн аппликейшн ашиглан маршрутын зааварчилгаа хийгдэж байгаа үед автомашины навигацийн систем дээр шинэ маршрут тохируулсан нөхцөлд Apple CarPlay эсвэл Android Auto-н газрын зургийн аппликейшн зогсоно.

- Apple CarPlay-р холбогдсон төхөөрөмж Bluetooth® функц ашиглах боломжгүй.
- Android Auto-р холбогдсон төхөөрөмж гарын оролцоогүй дуудлагаас бусад Bluetooth® функц ашиглах боломжгүй.
- USB холбогчоор холбосон ба USB холбогч салгагдсан үед Apple CarPlay эсвэл Android Auto-н ажиллагаа зогсоно. Аудио гаралт зогсож дэлгэц мультимедиа системийн дэлгэцэнд шилжинэ.

— Холбоотой холбоосууд —

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(X. 95\)](#)

[Аудио систем асаах/унтраах, дууны түвшин тохируулах\(X. 34\)](#)

[iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга\(X. 194\)](#)

[Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга\(X. 198\)](#)

[Android Auto-г тоглуулах үеийн анхааруулга\(X. 202\)](#)

[Тоглуулах үеийн анхааруулга. Miracast®\(X. 210\)](#)

[Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга\(X. 108\)](#)

[Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга\(X. 123\)](#)

[Bluetooth® аудио тоглуулах үеийн анхааруулга\(X. 205\)](#)

Бүртгэгдээгүй ухаалаг утасны Apple CarPlay ашиглах

v1m1649384125526.dita

Мултимедиа системд бүртгэгдээгүй ухаалаг утас холбон Apple CarPlay ашиглах боломжтой. Үйлдлийн дараалал нь бүртгэгдсэн утаснаас хамаарч өөр байна.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- Siri нь АНУ болон бусад улсад бүртгэлтэй Apple Inc-н барааны тэмдэгт болно.

Холбоотой холбоосууд

Бүртгэгдсэн ухаалаг утасны Apple CarPlay ашиглах(X. 134)

USB холболтоор Apple CarPlay ашиглах

pzd1649384125448.dita

Мултимедиа системд USB холбогчоор ухаалаг утас ашиглан Apple CarPlay ашиглах боломжтой.

1 Ухаалаг утасны тохиргооны цэс дээр Siri-г идэвхжүүлнэ.

2 USB портод ухаалаг утас холбоно.

- Apple CarPlay-н үндсэн дэлгэц **дэлгэц** дээр гарна.
- Холбосон ухаалаг утаснаас шалтгаалж анхны дэлгэц рүү шилжихэд 3-6 секунд шаардагдаж болно.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед түүнийг баримтална.

3 Apple CarPlay-г ажиллуулна.

Apple CarPlay-г дэмждэг iPhone аппликейшнийг ажиллуулах боломжтой.



Мултимедиа системийн дэлгэцийг харуулна.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний []-г дарна.



Дэлгэцийг өөр дэлгэцээр солино.

Удаан дарж Siri-г асаана.



МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарж Siri-г эхлүүлнэ. Siri-г цуцлах үед тус товчийг дахин дарна.
- Сэрээх үг [**Wake word**]-г идэвхжүүлсэн Apple CarPlay-г холбосон үед Siri-д сэрээх үг хэлж эхлүүлнэ.*¹
Siri-н сэрээх үгний функц нь зөвхөн Англи хэл дээр тохируулсан үед ажиллана. Мөн холбогдсон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.
- USB холболтоор холбон ухаалаг утас бүртгэх үедээ утасгүй холболт (wireless)-н тохиргоо хийсэн нөхцөлд дараагийн удаагаас утасгүй холболтоор холболт хийх боломж бүрдэнэ.

— Холбоотой холбоосууд —

[USB портод холбох\(Х. 39\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)

[Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх\(Х. 72\)](#)

Утасгүй холболтоор Apple CarPlay ашиглах

tvm1649384125495.dita

Автомашины утасгүй холболтоор (wireless) Apple CarPlay-г мультимедиа системд холбон ашиглах боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- 1 **Ухаалаг утасны тохиргоо дээрээс Siri-г идэвхжүүлнэ.**
- 2 **Үндсэн цэсний -г дарна.**
- 3 **Дэд цэсний [Bluetooth & Devices]-г дарна.**
 - Мультимедиа системд ухаалаг утас бүртгэгдээгүй үед төхөөрөмж хайх дэлгэц гарч ирнэ. 5-р үйлдэл рүү шилжинэ.
- 4 **[Add another device]-г дарна.**
- 5 **[If not found]-г дарна.**
- 6 **Бүртгэх ухаалаг утсаа сонгоно.**
- 7 **Дэлгэцний болон гар утасны PIN дугаар таарч байгааг шалгаад [OK]-г дарна.**
 - Дэлгэцний зааварчилгааны дагуу үйлдэл хийнэ.
- 8 **Хэрэв Apple CarPlay-н тохиргоо дэлгэцээр гарсан нөхцөлд [Yes]-г дарна.**
 - Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарч ирнэ.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- Тухайн холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.
- Үйлдэл амжилттай болоогүйг илтгэсэн дэлгэц гарсан үед үйлдлийн зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед үйлдлийн зааварчилгааг дагана.

9 Apple CarPlay-г удирдана.

iPhone-н Apple CarPlay-г дэмждэг аппликейшн дээр даран ашиглах боломжтой.



Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний []-г дарна.



Дэлгэцийг солино.

Товшоод удаан дарх үед Siri идэвхжинэ.



МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарж Siri-г асаана. Siri-г цуцлах үед товчийг дахин дарна.
- Apple CarPlay холбогдсон ба [Wake word]-г идэвхжүүлсэн үед идэвхжүүлэх үг хэлж Siri-г идэвхжүүлнэ.^{*2}
Siri-н идэвхжүүлэх үгний функцийг зөвхөн Англи хэл дээр тохируулсан үед ашиглах боломжтой. Мөн холбогдсон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.

Холбоотой холбоосууд

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)

[Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх\(Х. 72\)](#)

^{*2}:Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Бүртгэгдсэн ухаалаг утасны Apple CarPlay ашиглах

zyn1649384125479.dita

Бүртгэгдсэн ухаалаг утсыг мултимедиа системд холбон Apple CarPlay ашиглах боломжтой. Бүртгэгдээгүй ухаалаг утаснаас хийх үйлдэл өөрчлөгддөг.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

— Холбоотой холбоосууд —

[Бүртгэгдээгүй ухаалаг утасны Apple CarPlay ашиглах\(Х. 131\)](#)

USB холболтоор Apple CarPlay ашиглах

f1q1649384125464.dita

Мултимедиа системд USB холбогчоор ухаалаг утас ашиглан Apple CarPlay ашиглах боломжтой.

● Мултимедиа системд ухаалаг утас холбогдсон байгааг нягтлана.

1 Ухаалаг утасны тохиргооны цэс дээр Siri-г идэвхжүүлнэ.

2 USB портод ухаалаг утас холбоно.

- Apple CarPlay-н үндсэн дэлгэц **дэлгэц** дээр гарна.
- Холбосон ухаалаг утаснаас шалтгаалж анхны дэлгэц рүү шилжихэд 3-6 секунд шаардагдаж болно.
- Үйлдэл алдаатай болсон үед дэлгэцийн зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед түүнийг баримтална.
- Apple CarPlay-н үндсэн дэлгэц дараагүй үед дараах зүйлсийг шалгана.
 - Үндсэн цэсний []-г дарна.
 - Үндсэн дэлгэц дээр [] гараагүй үед Apple CarPlay-р ашиглах ухаалаг утас сонгоод [Use for Apple CarPlay]-г ON-д тохируулна.
 - Дээрх 2 зүйлийг шалгаад [Connect]-г Bluetooth® тохиргоон дээр сонгож ухаалаг утас холбоно.

3 Apple CarPlay-г ажиллуулна.

Apple CarPlay-г дэмждэг iPhone аппликейшнийг ажиллуулах боломжтой.



Мултимедиа системийн дэлгэцийг харуулна.



Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний []-г дарна.



Дэлгэцийг өөр дэлгэцээр солино.

Удаан дарж Siri-г асаана.

МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарж Siri-г эхлүүлнэ. Siri-г цуцлах үед тус товчийг дахин дарна.
- Сэрээх үг [**Wake word**]-г идэвхжүүлсэн Apple CarPlay-г холбосон үед Siri-д сэрээх үг хэлж эхлүүлнэ.*¹
Siri-н сэрээх үгний функц нь зөвхөн Англи хэл дээр тохируулсан үед ажиллана. Мөн холбогдсон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.

Холбоотой холбоосууд

[USB портод холбох\(Х. 39\)](#)

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 103\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)

[Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх\(Х. 72\)](#)

Утасгүй холболтоор Apple CarPlay ашиглах

fcz1649384125510.dita

Автомашины утасгүй холболтоор (wireless) Apple CarPlay-г мультимедиа системд холбон ашиглах боломжтой.

- Мультимедиа системд утас холбогдсон байгааг нягтлана.

- 1 **Ухаалаг утасны тохиргоо дээрээс Siri-г идэвхжүүлнэ.**
- 2 **Үндсэн цэсний** []-г дарна.
- 3 **Дэд цэснээс [Bluetooth & Devices]-г дарна.**
- 4 **Apple CarPlay-р ашиглах ухаалаг утас сонгоод [Use for Apple CarPlay]-г ON болгож тохируулна.**
- 5 **Ухаалаг утас холбогдоогүй үед [Connect]-г дарж холбоно.**
 - Apple CarPlay-н үндсэн дэлгэц гарч ирнэ.
 - Тухайн холбосон ухаалаг утаснаас хамаарч анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секунд шаардагдаж болно.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- Үйлдэл амжилттай болоогүйг илтгэсэн дэлгэц гарсан үед үйлдлийн зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед үйлдлийн зааварчилгааг дагана.
- Apple CarPlay-н үндсэн дэлгэц гараагүй үед үндсэн цэсний []-г дарна.

6 Apple CarPlay-г удирдана.

iPhone-н Apple CarPlay-г дэмждэг аппликейшн дээр даран ашиглах боломжтой.



Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Apple CarPlay-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний []-г дарна.



Дэлгэцийг солино.

Товшоод удаан дарах үед Siri идэвхжинэ.



МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбогдсон үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарж Siri-г асаана. Siri-г цуцлах үед товчийг дахин дарна.
- Apple CarPlay холбогдсон ба [Wake word]-г идэвхжүүлсэн үед идэвхжүүлэх үг хэлж Siri-г идэвхжүүлнэ.*²
Siri-н идэвхжүүлэх үгний функцийг зөвхөн Англи хэл дээр тохируулсан үед ашиглах боломжтой. Мөн холбогдсон төхөөрөмж iOS-н 14.3-с хойших хувилбартай байх шаардлагатай.

Холбоотой холбоосууд

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 103\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)

[Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх\(Х. 72\)](#)

*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Android Auto ашиглах

axf1656064973761.dita

3

Ухаалаг утас, харилцаа холбооны төхөрөмж холбох

Android Auto-г мултимедиа системд USB холбогчоор ухаалаг утас холбон ашиглах боломжтой.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

1 Холбосон ухаалаг утсанд Android Auto аппликейшн суулгасан байгааг нягтлана.

2 USB портод ухаалаг утас холбоно.

- Android Auto-н үндсэн дэлгэц гарч ирнэ.
- Холбосон ухаалаг утаснаас хамаарч дэлгэц анхны дэлгэцэнд буцах хүртэл 3-6 секундын хугацаа шаардагдаж болно.
- Үйлдэл амжилттай болоогүйг заасан мэдэгдэл гарсан үед зааварчилгааг дагана.
- Ухаалаг утасны дэлгэц дээр зааварчилгаа гарсан үед дагана.
- Android Auto-н үндсэн дэлгэц гарч ирээгүй үед дараах зүйлсийг шалгана.
 - Үндсэн цэсний []-г дарна.
 - Үндсэн дэлгэц дээр [] гараагүй үед Android Auto-р ашиглах ухаалаг утас сонгоод [Use for Android Auto]-г ON болгоно.
 - Дээрх 2 зүйлийг шалгаад [Connect]-г Bluetooth® тохиргоон дээрээс дарж ухаалаг утас холбоно.

3 Android Auto-г ажиллуулна.

Android Auto-г дэмждэг аппликейшн дээр дарж ашиглах боломжтой.




Мултимедиа системийн дэлгэц гаргана.

Android Auto-н үндсэн дэлгэцийг дахин гаргах үед үндсэн цэсний

[]-г дарна.



Google Assistant™-г эхлүүлнэ.



МЭДЭЭЛЭЛ

Android Auto холбогдох үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарж Google Assistant™-г эхлүүлнэ. Цуцлах үед тус товчийг дахин дарна.

— Холбоотой холбоосууд —

[USB портод холбох\(Х. 39\)](#)

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 103\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)

Apple CarPlay эсвэл Android Auto доголдсон үед

knz1649830594000.dita

Apple CarPlay эсвэл Android Auto доголдсон үед дараах хүснэгтийг шалгана.

Шинж тэмдэг	Шийдэл
Apple CarPlay эсвэл Android Auto асахгүй байх.	Холбосон ухаалаг утас Apple CarPlay эсвэл Android Auto-г дэмждэг эсэхийг нягтлана. Ухаалаг утсан дээр Apple CarPlay эсвэл Android Auto-г идэвхжүүлсэн байгааг нягтлана. Холбосон ухаалаг утсан дээр Android Auto аппликейшн суулгасан байгааг нягтлана. Дэлгэрэнгүйг дараах холбоосноос нягтлана уу. ● Apple CarPlay: https://www.apple.com/ios/carplay/ ● Android Auto: https://www.android.com/auto/
	Бүртгэгдсэн ухаалаг утасны Apple CarPlay эсвэл Android Auto функцийг мултимедиа систем дээр идэвхжүүлсэн байгааг нягтлана.
	USB холбогчоор холбосон үед USB холбогч ухаалаг утас болон USB портод бүрэн залгагдсан байгааг нягтлана. Ухаалаг утсыг USB портод шууд холбоно. USB салаалагч ашиглаж болохгүй. Apple CarPlay эсвэл Android Auto холболтод зориулсан зөв USB порт ашиглаж байгааг нягтлана. Зөвхөн цэнэглэх зориулалттай USB портыг ухаалаг утасны аппликейшнд ашиглах боломжгүй. Apple CarPlay-н утасгүй холболт нь утасгүй цэнэглэх төхөөрөмж ашиглагдаж байгаа үед холбогдохгүй. Apple CarPlay-н утасгүй холболт ашиглах үед дараах зүйлсийг шалгана ● Ухаалаг утас мултимедиа системд Bluetooth®-р холбогдох боломжтойг нягтлана. ● Ухаалаг утас Wi-Fi® ашиглах боломжтойг нягтлана.

3-3. Apple CarPlay болон Android Auto ашиглах

Шинж тэмдэг	Шийдэл
Apple CarPlay эсвэл Android Auto асахгүй байх.	Apple CarPlay: Apple-с гэрчилгээтэй холбогч ашиглаж байгааг нягтлана. Siri идэвхжсэн байгааг нягтлана. Зөвхөн цэнэглэх зориулалттай USB холбогчоор ухаалаг утас холбох боломжгүй. Дата дамжуулах хүчин чадалтай холбогч ашиглана. Зарим холбогч дата дамжуулдаггүй. Ашиглахад тохиромжтой USB холбогчийн үзүүлэлтийг жагсаав. ● iPhone: Албан ёсны Apple USB холбогч эсвэл Apple MFi гэрчилгээтэй USB холбогч ашиглана. ● Android: 1.8 м (6 фут) хүртэлх урттай холбогч ашиглах ба уртасгагч ашиглахгүй. ● USB логотой  холбогч ашиглана. Өмнө нь хэвийн холбогдож байсан ухаалаг утас холбогдохгүй үед USB холбогч солиход асуудал ихэвчлэн шийдэгддэг. Дээрх бүх нөхцөлүүдийг шалгаад Apple CarPlay эсвэл Android Auto-г дахин холбоно.
Apple CarPlay/Android Auto холболт үүсч видео тоглуулж байгаа үед дүрс гарахгүй ба системээс зөвхөн аудио дуу гарна.	Систем нь Apple CarPlay/Android Auto-р видео гаргах зориулалтгүй тул энэ нь доголдол биш болно.
Аудио дуу гарахгүй байх.	Мултимедиа системийн дууг хаасан эсвэл бага түвшинд тохируулсан. Дууны түвшинг нэмнэ. Apple-н дэмждэг аппликейшныг Apple CarPlay-д, Google™-н дэмждэг аппликейшныг Android Auto-д ашиглана. Веб хөтчөөс шууд дуу тоглуулах нь муу чанартай аудио дуугаралт үүсгэнэ.
Дэлгэц анивчиж шуугиан үүсэх.	Мултимедиа системд холбосон USB холбогч гэмтсэн эсэхийг шалгана. USB холбогчид дотоод гэмтэл байгаа эсэхийг компьютер зэрэг өөр төхөөрөмжинд ухаалаг утас холбон цэнэг шахаж байгаа эсэх, ухаалаг утсыг таньж байгаа эсэхээр шалгана.

Шинж тэмдэг	Шийдэл
Дэлгэц анивчиж шуугиан үүсэх.	USB холбогчийг өөрөөр солино.
Apple CarPlay газрын зургийн аппликейшн ашиглах үед газрын зураг томрохгүй, жижигрэхгүй байх.	Apple CarPlay газрын зургийн аппликейшн 2 хуруугаараа удирдах үйлдлийг дэмждэггүй.
Apple CarPlay дэлгэцийн голд гарч байгаа ба бүтэн дэлгэцээр гарахгүй байх.	Бүтэн дэлгэц нь iOS Ver. 10-с хойших хувилбар дээр гардаг. iOS-н хувилбараа шинэчилнэ үү.
Apple CarPlay-н дууны апп (Apple Music, Spotify зэрэг) дуу тоглуулах үед Apple CarPlay ⁽¹⁾ -г дэмждэггүй iPhone-н аппликейшн ажиллаж эхлэн мултимедиа системд дуу өгч мултимедиа системийн дууны түвшин өөрчлөгдсөн үед дэмждэггүй аппликейшны дуу хаагдаж анхны дууны апп үргэлжлүүлэн дуугарна.	Энэ нь мултимедиа системийн техникийн шаардлагын дагуу үйлдэл бөгөөд доголдол биш болно.
Мултимедиа систем дээр аудио тоглуулах (FM зэрэг) үед Apple CarPlay-г дэмждэггүй аппликейшнээс дуу гарсан үед мултимедиа систем анхны аудио эх үүсвэр лүү буцахгүй.	Энэ нь мултимедиа системийн техникийн шаардлагын дагуу үйлдэл бөгөөд доголдол биш болно. Аудио эх үүсвэрийг гараар солино. Мөн Apple CarPlay ⁽¹⁾ -г дэмждэггүй аппликейшн ашиглахаас татгалзах нь зүйтэй. Зарим навигацийн аппликейшн iOS 12 үйлдлийн системээс эхлэн Apple CarPlay-г дэмждэг. iOS болон аппликейшнийг сүүлийн хувилбарт шинэчилнэ.
Apple CarPlay-г ашиглах үед маршрутын зааварчилгааны сум болон эргэлт заах навигаци нь мэдээллийн дэлгэц дээр гарахгүй.	Тус функц нь мэдээллийн дэлгэцний техник үзүүлэлт эсвэл ашиглаж буй газрын зургийн аппликейшнээс хамаарч дэлгэцээр гарахгүй байж болно.
Android Auto-г ашиглах үед маршрутын зааварчилгааны сум мэдээллийн дэлгэц дээр гарахгүй.	

3-3. Apple CarPlay болон Android Auto ашиглах

Шинж тэмдэг	Шийдэл
Android Auto-г ашиглах үед эргэлт заах навигаци нь мэдээллийн дэлгэц дээр гарахгүй.	Тус функцаар эдгээр зүйлсийг дэлгэц дээр гаргах боломжгүй тул энэ нь доголдол биш болно.
Android Auto-г ашиглах үед гарын оролцоогүй дуудлагын дуу автомашины спикерээс гарахгүй.	Яриаг дуусгана. Ухаалаг утаснаас USB холбогчийг салгаж гарын оролцоогүй дуудлагыг ашиглаж үзнэ. Одоо аудио сонсогдож байгаа эсэхийг нягтлана.
	Мултимедиа системийн дууны түвшинг нэмээд гарын оролцоогүй дуудлага сонсогдох эсэхийг нягтлана. Өөр ухаалаг утас ашиглаж үзнэ. Одоо аудио сонсогдож байгаа эсэхийг нягтлана.

(1) "Apple CarPlay"-г дэмждэггүй аппликейшн нь iPhone-д суулгасан боловч Apple CarPlay-н дэлгэц дээр гардаггүй.

Холбоотой холбоосууд

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 103\)](#)

[USB портод холбох\(Х. 39\)](#)

[Аудио систем асаах/унтраах, дууны түвшин тохируулах\(Х. 34\)](#)

[Bluetooth® төхөөрөмжтэй холбох\(Х. 117\)](#)

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

[Мэдрэгчтэй дэлгэц ашиглах үед анхаарах зүйлс\(Х. 23\)](#)

4-1. Навигацийн систем

Wi-Fi® ашиглан авах боломжтой газрын зургийн мэдээлэл	144
Холбогдсон навигаци	146
Connected навигаци (системд суурилсан навигацитай)	147

4-2. Газрын зургийн мэдээлэл

Тухайн газрын мэдээлэл харуулах	148
Газрын зургийн сонголтын дэлгэц	149
POI тэмдэг гаргах	150
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо	151
Хурдны замын горим	155

4-3. Очих газар хайх

Очих газар хайх	156
Очих газраа хайх дэлгэц ..	157
Хайлтын үр дүнгийн дэлгэц	160
Замын цэг нэмэх	161
Ухаалаг утаснаасаа очих газар тохируулах	162

4-4. Очих газрын тохиргоо

Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц	164
Маршрут зааварчилгааны демо үзэх	165
Маршрутын сонголтыг өөрчлөх	166
Маршрут өөрчлөх	167

Маршрут дээр дайрч өнгөрөх цэг тохируулах .	168
--	-----

Замын цэг засварлах	169
---------------------------	-----

4-5. Маршрутын зааварчилгаа

Маршрут заах дэлгэц	170
Замын эгнээний дэлгэц	171
Маршрут дахин хайх	173
Ердийн дуут зааварчилгаа	174

4-6. Газрын зураг шинэчлэх

Газрын зургийн мэдээллийн сан ба хамрах хүрээ	175
---	-----

Wi-Fi® ашиглан авах боломжтой газрын зургийн мэдээлэл

xuo1649763096385.dita

- Wi-Fi® ашигласан сервис (цаашид "сервис")-г мултимедиа системийг худалдан авч угсарсан өдрөөс эхлэх хүчинтэй хугацааны*¹ дотор үнэгүй ашиглах боломжтой.
*¹: Хүчинтэй хугацааг навигацийн системийн тохиргооны дэлгэцээс харах боломжтой. Хүчинтэй хугацаа дууссаны дараа үргэлжлүүлэн ашиглах үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Тус үйлчилгээ нь гуравдагч талын дараах үйлчилгээг хамрана.
 - Замын түгжрэлийн мэдээлэл: Автомашин сервист холбогдох үед байрлалын мэдээлэл TomTom Global Content B.V. (цаашид [TomTom]) руу илгээгдэнэ. Тус мэдээлэл дээр үндэслэн TomTom нь мултимедиа систем дээр гарах замын түгжрэлийн мэдээлэл зэрэг онлайн үйлчилгээг үзүүлнэ.
 - Байгууламжийн мэдээлэл: Хайсан байгууламжийн нэр болон байрлалын нэр HERE Global B.V. (цаашид [HERE]) руу илгээгдэнэ. Тус мэдээлэл дээр үндэслэн HERE нь мултимедиа систем дээр гарах байгууламж болон ойр орчмын мэдээлэл зэрэг онлайн үйлчилгээг үзүүлнэ.
- Эдгээр үйлчилгээг ашиглах үед мултимедиа системийг Wi-Fi®-д холбоод дэлгэцээр гарах үйлчилгээ үзүүлэгч тус бүрийн*² анхааруулга, нууцлалын бодлого, үйлчилгээний нөхцөлийг шалгаад [Agree]-г дарна.
*²: Үйлчилгээ үзүүлэгч тус бүрийн үйлчилгээний нөхцөлийг дараах холбоосноос авна уу.

TomTom	https://www.tomtom.com/en_gb/legal/eula-automotive/ https://www.tomtom.com/en_us/privacy/
HERE	https://legal.here.com/terms/ https://legal.here.com/privacy/policy

- Тоёота Мотор Корпорац болон холбоотой байгууллагууд нь эдгээр үйлчилгээний мэдээллийн чанар, нарийвчлал, үйлчилгээтэй холбоотой аливаа баталгаа гаргахгүй ба үйлчилгээнээс шалтгаалан хэрэглэгчид учирсан хохирол, хоцрогдол болон бусад зүйлийн талаар аливаа хуулийн хариуцлага хүлээхгүй. Тус мултимедиа системийн мэдээллийг урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөх, зогсоох, цуцлаж болно.

Холбоотой холбоосууд

[Бусад тохиргоо\(Х. 89\)](#)

Холбогдсон навигаци*1

cxz1649763096150.dita

Автомашинд навигацийн газрын зургийн дата байдаггүй тул тус үйлчилгээ нь LEXUS Connect төвтэй холбогдох боломжгүй газарт түр хугацаанд хадгалсан газрын зургийн мэдээллийг харуулдаг. Маршрут хайх зэрэг навигацийн функц нь сүлжээ муутай орчинд ажиллахгүй байж болно.

 МЭДЭЭЛЭЛ

- LEXUS Connect төвийн үйлчилгээний эрхийг идэвхжүүлээгүй үед навигацийн функц ажиллахгүй ба зөвхөн луужингийн дэлгэц гарна.
- Автомашинаас нэг талдаа 80 км (50 миль) хэмжээтэй квадрат талбай болон маршрутын дагуу замуудын (очих газар тохируулсан үед) мэдээллийг түр хадгалдаг. Газрын зургийн мэдээлэл хадгалагдсанаас бусад газарт сүлжээ муутай үед навигацийн функцийг ажиллагаа хязгаарлагдаж навигацийн газрын зураг харагдахгүй байж болно.

*1 :Зөвхөн 9.8 инчийн дэлгэцтэй

Connected навигаци (системд суурилсан навигацитай)*1

otq1649763096431.dita

Автомашины төхөөрөмж нь системд суурилсан навигацитай ба тус үйлчилгээг Toyota Service Center-тэй холбогдох боломжгүй үед ашиглан навигацийн газрын зураг, маршрут хайлт хийх боломжтой. Автомашин буцаж сүлжээ сайтай орчинд орсон үед LEXUS Connect Center-тэй автоматаар холбогдож тус төвөөс навигацийн мэдээлэл авах, хайлт хийх боломжтой болдог.

МЭДЭЭЛЭЛ

- Очих газрын тохиргоо хийсэн үед LEXUS Connect Center-с маршрутын хайлт автоматаар хийгддэг. LEXUS Connect Center-с илгээсэн маршрутын мэдээллийг [] дээр гаргана.
- LEXUS Connect Center-н үйлчилгээнд хамрагдсан тухай гэрээний мэдээлэл оруулаагүй үед автомашины навигацийн системийн газрын зураг, маршрутын зааварчилгаа ашиглах боломжтой.

*1 :Зөвхөн 14 инчийн дэлгэц

Тухайн газрын мэдээлэл харуулах


Тухайн газрын мэдээлэл эсвэл POI-г газрын зураг дээрээс шалгах боломжтой.

1 POI эсвэл тухайн цэгийг удаан дарна.

Тухайн цэг сонгогдсон үед хаяг дэлгэцээр гарна. Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх үед []-г дарна.

2 Хүссэн зүйлээ сонгоно.

- A** Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх үед дарна.
- B** Тухайн сонгосон цэгийн дэлгэрэнгүй хаяг гаргана.
- C** Тухайн POI-д бүртгэгдсэн дугаар луу дуудлага хийх үед дарна.
- D** Тухайн цэг дээр хэд хэдэн POI байгаа үед POI-н жагсаалт гарна.



POI дарж дэлгэцээр мэдээлэл гаргана. Дэлгэцийн мэдээллийг [] эсвэл []-г дарж солих боломжтой.

- E** Тухайн сонгосон цэгийг дарж очих газраар тохируулан маршрутын зааварчилгааг эхлүүлнэ.
- F** Тухайн сонгосон цэгийг дарж очих газраар тохируулан маршрутын бүтэн газрын зургийг эхлүүлнэ. Очих газрыг өмнө нь тохируулсан үед замын цэгээр очих газрыг нэмэх боломжтой.

Газрын зургийн сонголтын дэлгэц

kzk1649763096306.dita

POI тэмдэг, замын хөдөлгөөний мэдээлэл зэрэг газрын зураг дээр гарах мэдээллийг тохируулах боломжтой.


1 Газрын зургийн дэлгэцний

[***]-г дарна.



2 [Points of interest] эсвэл [Display map]-г дарна.

- A Дэлгэц дээр гарах POI-г тохируулах боломжтой.
- B Газрын зураг дээр гарах мэдээллийг тохируулах боломжтой.



Холбоотой холбоосууд

POI тэмдэг гаргах(X. 150)

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо(X. 151)


POI тэмдэг гаргах

ygl1649763096228.dita

Ресторан зэрэг POI тэмдгийг газрын зураг дээр гаргах боломжтой.

- 1 Газрын зургийн дэлгэцний [...]-г дарна.
- 2 [Points of interest]-г дарна.
- 3 Дэлгэц дээр гаргах POI-г дарна.

Дэлгэц дээр гарснаас өөр төрлийн POI тохируулах үед [Edit POI]-г дарна.



МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн мэдээлэлд ороогүй POI-г гаргах боломжгүй.
- Газрын зургийн масштаб 1км (0.6миль)-с давсан үед POI гарахгүй.
- Одоогийн байршлаас 10 км (6 миль) радиус доторх POI [▲], эсвэл [●]-г гаргах боломжтой (200 хүртэлх POI).
- Газрын зургийн масштаб 1км (0.6миль)-с бага ба дэлгэцээр гаргах боломжтой POI-ний тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үед дэлгэц хялбар дэлгэцэнд (замыг илүү хялбар харагдуулах үүднээс) шилжинэ.
- Ойр байрлах POI-г навигацийн дэлгэрэнгүй тохиргооны дэлгэц дээр мөн тохируулах боломжтой.

Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 81)

Дэлгэцээр гарсан POI тэмдэгийн тохиргоо

lki1649763096635.dita

Жолоодлогын үед өөрчлөх боломжтой сонголтууд хязгаарлагддаг.

- 1 Газрын зургийн дэлгэцний [...]-г дарна.
- 2 [Points of interest]-г дарна.
- 3 [Edit POI]-г дарна.
- 4 Өөрчлөх бүртгэлтэй POI-г дарна.
- 5 Шинэ POI бүртгэнэ.

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо

nwa1649763096260.dita

Газрын зургийн дэлгэц дээр замын хөдөлгөөний мэдээлэл зэргийг гаргах боломжтой.

1 Газрын зургийн дэлгэцний [***]-г дарна.

2 [Display map]-г дарна.

- A** Газрын зургийн мэдээлэл харуулах, нуух тохиргоог хийх үед товшино.*1
- B** Ойр байрлах гудамжны зогсоолын мэдээлэл харуулах, нуух тохиргоог хийх үед товшино.*1
- C** Хурдны замын гарцыг дэлгэц дээр харуулах, нуух тохиргоог хийх үед товшино.
- D** Явсан маршрутыг дэлгэц дээр харуулах, нуух тохиргоог хийх үед товшино.
Нуух тохиргоог хийсэн үед хадгалагдсан мэдээллийг устгах эсэхийг нягтлах дэлгэц гарна.
- E** Хурдны камерны байршлыг дэлгэцээр харуулах, нуух тохиргоог хийнэ.*1*2
- F** Хэвийн газрын зураг, луужин, цаг агаарын газрын зургуудад солих үед дарна.*1



— Холбоотой холбоосууд —

[Гудамжны авто зогсоол\(Х. 151\)](#)

[Явсан маршрутыг харуулах\(Х. 152\)](#)

[Хурдны камер\(Х. 152\)](#)

[Замын хөдөлгөөний мэдээлэл\(Х. 153\)](#)

Гудамжны авто зогсоол*1


nac1649763096166.dita

Хэрэв [On street parking]-г газрын зургийн дэлгэцийн тохиргоо дээр идэвхжүүлсэн үед ойр байрлах гудамжны авто зогсоол дэлгэц дээр гарна. Идэвхжүүлээгүй үед очих газарт ойр байрлах гудамжны авто зогсоол дэлгэц дээр гарна.

4-2. Газрын зургийн мэдээлэл

Газрын зургийн дэлгэцний [P]-г дарна.

Газрын зурган дээр гудамжны авто зогсоол гарна. Зогсоол зайтай эсэхээс хамаарч өнгө өөрчлөгдөнө.



- 1/5,000-с дээш масштабтай үед (дэлгэцийн нэгж 50 м (150 фут)-с их) гудамжны авто зогсоол дэлгэц дээр гарахгүй.

Явсан маршрутыг харуулах

cao1649763096135.dita

1000 км (600 миль) орчим явсан маршрутыг хадгалж дэлгэцээр харуулах боломжтой.

- 1 Газрын зургийн дэлгэцний [***]-г дарна.
- 2 [Display map]-г дарна.
- 3 [Route trace]-г дарна.

МЭДЭЭЛЭЛ

- Хадгалагдсан туулсан зам хэмжээнээс давсан үед хуучин явсан замын мэдээлэл устгагдаж шинэ маршрут хадгалагдана.
- Явсан маршрутыг газрын зургийн 1/2,500 ба 1/5,120,000 масштабаар харуулах боломжтой.

Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо(X. 151)

Хурдны камер

bsc1649763096353.dita

Хурдны камерыг газрын зурган дээр тэмдгээр харуулах боломжтой. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

- A** Газрын зураг дээрх хурдны камерны байрлал.
- B** Хурдны камерны мэдээлэл болон камер хүртэлх зайг харуулна.



МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн масштабаас хамаарч дээрх мэдээлэл гарна.
- Газрын зургийн мэдээлэл байгаа эсэхээс хамаарч дээрх мэдээлэл гарна.
- Дэлгэцээр гарч буй дээрх мэдээллийг унтраах боломжтой.
- Контентийн нөхцөлөөс хамаарч камерны бодит байрлал гарахгүй байж болно.

Холбоотой холбоосууд

Зааварчилгааны тохиргоо(X. 87)

Замын хөдөлгөөний мэдээлэл*1

rih1649763096588.dita

Замын хөдөлгөөний мэдээллийг IP-Traffic-р дамжуулан авч дэлгэц дээр гаргах боломжтой.

Тус функцийг ашиглах үед LEXUS Connect Center-н ашиглалтын гэрээ, эсвэл Wi-Fi® холболттой байх шаардлагатай.

1 Газрын зургын дэлгэцийн []-г дарна.

2 [Display map]-г дарна.

3 [Traffic]-г дарна.


Газрын зургын дэлгэц дээр замын хөдөлгөөний мэдээлэл гарна.

- Зам засвар, авто осол зэрэг мэдээллийг тэмдгээр илэрхийлнэ.
- Замын хөдөлгөөний чиглэлийг сумаар заана. Хурдаас хамаарч сумны өнгө өөрчлөгдөнө.



Зам тээврийн ослын тэмдгийг дарсан үед тухайн ослын дэлгэрэнгүй мэдээлэл дэлгэцээр гарна.

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.



Холбоотой холбоосууд


[Wi-Fi® сүлжээнд холбох\(X. 123\)](#)

Хурдны замын горим

hbg1649763096541.dita

Хурдны зам эсвэл экспресс замд орсон үед дэлгэц автоматаар хурдны замын горимд шилжинэ.

- A** Одоогийн байрлалаас ямар зайтайг харуулна.
- B** Байгууламжийн 8 хүртэлх POI-г харуулна.
 - 8-с олон POI байгаа үед дэлгэцээр гараагүй POI байгааг илтгэх тэмдэг гарна.
- C** Дэлгэцээр гарах сегментийг өөрчилсөн үед одоо явж байгаа газрын зургийн сегмент рүү буцах үед дарна.



Очих газар хайх

Очих газар хайх дэлгэц дээр очих газар хайх, тохируулах боломжтой.

- 1 Газрын зургийн дэлгэцний [🔍]-г дарна.
- 2 Очих газар хайх дэлгэц гарч ирнэ. Хайх аргаа сонгоно.



- 3 Хайлтын үр дүн дэлгэцээр гарч ирнэ. Жагсаалтаас очих газраа сонгон тохируулна.

- Өөр очих газрыг одоо сонгосон байгаа үед **[New destination]** (шинэ очих газар сонгох) эсвэл **[Add to route]**-г дарна.
- Серверт холбогдсон навигаци ашиглах үед үүлэн хадгалах сан дахь агуулгаар мөн очих газрыг хайж болно.

Холбоотой холбоосууд


[Замын цэг засварлах\(Х. 169\)](#)

[Үсэг шивэх гар ашиглан мэдээлэл хайх\(Х. 49\)](#)

Очих газраа хайх дэлгэц

spv1649763096556.dita

- A** Байршлын нэр, хаяг эсвэл утасны дугаараар хайна.
- B** Текстийн курсорыг шилжүүлнэ.
- C** Тогтмол очдог байршилд бүртгэсэн цэгүүдийн газрыг зургийг гаргах үед дарна. Тогтмол очдог байршилд очих газруудаа бүртгэсэн үед зөвхөн ашиглах боломжтой.
- D** Очих газрын түүхэнд байгаа цэгүүдийн газрын зургийг гаргах үед дарна (өмнө нь очих газраар тохируулсан байршлууд). Очих газрын түүх байгаа үед зөвхөн ашиглах боломжтой.
- E** Ухаалаг утаснаас урьдчилан илгээсэн жолоодлогын төлөвлөгөөнд заасан очих газруудын газрын зургийг гаргах үед дарна.*1
- F** Өөрийн гэрт хүрэх маршрутыг хайж эхлэнэ.
- Өөрийн гэрийн байршлыг бүртгээгүй үед [🏠]-г даран бүртгэх боломжтой.
- G** Очих газрын нэрийг дарсан үед бүтэн маршрутын газрын зураг дэлгэцээр гарна. Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [Go]-г дарна.



Холбоотой холбоосууд

Тэмдэгт оруулан хайх(Х. 157)

Очих газрын түүхээс хайх(Х. 159)

Жолоодлогын төлөвлөгөөгөөр хайх(Х. 159)

Өөрийн гэрээ очих газраар тохируулах(Х. 158)

Тогтмол ашигладаг хаягнаас очих газар сонгох(Х. 158)

Тэмдэгт оруулан хайх

xdm1649763096681.dita

Байршлын нэр, хаяг, утасны дугаар оруулан очих газрыг хайх боломжтой.

- 1 Газрын зургийн дэлгэцний [🔍]-г дарна.
- 2 [Where to? (POI, Street, Town etc.)]-г дарна.

*1 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

3 Байршлын нэр, хаяг, утасны дугаар зэргийг оруулаад [Go]-г дарна.

- Очих газруудын хувилбаруудыг дэлгэцээр харуулна.
- Хайсан тэмдэгт, өмнөх хайлтын нөхцөл, хайлтын түүх, тогтмол ашигладаг хаяг зэрэг дээр үндэслэн хайлтын санал болгох нөхцөл дэлгэц дээр гарна.
- Үсгийн алдаа зэргээс шалтгаалан тохирох хайлтын үр дүн гараагүй үед санал болгох хайлтыг дэлгэцээр харуулна.
- Хайлтад ашиглах тэмдэгтийн тоо дээд хэмжээнээс давсан үед илүү тэмдэгтийг систем устгана.

— Холбоотой холбоосууд —

[Тоо, үсэг оруулах\(X. 27\)](#)

Гэрийнхээ байрлал тохируулах

nlt1649763096369.dita

- 1 Газрын зургийн дэлгэцний [🔍] -г дарна.
- 2 [🏠] -г дарна.
- 3 Газрын зургийг бүртгэхийг хүссэн байрлалд шилжүүлээд [OK] дарна.

Өөрийн гэрээ очих газраар тохируулах

nrrw1649763096697.dita

- 1 Газрын зургийн дэлгэцний [🔍] -г дарна.
- 2 [🏠] -г дарна.
Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [Start]-г дарна.

— Холбоотой холбоосууд —

[Тогтмол ашигладаг тохиргоо\(X. 90\)](#)

Тогтмол ашигладаг хаягнаас очих газар сонгох

bte1649763096103.dita

- 1 Газрын зургийн дэлгэцний [🔍] -г дарна.
- 2 Тогтмол ашигладаг хаягнаас сонгоно.
Очих газрын нэрийг дарсан үед бүтэн маршрутын газрын зураг гарна.
Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [Go]-г дарна.

МЭДЭЭЛЭЛ

Бүртгэгдсэн тогтмол ашигладаг хаягийг нэр оруулан хайх боломжтой.

Холбоотой холбоосууд

[Тогтмол ашигладаг тохиргоо\(Х. 90\)](#)**Очих газрын түүхээс хайх**

yxl1649763096478.dita

1 Газрын зургийн дэлгэцний [Q]-г дарна.**2 [Recents]-г дарна.****3 Очих газрын түүхээс сонголтоо хийнэ.**

Очих газрын нэр дээр дарсан үед бүтэн маршрут дэлгэцээр гарна.

Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [Go]-г дарна.

Жолоодлогын төлөвлөгөөгөөр хайх

aqi1649763096728.dita

Ухаалаг утсаар жолоодлогын төлөвлөгөөг (очих газар, хөдлөх цаг зэрэг) тохируулсан нөхцөлд автомашинд суух үед навигацийн систем жолоодлогын төлөвлөгөөг мэдэгдэж бүртгэгдсэн жолоодлогын төлөвлөгөөгөөр очих газрыг тохируулах боломжтой.

Тус функцийг ашиглах үед жолоочийн бүртгэл хийсэн байх шаардлагатай.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

1 Газрын зургийн дэлгэцний [Q]-г дарна.**2 [Trips]-г дарна.****3 Сонгох жолоодлогын төлөвлөгөөг дарна.**

Очих газрын нэрийг дарсан үед маршрутын бүтэн газрын зураг гарна.

Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед [Go]-г дарна.

МЭДЭЭЛЭЛ

Автомашиныг очих газраас зайтайгаар зогсоолд байрлуулсан үед навигацийн систем дээр тохируулсан очих газрын мэдээллийг гар утасны навигацийн системд илгээж болно.

Холбоотой холбоосууд


[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(Х. 52\)](#)

Хайлтын үр дүнгийн дэлгэц

vob1649763096572.dita

Очих газар хайх үед хайлтын олон үр дүн гарсан нөхцөлд дэлгэц дээр очих газрын жагсаалт гарна.

- A** Өмнөх дэлгэц рүү буцах үед дарна.
- B** Хайлтад ашигласан тэмдэгтүүдийг харуулна.
- C** Хайлтын нөхцөл гаргах үед дарна.
- D** Хайлтын үр дүнг жагсааж харуулна. Мөн боломжит маршрутуудыг дэлгэцээр харуулна.



- Тухайн байрлал доторх боломжит очих газруудыг харуулна.
- E** Жагсаалтаар гарч буй байршлыг газрын зураг дээр харуулна.

- Газрын зургийг хуруугаар өөр байрлалд шилжүүлээд **[Search this area]**-г дарсан үед очих газрыг тухайн хэсгээс хайна.

Хайлтын нөхцөлүүд

ota1649763096791.dita

Дэлгэцээр гарах мэдээллийн хэмжээ, хайлтын үр дүнгийн дарааллыг өөрчлөж болно.

- 1 **Хайлтын үр дүнгийн дэлгэцний [=]-г дарна.**
- 2 **Хайлтын нөхцөлүүдийг оруулна.**
- 3 **[OK] дарж тохиргооны өөрчлөлтийг дуусгана.**

Замын цэг нэмэх

rsq1649763096275.dita

Очих газрыг тохируулсан байгаа үед шинэ очих газрыг замын цэгээр нэмэх боломжтой.

● **Очих газрыг тохируулсан үедээ очих газрын хайлт хийнэ.**

Очих газар тохируулах оролдлого хийх үед мессеж гарна.

- **[New destination]:** Одоогийн очих газрыг устгаж шинэ очих газарт хүрэх шинэ маршрутыг хайна.
- **[Add to route]:** Сонгосон цэгийг замын цэгээр нэмж очих газар хүртэлх шинэ маршрут хайна.

 МЭДЭЭЛЭЛ

- Газрын зургийн дэлгэцийн дурын цэг дээр даран замын цэгээр нэмэх боломжтой.
- Замын цэгийг оролцуулан 10 хүртэлх очих газар хадгалах боломжтой.
- Хамгийн сүүлд нэмсэн замын цэг нь шинэ очих газраар тохируулагдана. Замын цэгүүдийг засварлах замаар очих газрын дарааллыг өөрчлөх боломжтой.

— **Холбоотой холбоосууд** —

[Очих газар хайх\(Х. 156\)](#)

[Замын цэг засварлах\(Х. 169\)](#)


Ухаалаг утаснаасаа очих газар тохируулах

vwi1649763096713.dita

NaviBridge

jhg1649763096494.dita

NaviBridge* нь навигацийн системийг дэмждэг ухаалаг утасны олон төрлийн аппликейшн дээр түлхүүр үгээр хайсан очих газруудыг навигацийн системд илгээдэг "Send To Car" аппликейшн бөгөөд навигацийн систем дээр тухайн очих газар автоматаар тохируулагдана.



NaviBridge (iOS/Android-д зориулсан)-г үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой.

Татах арга зэрэг мэдээллийн талаар дараах веб хуудаснаас харна уу.

NaviBridge-н харилцагчийн үйлчилгээний веб хуудас : <https://www.navicon.com/navibridge/support>



► Холбох арга:

Холбох арга	iOS төхөөрөмж	Android төхөөрөмж
Bluetooth® (утасгүй)	○	○
USB (утастай)	○	×

► Боломжит функцууд:


Очих газрын тохиргоо	Олон очих газар	Газрын зургийн ажиллагаа	Найзуудтайгаа байршлаа хуваалцах
○	○	×	×

*NaviBridge нь DENSO корпорацид бүртгэлтэй барааны тэмдэгт болно.

Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц

Очих газар тохируулсны дараа бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц гарна. Тус дэлгэц дээр хүссэн маршрутаа сонгох, маршрутын мэдээлэл шалгах боломжтой.

- A** Очих газрын нэр, хаяг харуулна.
- B** Очих газрыг тогтмол очдог газраар бүртгэнэ.
- C** Очих газрын одоогийн цаг агаар харуулна.*¹
- D** Эхлэл цэгээс очих газар хүртэлх зай, хугацаа, очих газарт очих цаг харуулна.



Олон очих газрыг зэрэг тохируулсан үед дэлгэц дээр товшиж очих газар тус бүрийн очих цагийг гаргана.

- E** Маршрутын сонголт гаргана.
- F** Дуут зааварчилгааны дууг хаана.
- G** Очих газрын дэлгэрэнгүй мэдээлэл гаргана.
- H** Өөр маршрут сонгох үед дарна.
- I** Маршрутын зааварчилгааг эхлүүлэх үед дарна. Маршрутын демо зааварчилгааг эхлүүлэх үед удаан дарна.
- J** Одоо зааж буй маршрутаас өөр маршрут сонгох үед дарна.
 - Дараах 3-н маршрутаас сонгоно: санал болгох маршрут, хугацаа богино маршрут болон энгийн замаар (төлбөргүй) түлхүү явах маршрут. Санал болгох маршрут нь анхны тохиргоогоор тохируулагддаг.

Холбоотой холбоосууд

Маршрутын тохиргоо(Х. 84)

Хайлтын үр дүнгийн дэлгэц(Х. 160)

Маршрут зааварчилгааны демо үзэх(Х. 165)

Маршрутын сонголтыг өөрчлөх(Х. 166)

Маршрут өөрчлөх(Х. 167)

Замын цэг засварлах(Х. 169)

*1 : Тус функц нь зөвхөн Connected навигаци ашиглах үед гарч ирнэ. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Маршрут зааварчилгааны демо үзэх

eos1649763096197.dita

Маршрут зааварчилгаа эхлүүлэхээс өмнө маршрут зааварчилгааны демо үзэх боломжтой.

- **Бүтэн маршрутын дэлгэцний [Go]-г удаан дарна.**

Демог дуусгах үед []-г дарах эсвэл жолоодлогыг эхлүүлнэ.

Маршрутын сонголтыг өөрчлөх

phx1649763096447.dita

Төлбөр хураах цэг, хурдны зам зэргийг тойрох байдлаар маршрут хайх нөхцөлийг өөрчлөх боломжтой.


1 Маршрутын бүтэн газрын зургийн дэлгэцний [Route options]-г дарна.

2 Хүссэн нөхцөлөө оруулан тохиргоог өөрчилнө.

A Зарим замыг тойрох/ тойрохгүй тохиргоог өөрчилнө. Тохиргоо хийсний дагуу тойрох замыг оруулалгүйгээр маршрутын зааварчилгаа гарна.

B Туулах цэгүүдийн дарааллыг өөрчлөх үед дарна.

C Маршрут дээр туулах цэг нэмэх, устгах, өөрчлөх үед дарна.



Холбоотой холбоосууд

Маршрут дээр дайрч өнгөрөх цэг тохируулах(X. 168)

Замын цэг засварлах(X. 169)

Маршрут өөрчлөх

deb1649763096291.dita

Олон өөр нөхцөлтэй маршрутын хувилбаруудаас маршрут сонгох боломжтой.

- 1 Газрын зургийн бүтэн маршрутын дэлгэцнээс [Alternative route]-г сонгоно.
- 2 Маршрут сонгоод [OK]-г дарна.

 МЭДЭЭЛЭЛ

- Маршрутын шинэ хувилбар даруй гарна. *1
- Газрын зургийн бүтэн дэлгэц дээр маршрут дарж сонгоно.

*1 : Тус функц зөвхөн Connected навигаци ашиглах үед гарна. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Маршрут дээр дайрч өнгөрөх цэг тохируулах ewt1649763096119.dita

Очих газраа тохируулсны дараа маршрут дээр дайрч өнгөрөх цэг тохируулах боломжтой.

- 1 **Замын цэгийн тохиргооны дэлгэцнээс []-г дарна.**



- 2 **Замын цэгээр нэмэх цэгийг газрын зураг дээр товшоод [OK]-г дарна.**

[]: Тухайн замын цэгийг устгана.

Замын цэг засварлах

qqu1649763096619.dita

Замын цэгийг устгах эсвэл маршрут дахь замын цэгүүдийн дарааллыг өөрчлөх боломжтой.

- 1 **[Move up]** болон **[Move down]**-г дарж замын цэгийн дараалал өөрчлөнө.

[]: Замын цэг устгана.



- 2 **[OK]**-г дарна.

— Холбоотой холбоосууд —

[Очих газар хайх\(X. 156\)](#)

Маршрут заах дэлгэц

Уулзвар, эргэлт зэрэг замын цэгүүд дээр дуу хоолойн болон дүрсэн зааварчилгааг ойлгоход хялбар байдлаар өгч маршрутыг заана.



- A** Одоогийн байрлалаас очих газар хүртэлх зай, шаардагдах хугацааг тооцон харуулна.
Маршрутаас хазайсан үед дэлгэц дээр очих газарт хүрэх цагийг заахгүй. Үүний оронд очих газар хүртэлх шулуун зайг заана.
Газрын зураг дээр маршрутыг бүтнээр харуулах үед дарна.
- B** Дараагийн эргэлт болон чиглэл хүртэлх зайг заана.
Очих газар хүртэлх замын жагсаалтыг гаргах үед дарна.
- C** Очих газар хүртэлх маршрутыг гаргана.
Маршрутын шугамны өнгийг газрын зургийн дэлгэцийн тохиргоогоор өөрчилнө.
- D** Дайрч өнгөрөх эсвэл эргэх хамгийн ойрын уулзварыг заана.
- E** Маршрутын зааварчилгааг дуусгах үед дарна. Хэд хэдэн очих газрын заасан үед **[Delete destination]**-г дарж бүх очих газрыг устган маршрутын зааварчилгааг зогсоох ба **[Delete next destination]**-г дарж зөвхөн дараагийн очих газрыг устгаж маршрутын зааварчилгааг үргэлжүүлнэ.
● Маршрутыг хайх боломжгүй үед дэлгэц дээр мэдээлэл гарна.

Холбоотой холбоосууд

Газрын зургийн дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 81)

Замын эгнээний дэлгэц(Х. 171)

Замын эгнээний дэлгэц

jrx1649763096181.dita


Маршрутын зааварчилгааны үед эргэх, чигээрээ гарах уулзварт ойртох үед уулзварыг дэлгэцээр томоор харуулна.

Уулзварыг томоор харуулах дэлгэц

mhn1649763096650.dita

Уулзварын зааварчилгаа нь эргэх ёстой уулзварт ойртох үед гардаг. Мөн уулзварт орохын өмнө уулзварыг томоор харуулах дэлгэцэнд шилжинэ.

- A** Явсан, эргэсэн замын нэрийг дэлгэцээр харуулна.
- B** Одоогийн байрлалаас ямар зайтайг харуулна.
- C** Уулзварыг томоор харуулах дэлгэцийг хаана.
- D** Зааварчилгаа өгөх цэг хүртэлх зайг харуулна.


 МЭДЭЭЛЭЛ

- Уулзварыг томоор харуулах дэлгэц нь газрын зургийн мэдээлэлгүй уулзвар дээр гарахгүй.
- Уулзварыг томоор харуулах дэлгэц нь бодит уулзвараас өөр байж болно.
- Маршрутын зааварчилгаа эхэлсний даруйд уулзварын зааварчилгаа гарахгүй байж болно.
- Уулзварыг томоор харуулах дэлгэц эрт эсвэл оройтож гарч болно.
- Эргэх ёстой уулзварууд хоорондоо ойр үед дэлгэц уулзваруудыг үргэлжлүүлэн харуулна.
- Уулзварыг томоор харуулах дэлгэц нь эргэх ёстой уулзвар дээр гарна. Эргэхээс өмнөх уулзваруудад уулзварын зааварчилгаа гарахгүй.
- Уулзварыг томоор харуулах дэлгэц болон мэдээллийн дэлгэцээр гарах уулзвар хүртэлх зай өөр байж болно.
- Навигацийн систем болон мэдээллийн дэлгэц дээр гарах уулзварыг томоор харуулах дэлгэцийн заалт өөр байж болно.

Холбоотой холбоосууд

Зааварчилгааны тохиргоо(X. 87)

Томруулсан 3D дэлгэц

ibf1649763096744.dita

Маршрутын зааварчилгааны үед эргэлтийг илүү ойлгомжтой болгох үүднээс томруулсан 3D дэлгэц гарч зам болон уулзварыг томоор харуулна.

МЭДЭЭЛЭЛ

Газрын зургийн мэдээлэл байгаа цэг дээр дэлгэцээр гарна.

Томруулсан дэлгэцийг цуцлах үед

[]-г дарна.



Маршрут дахин хайх

jha1649763096775.dita

Маршрутын зааварчилгааны үед (маршрутаас гажсан байсан ч) маршрут дахин хайх боломжтой.

- 1 Газрын зургийн дэлгэцний [V]-г дарна.



- 2 [Route options] эсвэл [Alternative route]-г дарна.
- 3 Хайх нөхцөлийг дарна.
- 4 [OK]-г дарна.

— Холбоотой холбоосууд —

Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц(Х. 164)

Маршрутын сонголтыг өөрчлөх(Х. 166)

Маршрут өөрчлөх(Х. 167)

Ердийн дуут зааварчилгаа

jum1649763096510.dita

Автомашин эргэлт хийх уулзвар эсвэл цэг рүү ойртох үед навигацийн системийн дуут заавар нь янз бүрийн мессежийг өгөх болно.

МЭДЭЭЛЭЛ

- Дуут зааварчилгаа нь эрт болон хожуу байж болно.
- Хэрэв навигацийн систем одоогийн байрлалыг зөв тодорхойлж чадахгүй бол дуут удирдамжийг зааварчилгаа, томруулсан уулзварын дэлгэц гарахгүй байж болно.

АЮУЛТАЙ

Ялангуяа IPD зам (манай мэдээллийн санд бүрэн дижиталчлаагүй зам) дээр жолоодохдоо замын хөдөлгөөний дүрмийг даган мөрдөж замын нөхцөл байдлыг анхаарна. Маршрутын зааварт нэг чигийн хөдөлгөөн зэрэг шинэчлэгдсэн мэдээлэл байхгүй байж болно.

— Холбоотой холбоосууд —

[Зааварчилгааны тохиргоо\(Х. 87\)](#)

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

Газрын зургийн мэдээллийн сан ба хамрах хүрээ

Хамрах хүрээ болон хуулийн мэдээллийг дэлгэцээр гаргах боломжтой ба газрын зургийн мэдээллийг шинэчилж болно.

■ Газрын зургийн мэдээлэл гаргах

1 Үндсэн цэсний []-г дарна.

2 [Navigation]-г дарна.

3 [Map update]-г дарна.


4 Газрын зургийн мэдээлэл дэлгэцээр гарч байгааг нягтлана.

☐ A Газрын зургийн хамрах хүрээ, хувилбарыг гаргана.

☐ B Газрын зураг шинэчилнэ.

☐ C Хуулийн мэдээллийг гаргана.

Газрын зургийн мэдээлэл шинэчлэх талаар та өөрийн Lexus дилерт хандана уу.



5-1. Радионы ажиллагаа

Радио сонсох	178
DAB сонсох.....	181
Аюулгүйн үүднээс эдгээр функцуудыг автомашин явж байх үед ашиглах боломжгүй.....	184

5-2. Интернет радио

Интернет радио ашиглах	185
------------------------	-----

5-3. USB флашны ажиллагаа

USB флаш тоглуулах үеийн анхааруулга.....	186
USB флашнаас дуу тоглуулах.....	188
USB флашнаас видео файл тоглуулах	191

5-4. iPod/iPhone-н ажиллагаа

iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга.....	194
iPod/iPhone тоглуулах.....	195

5-5. Apple CarPlay-н ажиллагаа

Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга.....	198
Apple CarPlay тоглуулах....	199

5-6. Android Auto-н ажиллагаа

Android Auto-г тоглуулах үеийн анхааруулга.....	202
Android Auto-г тоглуулах..	203

5-7. Bluetooth® аудионы
ажиллагаа

Bluetooth® аудио тоглуулах үеийн анхааруулга.....	205
Bluetooth® аудио тоглуулах.....	207

5-8. Miracast®-н ажиллагаа

Тоглуулах үеийн анхааруулга. Miracast®...	210
Miracast® дэмждэг төхөөрөмж холбох	211
Miracast® тоглуулах.....	212

Радио сонсох

Давтамжаа сонгон радио сонсох боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Стерео дамжуулалт хүлээн авсан үед радио стерео дамжуулалтанд автоматаар шилжинэ.
- Дохио суларсан үед радио сувгийн салаалалтын тоог бууруулж шуугиан үүсэхээс сэргийлнэ. Сигнал хэт сул болсон үед радио стереогоос моно хүлээн авах горимд шилжинэ.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 [AM] эсвэл [FM]-г дарна.
- 4 Шаардлагатай үед радио станц сонгох арга хэлбэрээ сонгоно.

[Presets] : Урьдчилан сануулах товчинд бүртгэсэн радио станцаас сонгоно.

[Station list] : Радио станцийн жагсаалтаас радио станц сонгоно.

[Refresh]*1-г дарж хүлээн авах боломжтой радио станцийг дахин хайна.

[Direct tune] : Давтамжийг тоогоор шууд бичиж оруулан радио станц сонгоно.

- 5 Шаардлагатай үед хүлээн авч буй радиог удирдана.

- Дэлгэцнээс удирдах



[Seek] : [◀] эсвэл [▶]-г дарж одоогийн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой станцийг автоматаар сонгоно.

Удаан дарж давтамж өөрчлөнө. Товчийг суллах үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой станцийг автоматаар сонгоно.

[Scan] : Өндөр давтамж руу автоматаар радио станц хайна.

Радио станц хүлээн авсан үед 5 секунд шалгах боломж өгнө. Тухайн станцийг үргэлжлүүлэн сонсох үед товшино.

[♥] : Сонсож буй радио станцийг урьдчилан сануулах товчинд бүртгэнэ. Цуцлах үед дахин товшино.


[...] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

- [Radio text]^{*1} : FM радио станцийн дамжуулж буй радио текстийг гаргана.

Урьдчилан сануулах товч эсвэл дэд цэсний радио станцийн жагсаалт : Сонгосон радио станц хүлээн авна.

- Жолооны хүрдний товчоор удирдах

► А төрөл



[<]/[>] товч


"Presets" дэлгэцнээс радио станц сонгосон үед урьдчилан сануулсан товчинд сануулсан давтамж эсвэл радио станцад шилжинэ.

"Station list" дэлгэцнээс сонгосон үед жагсаалт дахь радио станцад шилжинэ.

"Direct tune" дэлгэцнээс сонгосон үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой радио станцад автоматаар шилжинэ.

Удаан дарж давтамж солино. Товч суллах үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой радио станцад автоматаар шилжинэ.

► В төрөл



[<]/[>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хүрдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

"Presets" дэлгэцнээс радио станц сонгосон үед урьдчилан сануулсан товчинд сануулсан давтамж эсвэл радио станцад шилжинэ.

"Station list" дэлгэцнээс сонгосон үед жагсаалт дахь радио станцад шилжинэ.

"Direct tune" дэлгэцнээс сонгосон үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой радио станцад автоматаар шилжинэ.

Удаан дарж давтамж солино. Товч суллах үед тухайн байрлалаас дараагийн хүчтэй долгионтой радио станцад автоматаар шилжинэ.

Холбоотой холбоосууд

[Аудио эх үүсвэр солих\(Х. 36\)](#)

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

[Эх үүсвэр бүрийн дууг тохируулах\(Х. 100\)](#)

DAB сонсох*1

vmt1649896308664.dita

Хүссэн давтамжаа сонгон DAB сонсох боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

Тоглуулах боломжтой хугацаа нь DAB-н бичигдсэн битийн хурд, DAB нэгжийн санах ойн хэмжээ болон радио дамжуулалт эхэлсэн хугацаанаас хамаарна.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 [DAB]-г дарна.
- 4 Сонсох радио станцаа сонгоно.

[Presets] : Урьдчилан сануулах товчинд бүртгэгдсэн үйлчилгээнээс сонгоно.

[Station list] : Үйлчилгээний жагсаалтаас үйлчилгээ сонгоно.

Хүлээн авах боломжтой радио станцийг дахин хайх үед

[Refresh]*1 дарна.

[Manual tune] : Гараар станц сонгоно. [Ensemble] эсвэл

[Channel], [Service] эсвэл [Component]-г дарж станц сонгоно.

- 5 Шаардлагатай үед хүлээн авсан радиог гараар тохируулна.

- Үйлдлийг дэлгэц дээр хийнэ



[10]/[10] : Одоо сонсож байгаа үйлчилгээг цаг ухраах функцаар дахин сонсох боломжтой. Товч дарах үед 10 секундээр урагш болон арагш гүйнэ. Удаан дарах үед урагш болон арагш хурдан гүйнэ.

Удаан дарж хурдан урагш эсвэл арагш гүйлгэнэ.

[Live] : Одоо дамжуулагдаж байгаа дууг сонсох үед цаг ухраах функцийг унтраана.

*1 : Тоноглогдсон автомашинд

[] : Одоо сонсож буй үйлчилгээг урьдчилан тохируулах үйлчилгээнд бүртгэх ба цуцлах боломжтой.


[] : Тохируулах боломжтой зүйлсийг гаргана.

- **[Radio text]** : DAB-н дамжуулж радио текстийг дэлгэцээр гаргана.

Урьдчилан тохируулах товч, дэд цэсний радио станцийн жагсаалт : Сонгосон үйлчилгээг хүлээн авна.

- Жолооны хүрдний товчоор удирдана

► А төрөл



[<]/[>] товч


"Presets" дэлгэцээс сонгосон үед бүртгэгдсэн үйлчилгээг урьдчилан тохируулан товчны дарааллаар жагсаана.

"Station list" дэлгэцээс сонгосон үед үйлчилгээг радио станцийн дарааллаар жагсаана.

"Manual tune" дэлгэцээс сонгосон үед автоматаар тухайн байрлалаас ойр хамгийн хүчтэй долгионд тохируулна.

Үйлчилгээг солих үед удаан дарна. Товчноос гараа салгах үед автоматаар тухайн байрлалаас ойр хамгийн хүчтэй долгионд тохируулна.

► В төрөл



[<]/[>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор тогтмол ашигладаг жолооны хүрдний товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

"Presets" дэлгэцээс сонгосон үед бүртгэгдсэн үйлчилгээг урьдчилан тохируулан товчны дарааллаар жагсаана.

"Station list" дэлгэцээс сонгосон үед үйлчилгээг радио станцийн дарааллаар жагсаана.

"Manual tune" дэлгэцээс сонгосон үед автоматаар тухайн байрлалаас ойр хамгийн хүчтэй долгионд тохируулна.

Үйлчилгээг солих үед удаан дарна. Товчноос гараа салгах үед автоматаар тухайн байрлалаас ойр хамгийн хүчтэй долгионд тохируулна.

Холбоотой холбоосууд

Аудио эх үүсвэр солих(Х. 36)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх(Х. 95)

Эх үүсвэр бүрийн дууг тохируулах(Х. 100)

Аюулгүйн үүднээс эдгээр функцуудыг автомашин явж байх үед ашиглах боломжгүй.

rvp1649896308679.dita

Радио дохио хүлээн авдаг антен нь урд салхины шилэн дотор*¹ болон хойд цонхны шилэн дотор байрладаг.

АНХААР

- Антен суурилсан шилийг (дотор тал) утасны дагуу чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ. Антен гэмтээх аюултай тул шил толь цэвэрлэгч эсвэл бусад цэвэрлэгээний бодис ашиглаж болохгүй.
- Урд салхины шил*¹ болон хойд цонхны шилэнд байрлах антены утсанд дараах зүйлс тогтоож болохгүй. Долгион хүлээн авах чадвар бууруулах, шуугиан үүсгэхэд хүргэнэ.
 - Металлийн орцтой хуулга
 - Бусад металл зүйл (Lexus-н оригинал тоноглолоос бусад)

*1 :Тоноглогдсон автомашинд

Интернет радио ашиглах

AM/FM/DAB радио сонсох үед дууны нэр, хавтасны зураг, радио станцийн лого зэрэг мэдээллийг радио дамжуулалтын дуутай хамт авах боломжтой. Тус мэдээллийг Gracenote® сервэрээс DCM эсвэл Wi-Fi®-р дамжуулан авч дэлгэц дээр гаргах боломжтой.

Интернетэд DCM эсвэл Wi-Fi®-р холбогдсон үед радио сигналын хүч сулрах үед дамжуулалтыг интернет рүү шилжүүлж болно. Энэ нь тухайн радио станцийг тасралтгүйгээр сонсох боломж бүрдүүлнэ. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

- Зарим радио станцын дамжуулалтыг дэмждэггүй.
- Радио сигналын хүч буурах үед интернет радио ашиглах боломжтой.
- Интернет радио ашиглах үед радио долгионы хүч дахин сэргэсэн нөхцөлд аналог радиод автоматаар шилжинэ.
- Тохиргоо ашиглан интернет радиог идэвхжүүлэх, унтраах мөн автомат болон гар аргаар шилжүүлэх тохиргоог хийнэ.

Холбоотой холбоосууд

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

USB флаш тоглуулах үеийн анхааруулга

USB флаш тоглуулах үед дараах мэдээлэлд онцгой анхаарна.

МЭДЭЭЛЭЛ

- Тоглуулж байгаа USB флаш сугалах, холболт салгах үед шуугиан үүсгэнэ.
- USB флаш холбогдсон ба эх үүсвэрийг өөр эх үүсвэрээс USB флашинд шилжүүлсэн үед флаш дээрх эхний файлыг тоглуулна. Тухайн USB флашийг дахин холбосон (контент өөрчлөгдөөгүй) үед өмнө нь тоглуулж байсан дуунаас үргэлжлүүлэн тоглуулна.
- Дэмждэггүй форматтай файл уншуулах нь тоглуулах үйлдэлд сөргөөр нөлөөлж болно.
- USB салаалагч ашиглан олон төхөөрөмж холбосон үед эхлээд танигдсанаас бусад төхөөрөмжийг ашиглах боломжгүй.

АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед USB флаш удирдаж болохгүй.

АНХААР

- Бүхээг дотор USB флаш үлдээж болохгүй. Бүхээгийн хэм халуун болсон үед USB флаш гэмтэх аюултай.
- Холбогдсон USB флашийг доош дарах, хөшиж болохгүй. USB флаш болон порт гэмтэнэ.
- Портонд гадны биет орохоос сэргийлнэ. USB флаш эсвэл порт гэмтэх аюултай.
- Хонгконг болон Макао: USB видео файлын дүрс дэлгэцээр гарахгүй. Зөвхөн дууг тоглуулна.

■ MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis файл тоглуулах

MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis файлтай USB флаш залгасан үед эхлээд USB флаш дахь бүх файлыг систем шалгана.

USB флаш дээр MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis файлаас өөр файл болон шаардлагагүй фолдер хадгалахгүй байх нь зүйтэй. Ингэснээр USB флаш шалгах үйлдэл хурдан дуусна.

МЭДЭЭЛЭЛ

MP3/WMA/AAC/WAV/FLAC/ALAC/Ogg Vorbis форматад хөрвүүлэх олон төрлийн программ хангамж зах зээл дээр байдаг. Хөрвүүлэгч программ

эсвэл форматаас хамаарч дууны чанар муудах, шуугиан гарах эсвэл файлыг тоглуулах боломжгүй байж болно.

АНХААР

Файланд буруу өргөтгөл нэмж болохгүй. Файлын агуулгатай таарахгүй өргөтгөл нэмснээр файл буруу танигдаж систем тус файлыг тоглуулж болно. Энэ нөхцөлд спикерийг гэмтээх хэмжээний чанга шуугиан үүснэ.

Буруу өргөтгөлийн жишээ:

- MP3 биш файланд ".mp3" өргөтгөл нэмэх
- WMA биш файланд ".wma" өргөтгөл нэмэх

— Холбоотой холбоосууд —

[Ашиглах боломжтой медиагийн тухай мэдээлэл\(Х. 338\)](#)

[Форматын мэдээлэл\(Х. 338\)](#)

[USB флашнаас тоглуулах боломжтой видео дата\(Х. 341\)](#)

[USB санах ойн мэдээлэл\(Х. 345\)](#)

USB флашнаас дуу тоглуулах

wbz1649896308836.dita

USB портод холбосон USB флаш дуу тоглуулах боломжтой. USB флаш холбогдох үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Тус товч зарим төхөөрөмж дээр гарахгүй байж болно.


USB флаш холбоно.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 Төхөөрөмжийн нэр эсвэл [USB]-г дарна.
- 4 [Music]-г дарна.

USB флаш дээр видео файл байгаа үед дэлгэц дээр гарна.

- 5 Шаардлагатай үед USB флашийг удирдана.

- Дэлгэцнээс удирдах



[🔍] : Дурын дууг тоглуулах.

Товч дарах бүрт дурын файл эсвэл дуу тоглуулах, дурын дуу тоглуулахыг цуцлах мөн одоогийн хавтас, цомог доторх дурын дууг тоглуулах тохиргоонд солигдоно.

[⏮] : Одоогийн дуу эсвэл файлыг эхнээс нь тоглуулна. Дуу эсвэл файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[⏸] : Түр зогсоох.

[▶] : Тоглуулах.

[⏭] : Файл эсвэл дуу солино.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[] : Давтан тоглуулна.

Товч дарах бүрт одоогийн файл, дууг давтан тоглуулах, одоогийн хавтас, цомог доторх дууг давтан тоглуулах эсвэл бүх файл, дууг давтан тоглуулах горимд солигдоно.


[] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

Дэд цэсний жагсаалт : Дараах нөхцөлөөс дуу сонгоно.

- [**Artists**] : Дуучны нэрнээс дуу сонгоно.
- [**Albums**] : Цомгийн нэрнээс дуу сонгоно.
- [**Folders**] : Хавтасны нэрнээс дуу сонгоно.
- [**Songs**] : Дууны нэрнээс дуу сонгоно.
- [**Genres**] : Дууны төрлөөс дуу сонгоно.
- [**Composers**] : Хөгжмийн зохиолчийн нэрнээс дуу сонгоно.

● Жолооны хүрдний товчоор удирдах

► А төрөл




[< / >] товч

Дуу эсвэл файл солино.

Удаан дарж арагш болон урагш хурдан гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

► В төрөл



[<]/[>] switches

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хүрдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Дуу эсвэл файл солино.

Удаан дарж арагш болон урагш хурдан гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Холбоотой холбоосууд

[Аудио эх үүсвэр солих\(Х. 36\)](#)

[USB портод холбох\(Х. 39\)](#)

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

[Эх үүсвэр бүрийн дууг тохируулах\(Х. 100\)](#)

USB флашнаас видео файл тоглуулах

ehu1649896308648.dita

USB портод USB флаш холбон видео файл тоглуулах боломжтой. USB флаш холбогдох үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Зарим төхөөрөмж дээр тус товч гарахгүй байж болно.

USB флаш холбоно.

- 1 **Үндсэн цэсний [🎵]-г дарна.**
- 2 **[Sources]-г дарна.**
- 3 **Төхөөрөмжийн нэр эсвэл [USB]-г дарна.**
- 4 **[Video]-г дарна.**
- 5 **Шаардлагатай үед USB флашийг удирдана.**

- Бүтэн дэлгэцийн үед удирдах

Дэлгэц дээр товшин удирдах товч гаргана.



[⏮]: Одоо тоглуулж буй файлыг эхнээс нь тоглуулна. Файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[⏸]: Видеоог түр зогсооно.

[▶]: Видеоог тоглуулна.

[⏭]: Файл солино.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Видеоог түр зогсоосон үед удаан дарж удаанаар тоглуулна.

[Move]: Удирдлагын товчийг шилжүүлнэ.

Видеотой давхцаж үзэхэд хүндрэлтэй үед товчийг өөр байрлалд шилжүүлнэ.

[⛶]: Удирдлагын дэлгэц гаргана.

- Удирдлагын дэлгэцнээс удирдах

Бүтэн дэлгэцний []-г дарж удирдлагын дэлгэц гаргана.



[] : Одоо тоглуулж буй файлыг эхнээс нь тоглуулна. Файлын эхэнд байгаа үед өмнөх файлыг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[] : Видеог түр зогсооно.

[] : Видеог тоглуулна.

[] : Файл солино.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Видеог түр зогсоосон үед удаан дарж удаанаар тоглуулна.


[] : Бүтэн дэлгэцэнд шилжүүлнэ.

[] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

Хавтас эсвэл дэд цэсний файлын нэр : Хавтас эсвэл дэд цэсний файлын нэр дээр дарж тоглуулах файл солино.

- Жолооны хүрдний товчоор удирдах

► А төрөл




[<|/>] товч

Файл солино.

Удаан дарж видеог арагш эсвэл урагш хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Видеог түр зогсоосон үед [>] товч удаан дарж видеог удаанаар тоглуулна.

► В төрөл



[<|/>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хүрдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Файл солино.

Удаан дарж видеог арагш эсвэл урагш хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

Видеог түр зогсоосон үед [>] товч удаан дарж видеог удаанаар тоглуулна.

— Холбоотой холбоосууд —

Аудио эх үүсвэр солих(Х. 36)

USB портод холбох(Х. 39)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх(Х. 95)

Дэлгэцийн горим солих(Х. 98)

Дүрсний чанарыг тохируулах(Х. 99)

Эх үүсвэр бүрийн дууг тохируулах(Х. 100)

iPod/iPhone тоглуулах үеийн анхааруулга

iPod/iPhone тоглуулах үед дараах мэдээллийг анхаарна.

МЭДЭЭЛЭЛ

- Тус функцийг Apple CarPlay USB холбогчоор холбогдсон үед ашиглах боломжгүй.
- iPod/iPhone горимд байгаа үед портыг салгах, холбогдсон төхөөрөмжийг салгасан нөхцөлд шуугиан үүсч болно.
- USB салаалагч ашиглан олон төхөөрөмж холбосон үед эхний танигдсан төхөөрөмжөөс бусад төхөөрөмжийг ашиглах боломжгүй.
- iPod/iPhone холбоотой үед iPod/iPhone-с өөр эх үүсвэрт шилжүүлэх нөхцөлд өмнө нь тоглуулж байсан дуунаас тоглуулж эхэлнэ.*¹

АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед iPod/iPhone-г удирдаж болохгүй.

АНХААР

- iPod/iPhone-г бүхээгт үлдээж болохгүй. Бүхээгийн хэм өндөр болж iPod/iPhone-г гэмтээх аюултай.
- Холбогдсон iPod/iPhone-г доош дарах, шаардлагагүй хүч учруулж болохгүй. iPod/iPhone эсвэл порт гэмтэх аюултай.
- Портонд гадны биет оруулж болохгүй. iPod/iPhone эсвэл порт гэмтэх аюултай.

Холбоотой холбоосууд

iPod-ны тухай мэдээлэл(Х. 342)

*1 : Холбосон төхөөрөмжөөс хамаарч үйлдэл гарын авлагад тайлбарласнаас өөр байж болно.

iPod/iPhone тоглуулах

bdl1649896308617.dita


USB портод холбосон iPod/iPhone-н дууг тоглуулах боломжтой. iPod/iPhone холбогдсон үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Тус товч зарим төхөөрөмж дээр гарахгүй байж болно.

МЭДЭЭЛЭЛ

- Холбосон iPod/iPhone-н загвар, үеэс хамаарч хавтасны зураг бүдэг харагдах эсвэл дэлгэц удаан гүйж болно.
- Холбосон iPod/iPhone-н загвар, үеэс хамаарч зарим үйлдлийг ашиглах боломжгүй байх эсвэл функцийн ажиллагаа өөр байж болно.

iPod эсвэл iPhone-г холбоно.

- 1 Үндсэн цэсний [🎵] -г дарна.
 - 2 [Sources]-г дарна.
 - 3 Төхөөрөмжийн нэр эсвэл [USB]-г дарна.
 - 4 Шаардлагатай үед iPod/iPhone-г удирдана.
- Дэлгэцнээс удирдах



[🔍] : Дууг солиж тоглуулах.

Товч дарах бүрт дууг солиж тоглуулах горим өөрчлөгдөнө.*1

[⏮] : Одоогийн тоглож буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнө дууг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[⏸] : Түр зогсоох.

[▶] : Тоглуулах.

[▶] : Дуу солих.

Удаан дарж хурдан гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

[↺] : Дахин тоглуулах.

Товч дарах бүрт дахин тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*¹


[...] : Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

Дэд цэсний жагсаалт : Дараах нөхцөлөөс дуу сонгоно.

- **[Playlists]** : Тоглуулах жагсаалтаас дуу сонгоно.
- **[Artists]** : Дуучны нэрнээс дуу сонгоно.
- **[Albums]** : Цомгийн нэрнээс дуу сонгоно.
- **[Songs]** : Дууны нэрнээс дуу сонгоно.
- **[Genres]** : Дууны төрлөөс дуу сонгоно.
- **[Composers]** : Хөгжмийн зохиогчийн нэрнээс дуу сонгоно.
- **[Radio]** : Радио станцаас дуу сонгоно.
- **[Audiobooks]** : Аудио номны нэрнээс дуу сонгоно.
- **[Podcasts]** : Podcast-н нэрнээс дуу сонгоно.

● Жолооны хүрдний товчоор удирдах

► А төрөл




[<]/[>] товч

Дуу солих.

Удаан дарж хурдан арагш, урагш гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

*1 : Тухайн холбосон төхөөрөмжөөс хамаарч дуу хольж тоглуулах, давтан тоглуулах дараалал өөр байна.

► В төрөл



[<]/[>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хүрдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Дуу солих.

Удаан дарж хурдан арагш, урагш гүйлгэнэ. Товч суллах үед тухайн байрлалаас тоглуулж эхлэнэ.

— Холбоотой холбоосууд —

Аудио эх үүсвэр солих(Х. 36)

USB портод холбох(Х. 39)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх(Х. 95)

Эх үүсвэр бүрийн дууг тохируулах(Х. 100)

Apple CarPlay тоглуулах үеийн анхааруулга

Apple CarPlay тоглуулах үед дараах мэдээлэлд анхаарал хандуулна. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

- Android Auto холбоотой үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Apple CarPlay-г USB-р холбосон үед холбоотой төхөөрөмжийг салгах нь шуугиан үүсгэнэ.
- iPhone холбоотой үед бусад эх үүсвэрийг Apple CarPlay-д шилжүүлсэн үед өмнө нь тоглуулж байсан дуунаас үргэлжлүүлэн тоглуулна.

▲ АЮУЛТАЙ

Аюулгүй байдлын үүднээс жолооч хөдөлгөөний үед iPhone-г ажиллуулж болохгүй.

⚠ АНХААР

- Автомашины бүхээгт iPhone үлдээж болохгүй. Бүхээг хэт халж iPhone-д доголдол үүсгэх аюултай.
- Холбогдсон iPhone-г доош дарах, шаардлагагүй хүч учруулахаас зайлсхийнэ. iPhone эсвэл порт гэмтэх аюултай.
- Портод гадны эд зүйл орохоос сэргийлнэ. iPhone эсвэл порт гэмтэх аюултай.

Холбоотой холбоосууд

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 128)

Apple CarPlay тоглуулах

xgd1649896308820.dita


USB порт эсвэл утасгүй холболтоор холбосон iPhone утасны дууг тоглуулах боломжтой. Apple CarPlay холбогдсон үед эх үүсвэр сонгох дэлгэц дээр төхөөрөмжийн нэртэй товч гарна. Тус товч зарим дэлгэц дээр гарахгүй байж болно.

МЭДЭЭЛЭЛ

- Холбосон iPhone утасны загвар, үеэс хамаарч зарим функцийг ашиглах боломжгүй эсвэл өөрөөр ажиллаж болно.
- Дуу хэвийн тоглуулагдахгүй үед iOS-г сүүлийн хувилбарт шинэчилнэ. Шинэчлэлт нь тус асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Apple CarPlay холбох.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
 - 2 [Sources]-г дарна.
 - 3 [Apple CarPlay] (төхөөрөмжийн нэр)-г дарна.
 - 4 Apple CarPlay-г удирдана.
- Дэлгэцнээс удирдах



[🔍]: Дууг хольж тоглуулах.

Товч дарах бүрт хольж тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

[⏮]: Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулж эхлэнэ.

Удаан дарж хурдан буцаана. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[⏸]: Түр зогсоох.

[▶]: Тоглуулах.

[⏭]: Дуу солих.

Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[] : Дахин тоглуулах.


Товч дарах бүрт дахин тоглуулах тохиргоо өөрчлөгдөнө.*1

[] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

[Open CarPlay] : Apple CarPlay-н дэлгэц гаргана.

- Жолооны хурдний товчоор удирдах

► А төрөл




[<]/[>] товч

Дууг солих.

Удаан дарж хурдан урагш эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

► В төрөл



[<]/[>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хурдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Дууг солих.

Удаан дарж хурдан урагш эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

*1 : Холбосон төхөөрөмжөөс хамаарч дууг хольж эсвэл давтан тоглуулах дараалал өөрчлөгдөнө.

Холбоотой холбоосууд

[Аудио эх үүсвэр солих\(Х. 36\)](#)

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

[Эх үүсвэр бүрийн дууг тохируулах\(Х. 100\)](#)

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 103\)](#)

[Бүртгэгдээгүй ухаалаг утасны Apple CarPlay ашиглах\(Х. 131\)](#)

[Бүртгэгдсэн ухаалаг утасны Apple CarPlay ашиглах\(Х. 134\)](#)

Android Auto-г тоглуулах үеийн анхааруулга

Android Auto-г тоглуулах үед дараах зүйлсэд онцгой анхаарна.
Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay холбоотой үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Android Auto холбоотой үед USB-р холбосон төхөөрөмж салгахад шуугиан гарч болно.
- Android Auto холбоотой үед Android Auto-с өөр эх үүсвэрт шилжүүлсэн нөхцөлд өмнө тоглуулж байсан дуунаас үргэлжлүүлэн тоглуулна.

▲ АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед Android төхөөрөмжийг удирдаж болохгүй.

▲ АНХААР

- Android төхөөрөмжийг бүхээгт үлдээж болохгүй. Бүхээг өндөр хэмд халж Android төхөөрөмжинд доголдол үүсгэх аюултай.
- Android төхөөрөмжийг доош дарах, хөшихийг хориглоно. Android төхөөрөмж эсвэл порт гэмтэнэ.
- Портод гадны биет орохоос сэргийлнэ. Android төхөөрөмж эсвэл порт гэмтэх аюултай.

Холбоотой холбоосууд

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 128)

Android Auto-г тоглуулах


zfm1649896308851.dita

USB портод холбосон Android төхөөрөмжийн дуу тоглуулна. Android төхөөрөмж холбогдсон үед төхөөрөмжийн нэртэй товч эх үүсвэр сонгох дэлгэц дээр гарна. Тус товч зарим төхөөрөмж дээр гарахгүй байж болно.

Android Auto-г холбоно.

- 1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 [Android Auto] (төхөөрөмжийн нэр)-г дарна.
- 4 Шаардлагатай үед тоглуулж байгаа Android Auto-г удирдана.

- Дэлгэцнээс удирдах



[⏮]: Тухайн тоглож буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

[⏸]: Түр зогсооно.

[▶]: Тоглуулна.


[⏭]: Дууг солино.

[⋮]: Тохируулах боломжтой зүйлсийг харуулна.

[Open Android Auto]: Android Auto дэлгэцийг харуулна.

- Жолооны хурдний товчоор удирдах


► А төрөл



[<]/[>] товч

Дууг солино.

► В төрөл



[<]/[>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хурдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухайн дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Дууг солино.

— Холбоотой холбоосууд —

[Аудио эх үүсвэр солих\(Х. 36\)](#)

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

[Эх үүсвэр бүрийн дууг тохируулах\(Х. 100\)](#)

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(Х. 103\)](#)

[Android Auto ашиглах\(Х. 137\)](#)

Bluetooth® аудио тоглуулах үеийн анхааруулга xqi1649896308538.dita

Дараах мэдээлэлд Bluetooth® аудио тоглуулах үед онцгой анхаарна.

МЭДЭЭЛЭЛ

- Мультимедиа системд гар утас, бусад зөөврийн Bluetooth® аудио тоглуулагч (цаашид зөөврийн төхөөрөмж) ашиглах үед төхөөрөмжийг урьдчилан системд бүртгүүлнэ.
- Зөөврийн төхөөрөмжийн загвараас хамаарч зарим функцийн ажиллагаа хязгаарлагдаж болно.
- Apple CarPlay-г Wi-Fi®-р холбосон үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Утасгүй холболтын төхөөрөмжтэй зэрэг ашигласан үед тус тусын дамжуулалтанд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Мультимедиа системийн тохиргоон дээр Wi-Fi® функцийг асаасан үед Bluetooth® аудионы дуу тасалдаж болно.

АЮУЛТАЙ

- Аюулгүйн үүднээс жолооч жолоодлогын үед төхөөрөмжийг удирдаж болохгүй.
- Автомашины Bluetooth® антен мультимедиа систем дотор байдаг. Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, дотуур суулгасан зүрхний дахин синхрончлол эмчилгээний пэйсмейкэр, дотуур суулгасан зүрхний дефибриллятороос бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн аудиог ашиглахын өмнө цахилгаан долгион нь эмчилгээний төхөөрөмжинд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг төхөөрөмжийн үйлдвэрлэгч эсвэл эмчээсээ зөвлөгөө авна.

АНХААР

- Зөөврийн төхөөрөмжийг автомашин дотор үлдээж болохгүй. Бүхээг халж зөөврийн төхөөрөмжинд гэмтэл учруулах аюултай.
- Зөөврийн төхөөрөмжийг доош дарах, хөшиж болохгүй. Зөөврийн төхөөрөмж эсвэл порт гэмтэх аюултай.
- Портод гадны зүйлс оруулж болохгүй. Зөөврийн төхөөрөмж, порт гэмтэх аюултай.
- Зөөврийн төхөөрөмжийг мультимедиа системд ойрхон ашиглаж болохгүй. Хэт ойртуулах нь дуу, холболтын чанар бууруулж болно.

— **Холбоотой холбоосууд** —

Wi-Fi® тохиргоо өөрчлөх(Х. 101)

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 108)

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх(Х. 113)

Bluetooth® мэдээлэл(Х. 346)

Bluetooth® аудио тоглуулах

unf1649896308586.dita


Зөөврийн төхөөрөмж холбосон үед төхөөрөмжийг шууд удирдалгүйгээр ашиглах боломжтой.

 МЭДЭЭЛЭЛ

- Холбосон төхөөрөмжөөс хамаарч дараах мэдээлэл гарахгүй байж болно.
 - Хавтасны нэр
 - Дууны нэр
 - Цомгийн нэр
 - Дуучны нэр
 - Тоглуулах хугацаа
 - Нийт хугацаа
 - Дурын дуу
 - Давтан тоглуулах
 - Тоглуулах/түр зогсоох
 - Дууг дээш/доош
- Холбосон төхөөрөмжөөс хамаарч дараах зүйлс үүсч болно.
 - Мультимедиа системээс удирдах боломжгүй байж болно.
 - Үйлдэл эсвэл дууны түвшин өөр байж болно.
 - Дууны мэдээлэл, хугацаа зэрэг мэдээлэл мультимедиа систем болон зөөврийн төхөөрөмжөөс хамаарч өөр гарч болно.
 - Тоглуулж дууссан үед холболт салж болно.
- Удаан тоглуулсан үед дуу дараагийн дуунд шилжиж болно.
- Холболт үүсэх үед зөөврийн төхөөрөмжөөс хамаарч дууны түвшин өөр байж болно.

Зөөврийн төхөөрөмж мультимедиа системд холбох.

- 1 **Үндсэн цэсний**  -г дарна.
- 2 **[Sources]**-г дарна.
- 3 **Төхөөрөмжийн нэр эсвэл [Bluetooth]-г дарна.**
- 4 **Bluetooth® аудиог удирдана.**
 - Дэлгэцнээс удирдах



[] : Дурын дуу тоглуулах.

Товч дарах үед дурын дуу тоглуулах тохиргоог өөрчилнө.*1

[] : Одоо тоглуулж буй дууг эхнээс нь тоглуулна. Дууны эхэнд байгаа үед өмнөх дууг эхнээс нь тоглуулна.

Удаан дарж хурдан ухраана. Сулласан үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[] : Түр зогсооно.

[] : Тоглуулна.

[] : Дууг солино.

Удаан дарж хурдан урагш гүйлгэнэ. Сулласан үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

[] : Дахин тоглуулна.

Товч дарах бүрт дахин тоглуулах тохиргоог өөрчилнө.*1


[] : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг харуулна.

Дэд цэсний хавтасны нэр эсвэл дууны нэрийг гаргана :
Хавтасны нэр эсвэл дууны нэрийг дарж тоглуулах файлыг солино.

● Жолооны хүрдний товчоор удирдах

*1 : Утасны загвараас хамаарч дурын дуу эсвэл дахин тоглуулах тохиргооны дараалал өөрчлөгдөнө.

► А төрөл




[<]/[>] товч

Дуу солино.

Удаан дарж хурдан урагш эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

► В төрөл



[<]/[>] товч

Өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хүрдний тогтмол ашигладаг товчоор тохируулсан үед тус товчийг ашиглах боломжтой. Өөрчлөх боломжтой тохиргооны тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Дуу солино.

Удаан дарж хурдан урагш эсвэл арагш гүйлгэнэ. Суллах үед тухайн байрлалаас үргэлжлүүлэн тоглуулна.

— Холбоотой холбоосууд —

Аудио эх үүсвэр солих(Х. 36)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх(Х. 95)

Эх үүсвэр бүрийн дууг тохируулах(Х. 100)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 103)

Тоглуулах үеийн анхааруулга. Miracast®

Дараах зүйлсэд Miracast® ашиглах үед өндөр анхаарал болгоомжтой хандана.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

- Тус төхөөрөмж нь Wi-Fi® (P2P горим)-р холбогддог.
- Apple CarPlay-г Wi-Fi®-р холбосон үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Хамгийн өндөр хүчин чадлаар ажиллах функц.
- Төхөөрөмжөөс хамаарч Miracast®-н дэлгэцээр гарах нэр өөр байна.
- Wi-Fi® сүлжээнд холбогдсон үед Wi-Fi® сүлжээ болон Miracast® мэдээлэл дамжуулалт бие биендээ нөлөөлөх боломжтой. Энэ нь дүрсний гажуудал болон дууны гацалтыг үүсгэж болзошгүй.

АЮУЛТАЙ

Жолоодлогын үед ухаалаг утас, эвсэл таблетыг холбох болон удирдаж болохгүй.

АНХААР

Автомашин дотор ухаалаг утас, таблет үлдээж болохгүй. Бүхээгийн хэм нэмэгдсэн үед ухаалаг утас, таблетын ажиллагааг доголдуулна.

— Холбоотой холбоосууд —

[Дуу болон медиа тохиргоо өөрчлөх\(Х. 95\)](#)

[Wi-Fi® тохиргоо өөрчлөх\(Х. 101\)](#)

[Wi-Fi® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга\(Х. 123\)](#)

Miracast® дэмждэг төхөөрөмж холбох

aay1649896308726.dita

Miracast® дэмждэг Android ухаалаг утас, таблет холбох боломжтой.

Төхөөрөмж Miracast® дэмждэг эсэхийг тухайн төхөөрөмжийн гарын авлагаас харна уу.


1 Үндсэн цэсний [🎵]-г дарна.

2 [Sources]-г дарна.

3 [Miracast®]-г дарна.

4 Тус үйлдлээр Miracast® дэмждэг төхөөрөмж холбоно.

- Төхөөрөмжийн гарын авлагад заасан дарааллын дагуу холбоно.
- Холболт амжилтгүй болсон үед үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.



5 Төхөөрөмжийн нэрийг шалгаад [OK]-г дарна.

— Холбоотой холбоосууд —

[Wi-Fi® тохиргоо өөрчлөх\(Х. 101\)](#)

Miracast® тоглуулах

ubl1649896308491.dita

Ухаалаг утас, таблетны дуу болон видео файлыг мултимедиа систем дээр тоглуулах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Холбосон төхөөрөмжөөс хамаарч Miracast®-н дууны түвшин өөр байж болно.
- Wi-Fi® холболт салах үед аудио дуу хаагдана.

Miracast® дэмждэг төхөөрөмж холбоно.

- 1 Үндсэн цэсний -г дарна.
- 2 [Sources]-г дарна.
- 3 [Miracast®]-г дарна.
- 4 Шаардлагатай үед тухайн тоглож буй Miracast® контентийг удирдана.

- Бүтэн дэлгэцтэй үед удирдах

Дэлгэц дээр товшиж удирдлагын товч гаргана.



 : Удирдлагын дэлгэц гаргана.

- Удирдлагын дэлгэцээс удирдах


Бүтэн дэлгэцний  дээр дарж удирдлагын дэлгэц гаргана.

 : Тохиргоо хийх боломжтой зүйлсийг гаргана.

 : Бүтэн дэлгэцэнд шилжүүлнэ.

[Disconnect] : Miracast® салгана.

Аудио унтарна.



Холбоотой холбоосууд

Аудио эх үүсвэр солих(Х. 36)

Дуу болон медиа тохиргоо өөрчлөх(Х. 95)

Дэлгэцийн горим солих(Х. 98)

Дүрсний чанарыг тохируулах(Х. 99)

Эх үүсвэр бүрийн дууг тохируулах(Х. 100)

6-1. Гарын оролцоогүй дуудлага ашиглах үеийн анхааруулга	Давхар дуудлагад хариулах.....	238
Гарын оролцоогүй дуудлагын анхааруулга..	Дуудлага дундуур өөр хүн рүү дуудлага хийх.....	239
Гарын оролцоогүй дуудлагад доголдол үүсэх нөхцөл.....	Олон хүнтэй зэрэг дуудлага хийх.....	240
	Дуудлага дуусгах.....	241
6-2. Жолооны хүрдний товчоор гарын оролцоогүй дуудлага удирдах	6-6. Гарын оролцоогүй дуудлагад ашиглах утас солих	
Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл).....	Гарын оролцоогүй дуудлагад ашиглах гар утас солих	242
Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл).....		
	6-7. Холбоо барих хаяг засах	
6-3. Дуудлага хийх	Холбоо барих хаягийг дамжуулах.....	244
Дуудлагын түүхээс дуудлага хийх.....	Холбоо барих хаягт шинэ хаяг нэмэх.....	248
Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх.....	Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх.....	250
Холбоо барих хаяг руу дуудлага хийх.....	6-8. Мессеж функц хэрхэн ашиглах тухай	
Дэлгэцийн гарнаас дуудлага хийх.....	Мессежний функц ашиглах үеийн анхааруулга.....	251
Хүлээх эсвэл түр зогсоох дохио ашиглан дуудлага хийх.....	Мессежний функцаас дуудлага хийх.....	256
6-4. Дуудлага хүлээн авах		
Дуудлагад хариулах		
Дуудлага цуцлах		
6-5. Дуудлага дундах үйлдэл		
Дуудлагын дэлгэц дээр үйлдэл хийх		

Гарын оролцоогүй дуудлагын анхааруулга

Системд таниулсан Bluetooth® гар утас (цаашид "гар утас" гэх) ашиглан гар утсыг шууд удирдалгүйгээр утасны функцаар дуудлага хүлээн авах, хийх боломжтой. Тус функц нь гарын оролцоогүй дуудлага нэрээр түгээмэл танигдсан байдаг.

Системд холбох гар утас нь мултимедиа системийн техник үзүүлэлтийг дэмждэг байх шаардлагатай. Мөн гар утасны загвараас хамаарч зарим функцийн ажиллагаа хязгаарлагдаж болно.

Apple CarPlay эсвэл Android Auto-д холбогдсон байсан ч тухайн нөхцөл байдлаас хамаарч Apple CarPlay эсвэл Android Auto-н гарын оролцоогүй дуудлагын дэлгэц гарахгүй байж болно.

МЭДЭЭЛЭЛ

- Гарын оролцоогүй функцтай гар утас ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.
 - Гарын оролцоогүй функц ашиглахын өмнө гар утсыг мултимедиа системд бүртгэж Bluetooth®-р холбосон байх шаардлагатай. Эхлээд гар утас бүртгэнэ.
 - Тус функц ашиглах үед гар утас Bluetooth® функц ашиглах боломжтой байна.
 - Bluetooth® аудио тоглох үед дуудлага хийх, хүлээн авсан нөхцөлд функцийн дэлгэц болон аянд хоцрогдол үүсч болно.
- Мултимедиа систем нь бүх Bluetooth® төхөөрөмж дэмжих баталгаа байхгүй.

Гар утасны загвараас хамаарч дараах нөхцөл байдал үүсч болно.

 - Гарын оролцоогүй дуудлагын үед асаах товч <power товч> дарсан нөхцөлд дуудлага салгагдаж болно.
 - Таны залгасан хүн дуудлага хүлээн авах хүртэл утасны дэлгэц эсвэл дуудлага хийгдэж байгааг харуулах дэлгэц гарахгүй байж болно.
 - Дэлгэц дээр утасны дугаар оруулан залгасан ч үүрэн холбооны оператороос хамаарч дуудлага хийгдэх ая дуугарахгүй байж болно.
 - Утасны дугаар оруулсны дараа гар утсан дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- Дараах нөхцөлүүдэд гарын оролцоогүй дуудлага хийх боломжгүй байж болно.
 - Сүлжээгүй газар байгаа
 - Шугам завгүй зэргээр гарах дуудлага хязгаарлагдсан үед
 - Яаралтай дуудлагын үед

- Гар утаснаас холбоо барих хаягийг дамжуулж байгаа үед
 - Гар утасны дуудлага түгжих функц асаалттай
 - Дата өгөгдөл дамжуулах зэргээр гар утас ашиглагдаж байгаа үед
 - Гар утас доголдсон үед
 - Гар утас холбогдоогүй үед
 - Гар утасны цэнэг багассан
 - Гар утас унтраастай
 - Гарын оролцоогүй функцийг хязгаарласан тохиргоо гар утсан дээр хийгдсэн
 - Дата өгөгдөл дамжуулах эсвэл холбоо барих хаяг дамжуулах горимоос мултимедиа системийн гарын оролцоогүй дуудлагад шилжүүлэх үед. (Шилжүүлэх үед Bluetooth®-н холболтын байдлыг дэлгэцээр харуулахгүй)
 - Бусад шалтгаанаар гар утсыг ашиглах боломжгүй байгаа
- Гарын оролцоогүй дуудлага болон Wi-Fi® функц (Wi-Fi® эсвэл Miracast®) зэрэг ашиглагдаж байгаа үед гар утасны Bluetooth® холболт салж болно.

▲ АЮУЛТАЙ

- Аюулгүйн үүднээс хөдөлгөөний үед жолооч гар утсыг шууд удирдаж болохгүй.
- Дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэй хүн Bluetooth® антенаас хангалттай зай барина. Радио долгион эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлж болзошгүй.
- Bluetooth® төхөөрөмж ашиглахын өмнө дотуур суулгасан зүрхний пэйсмейкер, зүрхний ажиллагааг дахин синхрончлох эмчилгээний пэйсмейкер эсвэл дефибриллятор суулгац эмчилгээтэйгээс бусад эмчилгээний төхөөрөмжтэй хүн тухайн төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс радио долгионы төхөөрөмжинд учруулах нөлөөг тодруулна. Радио долгион нь эмчилгээний төхөөрөмжинд урьдчилан мэдэх боломжгүй нөлөөлөлтэй байж болно.

▲ АНХААР

Бүхээгт гар утас үлдээж болохгүй. Бүхээг халсан нөхцөлд гар утсанд доголдол үүсгэх аюултай.

— Холбоотой холбоосууд —

Bluetooth® төхөөрөмж ашиглах үеийн анхааруулга(Х. 108)

Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд(Х. 111)

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх(Х. 113)

Аудио дуудлагын анхааруулга

woz1649834505153.dita

Гарын оролцоогүй дуудлагын үед автомашины микрофон ашиглан ярих боломжтой. Гарын оролцоогүй дуудлага хийх үед дараах мэдээллийг анхаарна уу.

- Дуудлага хүлээн авах, дуудлагын үеэр ярих үеийн аудио нь урд 2 суудлын хажуу спикернээс гардаг.
- Гарын оролцоогүй системээс аудио эсвэл хонхны ая дуугарах үед дуу хоолойн аудионы дууг хаадаг.

МЭДЭЭЛЭЛ

- Дуудлагын үед утсаар ээлжлэн ярина. Нэгэн зэрэг ярисан үед нөгөө талынхаа хэлсэн үгийг сонсоход хүндрэлтэй болно.
- Хүлээн авагч дуугаа хэт чанга тохируулсан үед нөгөө талын дуу автомашины гадна талд сонсогдох, цуурайтаж болно.
- Чанга тод ярина.
- Дараах нөхцөлүүдэд таны дуу нөгөө талд сайн сонсогдохгүй байж болно.
 - Хатуу хучилтгүй замаар явах үед.
 - Өндөр хурдаар явах үед.
 - Дээврийн нээлхий, цонх нээлттэй.
 - Агааржуулалтын сэнсний дуу чанга.
- Гар утас, бусад сүлжээ ашиглагдаж байгаа зэргээр дууны чанарт сөрөг нөлөө (шуугиан, цуурай зэрэг) үзүүлэх зүйлс байгаа.
- Өөр Bluetooth® төхөөрөмж зэрэг холбогдсон үед гарын оролцоогүй системийн аудиод шуугиан үүсч болно.
- Мултимедиа системийг Wi-Fi® функц (Wi-Fi® эсвэл Miracast®) ашиглахаар тохиргоо хийсэн үед гарын оролцоогүй системийн аудиод шуугиан үүсч болно.

Автомашинаа зарах, устгалд оруулах үеийн анхааруулга

kbd1649834504653.dita

Гарын оролцоогүй систем ашиглах үед их хэмжээний хувийн мэдээлэл бүртгэгддэг. Автомашинаа зарах, устгалд оруулахаас өмнө эдгээр бүх мэдээллийг устгана.

Бүх мэдээллийг тэглэсэн үед мултимедиа системийн бүх дата тэглэгдэж үйлдвэрийн үндсэн тохиргоонд буцна. Тохиргоог тэглэхээс өмнөх байдалд буцаах боломжгүй.

— **Холбоотой холбоосууд** —

[Аюулгүй байдлын тохиргоо өөрчлөх\(Х. 75\)](#)

Гарын оролцоогүй дуудлагад доголдол үүсэх нөхцөл

mdv1649834505090.dita

Дараах шинж тэмдэг мэдрэгдсэн үед хүснэгт дэх боломжит шалтгаан болон шийдлийн дагуу арга хэмжээг аваад шинж тэмдгийг дахин шалгана.

■ Гарын оролцоогүй дуудлага ашиглах

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Гарын оролцоогүй дуудлага ашиглаж болохгүй байх	Гар утас Bluetooth® дэмждэггүй.	Мултимедиа системтэй холбох боломжтой төхөөрөмжийн мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.
	Гар утасны үйлдлийн системийн хувилбар Bluetooth®-тэй тохирохгүй.	Bluetooth® Core Specification Ver. 5.0-с хойших техник үзүүлэлттэй гар утас ашиглана.

■ Гар утас бүртгэх, холбох

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Гар утас бүртгэх боломжгүй байх	Гар утасны бүртгэх үйлдэл амжилттай дуусахгүй байх.	Гар утсан дээр баталгаажуулах товч гарсан үед товч дарж бүртгэлийг үргэлжлүүлнэ.
	Гар утас эсвэл мултимедиа систем дээр гар утасны бүртгэлтэй холбоотой мэдээлэл гарсаар байгаа.	Гар утас болон мултимедиа систем дээр бүртгэлийн мэдээллийг устгаад үйлдлийг дахин хийнэ.
Bluetooth®-р холбох боломжгүй байх	Тухайн холбох гэж байгаагаас бусад гар утас Bluetooth®-р холбогдсон байгаа.	Мултимедиа системээс гараар Bluetooth® холболт үүсгэнэ.
	Гар утасны Bluetooth® функц асаагүй.	Асаах товчны <power товч> АСС эсвэл ON горимд гар утасны Bluetooth® функцийг асаана.

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Bluetooth®-р холбох боломжгүй байх	Гар утасны бүртгэлийн мэдээлэл устгагдсан.	Гар утас болон мултимедиа систем дээр бүртгэлийн мэдээллийг устгаад үйлдлийг дахин хийнэ.

■ Дуудлага хийх, хүлээн авах

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Дуудлага хийх, хүлээн авах боломжгүй байх	Сүлжээгүй орчинд байгаа	Автомашиныг сүлжээтэй орчинд шилжүүлнэ.
	Гар утасны дуудлага хязгаарлах функц (дуудлага түгжих) ассан.	Гар утасны дуудлага хязгаарлах функц (дуудлага түгжих) унтраана.

■ Холбоо барих хаяг

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Холбоо барих хаяг шилжүүлэх боломжгүй эсвэл автоматаар шилжихгүй байх	Гар утасны профайл холбоо барих хаяг шилжүүлэхийг дэмждэггүй.	Мултимедиа системд ашиглах боломжтой төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.
	[Sync contacts] тохиргоог мултимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр унтраасан.	[Sync contacts] тохиргоог мултимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр асаана.
	Гар утас хаяг дамжуулах зөвшөөрөл хүлээж байгаа.	Гар утас дээр хаяг дамжуулахыг зөвшөөрсөн товч дарна.
Гар утас дээр хаяг дамжуулахыг баталгаажуулах дэлгэц гарсан	Үргэлж зөвшөөрөх тохиргоог хийгээгүй.	Гар утсан дээр үргэлж зөвшөөрөх тохиргоог хийнэ.

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Холбоо барих хаяг өөр газар хадгалагдсан	Гар утсан дээр хаяг бүртгэгдээгүй.	Гар утсан дээр хаяг бүртгэнэ.
Холбоо барих хаягийг засах боломжгүй байх	[Sync contacts] тохиргоог мультимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр асаасан.	[Sync contacts] тохиргоог мультимедиа системийн Bluetooth® тохиргоо дээр унтраана.

■ Bluetooth® мессеж функц ашиглах үед*1

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Мессеж дэлгэцээр гарахгүй байх.	Гар утсан дээр автоматаар мессеж дамжуулах функц идэвхжээгүй.	Гар утсан дээр мессеж дамжуулах тохиргоог идэвхжүүлнэ.
Шинэ мессежний мэдэгдэл дэлгэцээр гарахгүй байх.	Гар утсан дээр автоматаар мессеж дамжуулах функц идэвхжээгүй.	Гар утасны автоматаар мессеж дамжуулах функцийг идэвхжүүлнэ.

■ Бусад нөхцөлүүд

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Боломжит шийдлийн дагуу арга хэмжээ авсан ч шинж тэмдэг арилахгүй үед.	Гар утас болон мультимедиа систем хоорондоо хэт зайтай.	Гар утас болон мультимедиа системийг ойртуулна.
	Цахилгаан соронзон саад холболтонд нөлөөлж байгаа.	Wi-Fi® төхөөрөмж зэрэг цахилгаан соронзон долгион үүсгэх бүх төхөөрөмжийг унтраана. Мультимедиа системийн Wi-Fi® тохиргоог унтраана.
	Шалтгаан гар утсанд байж болно.	Гар утас унтраагаад зайг салгана.

*1 : Тоноглогдсон автомашинд

Шинж тэмдэг	Боломжит шалтгаан	Шийдэл
Боломжит шийдлийн дагуу арга хэмжээ авсан ч шинж тэмдэг арилахгүй үед.	Шалтгаан гар утсанд байж болно.	Гар утасны Bluetooth® холболтыг асаагаад унтраана.
		Гар утасны Wi-Fi® холболтыг унтраана.
		Гар утасны аливаа аюулгүй байдлын программ эсвэл далд программыг зогсооно.
		Гар утас ашиглахаас өмнө үүрэн холбооны оператор болон суулгасан аппликейшны ажиллагааны байдлыг шалгана.

МЭДЭЭЛЭЛ

Дэлгэрэнгүй мэдээллийг гар утасны зааварчилгаанаас харна уу.

— Холбоотой холбоосууд —

Мултимедиа системээс Bluetooth® төхөөрөмжийн бүртгэл үүсгэх(Х. 113)

Бүртгэлтэй Bluetooth® төхөөрөмж устгах(Х. 116)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 103)

Wi-Fi® холболт салгах(Х. 127)

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)

Гарын оролцоогүй утасны дуудлага хүлээн авах, дуудлага хийх зэрэг зарим функцийг жолооны хүрдний товч ашиглан удирдах боломжтой. Мультимедиа системийн ажиллагааны байдлаас хамаарч жолооны хүрдний товчны ажиллагаа өөрчлөгдөнө.

● Товч дарж удирдана.**[+] товч**


Утасны ая эсвэл ярианы дууны түвшинг нэмнэ.

Үргэлжлүүлэн өөрчлөх үед удаан дарна.

[-] товч

Утасны ая эсвэл ярианы дууны түвшинг хасна.

Үргэлжлүүлэн өөрчлөх үед удаан дарна.

**[📶] товч**

Дуу хоолойн удирдлагаар дуудлага хийх боломжтой.

Дуу хоолойн удирдлагыг дуусгах үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарна.

[📞] товч

● Мультимедиа систем утасны дэлгэц гаргаагүй үед утасны цэс дэлгэцээр гаргана.

● Мультимедиа систем гар утасны дэлгэцийг [📞]-тэй гаргах үед дуудлага хийнэ.

● Мультимедиа систем гар утасны дэлгэцийг [📞]-гүй гаргах үед дуудлагын түүхийн дэлгэц гаргана.

● Дуудлага хийх эсвэл утсаар ярих үед дуудлагыг дуусгана.

● Дуудлага ирэх эсвэл дуудлага хүлээлгэнд байгаа үед дуудлагад хариулна.

📄 МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay эсвэл Android Auto холбогдсон үед [📞]-г дарж мультимедиа системийн дэлгэц дээр Apple CarPlay эсвэл Android Auto утасны дэлгэцийг гаргана.

- Apple CarPlay болон гарын оролцоогүй утас холбогдсон үед -г дарж Apple CarPlay эсвэл мултимедиа утасны дэлгэцийг гаргана. Өмнө нь ашиглаж байсан функцийг нэн тэргүүнд гаргана.
- Android Auto болон гарын оролцоогүй утас холбогдсон үед -г дарж мултимедиа утасны дэлгэцийг гаргана.
- Дуудлага ирэх үед -г дарж утасны дэлгэцийг гарган дуудлагад хариулна (гарын оролцоогүй утас, Apple CarPlay эсвэл Android Auto).

Холбоотой холбоосууд

Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 128)

Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх(Х. 42)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)

vvh1649834505012.dita

Дуудлага хүлээн авах, хийх зэрэг гарын оролцоогүй утасны зарим функцийг жолооны хүрдний товчоор удирдах боломжтой. Мультимедиа системийн ажиллагааны байдлаас хамаарч тус товчны ажиллагаа өөрчлөгдөнө.

Жолооны хүрдний товч нь электростатик товч болно. Хуруугаар товших үед товч ажиллана. Мультимедиа системийн ажиллагааны байдлаас хамаарч дэлгэцээр гарах товчны функц болон байрлал өөр байна.

● Товч ажиллуулна.**[+] товч**

Дуудлагын ая, ярианы дууны түвшин нэмнэ.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

[-] товч

Дуудлагын ая, ярианы дууны түвшин хасна.

Удаан дарж үргэлжлүүлэн тохируулна.

[] товч

Дуу хоолойн командаар дуудлага хийнэ.

Дуу хоолойн командыг дуусгах үед дуудлага хийх, яриаг дуусгах товчийг удаан дарна.

[] товч

● Мультимедиа систем дээр утасны дэлгэцээс өөр дэлгэц гарч байгаа үед дуудлагын түүхийн дэлгэц гаргана.

● Мультимедиа систем утасны дэлгэцийг []-тэй хамт гаргах үед дуудлага хийнэ.

● Мультимедиа систем утасны дэлгэцийг []-тэй гаргаагүй үед дуудлагын түүх харуулна.


● Ярианы дундуур дуудлагыг өөрчлөх/хүлээлгэнд оруулна.

● Дуудлага ирэх, дуудлага хүлээлгэнд байгаа үед дуудлага авна.

[] товч

● Дуудлага хийх эсвэл ярианы дундуур яриаг дуусгана.

● Ирж буй дуудлага/хүлээлгэнд байгаа дуудлагыг цуцлана.



 МЭДЭЭЛЭЛ

- Apple CarPlay эсвэл Android Auto холбогдсон үед -г дарж мультимедиа системийн дэлгэц дээр Apple CarPlay эсвэл Android Auto утасны дэлгэц гаргана.
- Apple CarPlay болон гарын оролцоогүй дуудлага холбогдсон үед -г дарж мультимедиа системийн дэлгэц дээр Apple CarPlay эсвэл мультимедиа утасны дэлгэц гарна. Сүүлд ашигласан функц эхэлж ажиллана. Функц ашиглагдаагүй үед үндсэн төхөөрөмж түрүүлж холбогдоно.
- Android Auto болон гарын оролцоогүй дуудлага холбогдсон үед -г дарж мультимедиа системийн дэлгэц дээр утасны дэлгэц гаргана.
- Дуудлага хүлээн авах үед тухайн утсыг дэлгэцээр -г дарж гаргана (гарын оролцоогүй утас, Apple CarPlay, Android Auto).

Холбоотой холбоосууд


Apple CarPlay болон Android Auto ашиглах үеийн анхааруулга(Х. 128)

Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх(Х. 42)

Дуудлагын түүхээс дуудлага хийх

Ирсэн болон гарсан дуудлагын түүхэнд бүртгэгдсэн дугаар луу дуудлага хийх боломжтой.

- 1 **Үндсэн цэсний [📞]-г дарна.**
- 2 **Дэд цэснээс [Recents]-г дарна.**
- 3 **Хаяг сонгоно.**
Хаягт бүртгэгдээгүй дуудлага дээр зөвхөн дугаар гарна.
- 4 **Утасны дугаар дээр дарна.**



МЭДЭЭЛЭЛ


- Сүүлийн 100 хүртэлх дуудлага гарна. 100-с дээш давсан үед хамгийн хуучин дуудлагын түүх автоматаар устгагдана.
- Тухайн нөхцөлөөс хамаарч гарсан дуудлага дараах байдлаар бүртгэгдэнэ.
 - Холбоо барих хаяг, навигацийн системд бүртгэлтэй хаяг руу дуудлага хийсэн үед хаягны нэр болон зураг (зураг бүртгэсэн үед) харагдана.
 - Нэг дугаар луу олон дуудлага хийсэн үед нэрийн ард дуудлага хийсэн тоо гарна.
- Тухайн нөхцөлөөс хамаарч ирсэн дуудлага дараах байдлаар бүртгэгдэнэ.
 - Холбоо барих хаяг, навигацийн системд бүртгэлтэй хаягнаас дуудлага ирсэн үед хаягны нэр болон зураг (зураг бүртгэсэн үед) харагдана.
 - Нэг дугаараас олон дуудлага ирсэн үед нэрийн ард дуудлага хийсэн тоо гарна.
 - Аваагүй эсвэл цуцласан дуудлага мөн бүртгэгдэнэ.
 - Залгагчийн дугаар харагддаггүй сүлжээнээс дуудлага ирсэн үед "Unknown" гэж гарна.
- Хүлээлгэнд оруулсан дуудлага мөн бүртгэгдэнэ.
- Гар утасны загвараас хамаарч олон улсын дуудлага хийх боломжгүй байж болно.

Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх

pux1649834505215.dita

Холбоо барих хаягийг тогтмол ашигладаг жагсаалтад оруулан дуудлага хийх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [📧]-г дарна.
- 2 Дэд цэсний [Favorites]-г дарна.
- 3 Тогтмол ашигладаг жагсаалтаас дуудлага хийх хаяг сонгоно.
- 4 Утасны дугаар сонгоно.



МЭДЭЭЛЭЛ

- [Sync contacts] идэвхтэй үед гар утасны тогтмол ашигладаг жагсаалт мултимедиа системд автоматаар дамжуулагдана.
- Гар утасны загвараас хамаарч жагсаалт автоматаар дамжуулагдахгүй байж болно.
- Мултимедиа систем дээр мөн тогтмол ашигладаг жагсаалтад нэмэх боломжтой.

Холбоотой холбоосууд


Холбоо барих хаягийг дамжуулах(Х. 244)

Холбоо барих хаяг руу дуудлага хийх

otx1649834504949.dita

Мултимедиа системд бүртгэлтэй хаяг руу дуудлага хийх боломжтой.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэсний [Contacts]-г дарна.
- 3 Хаяг сонгоно.
- 4 Утасны дугаар дээр дарна.



МЭДЭЭЛЭЛ

- Дэлгэц дээр [Sync contacts] товч гарч байгаа үед тус товч дарж гар утаснаас холбоо барих хаягийг мултимедиа системд шилжүүлнэ.
- Хаяг бүртгэгдээгүй үед гар утаснаас шилжүүлэх эсвэл шинээр бүртгэх шаардлагатай.
- Ашигласан гарын оролцоогүй гар утасны хаягийг мултимедиа систем дээр гаргана.
2 гар утас холбогдсон ба гарын оролцоогүй дуудлагад ашиглах гар утас солигдсон үед хаяг мөн солигдоно.

Холбоотой холбоосууд

[Холбоо барих хаягт шинэ хаяг нэмэх\(Х. 248\)](#)

[Холбоо барих хаягийг дамжуулах\(Х. 244\)](#)


Дэлгэцийн гарнаас дуудлага хийх

kkg1649834505278.dita

Дэлгэцийн гараар утасны дугаар оруулан дуудлага хийнэ.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Keypad]-г дарна.
- 3 Утасны дугаар оруулна.
- 4 [📞]-г дарах эсвэл жолооны хүрдний [📞] товч дарна.

Дэд цэсний хаяг дээр даран дуудлага хийх боломжтой.

**МЭДЭЭЛЭЛ**

Гар утасны загвараас хамаарч гар утас дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.

Холбоотой холбоосууд

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)(Х. 224)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)(Х. 226)

Хүлээх эсвэл түр зогсоох дохио ашиглан дуудлага хийх


ffh1649834504590.dita

Wait (w) буюу хүлээх эсвэл pause (p) буюу түр зогсоох дохио агуулсан тоон сигналаар дуудлага хийх боломжтой. Хүлээх (w) эсвэл түр зогсоох (p) сигналын дараах тоог дамжуулах үйлдэл 2 секундын хугацаанд түр зогсоох эсвэл болиулдаг.

- Хүлээх (w) сигнал нь тоон дамжуулалтыг түр зогсоодог. Хэрэглэгч дараагийн хүлээх (w) эсвэл түр зогсоох (p) сигнал өгөх үед дамжуулалт дахин сэргэдэг.
- Түр зогсоох (p) сигнал нь тоо дамжуулалтын 2 секундын хугацаанд зогсоодог.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Contacts]-г дарна.
- 3 Холбоо барих хаягийг сонгоно.
- 4 Хүлээх (; эсвэл w) эсвэл түр зогсоох (эсвэл p) сигнал агуулсан утасны дугаар сонгоно.
- 5 Хүлээх (w) сигналтай утасны дугаарт [⋮]-г сонгоно.

Дараах [📞]-г дарсан үед дараагийн удаа хүлээх (w) эсвэл түр зогсоох (p) сигнал өгөх хүртэл хүлээх (w) сигналаар дамжуулалт түр зогсоогдоод байсан тоо дамжуулалт сэргэнэ.



МЭДЭЭЛЭЛ


- Гар утасны загвараас хамаарч хүлээх сигнал гар утасны дэлгэц дээр таслалаар (,) мөн түр зогсоох сигнал цэг таслалаар (;) илэрхийлэгдэж болно.
- Тус функцийг олон улсын дуудлага хийхэд ашиглана.
- Банкны лавлах утас, автомат хариултын үйлчилгээ зэрэг утсан харилцаанд суурилсан автомат үйлчилгээнд тохиромжтой. Хүлээх (w) эсвэл түр зогсоох (p) сигналтай утасны дугаарыг холбоо барих хаягийн жагсаалтад хадгалах боломжтой.

Дуудлагад хариулах

Дуудлага ирэх үед ая дуугарч ирж буй дуудлагын дэлгэц эсвэл мэдэгдэл дэлгэц дээр гарна. Дуу хоолойн удирдлагын систем дээр [Voice support]-г идэвхжүүлсэн нөхцөлд дуудлага ирэх үед тус систем ажиллана.

● Дараах аль нэг үйлдлээр дуудлагад хариулна.

- [📞] -г дарна.
- Жолооны хүрдний [📞] товч дарна.
- Дуу хоолойн команд өгч дуудлагад хариулна.



📖 МЭДЭЭЛЭЛ

- Ойр орчмыг харуулах камерын дэлгэц гарч байгаа үед ирж буй дуудлагын дэлгэц гарахгүй. Зөвхөн ая дуугарч дуудлага ирснийг мэдэгдэнэ.
- Дуудлага ирэх үед гарын оролцоогүй дуудлагаас бусад бүх дуу хаагдана. Нөгөөтэйгүүр гарын оролцоогүй дуудлагаас давуу эрхтэй дуут зааварчилгааны дуу хаагдахгүй.
- Гар утасны аяыг мултимедиа систем дээр тохируулсан ч гар утасны тохиргооноос хамаарч мултимедиа системээс өөр ая дуугарч болно.
- Жолоодлогын горим зэрэг гар утасны тохиргооноос хамаарч дуудлага хүлээн авах боломжгүй байж болно.
- Гар утасны тохиргооноос хамаарч дараах зүйлс үүсч болно.
 - Дуудлагын ая утас болон спикерээс зэрэг дуугарч болно.
 - Дуудлага хүлээн авах үед залгасан хүний дугаар харагдахгүй байж болно.
 - Гар утас дээр даран дуудлага хүлээн авсан эсвэл гар утас автоматаар дуудлага хариулсан үед дуудлага гар утсан дээр үлдэж болно.
 - Гар утас дата дамжуулах үед дуудлага ирсэн нөхцөлд мултимедиа систем дээр ирж буй дуудлагын дэлгэц гарахгүй байх, ая дуугарахгүй байж болно.
- Гар утас автоматаар хаяг дамжуулах (PBAP) функц дэмждэг үед холбоо барих хаягийн датаг дамжуулах ба [Display contact images]-г идэвхжүүлсэн үед тухайн хаягны зураг утасны дугаарын хамт гарна.

- Мультимедиа системийн утасны аяыг гар утаснаас өөр аяар тохируулсан үед гар утасны дууг хаасан (чичирхийлэх) эсвэл аяыг устгасан байсан ч мультимедиа системд тохируулсан ая дуугарна.
- Гар утасны тохиргоогоор дуудлага хүлээн авахгүй тохиргоо хийсэн дугаараас дуудлага ирэх үед систем дуудлагыг цуцлана.

Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх(Х. 72)

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)(Х. 224)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)(Х. 226)

Дуу хоолойн удирдлагаар систем удирдах(Х. 40)

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 103)

Дуудлага цуцлах

kex1649834505199.dita

Гарын оролцоогүй дуудлага дуусгах дараах аргууд байдаг.

● Дуудлага ирсэн үед дараах аль нэг үйлдлийг хийнэ.

- -г дарна.
- Гар утас даран дуудлага дуусгана.
- Дуут команд өгч дуу хоолойн удирдлагын системээр дуудлага цуцлана.

МЭДЭЭЛЭЛ

Гар утасны тохиргоогоор дуудлага хүлээн авахгүйгээр тохируулсан дугаараас ирсэн дуудлага цуцлагдана.

— Холбоотой холбоосууд —

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)(Х. 224)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)(Х. 226)

Дуу хоолойн удирдлагаар систем удирдах(Х. 40)


Дуудлагын дэлгэц дээр үйлдэл хийх

Дуудлагын үед дуудлагын дэлгэц дээр олон төрлийн үйлдэл хийх боломжтой.

[🔇]: Дуудлагын үед ярилцаж буй талд өөрийн дууг сонгохгүйгээр дууг хаана. Дууг хаах үед товч цэнхэр болно.

Цуцлах үед товчийг дахин дарна.

Энэ үед ярилцаж буй хүний дууг сонсох боломжтой.



[⋮]: Дэлгэцийн гар харуулна. Энэ үед дуудлагын дэлгэц жижиг болно.

[📞]: Дуудлагын үед таслах.

[+👤]: Өөр хүн рүү дуудлага хийх үед дэд цэсний хаягийн жагсаал гаргана.

● Дуудлагын үед утасны дугаар дээр дарж өөр хүн рүү дуудлага хийх боломжтой.

[📁]: Дуудлагыг гар утас болон мультимедиа систем хооронд шилжүүлнэ. Гар утаснаас дуудлага хийх үед товч цэнхэр болно.

[🔊]: Хүлээгдэж буй дуудлагыг цуцлана. Зөвхөн дуудлага хүлээлгэнд байгаа үед гарна.

[⌵]: Дуудлагын дэлгэцийг жижигрүүлнэ.


[⌶]: Дуудлагын дэлгэцийг үндсэн хэсэгт гаргана.

[⋮]: Сонголтын дэлгэц гаргана.

Сонголтын дэлгэцнээс дараах үйлдлийг хийх боломжтой.

● [Transmit]: Ярианы дууны түвшин тохируулна.

Ярианы дууны түвшин тохируулах нь дууны чанар буурахад хүргэж болзошгүй.



- **[Navigation]^{*1}** : Навигацийн системийн дуут зааварчилгааны дууг хаана.
Идэвхгүй болгох үед **[Navigation]**-г унтраана.
- **[On hold]** : Дуудлагыг түр хүлээлгэнд оруулах.
Идэвхгүй болгох үед **[On hold]**-г унтраана.
Гар утасны загвараас хамаарч дуудлага хүлээлгэнд оруулах боломжгүй байж болно.
- **[×]** : Дуудлагын дэлгэц рүү буцна. Дуудлага хүлээлгэнд байгаа үед дуудлагын дэлгэц рүү буцсан нөхцөлд сонголтын дэлгэцийг дахин гарган дуудлага хүлээлгийг зогсоох боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Мультимедиа системийн статусаас хамаарч дуудлагын дэлгэц жижигрэх эсвэл гарахгүй байж болно.
- Гар утасны загвараас хамаарч гар утас болон систем хооронд дуудлага шилжүүлэх боломжгүй байж болно.
- Жолоодлогын үед гарын оролцоогүй утасны системээс гар утас руу дуудлага шилжүүлэх боломжгүй. Гар утасны загвараас хамаарч гар утас болон систем хооронд дуудлага шилжүүлэх боломжгүй байж болно.
- Утсаар ярьж буй гар утсыг мультимедиа системд гарын оролцоогүй утсаар холбосон үед дуудлага хийгдэж байгаа дэлгэц гарна. Гар утасны загвараас хамаарч дуудлага гар утас болон мультимедиа системээс зэрэг хийгдэж болно.
- Гарын оролцоогүй утсаар дуудлага хийх явцдаа асаах товч <power товч> унтраасан нөхцөлд дуудлага тасрах эсвэл гар утасны загвараас хамаарч гар утсан дээр дуудлага үргэлжлэн хийгдэнэ. Гар утсан дээр үргэлжлүүлэх үед утсан дээр үйлдэл хийх шаардлагатай байж болно.

— Холбоотой холбоосууд —

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)(Х. 224)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)(Х. 226)

*1 : Навигацийн функцтай

Давхар дуудлагад хариулах

rwk1649834504699.dita

Дуудлага дундуур давхар дуудлага ирсэн нөхцөлд та дуудлага хүлээлгэх функцаар 2 дуудлагыг удирдах боломжтой. Давхар дуудлага ирсэн үед дэлгэцийн дээд талд мэдэгдэл гарна.


МЭДЭЭЛЭЛ

- Та өөрийн үүрэн холбооны операторын давхар дуудлага хүлээн авах үйлчилгээнд хамрагдсан байх шаардлагатай.
- HFP Ver 1.5 ба түүнээс хойших хувилбарыг дэмждэггүй гар утсаар давхар дуудлага хүлээн авах боломжгүй.
- Гар утасны загвар болон хамрагдсан багцаас хамаарч тус функцийг ашиглах боломжгүй байж болно.

- **Давхар дуудлагыг хүлээн авах үед [📞]-г дэлгэц дээр дарах эсвэл жолооны хүрдний [📞] товчийг дарна.**

Давхар дуудлага хүлээн авах үед өмнөх дуудлага хүлээлгийн горимд шилжинэ.

Дуудлага хооронд шилжүүлэх үед [Swap calls]-г дарна.

**Холбоотой холбоосууд**

[Жолооны хүрдний товчоор удирдах \(А төрөл\)\(Х. 224\)](#)

[Жолооны хүрдний товчоор удирдах \(В төрөл\)\(Х. 226\)](#)

Давхар дуудлагыг цуцлах

jak1649834504715.dita

Дуудлага дундуур давхар дуудлага орж ирэх үед дуудлагыг хүлээлгэнд оруулалгүй цуцлах боломжтой.

Давхар дуудлага орж ирэх үед [📞]-г дарна.

МЭДЭЭЛЭЛ

Гар утасны загвараас хамаарч 2 дуудлагыг зэрэг салгаж болно. Гар утасны хэрэглэгчийн гарын авлагаас дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

Холбоотой холбоосууд

[Жолооны хүрдний товчоор удирдах \(А төрөл\)\(Х. 224\)](#)

[Жолооны хүрдний товчоор удирдах \(В төрөл\)\(Х. 226\)](#)

Дуудлага дундуур өөр хүн рүү дуудлага хийх

amb1649834505231.dita


Та дуудлага дундуураа өөр хүн рүү давхар дуудлага хийх боломжтой.

1 Дуудлагын дэлгэц дээр []-г дарна.

2 Холбоо барих хаяг сонгоно.

3 Утасны дугаар сонгоно.

Тус функц нь шинэ дуудлага хийх үед одоогийн дуудлагыг хүлээлгийн горимд шилжүүлнэ.



МЭДЭЭЛЭЛ

- Та өөрийн үүрэн холбооны оператортой давхар дуудлага хийх үйлчилгээний гэрээ хийх шаардлагатай.
- Хэрэв гар утас HFP Ver 1.5 ба түүнээс хойших хувилбар дэмждэггүй нөхцөлд давхар дуудлага хийх боломжгүй.
- Гар утасны загвар болон үүрэн холбооны операторын үйлчилгээний багцаас хамаарч тус функцийг ашиглах боломжгүй байж болно.

Олон хүнтэй зэрэг дуудлага хийх

nlq1649834504731.dita

Өөр дуудлага хүлээлгэнд байгаа үед одоо ярьж буй дуудлагадаа хүлээж буй хүнийг нэмнэ.

● Утсаар ярих үедээ [Merge calls]-г дарна.

Хүлээлгэнд байгаа дуудлагыг хүлээн авч нэгэн зэрэг олон хүнтэй ярилцах горимд шилжинэ.

МЭДЭЭЛЭЛ

- Үүрэн холбооны оператортойгоо тус үйлчилгээний гэрээ хийх шаардлагатай.
- Гар утасны загвар болон хамрагдсан үйлчилгээнээс хамаарч тус функцийг ашиглах боломжгүй байж болно.
- Дуудлага дуусах үед бүх ярилцаж буй хүмүүстэй утасны яриа дуусна.

Дуудлага дуусгах

uxz1649834504668.dita

Гарын оролцоогүй дуудлага дуусгах дараах аргууд байдаг.

● **Дуудлагын үед дараах аль нэг үйлдлийг хийнэ.**

- Жолооны хүрдний [] товч дарна.
Тус товчийг удаан дарсан үед хүлээлгэнд байгааг оруулаад бүх дуудлага дуусгана.
- Дуудлага хийх эсвэл дуудлагын дэлгэц гарсан үед []-г дарна.
- Гар утас даран дуудлага дуусгана.

— **Холбоотой холбоосууд** —

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)(Х. 224)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)(Х. 226)

Гарын оролцоогүй дуудлагад ашиглах гар утас солих

Нэгэн зэрэг 2 гар утас гарын оролцоогүй утсаар холбогдсон үед зэрэг ашиглах боломжтой. Гарын оролцоогүй утас нь ашиглах гар утас солих функцтай байдаг. Гарын оролцоогүй утасны дэлгэц дээр тухайн ашиглахаар сонгосон хаяг, түүх зэрэг мэдээллийг гаргана. Сонгоогүй гар утсанд дуудлага ирэх үед гарын оролцоогүй утас хүлээн авах боломжтой.


Гарын оролцоогүй утсанд 2 гар утас холбох үед эхлээд жолоочийн тохиргоо хийх шаардлагатай.

1 Үндсэн цэсний [📞]-г дарна.

2 [Devices]-г дарна.

3 Ашиглах гар утсаа сонгоно.

Ярьж буй, дуудлага хүлээн авч болон хийж байгаа гар утсыг сонгох боломжгүй.



📄 МЭДЭЭЛЭЛ

- Гарын оролцоогүй утасны дэлгэцээс өөр дэлгэцнээс дуудлага хийсэн үед дуудлага үндсэн төхөөрөмжөөс хийгдэнэ.
- Хоёр төхөөрөмжийн аль нэгийг ашиглан гарын оролцоогүй дуудлага хийж байгаа үед нөгөө төхөөрөмжөөс дуудлага хийх боломжгүй.
- Аль нэг гар утсаар дамжуулан гарын оролцоогүй дуудлага хийж байгаа үед нөгөө утсаар орж ирсэн дуудлагыг гарын оролцоогүй утасны функцаар хүлээн авсан нөхцөлд эхний дуудлага таслагдана.
- Сонгоогүй гар утсан дээр дараах функц ашиглах боломжтой.
 - Дуудлага хүлээн авах
 - Мессеж хүлээн авах болон илгээх (мессеж ирсэн үед)*1
- Ашиглах гар утсыг сольсон ч системд холбогдох үндсэн төхөөрөмж заавал өөрчлөгдөхгүй.

*1 :Тоноглогдсон автомашинд

— **Холбоотой холбоосууд** —

Хэрэглэгчийн профайл бүртгэх(Х. 52)

Хэрэглэгчийн профайл бүртгэх, өөрчлөх(Х. 60)

Үндсэн төхөөрөмжөөр Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 121)

Холбоо барих хаягийг дамжуулах

Холбосон гар утас бүрт 5,000 холбоо барих хаягийг бүртгэх боломжтой. Зөвхөн тухайн холбогдсон гар утасны хаяг дэлгэцээр гарна. Хаяг тус бүрт 4 хүртэлх утасны дугаар хадгалах боломжтой. Хаягийг холбосон гар утас тус бүрд тусад нь санадаг.

Тус функцийг зөвхөн хаяг гар аргаар дамжуулах (OPP) эсвэл автоматаар дамжуулах (PBAP) функц дэмждэг гар утастай ашиглах боломжтой. Дэлгэрэнгүйг гар утасны зааварчилгаанаас харна уу.

Хаяг автоматаар (PBAP) дамжуулах үед **[Sync contacts]**-г Bluetooth® тохиргоо дээр идэвхжүүлэх шаардлагатай.

МЭДЭЭЛЭЛ

- Дата өгөгдөл дамжуулах үед дараах хязгаарлалтууд байдаг.
 - Нэг холбоо барих хаяг дээр 5-с олон утасны дугаар бүртгэгдсэн үед бүх утасны дугаар нь адил нэртэй өөр өөр холбоо барих хаягаар мултимедиа систем дээр бүртгэгддэг.
 - Утасны дугаартай нэг зэрэг нэр дамжуулагддаг. Загвараас хамаарч ханз үсэг, тэмдэгтүүд эсвэл бүх үсгүүд дамжуулагдахгүй байж болно. Мөн систем руу дамжуулагдсан ч дэлгэцээр зөв гарахгүй байж болно.
 - Нууцлалтай санах ойг ихэвчлэн уншдаггүй. (Гар утасны техник үзүүлэлтээс хамаарч зарим тохиолдолд боломжтой)
 - Гар утсанд бүртгэгдсэн холбоо барих хаягийн бүлэгчилсэн нэр дамжихгүй.
 - Мултимедиа систем дэх утасны дугаарын төрлүүдийг эх үүсвэр төхөөрөмжийн мэдээлэл дээр үндэслэн автоматаар тодорхойлдог. Нөгөөтэйгүүр гар утасны загвар, ашиглалтын нөхцөлөөс хамаарч бүх хаяг дээрх тэмдэг адил байж болно.
 - Гар утасны загвараас хамаарч хаяг дамжуулах үед гар утасны пин, бусад баталгаажуулах үйлдэл хийх шаардлагатай байж болно. Энэ нөхцөлд баталгаажуулах үг болгож **[1234]**-г оруулна.
 - Гар аргаар холбоо барих хаяг дамжуулах (OPP) функцгүй гар утасны хаягийг Bluetooth®-р шилжүүлэх боломжгүй.
- Хаяг дамжуулах үед багцаар дамжуулах функц дэмждэг гар утас нь дараах онцлогтой.
 - Дамжуулалтанд 10 хүртэлх минут шаардагдаж болно.
 - Хаяг дамжуулж байгааг харуулсан дэлгэц гарсан үед бусад дэлгэц рүү шилжүүлэх боломжтой. Энэ нөхцөлд хаяг дамжуулалт үргэлжилнэ.
- Хаяг дамжуулах үед дараах үйлдлүүдийг хийх боломжтой.

- Гар аргаар хаяг дамжуулах (OPP) үед дуудлага ирсэн нөхцөлд гар утаснаас хариулна. Мультимедиа системээр дуудлага хүлээн авах боломжгүй.
- Хэрэв гар утас хаяг автоматаар дамжуулах (PBAP), гар аргаар дамжуулах (OPP) функцуудыг дэмждэггүй үед хаягийг Bluetooth®-р дамжуулах боломжгүй. Холбоо барих хаягийг USB флашаар дамжуулах боломжтой.
- Хаяг дамжуулах үед асаах товч <power товч> унтраасан үед дамжуулалт цуцлагдана. Энэ нөхцөлд асаах товч <hybrid систем> систем дахин асаана.
- Дараах нөхцөлүүдэд дамжуулалт хаягийн өгөгдөл хадгалагдахгүй. (зарим дата өгөгдөл мөн хадгалагдахгүй.)
 - Мультимедиа системийн санах ойн багтаамжаас шалтгаалж автоматаар хаяг дамжуулах (PBAP) функц дамжуулалтын явцад зогссон.
 - Бусад шалтгаанаар автоматаар хаяг дамжуулах (PBAP) функцийн ажиллагаа зогссон.
- Мультимедиа системийн хаягийн өгөгдлийг гар утас руу дамжуулах боломжгүй.
- Хаягийн жагсаалт дамжуулах үед Bluetooth® аудиоогийн холболт салж болно. Дууссан үед дахин холбогдоно. (Зарим загвар дахин холбогдохгүй байж болно.)
- Дамжуулах үед мультимедиа системийг асаана.
- Автоматаар хаяг дамжуулах (PBAP) функц нь хаяг, тогтмол ашигладаг хаяг, түүхийн мэдээллийг мультимедиа системд дамжуулдаг. Зарим гар утас тогтмол ашигладаг хаягийг дамжуулдаггүй.
- [Sync contacts] асаалттай үед мультимедиа системд гар утасны тогтмол ашигладаг хаягууд автоматаар дамжуулагдана.
- Загвараас хамаарч автоматаар хаяг дамжуулах (PBAP) функц ашиглах үед гар утас дээр үйлдэл хийх шаардлагатай байдаг.
- Автоматаар хаяг дамжуулах (PBAP) функц ашиглах үед гар утас дээр хаягийн мэдээлэл хуваалцах тохиргоог хийнэ.
- Автоматаар хаяг дамжуулах (PBAP) функц асаагүй үед бусад бүх функцийн үйлдэл дуусах үед асна.
- Холбоо барих хаягны зургийг дэлгэцээр гаргах үед [Display contact images]-г Bluetooth® тохиргоон дээр асаана. Хаягны зургийг шилжүүлэх үед [Sync contacts] болон [Display contact images] тохиргоог Bluetooth® тохиргоон дээр асаана.

— Холбоотой холбоосууд —

Bluetooth® төхөөрөмж тохируулах(Х. 103)

Гар аргаар дамжуулах (OPP)-р гар утасны холбоо барих хаяг дамжуулах

dro1649834504778.dita

Гар утсанд бүртгэгдсэн утасны дугаар (холбоо барих хаяг)-г OPP-г ашиглан мултимедиа систем рүү дамжуулах боломжтой.

[Sync contacts]-г идэвхжүүлсэн үед утасны хаяг дамжуулж дууссан үед идэвхгүй болно.

МЭДЭЭЛЭЛ

Android Auto-р гар утас холбогдож өгөгдөл дамжуулж байгаа үед OPP-р холбоо барих хаяг дамжуулах боломжгүй.

- 1 **Үндсэн цэсний**  -г дарна.
- 2 **Дэд цэснээс** [update contacts] ([Edit contacts])-г дарна.
- 3 **Дараах шилжүүлэх аргуудаас сонгоно.**

[Overwrite with Bluetooth] :
Одоогийн холбоо барих хаяг дээр давхарлан хадгална.

[Add with Bluetooth] :
Одоогийн холбоо барих хаяг дээр нэмж хадгална.

- 4 **Гар утас ажиллуулан холбоо барих хаяг шилжүүлнэ.**

Үйлдэл амжилтгүй болсныг илтгэсэн мэдээлэл гарсан үед дахин эхнээс нь эхлэнэ.



— Холбоотой холбоосууд —

[Bluetooth® техник үзүүлэлт ба дэмжих функцууд\(X. 111\)](#)

USB флаш ашиглан холбоо барих хаягийг дамжуулах

hsh1649834505028.dita

USB флашинд хадгалагдсан утасны дугаар (холбоо барих хаягийн дата)-г мултимедиа системд шилжүүлэх боломжтой.

- **[Sync contacts]-г** идэвхжүүлсэн үед USB флаш дахь хаягийг шилжүүлэх боломжгүй.
- Apple CarPlay эсвэл Android Auto холбоотой үед тус функцийг ашиглах боломжгүй.
- Зөвхөн USB флашинд хадгалсан vCard format (.vcf) форматтай хаягийг шилжүүлэх боломжтой.

- USB флаш дискнээс өгөгдөл дамжуулах боломжгүй. Үйлдэл эхлэхээс өмнө гар утсыг мултимедиа системд ашиглах боломжтой эсэхийг шалгана уу.

1 **USB портонд USB флаш залгана.**

2 **Үндсэн цэсний [📞]-г дарна.**

3 **Дэд цэснээс [update contacts] ([Edit contacts])-г дарна.**

4 **Дараах шилжүүлэх аргаас сонгоно.**

[Overwrite with USB] : Одоо байгаа холбоо барих хаягийг USB флаш дахь хаягаар солино.

[Add with USB] : Одоо байгаа холбоо барих хаяг дээр USB флаш дахь хаягийг нэмнэ.



5 **Жагсаалтаас шилжүүлэх файлаа сонгоно.**

6 **[OK]-г дарна.**

Үйлдэл амжилттай дуусаагүй мэдээлэл гарсан үед дахин эхлэнэ.

МЭДЭЭЛЭЛ

vCard форматтай дата нь гар утас USB-р холбон дамжуулах боломжтой. Зарим нөхцөлд гар утсанд хийсэн SD картаас мөн дамжуулах боломжтой.

Холбоотой холбоосууд

[USB портод холбох\(X. 39\)](#)

Холбоо барих хаягт шинэ хаяг нэмэх

glz1649834505043.dita

Мултимедиа систем дээр хаягийн мэдээлэл оруулан шинэ хаяг үүсгэх боломжтой. Хаяг бүрт нэр, утасны дугаар (4 хүртэлх) болон утасны төрөл (дугаар бүрт гэр, гар утас зэрэг 1 төрөл) бүртгэх боломжтой.

- Дуудлагын түүхийн дэлгэцнээс хаяг засах дэлгэцэнд шилжүүлэн **[Modify contact list]** дарж шинэ хаяг нэмэх боломжтой.
- **[Sync contacts]**-г идэвхжүүлсэн үед мултимедиа систем дээр шинэ хаяг нэмэх боломжгүй. Эхлээд **[Sync contacts]**-г унтраана.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс **[update contacts]** (**[Edit contacts]**)-г унтраана.
- 3 **[Add manually]**-г дарна.
- 4 Шаардлагатай мэдээллийг оруулна.

- Нэмэлт дугаар нэмэх үед **[Add number]**-г дарна.

Утасны дугаар оруулаагүй үед дугаар нэмэх боломжгүй.

- Утасны дугаарын төрөл (гэр, гар утас зэрэг) сонгоно.



- 5 **[Save]**-г дарна.

Нэр, дуудлага, утасны дугаар оруулаагүй үед хадгалах боломжгүй.

Холбоотой холбоосууд

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)

[Дуудлагын түүхээс дуудлага хийх\(X. 228\)](#)

Холбоо барих хаягийн датаг өөрчлөх

xhf1649834504824.dita


Бүртгэгдсэн холбоо барих хаягийн датаг өөрчлөх боломжтой.

[Sync contacts] идэвхтэй үед мултимедиа системийн хаягийг өөрчлөх боломжгүй. Эхлээд **[Sync contacts]**-г унтраана.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэсний **[update contacts]** (**[Edit contacts]**)-г дарна.
- 3 **[Edit manually]**-г дарна.
- 4 Өөрчлөх хаягийг сонгоно.

5 Өөрчлөлт хийнэ.

- Шинэ утасны дугаар нэмэх үед [Add number]-г дарна.
- Утасны дугаарын доор дугаарын төрлийг (гэр, гар утас зэрэг) сонгоно.



6 [Save]-г дарна.

Нэр, утасны дугаар оруулаагүй үед хадгалах боломжгүй.

— Холбоотой холбоосууд —

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)


Холбоо барих хаяг устгах

qex1649834505121.dita

Бүртгэсэн хаяг устгах боломжтой.

[Sync contacts]-г идэвхжүүлсэн үед мултимедиа системийн хаяг устгах боломжгүй. [Sync contacts]-г унтраагаад устгана.

- 1 Үндсэн цэсний [📞] -г дарна.
- 2 Дэд цэсний [update contacts] ([Edit contacts])-г дарна.
- 3 [Delete manually]-г дарна.
- 4 Устгах хаяг сонгоно.
- 5 Дэд цэсний доод талын [Delete]-г дарна.



— Холбоотой холбоосууд —

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)


Тогтмол ашигладаг хаягаар бүртгэх

lvn1649834504981.dita

Тогтмол ашигладаг холбоо барих хаягийг бүртгэх боломжтой.

Тус функцийг ашиглах үед **[Sync contacts]**-г унтраана.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Contacts] эсвэл [Recents]-г дарна.
- 3 Бүртгэх дата өгөгдлийг сонгоно.
- 4 Бүртгэх дата өгөгдлийн [❤️]-г сонгоно.

**Холбоотой холбоосууд**

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)


Тогтмол ашигладаг тохиргоог устгах

bcn1649834504746.dita

Бүртгэгдсэн тогтмол ашигладаг тохиргоог устгах боломжтой.

Тус функцийг ашиглах үед **[Sync contacts]**-г унтраана.

- 1 Үндсэн цэсний [📞]-г дарна.
- 2 Дэд цэснээс [Favorites], [Contacts] эсвэл [Recents]-г дарна.
- 3 Устгах гэж буй датаг сонгоно.
- 4 Устгах датаны [❤️]-г дарна.

**Холбоотой холбоосууд**

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)

Мессежний функц ашиглах үеийн анхааруулга

Мессеж нь гарын оролцоогүй утсаар холбогдсон гар утсаар илгээгддэг. Мультимедиа систем нь мессеж шалгах, хариулах, илгээх боломжтой. Холбогдсон гар утасны загвараас хамаарч мультимедиа системд мессеж дамжуулах боломжгүй байж болно. Мессеж дэмждэггүй гар утсанд тус функцийг ашиглах боломжгүй.

Тус функцийг HFP болон MAP дэмждэг гар утастай ашиглах боломжтой. HFP болон MAP дэмждэг эсэхийг гар утасны гарын авлагаас шалгана уу.

Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

- Гар утас дээр мессежийг бусад төхөөрөмжид дамжуулах тохиргоо хийх шаардлагатай.
- Тус функцийг яаралтай түргэн тусламжийн зэрэг ослын дуудлага хийх үед ашиглах боломжгүй.
- Гар утасны загвараас хамаарч и-мэйл функцийг ашиглах боломжгүй байж болно.
- Гар утасны загвараас хамаарч хариу илгээх функцийг ашиглах боломжгүй байж болно.
- Мессежний аль нэг функц ашиглагдах үед мессеж автоматаар дамжуулагдана.
- Гар утасны загвараас хамаарч гар утсан дээр нэмэлт үйлдэл хийх шаардлагатай байж болно.
- SMS мессежний гарчиг дэлгэцээр гарахгүй.
- Гар утасны загвараас хамаарч хүлээн авсан MMS мессежний гарчиг дэлгэцээр гарахгүй байж болно.
- **[Auto read messages]** функц асаалттай үед мессежийг систем чангаар уншина.
- Дуу хоолойн удирдлагын системд орсон мессежийг систем чангаар уншина.
- Гар утасны загвар болон мультимедиа системд холбогдсон байдлаас хамаарч зарим мэдээллийг дэлгэцээр харуулах боломжгүй байж болно.

— Холбоотой холбоосууд —

[Bluetooth® төхөөрөмж тохируулах\(X. 103\)](#)

Мессеж шалгах


Илгээсэн болон хүлээн авсан мессеж шалгах боломжтой.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэснээс [Messages]-г дарна.
- 3 Хэрэглэгчийн аккаунт сонгоно.
- 4 Илгээгч сонгоно.
- 5 Шалгах мессежээ сонгоно.

[]: Мессежний дэлгэцийг томруулах буюу жижигрүүлнэ.

[]: Мессеж хариу бичих дэлгэц харуулна.

[]: Мессежийг чангаар уншина.



Мессеж дуугарч унших үйлдлийг зогсоох үед []-г дарна.

[]: Мессеж илгээгч рүү дуудлага хийнэ.

Хаяг бүртгэсэн байдлаас хамаарч утасны дугаар заавал бүртгэх шаардлагатай.

[]: Харилцагч талын хаягийн мэдээлэл харуулна.

МЭДЭЭЛЭЛ

И-мэйл мессежний томруулсан дэлгэц сонгогдсон үед **[Mark Unread]** эсвэл **[Mark Read]**-г дарж мессеж уншсан, уншаагүй тэмдэглэгээ хийнэ.

— Холбоотой холбоосууд —

[Мессежинд хариу өгөх\(Х. 253\)](#)

[Мессежний функцаас дуудлага хийх\(Х. 256\)](#)

[Холбоо барих хаяг руу дуудлага хийх\(Х. 230\)](#)

Шинэ мессеж шалгах


xfi1649834504918.dita

И-мэйл, SMS эсвэл MMS мессеж ирсэн үед дэлгэцний дээд талд шинэ мессежний мэдэгдэл гарна. **[Voice support]** функц идэвхтэй үед дуу хоолойн систем*¹ ажиллаж эхлэнэ.

● Мессеж ирэх үед дараах үйлдлийг хийх боломжтой.

[] : Дэлгэцээр мессеж харуулна.

[] : Мессежийг дуудаж уншина.



— Холбоотой холбоосууд —

[Дуу хоолойн удирдлагын тохиргоо өөрчлөх\(Х. 72\)](#)

[Мессежинд хариу өгөх\(Х. 253\)](#)

Мессежинд хариу өгөх

uyei649834504934.dita

Хүлээн авсан мессежинд хариу илгээх боломжтой.

● Дуу хоолойн удирдлагын системээр хариу өгөх боломжтой.*2
(Хурдан хариу)

● Дуу хоолойн систем ашиглах үед [] товч дарна.

- 1 Үндсэн цэсний []-г дарна.
- 2 Дэд цэсний [Messages]-г дарна.
- 3 Илгээх аккаунт сонгоно.
- 4 Мессеж илгээгчийг сонгоно.
- 5 []-г дарна.
- 6 Текстүүдийг бичнэ.

[Мессежний загвар] :
Сонгосон мессежний загвараа бөглөнө.

[] : Текстийг гараар бичиж оруулна.

7 [Send]-г дарж хариу илгээнэ.



— Холбоотой холбоосууд —

[Дуу хоолойн удирдлагаар систем удирдах\(Х. 40\)](#)

[Форматуудыг өөрчлөх\(Х. 254\)](#)

*1 : Тус функцийг и-мэйлд ашиглах боломжгүй. Мөн зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

*2 : Тус функц нь SMS эсвэл MMS болно.

Тоо, үсэг оруулах(X. 27)

Шинэ мессеж илгээх

lxe1649834504637.dita

Шинэ и-мэйл, SMS мессеж илгээх боломжтой. MMS-г дэмждэггүй.

Дуу хоолойн удирдлагын систем ашиглах үед []-г дарна.

- 1 **Үндсэн цэсний** []-г дарна.
- 2 **Дэд цэснээс** [Contacts]-г дарна.
- 3 **Холбоо барих хаягийн жагсаалтаас илгээх хаяг сонгоно.**
- 4 **Тухайн илгээх** [] эсвэл и-мэйл хаяг сонгоно.


И-мэйл хаягны хувьд илгээгчийн аккаунт сонгоно.

- 5 **Мессежээ бичнэ.**

[Template] : Сонгосон мессежний загвар ашиглан бичнэ.

[] : Дэлгэцийн гар ашиглан бичнэ.

- 6 [Send]-г дарна.



Холбоотой холбоосууд

Дуу хоолойн удирдлагаар систем удирдах(X. 40)

Форматуудыг өөрчлөх(X. 254)

Тоо, үсэг оруулах(X. 27)

Форматуудыг өөрчлөх

tuy1649834504793.dita


Форматуудыг өөрчлөх боломжтой.

- 1 **Үндсэн цэсний** []-г дарна.
- 2 **Дэд цэсний** [Template]-г дарна.
- 3 **Форматны** []-г дарж өөрчлөнө.

Навигацийн системийн форматуудыг өөрчлөх боломжгүй.

- 4 **Формат оруулаад хадгална.**

Бүх форматыг анхны тохиргоонд буцаах үед [Default]-г дарна.



 МЭДЭЭЛЭЛ

Форматууд нь гар утас тус бүрт өөр өөрөөр тохируулагдана.

— **Холбоотой холбоосууд** —

[Мессежинд хариу өгөх\(Х. 253\)](#)

[Шинэ мессеж илгээх\(Х. 254\)](#)

Мессежний функцаас дуудлага хийх

sef1649834504809.dita

Мессежний функцаас гарын оролцоогүй дуудлага хийх боломжтой. Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

● **Цэнхэр өнгөтэй дугаар дээр дарж дуудлага хийнэ.**

Үргэлжилсэн тоог утасны дугаар гэж таньж болно. Мөн бусад улсын дугаар зэрэг зарим утасны дугаарыг танихгүй байж болно.

И-мэйл, SMS, MMS мессежийн дэлгэцээс дуудлага хийх


yzx1649834505168.dita

И-мэйл, SMS, MMS мессеж илгээгч рүү дуудлага хийх боломжтой. И-мэйлээс дуудлага хийхэд тус холбоо барих хаяг дээр утасны дугаар бүртгэгдсэн байх шаардлагатай.

- 1 **Үндсэн цэсний [📞]-г дарна.**
- 2 **Дэд цэсний [Messages]-г дарна.**
- 3 **Хэрэглэгчийн аккаунт сонгоно.**
- 4 **Мессеж илгээгчийг сонгоно.**

- 5 **[📞]-г товших эсвэл жолооны хүрдний [📞] товч дарна.**

Хаяг хэрхэн бүртгэснээс хамаарч утасны дугаар сонгох шаардлагатай.

**Холбоотой холбоосууд**

Жолооны хүрдний товчоор удирдах (А төрөл)(Х. 224)

Жолооны хүрдний товчоор удирдах (В төрөл)(Х. 226)

7-1. Веб хөтөч (Интернет)

Интернет хөтөч функцийн тухай.....	258
Интернет хөтчийн дэлгэц гаргах.....	259
Веб хөтчийн дэлгэц удирдах	260

Интернет хөтөч функцийн тухай^{*1*2}

Интернетэд холбон веб хуудас (мэдээний сайт, блог, дуу хөгжимний сайт, видео сайт зэрэг) үзэх боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

Интернет хөтөч ашиглахын тулд Wi-Fi® холболт шаардлагатай.

АЮУЛТАЙ

Аюулгүйн үүднээс зөвхөн бүрэн зогсож зогсоолын тоормос татах эсвэл "P" араанд шилжүүлсний дараа веб хуудас үзнэ. (Жолоодлогын үед зөвхөн аудио дуугарна.)

*1 :Зөвхөн 14 инчийн дэлгэц

*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Интернет хөтчийн дэлгэц гаргах

zjf1649898642445.dita

1 Үндсэн цэсний []-г дарна.

2 [Web browser]-г дарна.

Интернет хөтчийн дэлгэц гарна.


МЭДЭЭЛЭЛ

- Зөвхөн "HTTPS" (аюулгүй холболт) бүхий веб хуудсанд нэвтрэх боломжтой.
- Веб хуудаснаас хамаарч зөв гарахгүй байж болно.
- Зарим веб хуудсыг дэлгэцээр гаргах эсвэл дамжуулах боломжгүй.
- Зарим веб хуудсыг хэсэгчлэн гаргах боломжгүй.
- Контентоос хамаарч видео, аудио тоглуулах боломжгүй байж болно.
- Видео, дүрсний нягтрал, сүлжээнээс шалтгаалж дэлгэцээр дүрс гарах хүртэл хугацаа шаардагдаж болно.
- Зохиогчийн эрхээр хамгаалагдсан видео контент тоглуулах боломжгүй.
- Кредит карт, банкны данс зэрэг мэдээллийг оруулж болохгүй.
- Файл татах, веб хуудсанд нэвтрэх зэрэг зарим функцийг ашиглах боломжгүй.

Веб хөтчийн дэлгэц удирдах

iaf1649898642539.dita

Дэлгэцээр гарсан зүйл эсвэл хөтчийн дээд талын сонголтууд дээр дарж веб хөтчийн дэлгэц удирдах боломжтой.



A Өмнөх хуудас руу буцах.

B Дараагийн хуудас руу шилжих.

C Хуудасны URL гаргах.

URL дээр дарж холбогдох хуудас руу шилжинэ.

D Хуудсыг дахин ачааллах.

Хуудас дахин ачааллагдах үед товч [X] болж өөрчлөгдөнө.

Цуцлах үед [X]-г дарна.

E Үндсэн хуудас гаргана.

F Дэлгэцийн bookmark management гаргана.

Жагсаалтаас сонгох үед тухайн хуудас руу шилжинэ.

G Хөтчийн түүхийн удирдлагын дэлгэц гаргана.

Жагсаалтаас сонгох үед тухайн хуудас руу шилжинэ.

H Нэмэлт цонхны удирдлагын дэлгэц рүү шилжинэ.

Жагсаалтаас сонгох үед тухайн хуудас руу шилжинэ.

I Тохиргоо гаргана.

МЭДЭЭЛЭЛ

- Хуудас дахин дуудагдах үед явцыг нь шалгах боломжтой.
- Дэлгэц дэх үгийг удаан дарж хуулах боломжтой. Хуулах үед хуулах товч дарна. Хуулсан үгийг URL хэсэг дээр даран буулгах боломжтой.
- Бүтэн дэлгэц дэмждэг видео контентыг бүтэн дэлгэцээр үзэх боломжтой. Бүтэн дэлгэц гарсан үед дэлгэц дээр товшиход [X] болон [▶] нь дэлгэц дээр 3 секунд гарна. Бүтэн дэлгэцийг цуцлах үед контентын дэлгэц жижигрүүлэх товч эсвэл [X]-г дарна. Хэрэв [X] явж байгаа үед [X]-г байрлалыг [▶] дээр товшин өөрчлөх боломжтой.

Хавчуурга цэгцлэх

npr1649898642508.dita

Хавчуурганы (Bookmark) дэлгэц дээр хавчуурга бүртгэх/засварлах/устгах боломжтой.

1 Хэрэгслийн мөрний [★] -г дарна.

2 Сонгох тохиргоог дарна.

A Хавчуурганы дэлгэц хаана.

B Хамгийн сүүлийн дэлгэцний URL-г харуулна.

Товшоод URL-г засварлана.


C Хамгийн сүүлд ашигласан хуудасны хавчуурганы нэрийг харуулна.

Хавчуурганы нэр дээр товшин нэрийг засварлаж болно.

D B болон C-д мэдээлэл оруулаад хавчуурга нэмнэ.

E Хавчуурга засварлана.

F Хавчуурга устгана.



МЭДЭЭЛЭЛ

100 хүртэлх хавчуурга хадгалах боломжтой.

Хавчуурга засварлах

hes1649898642430.dita

Хавчуургын нэр болон URL холбоос засварлах, шинэ хавчуурга сануулах үйлдлийг үндсэн хуудаснаас хийх боломжтой.


A Хавчуургын нэр өөрчилнө.

B Хавчуургын URL өөрчилнө.

C Хавчуургад бүртгэгдсэн хуудсыг [Set] дарж үндсэн хуудсаар бүртгэх боломжтой.

Үндсэн хуудсаар бүртгэгдсэн хавчуурга дээр [🏠] тэмдэг гарна.

Өөрчлөлт дууссан үед [OK] дарж хавчуурга удирдах дэлгэцэнд буцна.



Хөтөчийн түүх удирдах

oeq1649898642461.dita

Хөтөчийн түүх удирдах дэлгэц дээр түүхийг устгах боломжтой.

1 Хэрэгслийн мөрний [🕒] -г дарна.

2 Хүссэн зүйлээ сонгоно.

- ☐ A Хөтөчийн түүх удирдах дэлгэц хаана.
- ☐ B Хөтөчийн түүх устгана.



 МЭДЭЭЛЭЛ

Хөтөчийн түүх дээр 100 хүртэлх түүх хадгалагдана. Түүх 100-с давсан үед хамгийн хуучин түүхийг автоматаар устгана.

Программын цонхнуудыг удирдах

bby1649898642555.dita


Программын цонх (tab) удирдах дэлгэц дээр цонх өөрчлөх/нэмэх/хаах боломжтой.

1 Хэрэгслийн мөрний [1]-г дарна.

Нээлттэй байгаа цонхны тоо [1] хэсэгт гарна.

2 Сонгох зүйлээ дарна.

- ☐ A Цонх удирдах дэлгэцийг хаана.
- ☐ B Шинэ цонх нэмнэ. Нэмсэн цонх дээр товвшсон үед үндсэн дэлгэц гарч ирнэ.
- ☐ C Цонхыг хаана.



 МЭДЭЭЛЭЛ

- 10 хүртэлх цонх нээх боломжтой.
- Шинэ цонх нээсэн үед тухайн тоглуулж байсан видео эсвэл дуу тоглуулах үйлдэл зогсож болно.

Вeб хөтөчний функцний тохиргоо


pru1649898642476.dita

Вeб хөтөчний функцтай холбоотой тохиргоог өөрчлөх боломжтой.

1 Хэрэгслийн мөрнөөс (toolbar) [⚙️]-г дарна.

2 Хүссэн зүйлээ сонгоно.

- A** Бусад функц ашиглах үед веб хөтөч давхар ажиллах эсэхийг тохируулна.
- B** Cookie дата татах болон ачааллах тохиргоог идэвхжүүлэх болон цуцлах, гуравдагч этгээдийг блоклох, блок тайлах тохиргоог хийнэ.
- C** JavaScript ашиглалтын идэвхжүүлэх буюу цуцлана.
- D** Хөтөчний түүх, cookies болон бусад сайтын дата, дүрс болон файлын кеш устгана.


 МЭДЭЭЛЭЛ

[Background]-г [Allow] гэж тохируулсан нөхцөлд бусад функц ашиглаж байгаа үед ч дата дамжуулалт хийгдэнэ.

8-1. Lexus parking assist монитор

Lexus parking assist мониторын функц.....	266
Чиглүүлэх дэлгэц гаргах...	268
Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх	270
Lexus parking assist мониторын анхааруулга	275

8-2. Панорамик дэлгэц

Панорамик дэлгэцийн функц	285
Арааг "P"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим.	289
Арааны "D" эсвэл "N" байрлал дахь дэлгэцийн горим	291
Арааг "R"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим.	299
Хажуугийн толь эвхэгдсэн үеийн дэлгэц	307
Дэлгэц дээр томруулах	308
Автомашины доод талыг нэвт харуулах дэлгэц	310
Хөдөлж буй объектын анхааруулга	312
Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх	314
Панорамик дэлгэц ашиглах үеийн анхааруулга	316
Дараах шинж тэмдэг гарсан үед	333

Lexus parking assist монитормын функц^{*1}

Lexus parking assist монитор нь зогсоолд байрлуулахаар ухрах болон бусад нөхцөлүүдэд автомашины ар талд угсрагдсан камерны дүрс харуулан туслах функц юм.

□ МЭДЭЭЛЭЛ


Тус тайлбар дахь дэлгэцний зураг нь жишээ бөгөөд автомашины хурц гэрэл зэрэг камерны бодит дүрснээс хамаарч өөр байж болно.

▲ АЮУЛТАЙ

- Жолоодлогын үед цаг ямагт ойр орчмоо шууд харж нягтлана.
- Камерны линзний онцлогоос хамаарч дэлгэцээр гарч буй хүн, саад хүртэлх зай бодит зайнаас өөр байж болно.

Lexus parking assist монитормын дэлгэц гаргах

Асаах товч <power товч> ON горимд байгаа ба арааг "R" шилжүүлсэн нөхцөлд тус дэлгэц гарна.



- A Ард тал
B Өргөн ард тал
C Дэлгэцийн горим солих товч дарна

□ МЭДЭЭЛЭЛ

- Чиглүүлэх шугамын горим болон бусад дэлгэцийн тохиргоог хэрэглэгчийн профайлд сануулах боломжтой. Жолооч танигдсан үед эдгээр тохиргоо нь дуудагдана.
- Дуу хоолойн удирдлагын систем ашиглан дэлгэцийн горим солих боломжтой.^{*2}

*1 : Тоноглогдсон автомашинд

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Холбоотой холбоосууд

[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(Х. 52\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)


Чиглүүлэх дэлгэц гаргах

ypv1649836231874.dita


Арааг "R" байрлалд шилжүүлнэ.

Дэлгэцийн горимын товч дарах бүрт горим өөрчлөгдөнө.

■ Ард талыг харуулах



■ Ард талыг өргөнөөр харуулах



- A** Дэлгэцийн горим солих
Ард талыг харуулах болон ард талыг өргөнөөр харуулах горимд солино.
- B** Чиглүүлэх шугам солих товч
Чиглүүлэх шугамын горим солино.
- C** Дуу хоолой таних тэмдэг*¹
Дуу хоолойн удирдлагын систем ажиллах үед тус тэмдэг гарна.

D RCTA (Rear Cross Traffic Alert) функц^{*2}/RCD (Rear Camera Detection) функц^{*2}

Дараах нөхцөлүүдэд дэлгэц дээр индикатор гарна.

- Автомашин хойд талаас ойртож буйг арын радар мэдэрсэн үед.
- Автомашины ард талд явган зорчигч байгааг хойд камер мэдэрсэн үед.

(RCTA (Rear Cross Traffic Alert) функц/RCD (Rear Camera Detection) функцийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

E RCD (Rear Camera Detection) функц^{*2}

Автомашины ард талд явган зорчигч байгааг хойд камер мэдэрсэн үед дэлгэц дээр индикатор гарч дохио дуугарна. (RCD (Rear Camera Detection) функцийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

F Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч объект мэдэрсэн үед дэлгэц дээр индикатор гарч дохио дуугарна. (Lexus parking assist-мэдрэгчийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

G PKSB (Parking Support Brake) тоормос^{*2}

Мөргөлдөх эрсдэлтэй объект мэдрэгдсэн үед дэлгэц дээр мэдээлэл гарна. (PKSB (Parking Support Brake)-н тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

H Lexus parking assist-мэдрэгч/RCTA (Rear Cross Traffic Alert) функц^{*2}/RCD (Rear Camera Detection) функцийн^{*2} дууг хаах товч

Lexus parking assist-мэдрэгч, RCTA (Rear Cross Traffic Alert) функц болон RCD (Rear Camera Detection) функцийн дууг түр хугацаанд хаана. Арааны хөшүүрэг шилжүүлэх үед автоматаар цуцлагдана.

▲ АЮУЛТАЙ

- Дэлгэцээр гарах чиглүүлэх шугамын байрлал нь зорчигчдын тоо, ачаа тээш, замын хазайлт зэргээс хамаарч өөр байж болно. Жолоодлогын үед ойр орчмоо шууд харж нягтлана.
- Lexus parking assist-мэдрэгч, RCTA болон RCD функц нь камерны дүрсэн дээр давхарлаж гардаг тул орчны гэрлийн хэмжээ, өнгөнөөс хамаарч сайн харагдахгүй байж болно.

Lexus parking assist монитор унтраах

jqd1649836231858.dita

Lexus parking assist монитор нь арааг "R"-с бусад араанд шилжүүлэх үед унтарна.

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.


*2 :Тоноглогдсон автомашинд

Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх xry1649836231843.dita

Чиглүүлэх шугам солих товч дарах бүрт дэлгэцийн горим өөрчлөгдөнө.

■ Явах замыг харуулах шугамын горим

Тус горим нь жолооны хүрдний ажиллагаанд уялдуулан явах замыг тооцоолон харуулна.

**A Автомашины өргөнийг заах шугам**

Шулуун ухрах үеийн явах замыг харуулна.

- Тус шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байна.
- Автомашин шулуун үед чиглүүлэх шугам нь явах замыг заах шугамтай давхацна.

B Явах замыг заах шугам

Жолооны хүрдний ажиллагаатай уялдсан явах шугам (шар) харуулна.

C Зай заах шугам

Автомашины хойд талын зайг заана.

- Зай заах шугам нь явах замыг заах шугамтай холбоотой.
- Хойд гуперны төвөөс 0.5 м (улаан) болон 1 м (шар) зайг заана.

D Зай заах шугам


Хойд гупернээс 0.5 м (цэнхэр) зайг заана.

E Автомашины төвийг заах шугам

Автомашины өргөнийг заах шугам харуулна.

■ Зогсоолд байрлуулахад туслах шугамын горим

Тус горим нь жолооны хүрд эргүүлэх цэгийг харуулна (Зогсоолд байрлуулахад туслах шугам). Тус горим нь явах замыг заах шугам ашиглалгүйгээр зогсоолд байрлуулах чадвартай жолооч ашиглахад тохиромжтой.



A Автомашины өргөнийг заах шугам

Шулуун ухрах үеийн явах замыг харуулна.

- Тус шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байна.

B Зогсоолд байрлуулахад туслах шугам

Автомашины хойд талын эргэх боломжтой хамгийн бага замыг заана.

- Зогсоолд байрлуулах үед жолооны хүрд эргүүлэх байрлалыг мэдээллийн журмаар ашиглана.

C Зай заах шугам

Автомашины хойд талын зайг заана.


- Хойд гуперны төвөөс 0.5 м (улаан) зайг заана.

D Автомашины төвийг заах шугам

Автомашины өргөнийг заах шугамын төвийг харуулна.

■ Зай заах шугамын горим

Тус горим нь зөвхөн зай заах шугам харуулна. Чиглүүлэх шугам ашиглах шаардлагагүй жолооч ашиглахад тохиромжтой.



A Зай заах шугам


Автомашины хойд талын зайг заана.

- Хойд гуперны төвөөс 0.5 м (улаан) зайг заана.

■ Явах замын төвийг заах шугамын горим

Тус горим нь явах замыг заах шугам ба автомашины төвийг заах шугамыг жолооны хүрдний ажиллагаатай уялдуулан харуулна.

Тус горимыг замын шон зэрэгт автомашины төв хэсгээрээ ойртох үед ашиглахад тохиромжтой.



A Зай заах шугам

Автомашины хойд талын зайг заана.

- Зай заах шугам нь явах замыг заах шугамтай холбоотой.
- Хойд гуперны төвөөс 0.5 м (улаан) болон 1 м (шар) зайг заана.

B Явах замын төвийг заах шугам

Жолооны хүрдний ажиллагаатай уялдсан автомашины төвийг заах шугам (ногоон)-г харуулна.

C Явах замыг заах шугам

Жолооны хүрдний ажиллагаатай уялдсан явах шугам (шар) харуулна.

МЭДЭЭЛЭЛ

- Чиглүүлэх шугам нь тээшний хаалга хаагдаагүй үед гарахгүй. Тээшний хаалга бүрэн хаагдсан ч чиглүүлэх шугам гарахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.
- Lexus parking assist-мэдрэгч нь ойр байрлах объектыг дэлгэц дээр мэдрэгдсэн объектын чиглэлийг харуулж жолоочид мэдэгдэх функц болно.
- Lexus parking assist-мэдрэгчийн дэлгэц болон камерын дүрс дэх объектын байрлал өөр байж болно.

▲ АЮУЛТАЙ

Автомашины өргөнийг заах шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байдаг. Ухрах үед цаг ямагт ойр орчмоо толинд болон шууд харж нягтлана.


Туулах замыг тооцоолон харуулах шугам ашиглан
зогсоолд байрлуулах

jnx1649836231889.dita

1 Арааг "R"-д шилжүүлнэ.


- 2 Туулах замыг тооцоолон харуулах шугам зогсоолын талбайд орох байдлаар жолооны хүрдийг эргүүлэн зөөлөн ухарна.**

- A** Туулах замыг тооцоолон харуулах шугам
B Зогсоолын талбай



- 3 Автомашины хойд тал зогсоолын талбайд орох үед автомашины өргөнийг заах шугам зогсоолын талбайн баруун зүүн тусгаарлах шугам дотор орох байдлаар жолооны хүрдийг эргүүлнэ.**

- A** Автомашины өргөнийг заах шугам



- 4 Автомашины өргөнийг заах шугам болон зогсоолын талбайн шугам зэрэгцээ болох үед жолооны хүрдийг тэгшлэн зогсоолын талбайд бүрэн орох хүртэл зөөлөн ухарна.**

5 Тохиромжтой газарт автомашинаа зогсоож үйлдлийг дуусгана.

Зогсоолд байрлуулахад туслах шугамын горим ашиглан
зогсоолд байрлуулах


bzw1649836231780.dita

1 Арааг "R"-д шилжүүлнэ.

2 Зогсоолын талбайн зүүн гар талын тусгаарлах шугамтай зогсоолд байрлуулахад туслах шугам давхцах хүртэл ухарна.

A Зогсоолын талбайн тусгаарлах шугам

B Зогсоолд байрлуулахад туслах шугам



3 Жолооны хүрдээ баруун тийш бүрэн эргүүлээд зөөлөн ухарна.

4 Автомашин зогсоолын талбайтай нэг эгнээнд орсон үед жолооны хүрдээ тэгшлээд автомашин зогсоолын талбайд бүрэн орох хүртэл зөөлөн ухарна.

5 Автомашиныг зөв байрлуулаад үйлдлийг дуусгана.

Lexus parking assist монитормын анхааруулга

pid1649836231905.dita

Жолоодлогын анхааруулга

eza1649836231796.dita

Lexus parking assist монитор нь ухрах үйлдэл хийх үед жолоочид туслах төхөөрөмж юм. Ухрах үед цаг ямагт ард тал болон ойр орчмоо шууд харж нягтлана. Эсрэг тохиолдолд бусад автомашинтай мөргөлдөх эсвэл санамсаргүй осол үүсгэх аюултай. Lexus parking assist монитор ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

▲ АЮУЛТАЙ

- Зөвхөн дэлгэц рүү харан ухрахыг хориглоно. Дэлгэцний дүрс нь бодит нөхцөл байдлаас өөр байж болно. Эсрэг тохиолдолд бусад автомашинтай мөргөлдөх эсвэл санамсаргүй осол үүсгэх аюултай. Ялангуяа ойр орчмын зогсоолд байгаа автомашин, бусад эд зүйлтэй мөргөлдөхөөс сэргийлнэ. Ухрах үйлдэл хийх үед голын болон хажуу толь, мөн орчноо шууд харж шалгана.
- Тоормосны дөрөө гишгэн хурдаа тохируулан зөөлөн ухарна.
- Хэрэв ойр орчимд байгаа автомашин, саад, хүн, замын хашлага зэрэгтэй мөргөлдөх эрсдэлтэй үед тоормос гишгэж зогсоно.
- Lexus parking assist монитор нь зөвхөн зөвлөмж өгдөг. Зогсоолд байрлуулах үед жолооны хүрдийг ямар мөчид ямар хэмжээтэй эргүүлэх нь замын нөхцөл байдал, гадаргуу, автомашины байдлаас хамаарч өөр байдаг. Lexus parking assist монитор ашиглахаас өмнө эдгээрийг мэдэх шаардлагатай.
- Зогсоолд байрлуулах үед ухрах үйлдэл эхлэхээс өмнө талбай автомашин багтах зайтайг нягтлана.
- Дараах нөхцөлүүдэд Lexus parking assist монитор ашиглаж болохгүй:
 - Мөстсөн, цастай, хальтиргаатай зам дээр
 - Дугуйн гинж, ослын дугуй ашиглаж байгаа
 - Тээшний хаалга дутуу хаагдсан
 - Уул толгод, эргэлттэй зам зэрэг тэгш бус, шулуун бус зам дээр
- Гадна агаарын хэм хүйтэн үед дэлгэц харлах, дүрс бүдэгрэх болно. Автомашин явах үед дүрс хэлбэрээ алдах эсвэл дэлгэцээр гарахгүй байж болох тул цаг ямагт ойр орчмоо шууд харж нягтлана.
- Дугуйн хэмжээ өөрчлөгдсөн үед дэлгэцээр гарах чиглүүлэх шугамны байрлал буруу зааж болно.
- Камерны линзний онцлогоос хамаарч хүн болон саад хүртэлх дэлгэцээр харагдах байрлал болон зай бодит нөхцөлөөс өөр байж болно.

АНХААР

Камер зөв ажиллахгүй байж магадгүй бөгөөд зураг дараах байдлаар дэлгэцэн дээр гарч болно:


- Арааны "R" байрлалд дэлгэц хэсэгчлэн хар болж болно
- Арааны "R" байрлалд дэлгэц камерын дүрсийг гаргахгүй байж болно
- Арааны "R"-с өөр байрлал сонгосон үед камерын дүрс үргэлжлэн гарч болно
- Камерын дүрсэн дээр чиглүүлэх шугам гарахгүй бөгөөд анхааруулах тэмдэг, мэдээлэл гарч болно.

Дэлгэцээр гарах хэсэг

glz1649836231983.dita


■ Ард талын харагдац

- A** Дэлгэцээр гарах хэсэг
- B** Дэлгэцээр гарахгүй объект
- Гуперны 2 буланд ойр хэсэг дэлгэцээр гарахгүй.



■ Ард талын өргөн харагдац

- A** Дэлгэцээр гарах хэсэг
B Дэлгэцээр гарахгүй объект
 Гуперны 2 буланд ойр хэсэг дэлгэцээр гарахгүй.




☐ МЭДЭЭЛЭЛ

- Автомашины байрлал болон замын гадаргуугаас хамаарч дэлгэцээр гарах зай өөр байж болно.
- Гуперны 2 буланд ойр хэсэг болон доод тал дэлгэцээр гарахгүй.
- Дэлгэц дээр гарч буй зургийн гүний мэдрэмж нь камерын линзний шинж чанараас шалтгаалан бодит зайнаас ялгаатай.
- Камернаас өндөр байрлах объект дэлгэцээр гарахгүй байж болно.

Камерны байрлал

kdc1649836231952.dita

Lexus parking assist мониторын камерны байрлалыг зурагт үзүүлэв.



Камер цэвэрлэх

xbk1649836232030.dita

Усны дусал, цас, шавар зэрэг бохирдол, гадны биет камер дээр тогтсон үед дүрс цэвэр харагдахгүй. Энэ нөхцөлд камерыг их хэмжээний усаар угааж цэвэр, зөөлөн даавуу норгон арчина.

АНХААР

- Lexus parking assist монитормын хэвийн ажиллагаа алдагдаж болно. Дараах зүйлсийг анхаарна уу:
 - Камерыг цохих, хүчтэйгээр дарж болохгүй. Ингэснээр камерны тусгал алдагдах аюултай.
 - Камер нь усны хамгаалалттай. Салгах, задлах болон өөрчлөхийг хориглоно.
 - Камерны линз угаах үед их хэмжээний усаар угаагаад цэвэр, зөөлөн даавуу норгон арчина. Камерны линзийг хүчтэй зүлгэх нь линзэнд хортон суулгах, улмаар дүрс цэвэр харагдахгүй болгоно.
 - Камерын таг нь резинээр хийгдсэн байдаг. Органик нэгдэл, автомашины вакс, шил толь цэвэрлэгч, шилний хуулга зэргийг камерт хүргэхийг хориглоно. Хүргэсэн нөхцөлд даруй арчина.
 - Хүйтэн үед автомашин руу халуун ус цацах болон бусад хэлбэрээр температурын огцом хэлбэлзэл үүсгэж болохгүй.
 - Өндөр даралтын автомашин угаагчаар угаасан үед камер болон камерны ойр орчим руу шууд шүршиж угааж болохгүй. Хүчтэй даралттай ус нь камер доголдуулах аюултай.
- Камер цохилтонд өртсөн нөхцөлд доголдол үүсч болзошгүй. Энэ нөхцөлд даруй өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Шил арчигчийн шингэнээр арын камер цэвэрлэх*1

Арын камерт тогтсон бохирдлыг камер цэвэрлэгчийн шингэн ашиглан цэвэрлэх боломжтой. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

- Камер цэвэрлэх үед шил арчигчийн шингэнээс шалтгаалж дүрс сайн харагдахгүй байж болно. Ухрах үед үйлдэл эхлэхээс өмнө автомашины ойр орчмыг шууд болон толиндоо давхар харж шалгана.
- Цэвэрлэсний дараа хэрэв шингэн камерны линз дээр үлдсэн нөхцөлд шөнийн цагаар арын автомашины их гэрлийн тусгалаас хамаарч дүрс сайн харагдахгүй байж болно.
- Зарим бохирдол бүрэн цэвэрлэгдэхгүй байж болно. Энэ нөхцөлд камерны линзийг их хэмжээний усаар зайлаад цэвэр, зөөлөн даавуу норгон арчина.

*1 : Тоноглогдсон автомашинд

- Шил арчигчийн шингэн нь камерны линз рүү цацагддаг. Камерны ойр орчимд тогтсон цас, мөс зэргийг цэвэрлэх боломжгүй.

⚠ АНХААР

Шил арчигчийн хошууны байрлал болон тусгал өөрчлөгдөх тул хошууг хүчтэй цохилтод өртөхөөс сэргийлнэ.


Дэлгэц болон бодит замын ялгаа

umb1649836231921.dita

- Зай заах шугам болон автомашины өргөнийг заах шугам нь зогсоолын талбайн тусгаарлах шугамтай зэрэгцээ харагдаж байгаа ч бодит байдал дээр өөр байж болно. Шууд харж шалгана уу.
- Зай заах шугам болон автомашины өргөнийг заах шугам нь зогсоолын талбайн баруун зүүн шугамтай тэнцүү харагдаж байгаа ч бодит байдал дээр өөр байж болно. Шууд харж шалгана уу.
- Зай заах шугам тэгш талбай дээрх зайг заана. Тиймээс дэлгэцийн чиглүүлэх шугам болон бодит зай, мөн автомашины явах зам өөр байж болно.


■ Автомашины ард талын зам огцом өгсүүр үед

Зай заах шугам нь бодит зайнаас илүү ойр харагдах болно. Тиймээс налуу дээр байгаа объектууд бодит байдлаасаа хол байна. Мөн үүнтэй адилаар чиглүүлэх шугам болон автомашины туулах зам хооронд зөрүү үүснэ.



■ Автомашины ард талын зам огцом уруу үед


Зай заах шугам нь бодит зайнаас илүү хол харагдах болно. Тиймээс налуу дээр байгаа объектууд бодит байдлаасаа ойр байна. Мөн үүнтэй адилаар чиглүүлэх шугам болон автомашины туулах зам хооронд зөрүү үүснэ.



■ Автомашины аль нэг тал доош хазайсан үед


Зорчигчдын тоо, ачааны хуваарилалтаас хамаарч автомашины аль нэг тал хазайсан үед чиглүүлэх шугам болон автомашины туулах зам хооронд зөрүү үүснэ.

A Зөрүү



■ Явах замын төвийг заах шугам

Чиглүүлэх шугам нь арын гуперны төв хэсгийг газраас хөндий байдлаар харуулдаг тул зарим нөхцөлд тус шугам төвөөс хазайсан мэт харагдаж болно.



Дэлгэц болон бодит объектын (3 хэмжээст) зөрүү


ggq1649836231811.dita

Туулах замыг тооцоолон харуулах шугам болон зай заах шугам нь тэгш талбай дээр чиглэлийг тооцоолон харуулдаг тул гурван хэмжээст объектын байрлалыг тогтоох боломжгүй. Гадагш түрж гарч ирсэн гурван хэмжээст объектод (ачааны машины тэвш зэрэг) ойртох үед дараах зүйлсэд анхаарна.

■ Туулах замыг тооцоолон харуулах шугам


Дэлгэц дээр ачааны машины тэвш туулах замыг тооцоолон харуулах шугамны гадна бөгөөд мөргөлдөх эрсдэлгүй харагдаж байгаа ч бодит байдал дээр мөргөлдөх эрсдэлтэй байж болно. Ойр орчмоо шууд харж шалгана.

A Туулах замыг тооцоолон харуулах шугам



■ Зай заах шугам

Автомашины ойр орчмыг шууд харж шалгана. Дэлгэц дээр ачааны машин **В** байрлалд харагдана. Гэвч бодит байдал дээр хэрэв та **А** хүртэл ухрах үед та ачааны машиныг мөргөнө. Дэлгэц дээр **А** хамгийн ойр, **В** болон **С** дарааллаар харагдаж байна. Гэвч бодит байдал дээр **А** ба **С** хүртэлх зай адил ба **В** нь **А** ба **С**-с хол зайд байна. **Д** хүртэлх зай 1 м орчим байна.



Дараах аль нэг шинж тэмдэг мэдрэгдсэн үед

qkw1649836232014.dita

Дараах аль нэг шинж тэмдэг мэдрэгдсэн үед хүснэгтэд заасан тохирох арга хэмжээг авна.

Арга хэмжээ авсан ч шинж тэмдэг арилахгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж оношуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Дүрс муу харагдаж байгаа	● Автомашин харанхуй орчинд эсвэл шөнийн цагаар. ● Камерын орчмын хэм хэт халуун/хүйтэн. ● Гадна орчны хэм хэт хүйтэн. ● Камер дээр усны дусал байгаа. ● Бороо орж байгаа эсвэл хэт чийгшилттэй. ● Камер дээр (шавар зэрэг) тогтсон. ● Линз дээр нар эсвэл автомашины их гэрэл шууд тусч байга. ● Флуоресцент гэрэл (өдрийн гэрэл), натрийн ламп, мөнгөн усны орцтой гэрлийн дор байгаа үед.	Жолоодлогын үед автомашины ойр орчмыг шууд нүдээр харж шалгана. (Камер болон орчны нөхцөл сайжирсны дараа Lexus parking assist монитормыг дахин ашиглана.) Lexus parking assist монитормын дүрсний чанарыг мультимедиа дэлгэцийн тохиргоотой адил дарааллаар хийж гүйцэтгэнэ.
Дүрс бүрсгэр байгаа	Усны дусал, тоос зэрэг гадны биет камерны линз дээр тогтсон.	Камерыг их хэмжээний усаар угаагаад цэвэр зөөлөн даавууг норгон линз арчина. Камер угаагчаар камер угаана. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.^{*2}
Дэлгэцийн өнцөг алдагдсан	Камер хүчтэй цохилтонд өртсөн.	Та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү.
Чиглүүлэх шугамны тохиргоо илт алдагдсан	Камерны байрлал алдагдсан.	Та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү.

8-1. Lexus parking assist монитор

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Чиглүүлэх шугамны тохиргоо илт алдагдсан	● Автомашин хазайсан (автомашинд хүнд ачаа ачсан, дугуй хагарсан зэргээс дугуйн хий сул зэрэг). ● Автомашин хазгай газар байгаа.	Жолоодлогын үед автомашины ойр орчмыг шууд нүдээр харж шалгана.
Жолооны хүрд эгц шулуун байгаа ч туулах замыг тооцоолон харуулах шугам хөдөлж байгаа (тус шугам нь өргөнийг заах шугамаас зөрөх)	Жолооны хүрдний мэдрэгчийн сигналд доголдол үүссэн.	Та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү.
Дэлгэц дээр чиглүүлэх шугам гарахгүй байх	Тээшний хаалга нээлттэй.	Тээшний хаалга хаана. Дээрх үйлдлийг хийсэн ч шинж тэмдэг арилахгүй үед та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү.

Холбоотой холбоосууд

[Дэлгэцийн тохиргоо өөрчлөх\(Х. 70\)](#)

*2 : Тоноглогдсон автомашинд

gwb1649841251519.dita

Панорамик дэлгэцийн функц^{*1}

jqm1649841251456.dita

Панорамик дэлгэц нь бага хурдаар явах үед урд, хажуу болон хойд талд байрлах камерны нийлмэл дүрсийг автомашины дээрээс харж байгаа байдлаар гаргадаг.

МЭДЭЭЛЭЛ

Зурагт үзүүлсэн дэлгэц нь зөвхөн жишээ бөгөөд камер дээр гялбаа тусах эргээр бодит харагдах байдлаас өөр байж болно.

▲ АЮУЛТАЙ



- Панорамик дэлгэц нь таньд автомашины эргэн тойронг нягтлахад туслах төхөөрөмж юм. Жолоодлогын үед ойр орчноо шууд нүдээр харж нягтлана уу.
- Камерны линзний онцлогоос хамаарч ойр орчимд байгаа хүн болон саад хүртэлх бодит зай болон байрлал өөр байж болно.

Камерны товч

kox1649841251175.dita

Панорамик дэлгэц гаргах ба дэлгэцийн горим солино.

Автомашины өөрчлөх боломжтой тохиргоогоор жолооны хүрдний товчийг идэвхжүүлсэн үед тус товч ашиглан панорамик дэлгэц гаргах боломжтой. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

► А төрөл**► В төрөл**


^{*1} : Тоноглогдсон автомашинд

Панорамик дэлгэц гаргах

dan1649841251534.dita


Камерны товч дарах эсвэл асаах товч <power товч> ON-д байгаа үед арааг "R"-д шилжүүлэх үед панорамик дэлгэц гарна.

■ Арааг "R"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим




- A** Навигацийн дэлгэц, аудио дэлгэц зэрэг.
- B** Камерны товч дарна
- C** Хөдлөх үеийн дэлгэц
- D** Нэвт харагдах дэлгэц
- E** Дэлгэцийн горим солих товч дарна

■ Арааны “D” эсвэл “N” байрлалын дэлгэцийн горим



- A Навигацийн дэлгэц, аудио дэлгэц зэрэг.
- B Урд талын өргөн, панорамик дэлгэц
- C Хажуугийн оврын, панорамик дэлгэц
- D Эргэлтийн үеийн, панорамик дэлгэц
- E Камерны товч дарна
- F Дэлгэцийн горим солих товч дарна
- G Жолооны хүрдийг шулуун байрлалаас 180-с их хэмээр эргүүлэх үед

■ Арааны “R” байрлалын дэлгэцийн горим



- A Арын болон панорамик дэлгэц
- B Арын өргөн, панорамик дэлгэц
- C Дэлгэцийн горим солих товч дарна

МЭДЭЭЛЭЛ

- Автомашин 20 км/ц-с бага хурдтай явах үед камерны товч дарсан нөхцөлд панорамик дэлгэц гарна. Хурд 20 км/ц-с их үед панорамик дэлгэц унтарч өмнөх дэлгэцэнд шилжинэ.
- Хэрэглэгчийн профайл бүртгэн чиглүүлэх шугамын горим болон дэлгэцийн бусад тохиргоог сануулах боломжтой. Жолооч танигдах үед эдгээр тохиргоо нь дуудагдана.
- Дуу хоолойн систем ашиглан панорамик дэлгэц, гаргах, дэлгэцийн горим өөрчлөх, бусад үйлдэл хийх боломжтой.*²

Холбоотой холбоосууд

[Хэрэглэгчийн профайл бүртгэх\(Х. 52\)](#)

[Дуу хоолойн удирдлагыг эхлүүлэх\(Х. 42\)](#)

*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.


Араг "P"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим

rhz1649841251472.dita


Тус горим нь автомашины ойр орчмыг нягтлах боломж олгох үүднээс камерны дүрсийг нэгтгэн гаргадаг. Дүрсийг жолоочийн суудлаас харагдах мөн автомашин дээрээс харагдах байдлаар гаргана.

1. Араг "P"-д шилжүүлнэ.
2. Камерны товч дарна.
 - Дэлгэцийг горим солих товч дарах бүрт горим солигдоно.
 - Камерны товч дахин дарж навигацийн дэлгэц зэрэг өмнөх дэлгэц рүү буцна.

■ Нэвт харагдах дэлгэц



■ Хөдөлгөөнт дэлгэц



- A** Дэлгэц унтраах товч
Камерны дэлгэц унтрааж навигаци зэрэг өмнөх дэлгэц рүү буцаана.
- B** Дэлгэцийн горим солих товч
Нэвт харагдах болон хөдөлгөөнт дэлгэцийн горимд шилжүүлнэ.
- C** Эргэлтийг түр зогсоох/дахин эхлүүлэх товч
Дэлгэцийн эргэлтийг түр зогсоох болон дахин эхлүүлнэ.
- D** Өөрчлөх тохиргооны товч

Эргэлтийн үеийн автомат дэлгэц, автомашины өнгө, Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх зай зэрэг тохиргоог өөрчилнө.

E Дуу хоолой таних тэмдэг*¹

Дуу хоолой таних систем ажиллах үед тус тэмдэг гарна.

МЭДЭЭЛЭЛ

- Lexus parking assist-мэдрэгч асаалттай үед нэвт харагдах дэлгэц эсвэл хөдөлгөөнт дэлгэц гаргах боломжтой. (Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)
- Дэлгэцийн дурын цэг дээр даран нэвт харагдах дэлгэц, хөдөлгөөнт дэлгэцийн эргэлтийг зогсоох, дахин эхлүүлэх боломжтой.

Холбоотой холбоосууд

Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 314)

*1 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.


Арааны "D" эсвэл "N" байрлал дахь дэлгэцийн горим

gbz1649841251394.dita

Үзэгдэх орчин муутай уулзвар дээр эргэн тойрноо дэлгэц дээр гарган ойр орчмын явган зорчигч, унадаг дугуй, автомашиныг нягтлах боломжтой. Мөн тус горим нь нарийн замаар явах, замын хажуу талын зогсоолд орох үед автомашины 2 хажуу талын аюулгүй байдлыг нягтлахад тусладаг.

1. Арааг "D" эсвэл "N" байрлалд шилжүүлнэ.
2. Камерны товч дарна.
 - Камерны товч дарах бүрт горим солигдоно.
 - Эргэлтийн үеийн дэлгэц идэвхтэй ба жолооны хүрдийг шулуун чиглэлээс 180-с их хэмээр эргүүлсэн үед дэлгэц оврын & панорамик дэлгэцээс эргэлтийн & панорамик дэлгэцэнд шилжинэ.

■ Урд өргөн & панорамик дэлгэц



A Урд зай заах шугам

Автомашины урд талын 1 м зайг заана.

B Урагш явах замыг заах шугам

Жолооны хүрдний ажиллагаатай уялдуулан явах замыг харуулна. (Шар)
Жолооны хүрдийг шулуун байрлалаас 90-с дээш хэмээр эргүүлэх үед тус шугам гарна.

C Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч объект мэдрэх үед дэлгэц дээр индикатор гаргаж дохио дуугаргана. (Lexus parking assist-мэдрэгчийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

- D** FCTA (Front Cross Traffic Alert) функц/Хөдлөж буй объектын анхааруулга*¹

Дараах нөхцөлүүдэд дэлгэц дээр индикатор гарна.

- FCTA (Front Cross Traffic Alert) урд талаас автомашин эсвэл объект ойртож буйг мэдэрсэн.
- Хөдлөж буй объектын анхааруулга автомашины ойр орчимд автомашин байгааг, урд эсвэл хойд талд объект байгааг мэдэрсэн.

- E** Дэлгэц унтраах товч

Камерын дэлгэц унтрааж навигаци зэрэг өмнөх дэлгэц рүү буцаана.

- F** Дэлгэцийн горим солих товч

Товч дарах бүрт дэлгэцийн горим солигдоно.

- G** Чиглүүлэх шугам солих товч

Товч дарах бүрт чиглүүлэх шугам солигдоно.

- H** Автомат дэлгэцийн товч

Автомат дэлгэцийг асааж унтраана. Араа "D" эсвэл "N", урд өргөн & панорамик дэлгэц эсвэл хажуугийн дэлгэц/эргэлтийн дэлгэц & панорамик дэлгэц тухайн хурдад нийцүүлэн автоматаар гарна.

- I** Өөрчлөх тохиргооны товч

Эргэлтийн дэлгэц автоматаар гаргах, автомашины өнгө, Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх зай зэрэг тохиргоог өөрчлөнө.

- J** Камерны бохирдол мэдрэх тэмдэг

Камер дээр бохирдол мэдрэгдэх үед тус тэмдэг гарна.

- K** Хөдлөж буй объектын анхааруулга*¹

Хөдлөж буй объектын анхааруулга автомашины урд эсвэл хажуу талаас автомашин, объект ойртож байгааг мэдэрсэн үед дэлгэц дээр индикатор гарна.

- L** Дуу хоолой таних тэмдэг*²

Дуу хоолой таних систем ажиллах үед тус тэмдэг гарна.


- M** PKSB (Parking Support Brake) тоормос*¹

Мөргөлдөж болзошгүй саад мэдрэгдэх үед дэлгэц дээр мэдээлэл гаргана. (PKSB-н тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)


- N** Lexus parking assist-мэдрэгч/Хөдлөж буй объектын анхааруулга*¹-н дууг хаах товч

Lexus parking assist-мэдрэгч/Хөдлөж буй объектын анхааруулгын дууг түр хаана.

■ Хажуугийн оврын & панорамик дэлгэц



■ Эргэлтийн дэлгэц & панорамик дэлгэц



A Урагш явах замыг заах шугам

Жолооны хүрдний ажиллагаатай уялдуулан явах замыг харуулна. (Шар)
Жолооны хүрдийг шулуун байрлалаас 90-с дээш хэмээр эргүүлэх үед тус шугам гарна.

B Автомашины өргөнийг заах шугам

Хажуугийн толь орсон автомашины өргөнийг заах шугам харуулна.

C Урд зай заах шугам

Автомашины урд талын 1 м зайг заана.

D Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч объект мэдрэх үед дэлгэц дээр индикатор гаргаж дохио дуугаргана. (Lexus parking assist-мэдрэгчийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

- E** FCTA (Front Cross Traffic Alert) функц/Хөдлөж буй объектын анхааруулга*¹

Дараах нөхцөлүүдэд дэлгэц дээр индикатор гарна.

- FCTA (Front Cross Traffic Alert) урд талаас автомашин эсвэл объект ойртож буйг мэдэрсэн.
- Хөдлөж буй объектын анхааруулга автомашины ойр орчимд автомашин байгааг, урд эсвэл хойд талд объект байгааг мэдэрсэн.

- F** Дэлгэц унтраах товч

Камерын дэлгэц унтрааж навигаци зэрэг өмнөх дэлгэц рүү буцаана.

- G** Дэлгэцийн горим солих товч

Товч дарах бүрт дэлгэцийн горим солигдоно.

- H** Чиглүүлэх шугам солих товч

Товч дарах бүрт чиглүүлэх шугам солигдоно.

- I** Автомат дэлгэцийн товч

Автомат дэлгэцийг асааж унтраана. Араа "D" эсвэл "N", урд өргөн & панорамик дэлгэц эсвэл хажуугийн дэлгэц/эргэлтийн дэлгэц & панорамик дэлгэц тухайн хурдад нийцүүлэн автоматаар гарна.

- J** Өөрчлөх тохиргооны товч

Эргэлтийн дэлгэц автоматаар гаргах, автомашины өнгө, Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх зай зэрэг тохиргоог өөрчлөнө.

- K** Хөдлөж буй объектын анхааруулга*¹

Хөдлөж буй объектын анхааруулга автомашины урд эсвэл хажуу талаас автомашин, объект ойртож байгааг мэдэрсэн үед дэлгэц дээр индикатор гарна.

- L** Камерны бохирдол мэдрэх тэмдэг

Камер дээр бохирдол мэдрэгдэх үед тус тэмдэг гарна.

- M** Урд дугуйн чиглүүлэх шугам

Урд дугуйн байрлал заана.

- N** Дуу хоолой таних тэмдэг*²

Дуу хоолой таних систем ажиллах үед тус тэмдэг гарна.

- O** PKSB (Parking Support Brake) функц*¹

Мөргөлдөж болзошгүй саад мэдрэгдэх үед дэлгэц дээр мэдээлэл гаргана. (PKSB-н тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

- P** Lexus parking assist-мэдрэгч/Хөдлөж буй объектын анхааруулга*¹-н дууг түр хаана

Lexus parking assist-мэдрэгч/Хөдлөж буй объектын анхааруулгын дууг түр хаана.

*¹ : Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

- Lexus parking assist-мэдрэгч асаалттай үед хажуугийн оврын & панорамик дэлгэц/эргэлтийн дэлгэц гаргах боломжтой. (Lexus parking assist-мэдрэгчийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)
- Объектын Lexus parking assist-мэдрэгчийн зааж буй болон камерны дэлгэцээр гарч буй байрлал өөр байж болно.

▲ АЮУЛТАЙ

- Зорчигчдын тоо, ачаа тээш, замын хазгай зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч дэлгэцээр гарч буй чиглүүлэх шугамын байрлал өөрчлөгдөж болно. Жолоодлогын үед хойд тал болон ойр орчмоо цаг ямагт шууд харж нягтлана.
- Lexus parking assist-мэдрэгч болон FCTA нь камерны дүрсэн дээр давхардаж гардаг тул орчны гэрлийн хэмжээ, өнгөнөөс хамаарч сайн харагдахгүй байж болно.

— Холбоотой холбоосууд —

Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх(Х. 295)

Авто дэлгэцийн горим(Х. 296)


Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 314)

Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх asf1649841251581.dita

Чиглүүлэх шугам солих товч дарах бүрт дэлгэцийн горим өөрчлөгдөнө.

■ Зай заах шугамын горим


Автомашины урд талаас 1 зайг (цэнхэр) заана.



*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

■ Явах замыг харуулах шугамын горим

Жолооны хүрдний ажиллагатай уялдуулан явах замыг харуулна. (Шар) Жолооны хүрдийг шулуун байрлалаас 90-с дээш хэмээр эргүүлэх үед тус шугам гарна.



Авто дэлгэцийн горим

teh1649841251300.dita

Урд өргөн & панорамик мөн хажуугийн оврын & панорамик/ эргэлтийн дэлгэцийг камерны товч даран гаргах боломжтой ба мөн автомашины хурдад хамааруулан автоматаар гарах автомат дэлгэцийн горимыг тохируулах боломжтой.

- Автомат дэлгэцийн горим гаргах үед [] товч дарна.
- Дараах нөхцөлүүдэд автомат дэлгэцийн горимоор дэлгэц асна:
 - Арааны "D" эсвэл "N" байрлалд
 - Автомашины хурд 10 км/ц (6 миль/ц)-с буурсан (Арааны "R"-с бусад байрлалд)

Эргэлтийн үеийн харагдац автоматаар гарах

njv1649841251409.dita

Жолооны хүрдний ажиллагаанд нийцүүлэн эргэлтийн үеийн харагдацын горимыг эргэлтийн үеийн болон панорамик харагдацад автоматаар шилжих тохиргоо хийх боломжтой.

- Эргэлтийн үеийн харагдац автоматаар гаргах горим идэвхжүүлсэн ба жолооны хүрдийг шулуун байрлалаас 180-с дээш хэмээр эргүүлсэн үед хажуугийн оврын харагдаж автоматаар эргэлтийн үеийн харагдацад шилжинэ.
- Жолооны хүрдийг шулуун байрлалаас 90 хүртэлх хэмд буцаах хүртэл эргэлтийн үеийн харагдац дэлгэцээр гарна.

МЭДЭЭЛЭЛ

- Өөрчлөх боломжтой тохиргоогоор эргэлтийн үеийн харагдацын автомат горимыг өөрчлөх боломжтой.
- Автомашины хурд 12 км/ц-с их үед эргэлтийн үеийн харагдац дэлгэцээр гарахгүй.

Холбоотой холбоосууд

Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 314)

Lexus parking assist-мэдрэгчтэй холбоотой дэлгэц

kde1649841251284.dita

Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх байдлаас хамаарч урд өргөн & панорамик дэлгэц/хажуугийн оврын дэлгэц/эргэлтийн дэлгэц & панорамик дэлгэц гарч болно.

- Lexus parking assist-мэдрэгч объект мэдрэх үед (арааны "D" эсвэл "N" байрлалд) дэлгэц автоматаар гарна.
- Lexus parking assist-мэдрэгч объект мэдрэхээ болих үед автоматаар өмнөх дэлгэцэнд буцна.

МЭДЭЭЛЭЛ


- Дэлгэц дэх камерны товч даран өмнөх дэлгэцэнд буцаах боломжтой.
- Саад мэдрэгдсэн үед панорамик дэлгэц цуцласан нөхцөлд мултимедиа системийн дэлгэц дэх Lexus parking assist-мэдрэгчийн тэмдэг дээр даран панорамик дэлгэц дахин гаргах боломжтой.

Автомашины өргөнийг заах чиглүүлэх шугам ашиглах


wgm1649841251425.dita

■ Хажуугийн оврын болон панорамик харагдац

- Автомашиныг өргөнийг заах шугам болон саад хоорондын зай, байрлалыг шалгана.
- Жолооны хүрдийг эргүүлж өргөнийг заах шугам бодит саадтай давхцахгүй байхаар урагш явна.



- Автомашины өргөнийг заах шугам болон замын хөвөө дэх эргэлт зэрэг объект хоорондын зай, байрлалыг шалгана.
- Өргөнийг заах шугам саадтай зурагт үзүүлсэн байдлаар давхцахгүйгээр замын хажуу руу зогсоно.
- Өргөнийг заах шугамыг объектод дагуу байрлуулсан объектын дагуу зогсох боломжтой.




Урагш явах замыг тооцоолон харуулах шугам ашиглах

sss1649841251269.dita

■ Эргэлтийн үеийн болон панорамик харагдац

- Урагш явах замыг тооцоолон харуулах шугам болон саад хоорондын зай, байрлалыг шалгана.
- Жолооны хүрд эргүүлэн урагш явах замыг тооцоолон харуулах шугам болон бодит саад давхцахгүй байхаар урагш явна.



Арааг "R"-д шилжүүлэх үеийн дэлгэцийн горим


wxj1649841251191.dita

Зогсоолд байрлуулах үед аюулгүй байдлыг шалгах үүднээс автомашины дээд талаас харуулсан болон хойд талыг харуулсан дэлгэц гардаг.


1. Арааг "R"-д шилжүүлнэ.

- Дэлгэцийн горим солих товч дарах бүрт горим өөрчлөгдөнө.

■ Ард тал, панорамик дэлгэц



■ Ард талын өргөн, панорамик дэлгэц



A Камерны бохирдол мэдрэх тэмдэг

Камер дээр бохирдол мэдрэгдэх үед тус тэмдэг гарна.

B Хөдөлж буй объектын анхааруулга*1

Автомашины хойд эсвэл хажуу талаас автомашин эсвэл объект ойртож буйг хөдөлж буй объектын анхааруулга мэдэрсэн үед дэлгэц дээр индикатор гарна.

C Дэлгэцийн горим солих товч

Товч дарах бүрт дэлгэцийн горим солигдоно.

D Чиглүүлэх шугам солих товч

Товч дарах бүрт чиглүүлэх шугам солигдоно.

E RCTA (Rear Cross Traffic Alert) функц /RCD (Rear Camera Detection) функц^{*1}/Хөдөлж буй объектын анхааруулга^{*1}

Дараах нөхцөлүүдэд дэлгэц дээр индикатор гарна.

- Арын радар автомашины хойд талаас автомашин ойртож буйг эсвэл объект байгааг мэдэрсэн үед.

- Арын камер ард талд явган зорчигч байгааг мэдэрсэн үед.

- Арын камер хөдлөж буй объект мэдэрсэн үед.

(RCTA функц /RCD функцийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

F Өөрчлөх тохиргооны товч

Эргэлтийн үеийн автомат дэлгэц, автомашины их биеийн өнгө, Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх зай зэрэг тохиргоог өөрчилнө.

G Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч объект мэдрэх үед дэлгэц дээр индикатор гарган дохио дуугаргана. (Lexus parking assist-мэдрэгчийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

H RCD функц^{*1}/Хөдлөж буй объектын анхааруулга^{*1}

Дараах нөхцөлүүдэд дэлгэц дээр индикатор гарна.

- Арын камер ард талд явган зорчигч байгааг мэдэрсэн үед.

- Арын камер хөдлөж буй объект мэдэрсэн үед.

(RCD функцийн тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

I Дуу хоолой таних тэмдэг^{*2}

Дуу хоолойн удирдлагын систем ажиллах үед тус тэмдэг гарна.

J PKSB (Parking Support Brake) тоормос^{*1}

Мөргөлдөж магадгүй саад мэдрэгдсэн үед дэлгэц дээр мэдээлэл гарна.

(PKSB (Parking Support Brake)-н тухай дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

K Lexus parking assist-мэдрэгч/RCTA функц/RCD функц^{*1}/Хөдлөж буй объектын анхааруулга^{*1}-н дууг хаах товч

Lexus parking assist-мэдрэгч/RCTA функц/RCD функц/Хөдлөж буй объектын анхааруулгын дууг түр хаана. Арааг шилжүүлэх үед дууг хаах тохиргоо автоматаар цуцлагдана.

МЭДЭЭЛЭЛ

- Арааны "R" байрлалд камерны товч дарах үед панорамик & урд өргөн дэлгэцэнд шилжинэ.
- Lexus parking assist-мэдрэгчийн дэлгэцийн байрлал нь камерын дүрс дэх саадны байрлалаас өөр байж болно.

▲ АЮУЛТАЙ

- Дэлгэц дэх чиглүүлэх шугамын байрлал нь зорчигчдын тоо, ачаа тээш, замын налуу зэргээс шалтгаалж өөрчлөгдөж болно. Жолоодлогын үед ойр орчмоо цаг ямагт шууд харж нягтлана.
- Lexus parking assist-мэдрэгч, RCTA, RCD болон хөдлөж буй объектын анхааруулга нь давхацдаг ба камерын дүрс дээр гардаг тул орчны гэрэл, өнгөнөөс хамаарч сайн харагдахгүй байж болно.

Холбоотой холбоосууд

Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх(Х. 301)

Авто дэлгэцийн горим(Х. 296)

Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 314)


Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим өөрчлөх

qhm1649841251331.dita

Чиглүүлэх шугам солих товч дарах бүрт дэлгэцийн горим өөрчлөгдөнө.

■ Явах замыг харуулах шугамын горим

Тус горим нь жолооны хүрдний ажиллагаанд уялдуулан явах замыг тооцоолон харуулна.



A Урд талын зай заах шугам

*1 : Тоноглогдсон автомашинд

*2 : Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Автомашины урд талаас 1 м (цэнхэр) зайг заана.

B Хажуугийн явах замыг харуулах шугам

Жолооны хүрдний ажиллагаанд уялдуулан явах замыг (шар) тооцоолон харуулна

C Ухрах үеийн явах замыг харуулах шугам

Жолооны хүрдний ажиллагаанд уялдуулан явах замыг (шар) тооцоолон харуулна

D Хойд зай заах шугам

Автомашины хойд талын зайг заана.

- Зай заах шугам нь явах замыг заах шугамтай холбоотой.

- Хойд гуперны төвөөс 0.5 м (улаан) болон 1 м (шар) зайг заана.

E Хойд зай заах шугам

Хойд гупернээс 0.5 м (цэнхэр) зайг заана.

F Автомашины өргөнийг заах шугам

Шулуун ухрах үеийн явах замыг харуулна.

- Тус шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байна.


- Автомашин шулуун үед чиглүүлэх шугам нь явах замыг заах шугамтай давхацна.

G Автомашины төвийг заах шугам

Автомашины өргөнийг заах шугамны төвийг харуулна.

■ Зогсоолд байрлуулахад туслах шугамын горим

Тус горим нь жолооны хүрд эргүүлэх цэгийг харуулна (Зогсоолд байрлуулахад туслах шугам). Тус горим нь явах замыг заах шугам ашиглалгүйгээр зогсоолд байрлуулах чадвартай жолооч ашиглахад тохиромжтой.



A Урд талын зай заах шугам

Автомашины урд талаас 1 м (цэнхэр) зайг заана.

B Хойд зай заах шугам

Автомашины хойд талын зайг заана.

- Хойд гуперны төвөөс 0.5 м (1.5 фут) (улаан) зайг заана.

C Автомашины төвийг заах шугам

Автомашины өргөнийг заах шугамны төвийг харуулна.

D Автомашины өргөнийг заах шугам

Шулуун ухрах үеийн явах замыг харуулна.

- Тус шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байна.


E Зогсоолд байрлуулахад туслах шугам

Автомашины хойд талын эргэх боломжтой хамгийн бага замыг заана.

- Зогсоолд байрлуулах үед жолооны хүрд эргүүлэх байрлалыг мэдээллийн журмаар ашиглана.

■ Зай заах шугамын горим

Тус горим нь зөвхөн зай заах шугам харуулна. Чиглүүлэх шугам ашиглах шаардлагагүй жолооч ашиглахад тохиромжтой.

**A** Урд талын зай заах шугам

Автомашины урд талаас 1 м (цэнхэр) зайг заана.

B Хойд зай заах шугам


Автомашины хойд талын зайг заана.

- Хойд гуперны төвөөс 0.5 м (1.5 фут) (улаан) зайг заана.

■ Явах замын төвийг заах шугамын горим

Тус горим нь явах замыг заах шугам ба автомашины төвийг заах шугамыг жолооны хүрдний ажиллагаатай уялдуулан харуулна.

Тус горимыг замын шон зэрэгт автомашины төв хэсгээрээ ойртох үед ашиглахад тохиромжтой.



- A** Урд талын зай заах шугам
Автомашины урд талаас 1 м (цэнхэр) зайг заана.
- B** Хажуугийн явах замыг харуулах шугам
Жолооны хурдний ажиллагаанд уялдуулан явах замыг (шар) тооцоолон харуулна
- C** Хойд зай заах шугам
Автомашины хойд талын зайг заана.
● Зай заах шугам нь явах замыг заах шугамтай холбоотой.
● Хойд гуперны төвөөс 0.5 м (улаан) болон 1 м (шар) зайг заана.
- D** Ухрах үеийн явах замыг харуулах шугам
Жолооны хурдний ажиллагаанд уялдуулан явах замыг (шар) тооцоолон харуулна
- E** Явах замын төвийг заах шугам
Жолооны хурдний ажиллагаатай уялдсан автомашины төвийг заах шугам (ногоон)-г харуулна.

МЭДЭЭЛЭЛ

Чиглүүлэх шугам нь тээшний хаалга хаагдаагүй үед гарахгүй. Тээшний хаалга бүрэн хаагдсан ч чиглүүлэх шугам гарахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

АЮУЛТАЙ

Автомашины өргөнийг заах шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байдаг. Ухрах үед цаг ямагт ойр орчмоо толинд болон шууд харж нягтлана.

Туулах зайг тооцоолон харуулах горим ашиглан зогсоолд байрлуулах


spu1649841251550.dita

1 Арааг "R"-д шилжүүлнэ.

- 2 Зогсоолын талбайд туулах зайг тооцоолон харуулах шугам орох байдлаар жолооны хүрдийг эргүүлэн удаан ухарна.


A Зогсоолын талбай

B Туулах зайг тооцоолон харуулах шугам



- 3 Зогсоолын талбайд автомашины хойд тал орох үед автомашины өргөнийг заах шугам зогсоолын талбайн баруун болон зүүн тусгаарлах шугамны дотор оруулах байдлаар жолооны хүрдийг эргүүлнэ.

A Автомашины өргөнийг заах шугам




- 4 Зогсоолын талбайн шугам болон автомашины өргөнийг заах шугам зэрэгцээ болох үед жолооны хүрдийг шулуун чиглэлд буцааж зогсоолын талбайд бүрэн орох хүртэл зөөлөн ухарна.

5 Тохиромжтой газарт зогсоогоод зогсоолд байрлуулах үйлдлийг дуусгана.

Зогсоолд байрлуулахад туслах шугамын горим ашиглан зогсоолд байрлуулах

cag1649841251222.dita

- 1 Арааг "R"-д шилжүүлнэ.**
- 2 Зогсоолын талбайн зүүн гар талын тусгаарлах шугамтай зогсоолд байрлуулахад туслах шугам давхцах хүртэл ухарна.**
 - A** Зогсоолд байрлуулахад туслах шугам
 - B** Зогсоолын талбайн тусгаарлах шугам




- 3 Жолооны хүрдээ зүүн тийш бүрэн эргүүлээд зөөлөн ухарна.**
- 4 Автомашин зогсоолын талбайтай нэг эгнээнд орсон үед жолооны хүрдээ тэгшлээд автомашин зогсоолын талбайд бүрэн орох хүртэл зөөлөн ухарна.**
- 5 Автомашиныг зөв байрлуулаад үйлдлийг дуусгана.**

Хажуугийн толь эвхэгдсэн үеийн дэлгэц

vfz1649841251347.dita

Хажуугийн толь эвхэгдсэн үед панорамик камер биш хажуугийн толины дүрс дэлгэцээр гарна. Энэ нь зай талбай багатай зогсоолын талбайд байрлуулах зэрэг үед автомашины ойр орчмыг нягтлах боломж олгоно.



A Хажуу талын харагдац

B Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч объект мэдрэх үед дэлгэц дээрх индикатор асч дохио дуугарна. (Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

C Урд/хойд/хойд талын өргөн харагдац

МЭДЭЭЛЭЛ

- Хажуу талын харагдац болон урд талын өргөн харагдац гарч байгаа үед камерны товч дарахад өмнөх дэлгэцэнд буцна.*1
- Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэсэн объектын байрлал нь камерны дүрсний байрлалаас өөр байж болно.

*1 :Зөвхөн 14 инчийн дэлгэц


Дэлгэц дээр томруулах

yor1649841251206.dita


Дүрс хэт жижиг ба сайн харагдахгүй үед дэлгэц дээр томруулах боломжтой.

Панорамик эсвэл урд талын өргөн харагдац гарах үед томруулах хэсгийг товшино.


► Панорамик харагдац (14 инчийн дэлгэц)



► Панорамик харагдац (9.8 инчийн дэлгэц)



► Урд талын өргөн харагдац (9.8 инчийн дэлгэц)



- Дэлгэцийн сонгосон хэсэг томорч харагдана.
- Панорамик харагдацын үед автомашины урд эсвэл хойд талд дэлгэцийн 2 хэсгийн нэгийг томруулж харах боломжтой (эсвэл урд баруун/зүүн эсвэл хойд баруун/зүүн 4 хэсгийн нэгийг томруулж харах боломжтой*1).

- Томруулсан дэлгэцийг цуцлах үед дахин товшино.




МЭДЭЭЛЭЛ

- Дараах бүх нөхцөл бүрдсэн үед томруулах боломжтой:
 - Автомашины хурд 12 км/ц-с бага
 - Lexus parking assist-мэдрэгч асаалттай
- Дараах аль нэг нөхцөлд тус функц автоматаар цуцлагдана:
 - Автомашины хурд 12 км/ц-с их
 - Lexus parking assist-мэдрэгчийг унтраасан
- Панорамик харагдац дээр дэлгэц томруулсан үед чиглүүлэх шугам гарахгүй.

Автомашины доод талыг нэвт харуулах дэлгэц aak1649841251566.dita

Одоогийн байрлалд очихоос өмнө авсан камерны дүрсийг нийлүүлэн дэлгэцээр харуулж автомашины доод тал болон дугуйн байрлал мэдэхэд туслана. Дүрсийг панорамик, хажуугийн оврын, мөн эргэлтийн үеийн харагдацаар гаргах боломжтой.

Автомашины доод талыг нэвт харуулах дэлгэц нь өөрчлөх боломжтой тохиргооны дэлгэц дээр тохиргоог идэвхжүүлсэн ба автомашин урагш явах эсвэл ухарч байгаа үед гарна.

**A Дугуйн мөр**

Жолооны хүрдний ажиллагаатай уялдуулан дугуй явах замыг харуулна.

B Автомашины чиглүүлэх шугам

Автомашины гадна талыг харуулна.

МЭДЭЭЛЭЛ

- Тус дэлгэц дараах нөхцөлүүдэд гарахгүй:
 - Автомашины хурд 20 км/ц-с дээш
 - Автомашин зогссоноос хойш тодорхой хугацаа өнгөрсөн
 - Автомашин ассаны дараа тодорхой хугацаанд хөдлөөгүй
 - Хажуугийн толь эвхэгдсэн
 - ABS ажиллаж байгаа
 - Систем зөв ажиллахгүй байгаа
- Дараах нөхцөлүүдэд систем зөв ажиллахгүй байж болно:
 - Цасаар бүрхэгдсэн зам дээр
 - Сүүдэр байгаа
 - Камерны линз дээр шавар шороо зэрэг гадны биет байгаа
 - Ус (гол, нуур зэрэг.)
 - Нэмэлт тоноглол угсарсан
 - Камерны урд саад байгаа

- Дугуйг сольсон
- Тээшний хаалга нээлттэй ба камерны байрлал буруу
- Зам хальтиргаатай эсвэл дугуй хий эргэсэн
- Автомашин налуу зам дээр байгаа
- Өмнө авсан дүрсийг дэлгэцээр гаргаж байгаа тул дараах нөхцөлүүдэд бодит байдлаас өөр байж болно:
 - Дүрс авснаас хойш объект хөдөлсөн
 - Дүрс авсны дараа элс, цас зэрэг хөдөлсөн
 - Дэлгэцээр харуулах талбайд шавар, цөөрөм байгаа
 - Автомашин шарвасан үед
- Дараах нөхцөлүүдэд дүрсний зарим хэсэг харлаж харагдаж болно:
 - Дүрс аваагүй үед автомашин хөдлөж эхлэх
 - Жолооны хүрдийг тодорхой хэмжээнээс ихээр эргүүлсэн

▲ АЮУЛТАЙ

- Зорчигчдын тоо, ачаа тээш, замын хазайлт, замын гадаргуугийн нөхцөл, орчны гэрлийн хэмжээ, нэмэлт тоноглол, дугуй болон бусад зүйлсээс шалтгаалж дугуй болон автомашины чиглэлийг заах шугам нь автомашины бодит байрлал өөр байж болно. Жолоодлогын үед ойр орчмоо цаг ямагт нягтлана.
- Дэлгэцээр гарч буй дүрс нь цаг хугацааны хувьд өмнө нь авсан дүрс болно. Дүрс авснаас хойш саад болон объект хөдөлсөн үед дүрс нь бодит байдлаас өөр байж болно.

— Холбоотой холбоосууд —

Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх(Х. 314)

Хөдөлж буй объектын анхааруулга^{*1}

nfv1650440259247.dita

Панорамик харагдац сонгосон үед автомашины эргэн тойронд хөдөлж буй объект илэрсэн тохиолдолд дохио дуугарч, дэлгэц дээр анхааруулга гарна.

Хөдөлж буй объектын анхааруулга нь дараах бүх нөхцөл хангагдсан нөхцөлд ажиллана:

- Арааны "D" эсвэл "R" байрлал сонгогдсон үед
- Автомашины хурд 15 км/ц-с бага
- Хажуу толь эвхэгдээгүй

МЭДЭЭЛЭЛ

- Дараахь тохиолдлуудад камерын мэдрэгч нь хөдөлж буй объектыг зөв мэдрэхгүй байж болно:
 - Тухайн объект нь гүйж буй хүн
 - Бусад автомашин эсвэл барилгын цаанаас хүн гэнэт гарч ирэх үед
 - Объект нь скейтборд унаж буй хүн эсвэл өөрийгөө тэнцвэржүүлдэг хувийн тээвэрлэгч байх үед
 - Тухайн объект нь хүрээлэн буй орчинтой ижил өнгөтэй хувцасласан хүн байх үед
 - Хүний бие хэсэгчлэн автомашин, ачаа тээш зэрэгт халхлагдсан үед
 - Нар жаргаж харанхуй болсон үед
 - Бороо, цас, манан гэх мэт цаг агаар муу үед.
 - Камерын линз шавар, цас хайлуулах бодис зэрэгт бохирдсон эсвэл гэмтсэн үед
 - Камерын линз дээр усны дусал тогтсон үед
 - Маш хүчтэй гэрэл камерын мэдрэгч рүү шууд тусах үед
 - Гараж, газар доорх зогсоолын орох хаалганы ойр орчимд зэргээр гэрэлтэй болон харанхуй орчинд байгаа үед
- Дараах объект мэдрэгдсэн үед мөргөлдөх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болно:
 - Туг далбаа, автомашины утаа, их хэмжээний борооны дусал, цас, зам дээрх борооны ус гэх мэт хөдөлж буй объект/бодис
 - Цагаан шугам, явган хүний гарц, чулуун хучилт, трамвайны төмөр зам, зам засварын ул мөр, унасан навч, хайрга, шалбааг гэх мэт зам дээр үүссэн хээ, дүрс
 - Борооны ус зайлуулах төмөр торон хаалт
 - Замын мөр эсвэл налуу зам

*1 :Тоноглогдсон автомашинд


- Тогтоол ус эсвэл нойтон замын гадаргуу дээрх объектын тусгал
- Сүүдэр
- Багана, замын конус, галын гидрант зэрэг өндөр нарийн объект
- Хөдөлгөөнгүй байгаа явган зорчигч, унадаг дугуй эсвэл автомашин
- Дараах нөхцөлүүдэд мөргөлдөх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болно:
 - Автомашин налуу замаар явах үед
 - Налуугийн хэмжээ өөрчлөгдөх зам дээр
 - Ачсан ачаа тээш, гэнэт тоормослох зэргээс шалтгаалан автомашин огцом хазайсан үед
 - Үйлдвэрлэгчийн зааснаас өөр дугуй ашигласан үед
 - Автомашины өндрийг хэт их өөрчилсөн үед (урд талыг өргөсөн, доош буулгасан)
 - Камерын мэдрэгчийн ойр орчимд оригинал бус нэмэлт тоноглол суурилуулсан үед
 - Гуперны хормой зэрэг оригинал бус гупер хамгаалагч суурилуулсан үед
 - Цонхноос гараа гадагш гаргасан үед
 - Дахин суулгасан эсвэл мөргөлдсөний улмаас камерын мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Чирэх дэгээ угсарсан үед
 - Камерын линз шавар, цас хайлуулах бодис гэх мэтээр бохирдсон үед.
 - Камерын линз дээр усны дусал тогтсон үед
 - Ослын дохионы гэрэл зэрэг анивчих гэрэл ойр орчимд байгаа үед

Панорамик дэлгэцийн тохиргоо өөрчлөх

xul1649841251253.dita

Эргэлтийн үеийн автомат дэлгэц болон их биеийн өнгө зэрэг панорамик дэлгэцийн тохиргоог өөрчлөх боломжтой.

1 [⚙️]-г дарна.



2 Хүссэн зүйлээ сонгоно.

● [Cornering View]


Эргэлтийн үеийн харагдацыг автоматаар харуулна.

● [View Under Vehicle]

Автомашины шалыг нэвт харагдуулах харагдацын дэлгэцийг асааж унтраана.

Тохиргоог асаан автомашиныг урагш эсвэл арагш хөдөлгөсөн

үед автомашины доод тал, дугуйн байрлал зэргийг харахад туслах үүднээс автомашины одоогийн байрлалд очихоос өмнө авсан камерын дүрсийг харуулна. Дүрс нь панорамик харагдац, хажуугийн оврын харагдац, эргэлтийн харагдац байдлаар гарна.



● [LEXUS Park Assist 3D Disp.]

Lexus parking assist-мэдрэгчийн 3D дэлгэцийг асаах буюу унтраана.

● [LEXUS Park Assist Dist.]

Lexus parking assist-мэдрэгч саад мэдрэх хүртэлх зайг тохируулна.

● [Vehicle Body Color]

Дэлгэцээр гарах автомашины их биеийн өнгийг өөрчлөнө.

● [Moving object alert]*1

Ойр орчимд байх бүх объектын анхааруулгыг идэвхжүүлэх буюу цуцлана.

● [Warnings when auto display mode enabled]*1

Автомат дэлгэцийн горим асаалттай үеийн анхааруулгыг идэвхжүүлэх буюу цуцлана.

*1 :Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

- Аюулгүйн үүднээс автомашин явж байх үед дэлгэцийн тохиргоог өөрчлөх боломжгүй.
- Тохиргоо өөрчлөх дэлгэц нь арааны "R" байрлалд идэвхжихгүй.*2

Холбоотой холбоосууд

Их биеийн өнгө өөрчлөх(Х. 315)

Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх зайг өөрчлөх(Х. 315)

Их биеийн өнгө өөрчлөх

tos1649841251237.dita

Дэлгэц дээр гарах автомашины их биеийн өнгө өөрчлөнө.


- 1 [Vehicle Body Color]-г дарна.
- 2 Тохируулах өнгө сонгоно.
- 3 [OK]-г дарна.

Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх зайг өөрчлөх

ulw1649841251159.dita

Lexus parking assist-мэдрэгч объектыг мэдэрч эхлэх зайг тохируулна.

- 1 [LEXUS Park Assist Dist.]-г дарна.
- 2 Объект мэдэрч эхлэх зайг сонгоно.
- 3 [OK]-г дарна.



*2 :Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

Панорамик дэлгэц ашиглах үеийн анхааруулга

xug1649841251503.dita

Жолоодлогын үед автомашины ард болон эргэн тойрныг шууд харж шалгана. Эсрэг тохиолдолд бусад автомашинтай мөргөлдөх, санамсаргүй осолд хүргэх аюултай. Панорамик дэлгэц ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

▲ АЮУЛТАЙ

- Панорамик дэлгэцэнд бүрэн даатгах, найдахыг хориглоно. Жолоодлогын үед бусад автомашин жолоодохтой нэгэн адилаар автомашины ард болон эргэн тойрныг шууд харж шалгана. Ялангуяа ойр орчимд зогсож буй автомашин болон бусад объекттой мөргөлдөхөөс сэргийлнэ.
- Жолоодлогын үед цаг ямагт автомашины ард болон эргэн тойрныг шууд харж шалгана.
- Зөвхөн дэлгэц рүү харангаа жолоодож болохгүй. Дэлгэцийн дүрс бодит байдлаас өөр байж болно. Мөн камерын дүрс харуулах боломжтой талбай нь хязгаартай. Зөвхөн дэлгэц харангаа эргэлт, ухрах үйлдэл хийж болохгүй. Эсрэг тохиолдолд бусад автомашинтай мөргөлдөх, санамсаргүй осолд хүргэх аюултай. Автомашины ойр орчмыг шууд харж шалгах мөн голын болон хажуугийн толь ашиглах нь зүйтэй.
- Зорчигчдын тоо, ачаа тээш, замын хазайлт зэргээс шалтгаалж чиглүүлэх шугамны байрлал өөрчлөгдөж болно. Жолоодлогын үед хойд тал, эргэн тойрноо шууд харж шалгана.
- Дараах нөхцөлүүдэд панорамик дэлгэц ашиглаж болохгүй:
 - Мөстэй, хальтиргаатай замын гадаргуу дээр эсвэл цастай үед
 - Дугуйны гинж эсвэл онцгой үед ашиглах дугуйтай үед
 - Урд хаалга, тээшний хаалга бүрэн хаагдаагүй үед
 - Уул толгод зэрэг зам тэгш бус үед
 - Lexus-н зааснаас өөр дугуй ашигласан үед
 - Явах эд ангид өөрчлөлт хийсэн үед
 - Дэлгэцээр харагдах хэсэг дээр Lexus-н оригинал биш бүтээгдэхүүн угсарсан үед
- Гадна агаарын хэм хүйтэн үед дэлгэц харлаж дүрс бүдэг болж болно. Автомашин явах үед дүрс хэлбэрээ алдах эсвэл дүрс гарахгүй байж болох тул жолоодлогын үед ойр орчмоо цаг ямагт шууд харж шалгана.
- Дугуйгаа сольсон үед чиглүүлэх шугамын байрлал буруу зааж болно.


АНХААР

- Нэвт харагдах, хөдөлгөөнтэй, панорамик, хажуугийн оврын болон эргэлтийн үеийн харагдацууд нь урд, хойд болон 2 хажуугийн камерны дүрснээс бүрддэг. Дэлгэцээр харуулах боломжтой талбай болон агуулга нь хязгаартай тул панорамик дэлгэцийг ашиглахаас өмнө дэлгэцийн онцлогтой сайтар танилцах нь зүйтэй.
- Нэвт харагдах, хөдөлгөөнтэй, панорамик, хажуугийн оврын болон эргэлтийн үеийн харагдацууд нь автомашины 4 буланг харуулах үедээ камерны дүрсний зах хэсгүүдийг видео хэлбэрээр нэгтгэдэг тул дүрс тод харагдах байдал буурч болно. Нөгөөтэйгүүр энэ нь алдаа биш болно.
- Камер тус бүрийн ойролцоох гэрлийн байдлаас шалтгаалж тод болон хар цэгүүд нэвт харагдах, хөдөлгөөнтэй, панорамик, хажуугийн оврын болон эргэлтийн үеийн харагдацууд дээр гарч болно.
- Нэвт харагдах, хөдөлгөөнтэй, панорамик, хажуугийн оврын болон эргэлтийн үеийн харагдацууд нь камер тус бүрийн байрлалаас өндөр эсвэл тусгалд орохгүй хэсгийг харуулах боломжгүй.
- Автомашины эргэн тойронд жолоочид үл харагдах хэсгүүд байдаг ба эдгээрийг панорамик дэлгэцээр харуулах боломжгүй.
- Урд талын өргөн харагдац, хойд тал, хойд талын өргөн харагдац, хажуугийн харагдац горим дээр дэлгэцээр харагдах 3 хэмжээст объект нь нэвт харагдах, хөдөлгөөнтэй, панорамик, хажуугийн оврын болон эргэлтийн үеийн харагдацаар харагдахгүй байж болно.
- Хүн, бусад 3 хэмжээст саад панорамик дэлгэцээр өөр харагдаж болно. (Үүнд объектууд нааш налсан харагдах, дүрс нийлж байгаа хэсэгт объект харагдахгүй байх эсвэл байхгүй дүрс харагдах, бодит зай өөрөөр харагдах зэрэг хамаарна.)
- Камертай тээшний хаалга, хажуугийн толин дээр камер суурилагдсан урд хаалга нээлттэй үед панорамик дэлгэц дээр дүрс зөв гарахгүй.
- Нэвт харагдах дэлгэц, хөдөлгөөнт дэлгэц, панорамик дэлгэц, хажуугийн оврын болон эргэлтийн дэлгэц гарах үеийн автомашины тэмдэг нь компьютерийн дүрс тул автомашины бодит хэмжээ, дүрс, өнгөнөөс өөр байж болно. Ойр орчмын 3 хэмжээст объект автомашинд шүргэсэн харагдах эсвэл бодит зай өөр харагдаж болно.
- Камер зөв ажиллахгүй байж магадгүй бөгөөд зураг дараах байдлаар дэлгэцэн дээр гарч болзошгүй:
 - Араа "R"-д байгаа үед дэлгэц хэсэгчлэн эсвэл бүхэлдээ харлаж болно
 - Араа "R"-д байгаа үед камерны дүрс гарахгүй байж болно
 - "R"-с өөр араа сонгосон үед камерны дүрс үргэлжлэн гарч болно.
 - Камерны дүрс дээр чиглүүлэх шугам гарахгүй ба анхааруулах тэмдэг, мэдэгдэл гарна

Дэлгэцээр харагдах хэсэг

wpr1649841251487.dita


Автомашины ойр орчимд дэлгэцээр харагдахгүй сохор бүсүүд байдаг. Автомашины ойр орчимд аливаа зүйл байхгүй гэж дэлгэцээр харагдаж байгаа ч зам дээр мөргөлдөж болзошгүй бодит саад байж болно. Цаг ямагт ойр орчмоо шууд харж шалгана.



A Дэлгэцээр харагдах хэсэг

B Дэлгэц дээр харагдахгүй объект

Хар хэсэгт байгаа объект дэлгэцээр гарахгүй.




A Дэлгэцээр харагдах хэсэг

B Дэлгэц дээр харагдахгүй объектын хэсэг

Замаас өндөрт байрлах объект дэлгэцээр харагдахгүй.

МЭДЭЭЛЭЛ

- Автомашины тэмдгийн ойр орчмын хар хэсэг нь камерт харагдахгүй. Энэ хэсгүүдийг шууд харж шалгана.
- 4 камернаас авсан дүрсийг тэгш талбай дээр авсан гэж тооцоолон нийлүүлдэг тул нэвт харагдах дэлгэц, хөдөлгөөнт дэлгэц, панорамик дэлгэц (томруулсан хамаарна), хажуугийн оврын болон эргэлтийн дэлгэц дараах байдлаар харагдаж болно:
 - Объект бодит хэмжээнээс нарийн, том эсвэл хазайсан харагдаж болно.
 - Замын гадаргуунаас өндөрт байрлах объект бодит зайнаас хол харагдах эсвэл огт харагдахгүй байж болно.
 - Дүрсний харагдахгүй хэсгүүдээс өндөр объектууд цухуйсан мэт харагдаж болно.
- Гэрэлтүүлгийн нөхцөлөөс шалтгаалж камер бүрт зургийн тод байдлын ялгаа гарч болно.
- Автомашины хазайлт, зорчигчдын тоо, ачаа тээш, шатахууны хэмжээ зэргээс шалтгаалан дүрс буруу харагдаж болно.
- Хаалга бүрэн хаагдаагүй үед дүрс болон чиглүүлэх шугам зөв гарахгүй байж болно.
- Автомашины бодит байрлал болон нэвт харагдах дэлгэц, хөдөлгөөнт дэлгэц, панорамик дэлгэц (томруулсан хамаарна), хажуугийн оврын болон эргэлтийн дэлгэцний автомашины тэмдгийн байрлал өөр байж болно.
- [○] тэмдгээр тэмдэглэгдсэн дүрс нь нийлмэл дүрс тул муу харагдаж болно.




■ Урд талын өргөн дэлгэц

A Дэлгэцээр харагдах хэсэг

B Дэлгэц дээр харагдахгүй объект

Гупернүүдийн 2 буланд ойр байрлах хэсгүүд дэлгэц дээр харагдахгүй.




☐ МЭДЭЭЛЭЛ

- Камерны дүрс авах талбай хязгаарлагдмал байдаг. Гуперны 2 буланд ойр, гупер доор байх объект дэлгэцээр гарахгүй.
- Дэлгэц дээр гарч буй дүрсний алслалт нь бодит зайнаас өөр байна.
- Урд өргөн дэлгэцийн камер нь тусгай линз ашигладаг тул дэлгэц дээр гарч буй дүрсний алслалт нь бодит зайнаас өөр байна.

■ Хоёр хажуугийн дэлгэц (хажуугийн толь эвхэгдсэн үед)

A Дэлгэцээр харагдах хэсэг



МЭДЭЭЛЭЛ


- Дэлгэцээр харуулах боломжтой талбай нь автомашин болон замын нөхцөлөөс хамаарч өөр байна.
- Камерны дүрс авах талбай хязгаарлагдмал байдаг. Зорчигч талын гуперт ойр эсвэл гупер доор байх объект дэлгэцээр гарахгүй.
- Дэлгэц дээр гарч буй дүрсний алслалт нь бодит зайнаас өөр байна.
- Хоёр хажуугийн дэлгэцний камер нь тусгай линз ашигладаг тул дэлгэц дээр гарч буй дүрсний алслалт нь бодит зайнаас өөр байна.

■ Хойд талын дэлгэц

A Дэлгэцээр харагдах хэсэг

B Дэлгэц дээр харагдахгүй объект

Гупернүүдийн 2 буланд ойр байрлах хэсгүүд дэлгэц дээр харагдахгүй.




■ Хойд талын өргөн дэлгэц

A Дэлгэцээр харагдах хэсэг

B Дэлгэц дээр харагдахгүй объект

Гупернүүдийн 2 буланд ойр байрлах хэсгүүд дэлгэц дээр харагдахгүй.



МЭДЭЭЛЭЛ


- Дэлгэцээр харуулах боломжтой талбай нь автомашин болон замын нөхцөлөөс хамаарч өөр байна.
- Камерны дүрс авах талбай хязгаарлагдмал байдаг. Гуперны 2 буланд ойр, гупер доор байх объект дэлгэцээр гарахгүй.
- Дэлгэц дээр гарч буй дүрсний алслалт нь бодит зайнаас өөр байна.
- Хойд талын дэлгэц болон хойд талын өргөн дэлгэц нь тусгай линз ашигладаг тул дэлгэц дээр гарч буй дүрсний алслалт нь бодит зайнаас өөр байна.
- Хойд камернаас өндөрт байрлах объект дэлгэц дээр харагдахгүй байж болно.

Камерны байрлал


bxs1649841251612.dita

Панорамик (360°) дэлгэцийн камерыг дараах байдлаар харуулав.


■ Урд камер



■ Хажуугийн камер



■ Арын камер



Камер цэвэрлэх

nca1649841251316.dita

Усны дусал, цас, шавар зэрэг бохирдол, гадны биет камер дээр тогтсон үед дүрс цэвэр харагдахгүй. Энэ нөхцөлд камерыг их хэмжээний усаар угааж цэвэр, зөөлөн даавуу норгон арчина.

⚠ АНХААР

- Панорамик дэлгэцийн хэвийн ажиллагаа алдагдаж болно. Дараах зүйлсийг анхаарна уу:

АНХААР

- Камерыг цохих, хүчтэйгээр дарж болохгүй. Ингэснээр камерны тусгал алдагдах аюултай.
- Камер нь усны хамгаалалттай. Салгах, задлах болон өөрчлөхийг хориглоно.
- Камерны линз угаах үед их хэмжээний усаар угаагаад цэвэр, зөөлөн даавуу норгон арчина. Камерны линзийг хүчтэй зүлгэх нь линзэнд хортон суулгах, улмаар дүрс цэвэр харагдахгүй болгон.
- Камерын таг нь резинээр хийгдсэн байдаг. Органик нэгдэл, автомашины вакс, шил толь цэвэрлэгч, шилний хуулга зэргийг камерт хүргэхийг хориглоно. Хүргэсэн нөхцөлд даруй арчина.
- Хүйтэн үед автомашин руу халуун ус цацах болон бусад хэлбэрээр температурын огцом хэлбэлзэл үүсгэж болохгүй.
- Өндөр даралтын автомашин угаагчаар угаасан үед камер болон камерны ойр орчим руу шууд шүршиж угааж болохгүй. Хүчтэй даралттай ус нь камер доголдуулах аюултай.
- Камер цохилтонд өртсөн нөхцөлд доголдол үүсч болзошгүй. Энэ нөхцөлд даруй өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Шил арчигчийн шингэнээр арын камер цэвэрлэх

Арын камерт тогтсон бохирдлыг камер цэвэрлэгчийн шингэн ашиглан цэвэрлэх боломжтой. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

- Камер цэвэрлэх үед шил арчигчийн шингэнээс шалтгаалж дүрс сайн харагдахгүй байж болно. Ухрах үед үйлдэл эхлэхээс өмнө автомашины ойр орчмыг шууд болон толиндоо давхар харж шалгана.
- Цэвэрлэсний дараа хэрэв шингэн камерны линз дээр үлдсэн нөхцөлд шөнийн цагаар арын автомашины их гэрлийн тусгалаас хамаарч дүрс сайн харагдахгүй байж болно.
- Зарим бохирдол бүрэн цэвэрлэгдэхгүй байж болно. Энэ нөхцөлд камерны линзийг их хэмжээний усаар зайлаад цэвэр, зөөлөн даавуу норгон арчина.
- Шил арчигчийн шингэн нь камерны линз рүү цацагддаг. Камерны ойр орчимд тогтсон цас, мөс зэргийг цэвэрлэх боломжгүй.


АНХААР

Шил арчигчийн хошууны байрлал болон тусгал өөрчлөгдөх тул хошууг хүчтэй цохилтод өртөхөөс сэргийлнэ.

Зогсоолд байрлуулахад туслах гэрэл

zwv1649841251441.dita

Панорамик дэлгэцийн зогсоолд байрлуулахад туслах гэрлийн байрлалыг зурагт харуулав.



АНХААР

- Панорамик дэлгэц зөв ажиллахгүй тул дараах анхааруулгыг мөрдөнө:
 - Гэрэл дээр хэт хүчтэй дарах, хүчтэй цохилтод учруулахаас сэргийлнэ. Гэрлийн байрлал, тусгал алдагдах аюултай.
 - Гэрэл нь усны хамгаалалттай тул салгах, задлах, өөрчлөхийг хориглоно.
 - Гэрлийг цэвэрлэх үед их хэмжээний усаар угаагаад цэвэр, зөөлөн алчуур норгон арчина.
 - Гэрэл нь резин тул органик уусгагч, вакс, тос задлах бодис, шил өнгөлгөө зэргийг ашиглаж болохгүй. Гэрэлд эдгээр нь хүрсэн нөхцөлд даруй цэвэрлэнэ.
 - Хүйтэн үед ус хүрэх зэргээр температурын огцом өөрчлөлтөд оруулж болохгүй.
 - Автомашиныг өндөр даралтын авто угаагчаар угаах үед гэрэл болон гэрлийн ойр орчим руу шууд шүршиж болохгүй. Өндөр даралттай ус нь гэрлийг гэмтээх аюултай.
- Гэрэл хүчтэй цохилтод өртсөн үед гэмтсэн байж болзошгүй. Даруй өөрийн Lexus дилер дээр оношуулна уу.


Дэлгэц болон бодит замын ялгаа

lha1649841251597.dita

Панорамик дэлгэц болон чиглүүлэх шугам нь хамтдаа тэгш зам дээрх зайг харуулдаг. Дэлгэц дээрх чиглүүлэх шугам болон бодит замын хооронд зөрүү үүсч болно.


■ Автомашины ард талын зам огцом өгсүүр үед

Зай заах шугам нь бодит зайнаас илүү ойр харагдах болно. Тиймээс налуу дээр байгаа объектууд бодит байдлаасаа хол байна. Мөн үүнтэй адилаар чиглүүлэх шугам болон автомашины туулах зам хооронд зөрүү үүснэ.



■ Автомашины ард талын зам огцом уруу үед


Зай заах шугам нь бодит зайнаас илүү хол харагдах болно. Тиймээс налуу дээр байгаа объектууд бодит байдлаасаа ойр байна. Мөн үүнтэй адилаар чиглүүлэх шугам болон автомашины туулах зам хооронд зөрүү үүснэ.



■ Автомашины аль нэг тал доош хазайсан үед


Зорчигчдын тоо, ачааны хуваарилалтаас хамаарч автомашины аль нэг тал хазайсан үед чиглүүлэх шугам болон автомашины туулах зам хооронд зөрүү үүснэ.

A Зөрүү



■ Явах замын төвийг заах шугам

Чиглүүлэх шугам нь арын гуперны төв хэсгийг газраас хөндий байдлаар харуулдаг тул зарим нөхцөлд тус шугам төвөөс хазайсан мэт харагдаж болно.



Дэлгэц болон бодит объектын (3 хэмжээст) зөрүү

meq1649841251362.dita


Чиглүүлэх шугам нь тэгш талбай дээр чиглэлийг тооцоолон харуулдаг тул гурван хэмжээст объектын байрлалыг тогтоох боломжгүй. Гадагш түрж гарч ирсэн гурван хэмжээст объектод (ачааны машины тэвш зэрэг) ойртох үед дараах зүйлсэд анхаарна.

▲ АЮУЛТАЙ

Lexus parking assist-мэдрэгчийн дэлгэц улаан үед автомашиныг дахин явуулахаас өмнө нүдээр шалгана. Бусад тээврийн хэрэгслийг мөргөх эсвэл бусад санамсаргүй осол үүсгэнэ.

■ Панорамик харагдац (томсгох дэлгэц хамаарна)


Дэлгэц дээр автомашины гупер болон бусад объект, автомашин хүртэл зайтай ба мөргөлдөх эрсдэлгүй харагдаж байгаа ч бодит байдал дээр мөргөлдөх эрсдэлтэй байж болно. Ойр орчмоо шууд харж шалгана.



■ Туулах замыг тооцоолон харуулах шугам


- Дэлгэц дээр автомашины гупер туулах замыг тооцоолон харуулах шугамны гадна байгаа ба бусад объект, автомашин хүртэл зайтай ба мөргөлдөх эрсдэлгүй харагдаж байгаа ч бодит байдал дээр мөргөлдөх эрсдэлтэй байж болно. Ойр орчмоо шууд харж шалгана.

A Туулах замыг тооцоолон харуулах шугам




- Өндөрт байгаа гурван хэмжээс объект (дээврийн илүү гарсан хэсэг, ачааны машины ачих тавцан зэрэг) дэлгэц дээр гарахгүй байж болно. Ойр орчмоо шууд харж шалгана.

A Дээврийн илүү гарсан хэсэг




- Дэлгэц дээр ачааны машины тэвш туулах замыг тооцоолон харуулах шугамны гадна бөгөөд мөргөлдөх эрсдэлгүй харагдаж байгаа ч бодит байдал дээр мөргөлдөх эрсдэлтэй байж болно. Ойр орчмоо шууд харж шалгана.

A Туулах замыг тооцоолон харуулах шугам




■ Зай заах шугам

Дэлгэц дээр ачааны машин **В** байрлалд харагдана. Гэвч бодит байдал дээр хэрэв та **А** хүртэл ухрах үед ачааны машиныг мөргөнө. Дэлгэц дээр **А** хамгийн ойр, **В** болон **С** дарааллаар харагдаж байна. Гэвч бодит байдал дээр **А** ба **С** хүртэлх зай адил ба **В** нь **А** ба **С**-с хол зайд байна. Автомашины ойр орчмыг шууд харж нягтлана. **Д** хүртэлх зай 1м орчим байна.




■ Ташуу багана

Панорамик дэлгэцийг сонгосон үед ташуу багана нь эгц босоо бөгөөд зайтай харагдах боловч бодит байдал дээр баганы дээд тал наашаа ташуу байрласан ба автомашин баганыг мөргөх магадлалтай. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг шууд харж нягтлана уу.



■ Томруулж харуулах функц

Энгийн панорамик харагдацаас ялгаатай нь панорамик дэлгэцийн томруулж харуулах функц нь автомашины тэмдгийг дарж томруулж харуулна. Тиймээс зам, хана дээрх цагаан шугам нь гулзайсан байдлаар харагдаж болно.



Дараах шинж тэмдэг гарсан үед

ext1649841251378.dita

Дараах шинж тэмдэг мэдрэгдсэн үед тухайн шалтгааны дагуу арга хэмжээ авч дахин шалгана.

Тохирох арга хэмжээ авсан ч засагдахгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Дүрс муу харагдах	● Автомашин харанхуйд байгаа. ● Линзний ойр орчмын хэм хэт өндөр, хэт бага. ● Гадна агаарын хэм хэт бага. ● Камер дээр усны дусал байгаа. ● Бороотой, чийгшил ихтэй. ● Камер дээр гадны биет (шавар зэрэг) тогтсон. ● Камер дээр нарны гэрэл, машины их гэрэл шууд туссан. ● Автомашин өдрийн гэрэл, натрийн гэрэл, мөнгөн усны уурын гэрэл зэргийн гэрэлтүүлэг доор байгаа үед.	Автомашинны ойр орчмыг шууд харангаа жолоодно. Харагдах байдал сайжирсны дараа панорамик дэлгэцийг дахин ашиглана. Multi-terrain монитор системийн дүрсний чанарыг панорамик дэлгэцийн тохиргоотой адил аргаар хийнэ.
Дүрс бүрсийх	Усны дусал, цас, шавар зэрэг гадны биет камерт тогтсон.	Камерыг их хэмжээний усаар угаасны дараа линзийг зөөлөн нойтон даавуугаар арчина. Камер угаагч ашиглан линзийг цэвэрлэнэ. Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.
Камерын чиглэл алдагдах	Камер хүчтэй цохилтонд өртсөн.	Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.
Чиглүүлэх шугамын	Камерын байрлалын тохиргоо алдагдсан.	Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

8-2. Панорамик дэлгэц

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
тохиргоо алдагдах	● Автомашин хазайсан (хүнд ачаа ачсан, дугуй хагарч хийн даралт буурсан зэрэг). ● Автомашин налуу газар байгаа.	Жолоодлогын үед ойр орчмыг шууд харж шалгана.
Жолооны хүрд шулуун байгаа ч эргэх чиглэл заах шугам хөдлөх (өргөнийг заах болон эргэх чиглэл заах шугам зөрөх).	Жолооны хүрдний мэдрэгч буруу сигнал өгч байгаа.	Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.
Чиглүүлэх шугам гарахгүй байх	Тээшний хаалга нээлттэй.	Тээшний хаалга хаана. Шалтгаан шийдвэрлэгдэхгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.
Панорамик дэлгэц томорч харагдахгүй байх. Нэвт харагдах дэлгэц/хөдлөх үеийн дэлгэц, хажуугийн оврын дэлгэц, эргэлтийн үеийн дэлгэц гарахгүй байх.	Lexus parking assist-сенсор доголдсон эсвэл бохирдсон.	Lexus parking assist-мэдрэгчийн доголдлыг засах аргын дагуу засна. (Дэлгэрэнгүйг "Хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.)

— Холбоотой холбоосууд —

[Дэлгэцийн тохиргоо өөрчлөх\(Х. 70\)](#)

Программ хангамжийн нээлттэй эх сурвалжийн тухай мэдээлэл

yoe1649841251628.dita

Тус бүтээгдэхүүн нь нээлттэй эх сурвалжтай программ хангамж ашигладаг.

Программ хангамжийн нээлттэй эх сурвалжийн тухай мэдээллийг дараах холбоосноос харах боломжтой:

<https://www.denso.com/global/en/opensource/svss/toyota>

9-1. Хавсралт

Аудио системд ашиглаж болох медиа болон датагийн тухай мэдээлэл.....	338
Сертификат.....	348

Аудио системд ашиглаж болох медиа болон датагийн тухай мэдээлэл

Ашиглах боломжтой медиагийн тухай мэдээлэл

Дараах үзүүлэлттэй медиа, бусад төхөөрөмж ашиглах боломжтой.

■ USB флашны формат болон үзүүлэлт

USB флашны формат болон үзүүлэлт мөн ашиглалтын үеийн хязгаарлалтыг дурдав.

USB дамжуулалтын формат	USB 2.0 HS (480MBPS)
Файлын формат	FAT 16/32
Дамжуулалтын төрөл	Масс хадгалах төрөл
Хавтасны зөвшөөрөгдөх дээд тоо	3000 (үндсэн хавтас орно)
Хавтасны зөвшөөрөгдөх дээд түвшний тоо	8
Файлын зөвшөөрөгдөх дээд тоо	9999 (хавтас тутам 255 файл)
Санах ойн багтаамж	32 GB хүртэл
Нэг файлын дээд хэмжээ	2GB

- Дээд дурдсанаас бусад файл зөв тоглогдохгүй байх эсвэл файл, хавтасны нэр зэрэг мэдээлэл зөв гарахгүй байж болно.
- Таны USB флашийг тоглуулах боломжгүй байж болохыг анхаарна уу.
- USB флашинд файл хадгалсан компьютераас хамаарч тоглуулах файлаас гадна үл харагдах файлууд хадгалагдсан байж болно. Эдгээр файлуудыг устгах нь зүйтэй. Эдгээр нь файл тоглуулахад сөргөөр нөлөөлөх эсвэл тоглуулах файл зөв солигдохгүй байдалд хүргэж болно.

Форматын мэдээлэл

Ашиглах боломжтой дууны үзүүлэлтийг дараах байдлаар харуулав.

■ MP3

Дэмждэг стандартууд	MP3 (MPEG1 LAYER 3, MPEG2 LSF LAYER 3)
---------------------	--

Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz)	MPEG1 LAYER 3:32, 44.1, 48 MPEG2 LSF LAYER 3:16, 22.05, 24
Дэмждэг битийн хурд (kbps) ⁽¹⁾	MPEG1 LAYER 3:32-с 320 MPEG2 LSF LAYER 3:8-с 160
Дэмждэг сувгийн горим	Stereo, joint stereo, dual channel, monaural
ID3 таг	ID3 Ver. 1.0, 1.1, 2.2, 2.3 (хувилбар тус бүрийн тэмдэгтийн тоо)

(1) VBR (Variable Bit Rate)-г дэмждэг.

■ WMA

Дэмждэг стандартууд	WMA Ver. 7, 8, 9 (9.1, 9.2)
Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz)	32, 44.1, 48
Дэмждэг битийн хурд (kbps) ⁽¹⁾⁽²⁾	Ver. 7, 8:CBR (Тогтмол битийн хурд) 48-с 192 Ver. 9 (9.1/9.2): CBR 48-с 320

(1) VBR (Variable Bit Rate)-г дэмждэг.

(2) Олон сувагтай аудио эх үүсвэрийг 2 сувагт хөрвүүлдэг.

■ AAC

Дэмждэг стандартууд ⁽¹⁾	MPEG4 AAC-LC
Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz)	11.025, 12, 16, 22.05, 24, 32, 44.1, 48
Дэмждэг битийн хурд (kbps) ⁽²⁾	8-с 320
Дэмждэг сувгийн горим ⁽³⁾	1ch (1/0), 2ch (2/0)

(1) ADIF-г дэмждэггүй.

(2) VBR (Variable Bit Rate)-г дэмждэг.

(3) Давхар сувгийг дэмждэггүй.

■ WAV(LPCM)

Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz) ⁽¹⁾	8, 11.025, 12, 16, 22.05, 24, 32, 44.1, 48, 88.2, 96, 176.4, 192
Дэмждэг квантчлалын битийн тоо (bit) ⁽²⁾	16/24
Дэмждэг сувгийн горим	1ch (1/0), 2ch (2/0)

(1) 96 kHz/24 битээс их аудио эх үүсвэрийг 96 kHz/24 битэд хөрвүүлдэг.

(2) Олон сувагтай аудио эх үүсвэрийг 2 сувагт хөрвүүлдэг.

■ FLAC

Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz) ⁽¹⁾	8, 11.025, 12, 16, 22.05, 24, 32, 44.1, 48, 88.2, 96, 176.4, 192
Дэмждэг квантчлалын битийн тоо (bit) ⁽²⁾	16/24

(1) 96 kHz/24 битээс их аудио эх үүсвэрийг 96 kHz/24 битэд хөрвүүлдэг.

(2) Олон сувагтай аудио эх үүсвэрийг 2 сувагт хөрвүүлдэг.

■ ALAC

Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz) ⁽¹⁾	8, 11.025, 12, 16, 22.05, 24, 32, 44.1, 48, 64, 88.2, 96
Дэмждэг квантчлалын битийн тоо (bit) ⁽²⁾	16/24

(1) 96 kHz/24 битээс их аудио эх үүсвэрийг 96 kHz/24 битэд хөрвүүлдэг.

(2) Олон сувагтай аудио эх үүсвэрийг 2 сувагт хөрвүүлдэг.

■ Ogg Vorbis

Дэмждэг түүвэрлэх давтамж (kHz) ⁽¹⁾	8, 11.025, 16, 22.05, 32, 44.1, 48
Дэмждэг битийн хурд (kbps) ⁽²⁾	32-с 500

(1) 96 kHz/24 битээс их аудио эх үүсвэрийг 96 kHz/24 битэд хөрвүүлдэг.

(2) VBR (Variable Bit Rate)-г дэмждэг.

■ Файлын нэр

MP3/WMA/AAC/WAV(LPCM)/FLAC/ALAC/OGG Vorbis файл гэж танигдсан ба

".mp3"/".wma"/".m4a"/".3gp"/".aac"/".wav"/".flac"/".fla"/".ogg"/".ogx"/".oga" өргөтгөлтэй хадгалагдсан файлыг тоглуулна. MP3/WMA/AAC/WAV(LPCM)/FLAC/ALAC/OGG Vorbis файлыг ".mp3"/".wma"/".m4a"/".3gp"/".aac"/".wav"/".flac"/".fla"/".ogg"/".ogx"/".oga" өргөтгөлтэй хадгална.

■ ID3 таг, WMA таг, AAC таг, таг болон Vorbis комментын тухай

- MP3 файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан ID3 тагтай байдаг.
- WMA файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан WMA тагтай байдаг.

- AAC файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан AAC тагтай байдаг.
- WAV (LPCM) файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан тагтай байдаг.
- FLAC файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан тагтай байдаг.
- ALAC файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан тагтай байдаг.
- Ogg Vorbis файл нь дуучны нэр, гарчиг, цомгийн нэр болон бусад мэдээлэл агуулсан Vorbis комменттой байдаг.

■ Өндөр нягтралтай дууны эх үүсвэр

Тус төхөөрөмж нь өндөр нягтралтай дууны эх үүсвэр дэмждэг. "High-resolution" нь Японы Электрон болон Мэдээллийн Технологийн Аж Үйлдвэрийн холбооны (JEITA) тодорхойлолт болно. Дараах формат болон медиаг дэмжинэ.

Дэмждэг формат

WAV, FLAC, ALAC, Ogg Vorbis

Тоглуулах боломжтой медиа

USB флаш

USB флашнаас тоглуулах боломжтой видео дата

uxa1649896321866.dita

Компьютернаас USB флаш дээр хадгалсан дараах форматыг дэмждэг.

Формат	Кодек
MPEG4 өргөтгөл:".mp4" ".m4v"	● Видео кодек: H.264, MPEG-4 AVC, MPEG-4 ● Аудио кодек: MP3, AAC
AVI өргөтгөл:".avi"	● Видео кодек: H.264, MPEG-4, MPEG-4 AVC, WMV9, WMV9 Advanced Profile ● Аудио кодек: MP3, AAC, WMA 9.2 (7, 8, 9.1, 9.2)
Windows Media Video өргөтгөл:".wmv"	● Видео кодек: WMV9, WMV9 Advanced Profile ● Аудио кодек: WMA 9.2 (7, 8, 9.1, 9.2)

- 1920 x 1080 пиксел хүртэлх хэмжээтэй зургийг дэмжинэ.
- 60i/30p хүртэлх фреймийн тоог дэмжинэ.

- Бичлэгийн төхөөрөмж, бичлэг хийсэн нөхцөл байдал болон ашиглаж байгаа USB флашнаас хамаарч видеог тоглуулах боломжгүй байж болно.

iPod-ны тухай мэдээлэл

bsi1649896321709.dita

МЭДЭЭЛЭЛ

■ Барааны тэмдэгт болон дизайны сертификатын мэдээлэл

● А төрөл

Made for Apple тэмдэг ашиглаж байгаа нь Apple-н бүтээгдэхүүнд ашиглагдахаар дизайнчлагдсан Apple-н чанарын стандарт хангасан үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн болохыг илтгэнэ.

Apple нь тус автомашины ажиллагаа мөн хууль журам, стандартын шаардлага хангасан эсэх талаар аливаа хариуцлага хүлээхгүй.

Тус нэмэлт хэрэгслийг Apple-н бүтээгдэхүүнтэй хамт ашиглах нь утасгүй холболтыг бууруулах магадлалтай.

iPhone, iPod, iPod touch, Siri болон Lightning нь АНУ болон бусад улсад бүртгэлтэй Apple Inc-н барааны тэмдэгт болно.



● В төрөл

Made for Apple тэмдэг ашиглаж байгаа нь Apple-н бүтээгдэхүүнд ашиглагдахаар дизайнчлагдсан Apple-н чанарын стандарт хангасан үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн болохыг илтгэнэ. Apple нь тус автомашины ажиллагаа, мөн хууль журам, стандартын шаардлага хангасан эсэх талаар аливаа хариуцлага хүлээхгүй. Тус нэмэлт хэрэгслийг Apple-н бүтээгдэхүүнтэй хамт ашиглах нь утасгүй холболтыг бууруулах магадлалтай.

iPhone, iPod, iPod touch, iPad, iPad mini, iPad Pro болон Lightning нь АНУ болон бусад улсад бүртгэлтэй Apple Inc-н барааны тэмдэгт болно.



■ А төрөл

Made for

- iPhone 12 Pro Max
- iPhone 12 Pro
- iPhone 12
- iPhone 12 mini

- iPhone SE (2nd generation)
- iPhone 11 Pro Max
- iPhone 11 Pro
- iPhone 11
- iPhone XS Max
- iPhone XS
- iPhone XR
- iPhone X
- iPhone 8 Plus
- iPhone 8
- iPhone 7 Plus
- iPhone 7
- iPhone SE
- iPhone 6s Plus
- iPhone 6s
- iPod touch (7th generation)

■ В төрөл

Made for

- iPhone 12 Pro Max
- iPhone 12 Pro
- iPhone 12
- iPhone 12 mini
- iPhone SE (2nd generation)
- iPhone 11 Pro Max
- iPhone 11 Pro
- iPhone 11
- iPhone XS Max
- iPhone XS
- iPhone XR
- iPhone X
- iPhone 8 Plus
- iPhone 8
- iPhone 7 Plus
- iPhone 7
- iPhone SE

- iPhone 6s Plus
- iPhone 6s
- iPhone 6 Plus
- iPhone 6
- iPhone 5s
- iPad Pro 12.9-inch (5th generation)
- iPad Pro 12.9-inch (4th generation)
- iPad Pro 12.9-inch (3rd generation)
- iPad Pro 12.9-inch (2nd generation)
- iPad Pro 12.9-inch (1st generation)
- iPad Pro 11-inch (3rd generation)
- iPad Pro 11-inch (2nd generation)
- iPad Pro 11-inch
- iPad Pro 10.5-inch
- iPad Pro 9.7-inch
- iPad Air (3rd generation)
- iPad Air 2
- iPad Air
- iPad mini (5th generation)
- iPad mini 4
- iPad mini 3
- iPad mini 2
- iPad (8th generation)
- iPad (7th generation)
- iPad (6th generation)
- iPad (5th generation)
- iPod touch (7th generation)
- iPod touch (6th generation)

Apple CarPlay-н мэдээлэл

bbt1649896321677.dita

 МЭДЭЭЛЭЛ

■ Барааны тэмдэгт болон дизайны гэрчилгээний мэдээлэл

- Apple CarPlay лого ашиглах нь тус автомашины интерфейс Apple-н стандартыг хангаж байгааг илтгэнэ. Apple нь тус автомашины ажиллагаа эсвэл аюулгүй байдал холбогдох стандартыг хангахтай холбоотой хариуцлага хүлээхгүй. Тус бүтээгдэхүүнийг iPhone, iPod, iPad-тай холбон ашиглах нь утасгүй холболтын ажиллагаанд нөлөөлж болохыг анхаарна уу.

Apple CarPlay нь Apple Inc-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.



Android Auto-н мэдээлэл

fou1649896321708.dita

 МЭДЭЭЛЭЛ

■ Барааны тэмдэгт болон дизайны гэрчилгээний мэдээлэл

- Android болон Android Auto нь Google компанийн барааны тэмдэгт болно.



USB санах ойн мэдээлэл

uuq1649896321757.dita

■ Компьютер ашиглан хадгалсан аудио файлууд

Дараах аудио файлуудыг тоглуулах боломжтой.

- MP3
- WMA
- AAC
- FLAC
- WAV
- ALAC
- OGG Vorbis

MP3/WMA/AAC үзүүлэлт

mxz1649896321726.dita

Ашиглах боломжтой MP3/WMA/AAC файлуудад тодорхой шаардлагууд байдаг. Microsoft, Windows болон Windows Media нь АНУ болон бусад улсуудад бүртгэлтэй Microsoft Corporation-н барааны тэмдэгт болно.

Дараах үзүүлэлттэй файл ашиглах боломжтой.

MP3

MP3 (MPEG Audio LAYER 3) нь аудио шахалтын технологийн стандарт формат болно. MP3 ашиглах үед файл нь анхны хэмжээний 1/10 хүртэлх хэмжээнд шахагддаг.

WMA

WMA (Windows Media Audio) нь Microsoft Corporation-н аудио шахалтын формат болно. Тус формат нь аудио файлыг MP3-с бага хэмжээнд шахдаг.

Тус бүтээгдэхүүн нь Microsoft-н тодорхой оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан. Microsoft-н лицензгүйгээр тус бүтээгдэхүүнээс гадуур эдгээр технологийг ашиглах нь хориотой.

AAC

AAC (Advanced Audio Coding) нь MPEG2 болон MPEG4-т ашиглагддаг аудио шахалтын технологи болно.

Bluetooth® мэдээлэл

mus1649896321804.dita

Ашиглах боломжтой Bluetooth® үзүүлэлт болон тохиргоог дараах байдлаар харуулав.

Зүйл	Bluetooth® аудио
Дэмждэг Bluetooth® үзүүлэлтүүд	Bluetooth® Core Specification Ver.5.0-с хойших
Дэмждэг тохиргоонууд	● A2DP (Advanced Audio Distribution Profile) дууны файл дамжуулах тохиргоо: Ver. 1.3.2-с хойших ● Мультимедиа системээс зөөврийн аудиог удирдах (тоглуулах, зогсоох зэрэг) AVRCP (Audio/Video Remote Control Profile) тохиргоо: Ver. 1.6.2-с хойших
Дэмждэг кодекс	LDAC/AAC/SBC

МЭДЭЭЛЭЛ

- Систем нь бүх Bluetooth® төхөөрөмжтэй холбогдох баталгаа байхгүй.

■ Гэрчилгээ

Bluetooth нь Bluetooth SIG, Inc-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.



■ LDAC

LDAC болон LDAC лого нь Sony Corporation-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.



Gracenote® мэдээлэл

yzt1649896321693.dita

Хөгжим тоглуулах үед мултимедиа системийн дата сан цомгийн нэр, дуучны нэр, төрөл, дууны нэрийг хайна. Холбогдох мэдээлэл дата санд хадгалагдсан байгаа үед мэдээллийг автоматаар гаргана. Gracenote® медиа дата сан нь тус мултимедиа системийн дата өгөгдлийг хадгалахад ашиглагддаг.

МЭДЭЭЛЭЛ

■ Gracenote® медиа дата сан

- Дата сангаас автоматаар татсан мэдээлэл нь бодит мэдээллээс өөр байж болно.
- "Gracenote media database"-н мэдээлэл нь 100% нарийвчлалтай баталгаа байдаггүй.
- Gracenote, Gracenote лого, "Powered by Gracenote" болон нь бүгд АНУ болон бусад улсад бүртгэлтэй Gracenote, Inc-н барааны тэмдэгт болно.



Сертификат

pmc1649896321710.dita



A20000210

[R] C-25672

Para consultas, visite:
www.anatel.gov.br

Este equipamento não tem direito à proteção contra interferência prejudicial e não pode causar interferência em sistemas devidamente autorizados.

[Para los vehículos que se venden en Paraguay]

Toyotoshi S.A.

Avda. Mariscal López 2801/99 y Reclus. Asunción – Paraguay.

This product is licensed under the MPEG-4 patent portfolio license, AVC patent portfolio license and VC-1 patent portfolio license for the personal use of a consumer or other uses in which it does not receive remuneration to

- (i) encode video in compliance with the MPEG-4 Visual Standard, AVC Standard and VC-1 Standard ("MPEG-4/AVC/VC-1 Video") and/or
- (ii) decode MPEG-4/AVC/VC-1 Video that was encoded by a consumer engaged in a personal activity and/or was obtained from a video provider licensed to provide MPEG-4/AVC/VC-1 Video.

No license is granted or shall be implied for any other use.
Additional information may be obtained from MPEG LA, L.L.C. See <http://www.mpegla.com>.

QR код

uni1649896321819.dita

"QR код" үг нь Япон болон бусад улсад бүртгэлтэй DENSO WAVE INCORPORATED-н барааны тэмдэгт болно.

Газрын зургийн дата

ous1649896408487.dita

©2021 HERE

Дата өгөгдлийн лицензийг дараах холбоосноос үзнэ үү.

<https://legal.here.com/terms/general-content-supplier/terms-and-notices/>

ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЛИЦЕНЗИЙН ГЭРЭЭ

<https://legal.here.com/en-gb/terms/end-user-license-agreement>

А

Автомат дууны түвшин тохируулагч.....	95
Автомашинаа зарах, устгалд оруулах.....	218
Антен	
Радио.....	184
Асуудал шийдвэрлэх	
Гарын оролцоогүй утас.....	220
Панорамик дэлгэц.....	333
Apple CarPlay/Android Auto.....	139
Lexus parking assist монитор...	282
Аудио.....	178
Аудио систем асаах/унтраах.....	34
Аюулгүй байдлын тохиргоо.....	75

Б

Байрлал	
Байрлал засах.....	89
Бүртгэх	
Дилерийн мэдээлэл.....	74
Нүүр таних.....	65
Тогтмол ашигладаг хаягийн жагсаалт.....	250
Хэрэглэгчийн профайл.....	52
Хэрэглэгчийн профайлын тохиргоо.....	60
Bluetooth® төхөөрөмж.....	113
Бүтэн маршрутын газрын зургийн дэлгэц	
Очих газарт хүрэх цаг	164

В

Веб хөтөч.....	258
Удирдах.....	260

Г

Газрын зураг	
3D харагдацын тохиргоо.....	81

Газрын зургийн төрөл өөрчлөх.....	81
Замын хөдөлгөөний мэдээлэл.....	81
Томруулах/жигжгүүлэх.....	31
Хөдөлгөх.....	33
Чиглэл өөрчлөх.....	32
Газрын зургийн дэлгэц.....	28
Газрын зургийн дэлгэцийн тохиргоо.....	151
Газрын зургийн дэлгэцний тохиргоо	
Гудамжны авто зогсоол	151
Газрын зургийн тэмдэг	
Хурдны камер	152
Газрын зургийн хэл.....	81
Гар ашиглан хайх.....	49
Гар утас	

Автомашинаа зарах, устгалд оруулах.....	218
Бүртгэх.....	113
Устгах.....	116
Холбох.....	117
Гар утас солих.....	242
Гарын оролцоогүй дуудлага.....	216
Мессеж.....	256
Гудамжны авто зогсоол санал болгох.....	81
Гэр	
Бүртгэх	158
Очих газраар тохируулах	158

Д

Дамжуулах	
Холбоо барих хаягийн дата (утасны дугаар).....	244
Дилерийн мэдээлэл.....	74
Дуу хоолойн команд.....	45
Дуу хоолойн удирдлагаар систем удирдах.....	40
Дуу хоолойн удирдлагын систем	40

Дуудлага дундах үйлдэл.....	236
Дуудлага дуусгах.....	241
Дуудлага хийх	
Ирсэн болон гарсан дуудлагын түүх.....	228
Тогтмол ашигладаг жагсаалт...	229
Тоон гараар оруулах.....	231
Утсаар яриж байгаа.....	239
Үргэлжилсэн сигнал.....	232
Холбоо барих хаяг.....	230
Дуудлага цуцлах.....	235
Дуудлагад хариулах/Дуудлага хүлээн авах.....	233
Дууны түвшин тохируулах.....	34
Аудио.....	34
Гар утас (Ая)	224
Навигацийн дууны түвшин.....	95
Системийн дууны түвшин.....	95
Утас (Ая)	226
Утас (Ая/хүлээн авагч).....	103
Дууны чанар тохируулах.....	100
Дүрсний чанарыг тохируулах.....	99
Дэлгэц асаах/унтраах.....	70
Дэлгэцийн ажиллагаа.....	25
Дэлгэцийн гар	
Тоо, үсэг оруулах.....	27
Дэлгэцийн горим өөрчлөнө.....	98
Дэлгэцийн өнгөний ялгарал, гэрлийн хэмжээ.....	70
Дэмжих функцууд.....	111

Е

Ерөнхий тохиргоо.....	67
-----------------------	----

Ж

Жолооны хүрдний товч	
Аудио.....	34
Гарын оролцоогүй утас.....	224,226
Дуу хоолойн удирдлага.....	42

З

Зааварчилгааны демо	165
Зайлсхийх.....	84
Замын цэг нэмэх.....	161
Замын цэгүүд	168
Замын эгнээний дэлгэц.....	171
Засварлах.....	169

И

Интернет.....	258
Дэлгэц.....	259
Удирдах.....	260
Интернет радио.....	185
Интернет хөтөч	
Дэлгэц.....	259

К

Камер цэвэрлэх.....	275,316
---------------------	---------

М

Маршрут дахин хайх	173
Маршрут өөрчлөх	167
Маршрутын зааварчилгаа	170
Маршрутын сонголтыг өөрчлөх	166
Масштаб.....	31
Масштаб өөрчлөх.....	31
Мессеж.....	251
Мессежинд хариу өгөх.....	253
Мэдрэгчтэй дэлгэц.....	22

Н

Навигацийн систем	144
Навигацийн тохиргоо.....	89
Нууцлалын түгжээ.....	75

О

Огноо, цагны тохиргоо.....	67
Одоогийн байрлал	
Дэлгэцээр харуулах	30
Олон хүнтэй зэрэг дуудлага хийх....	
.....	240
Очих газар	
Нэмэх.....	161
Сүүлд ашигласан очих газрууд	
устгах.....	89
Устгах.....	170
Хайх	156
Очих газар хайх.....	156
Гэр	158
Жолоодлогын төлөвлөгөө	159
Очих газрын түүх	159
Тогтмол ашигладаг хаягнаас очих	
газар сонгох	158
Тэмдэгт оруулах	157
Ухаалаг утасны дэмждэг апп ..	162
Очих газрын тохиргоо	164

Ө

Өндөр нягтаршилтай дууны эх	
үүсвэр.....	338

П

Панорамик дэлгэц.....	285
Программ хангамжийн мэдээлэл	
шинэчлэх.....	77

Р

Радио сонсох.....	178
-------------------	-----

С

Систем дахин асаах.....	15
Статусын тэмдэг.....	20

Т

Тоглуулах	
Android Auto.....	203
Apple CarPlay.....	199
Bluetooth® аудио.....	207
iPod/iPhone.....	195
Miracast®.....	212
USB флаш.....	188,191
Тоо оруулах.....	27
Тохиргоо	
Аюулгүй байдлын тохиргоо.....	75
Газрын зургийн дэлгэцийн	
тохиргоо.....	81,151
Гэрлийн хэмжээ.....	70
Дилерийн мэдээлэл тохируулах	
74	
Дуу болон медиа тохиргоо.....	95
Дуу хоолойн удирдлагын	
тохиргоо.....	72
Дэлгэцийн тохиргоо.....	70
Ерөнхий тохиргоо.....	67
Зааварчилгааны тохиргоо	87
Маршрут хайх тохиргоо.....	84
Навигацийн системийн тохиргоо	
.....	80
Нууцлалын тохиргоо.....	75
Олон төрлийн тохиргоо.....	58
Өнгөний ялгарал.....	70
Панорамик дэлгэцийн тохиргоо...	
.....	314
Радио тохиргоо.....	95
Хэрэглэгчийн профайлын	
тохиргоо.....	63
Цаг.....	67
Bluetooth® төхөөрөмжийн	
тохиргоо.....	103
Wi-Fi® тохиргоо.....	101
Тохируулах	
Дууны чанар.....	100
Дүрсний чанар.....	99

Тухайн газрын мэдээлэл харуулах...
..... 148

У

Устгах

Очих газар 170

Сүүлд ашигласан очих газрууд.. 89

Тогтмол ашигладаг тохиргооны
жагсаалт..... 250

Хавчуурга..... 261

Холбоо барих хаяг (Утасны
дугаар)..... 249

Хөтөчийн түүх..... 261

Хэрэглэгчийн профайл..... 63

Bluetooth® төхөөрөмж..... 116

Ухаалаг утас

Бүртгэх..... 113

Очих газар тохируулах
(NaviBridge) 162

Устгах..... 116

Холбох..... 117

Ү

Үндсэн цэс..... 18

Үсэг оруулах..... 27

Ф

Форматын мэдээлэл..... 338

Х

Холбоо барих хаяг (утасны дугаар)

Нэмэх..... 248

Холбоо барих хаяг (Утасны дугаар)

Устгах..... 249

Холбоо барих хаягийн дата
(утасны дугаар)

Дамжуулах..... 244

Холбоо барих хаягийн дата
(Утасны дугаар)

Өөрчлөх..... 248

Холбох

Bluetooth® төхөөрөмж..... 117

iPod..... 39

Miracast®..... 211

USB порт..... 39

Wi-Fi®..... 125

Хотын газрын зураг..... 31

Хөтөч..... 258

Дэлгэц..... 259

Удирдах..... 260

Хурдны замын горим 155

Хэлний тохиргоо..... 67

Хэрэглэгчийн профайл

Бүртгэх..... 52

Хэрэглэгчийн профайл бүртгэх,
өөрчлөх..... 60

Ц

Цаг агаарын удирдлагын товч..... 16

Цагны тохиргоо..... 67

Ч

Чиглэл өөрчлөх..... 32

Ш

Шинэ мессеж илгээх.....254

Шинэчлэх

Программ хангамжийн мэдээлэл..
.....77**Э**

Эргэн тойрноос дуугарах дуу.....95

ЯЯвж буй зүгийг дээд талд харуулах
дэлгэц.....32**Латин үсгийн дарааллаар**

AM радио..... 178

Android Auto..... 137,203

Apple CarPlay..... 199

Бүртгэгдсэн ухаалаг утас..... 134

Бүртгэгдээгүй ухаалаг утас..... 131

Bluetooth® аудио.....207

Bluetooth® төхөөрөмж

Үндсэн төхөөрөмжөөр тохируулах
.....121

Bluetooth® төхөөрөмж

Бүртгэх..... 113

Устгах..... 116

Хоёрдогч төхөөрөмжөөр
тохируулах..... 122

Холбох.....117

DAB радио.....181

DAB сонсох.....181

FM радио..... 178

Gracenote® 185,338

iPod/iPhone..... 195

Lexus хэрэглэгчийн аккаунт..... 52

Lexus parking assist монитор.....266

Чиглүүлэх шугам гаргах268

Lexus parking assist мониторийн
анхааруулга

Камерны байрлал..... 277

Miracast®212

Miracast® дэмждэг төхөөрөмж
холбох.....211

NaviBridge..... 162

POI тэмдэг гаргах..... 150

USB порт.....39

USB салаалагч.....186,194

USB флаш.....188,191

Wi-Fi®

Холбох.....125

Wi-Fi® тохиргоо.....101

Хэвлэлийн дугаар. OM48L02E

Эдийн дугаар. 01999-48L02

Хэвлэсэн газар: Монгол 01-2210-00 C

RX500h / RX450h+ / RX350h / RX350 マルチメディア (一般 / 豪州E)